|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдлэг чадварыг сайжруулна. | | | | | | | | сургалтын өмнөх сорил 83%, дараах сорил 90% буюу 7% ахисан үр дүнтэй байна. Хамрагдалт 420 сувилагч.<br>**2022** онд Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн хувийн суурь чадамж, ёс зүй хандлагыг чадавхжуулах, Орчин үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний шаардлагад нийцүүлэн мэргэжлийн болон компьютер, цахим технологийн чадамжийг дээшлүүлэх,<br>Төрөлжсөн мэргэшил олгох сургалт, Сувилагч, тусгай мэргэжилтний ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах зэрэг 4 удаагийн мэдлэг чадварыг сайжруулах сургалтад нийт 278 сувилагчийг хамруулсан.<br>**2023** онд АЗДТГ, ЭМГ, Жайка ОУБ хамтран “Эрүүл мэндийн хөгжлийн төв”-ийн санаачилгаар “Сувилахуйн сургагч багш бэлтгэх сургалт”-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, эмнэлзүйн сургагч багшаар 24 сувилагч,<br>11 чиглэл сэдвийн хүрээнд ажлын байрны сургалтад 367 сувилагчид сургалтад хамрагдсан. “Олон нийтэд түшиглэсэн нялх, бага насны хүүхдийн хооллолт”-ын сургагч багш бэлтгэх сургалт 23 сувилагч хамрагдсан. Хятад 1, БНСУ 1 эх баригч сургалтад хамрагдсан.<br>Нийт 11 чиглэлээр, 14 удаагийн сургалтад 414 сувилагчид хамрагдсан.<br>**2024** онд Сувилахуйн тусламж, үйлчилгээний гардан үйлдлийн сургалтыг 6 төрлөөр 10 удаа сургалт зохион байгуулж, нийт 403 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан. “Цэнхэр кодоор тусламж үзүүлэхэд сувилагчийн оролцоо” сэдэвт ур чадварын тэмцээн зохион байгуулж, ЭМБ-уудын 24 сувилач оролцож, үзүүлэх дадлага сургалтанд 120 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн оролцсон байна. Гадаад сургалтад нийт 6 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан байна. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | **Үр дүн:** 2021 онд 420, 2022 онд 278, 2023 онд 414, 2024 онд давхардсан тоогоор 547 сувилагч хамрагдсан нь 4 жилийн хугацаанд 1659 сувилагч тусгай мэргэжилтэн мэдлэг чадварыг сайжруулах сургалтад хамрагдсан. | |
| 31 | 1.1.5.5. Эмнэлгийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулна. | 2021-2024 | НБХ | - | - | Хөнгөлөлттэй нөхцөлөөр 15-20 ажилтныг хамруулна. | - | ОНТ 58.5 | 2021 онд Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах хүрээнд 2021 онд шинээр ашиглалтад орсон орон сууцанд 14 хүн орж, Ковидын улаан бүсэд ажиллаж байгаа өрх толгойлсон 2 сувилагчид гэр олгосон. Ковид цар тахлын халдварын эсрэг үйл ажиллагаанд оролцон ажиллаж байгаа ажилчдын илүү цагийн цалин хөлсийг 100% олгосон.<br>2022 онд Нэгдсэн эмнэлгийн бүх шатлалын үндсэн цалинг 8.2-13.2%-иар нэмэгдсэн. Засаг даргын нөөц хөрөнгөөс 585 сувилагчид 58,5 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. 154 эмч, эмнэлгийн ажилчдад нийт 60 тонн нүүрс олгосон.<br>2023 онд 07 сарын 01-ний өдрөөс төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл сангаас орон нутгийн 40%-ийн нэмэгдэл олгож эхэлсэн. Аймгийн Засаг даргаас өгсөн чиглэлийн дагуу бага насны хүүхэдтэй төрийн албан хаагчдад өглөө, орой сургууль цэцэрлэгт хүргэх, авах тус бүр 30 минутын чөлөө олгосон.<br>Нэгдсэн эмнэлэг нийт 5 эмнэлгийн ажилтанд 2,4 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосон.<br>Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр орон нутгийн барилгын компанийн хандиваар нийт 3 сувилагчид 1 өрөө 1ш, 2 өрөө 2 ш олгох эрхийн бичгийг Засаг дарга олон улсын сувилагчдын өдрөөр Эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудад гардуулсан.<br>Олон улсын сувилагч нарын өдрийг тохиолдуулан аймгийн Засаг дарга “Гэгээн дагина” номинаци шалгаруулж, 1.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2024 онд Эрүүл мэндийн байгууллагуудын үйлдвэрчний эвлэлийн хорооны санаачлан хэрэгжүүлж байгаа эрүүл мэндийн ажилтны 108 айлын 10 давхар орон сууцны “Health apartment барилгын төсөл”-ийг Эрүүл мэндийн газрын даргын зөвлөлийн 4 дүгээр хурлаар хэлэлцэн баталж гэрээ байгуулсан ба барилга 2025 оны 4-р улиралд ашиглалтад орохоор төлөвлөгдсөн. Тус компаниас 2 хүүхдийн сургалтын төлбөрийг 100 олгохоор болж, 2 өрхөд байрны урьдчилгаа 15 хувийн хөнгөлөлт өгсөн.<br>Мөн байрны захиалга өгсөн эхний 20 ажилтанд зах зээлийн үнээс бага үнээр захиалга авсан байна.<br>Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын нэмэлт өөрчлөлтөөр сумын эрүүл мэндийн төвд ажиллагсдын цалин орон нутгийн 40%-иар, 2024 онд Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр Эрүүл мэндийн газрын 63 ажилтан үндсэн цалингийн 40%-иар орон нутгийн нэмэгдэл тус тус олгогдсон.<br>**Үр дүн:** аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр нийт 3 сувилагчид 1 өрөө, 2 сувилагчид 2 өрөөний эрхийн бичгийг олгосон. 2 хүүхдэд сургалтын төлбөр, 2 өрхөд байрын урьдчилгааг хөнгөлсөн. | |
| 32 | 1.1.5.5. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг тасралтгүй сайжруулна. | 2021-2024 | НБХ | - | “Эерэг хандлага-эмчилгээний эхлэл” аян зохион байгуулж, 482 эмч, мэргэжилтэн эмч, ажилта | 500 эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг тасралтгүй сайжруулна. | - | - | **2021** онд Сургалтад 606 эмнэлгийн ажилтан хамрагдаж “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийн сорил өгсөн 128 ажилтны дундаж үнэлгээ 83%<br>**2022** онд 5 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 748 эмч, мэргэжилтэн хамрагдсан. Мэдлэгийн түвшин 35%-иар нэмэгдсэн байна.<br>**2023** онд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг тасралтгүй сайжруулах үйл ажиллагаанд давхардсан тоогоор 826 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>**2024** онд Ёс зүйн сургалтад Нэгдсэн эмнэлэг -3 удаа -236 ажилтан, мэргэжилтэн, Төрийн албан хаагчдад | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | н хамрагдсан. | | | | зориулсан цахим сургалтаар 1,2,3 түвшинд ёс зүйн чиглэлээр ЭМГ, өрхийн эрүүл мэндийн төвийн 48 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, гэрчилгээ авсан.<br>-Төрийн албаны салбар зөвлөл, АШУҮИС-ийн багш Цэрэнбат зохион байгуулсан Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтад ЭМБ-уудын удирдах албан тушаалтан, мэргэжилтэн, тасгийн эрхлэгч, эмч нарын төлөөлөл 220 хүн хамрагдсан.<br>**Үр дүн:** 2021-2024 онд давхардсан тоогоор нийт 2684 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. | |
| **1.2. БИЕИЙН ТАМИР, СПОРТ** | | | | | | | | | | |
| **1.2.1 Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт сургах зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 33 | 1.2.1.1. Ахмадуудын спортын III их наадмыг спортын 5 төрлөөр зохион байгуулна. | 2021-2024 | НБХ | 8.0 | Ахмадын спортын II наадамд спортын 5 төрлөөр 360 тамирчин оролцсон. | 1,5%-иар нэмэгдүүлнэ. | ОНТ 2.0 | Улсын төсөв, ОНТ 6.0 | Ахмад настны авьяас, чадварыг алдаршуулах, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор Дархан-Уул аймгийн Ахмадын холбоо, Дархан сумын ахмадын холбоо, Монгол ахмад мастеруудын спортын холбооны Дархан-Уул аймаг дахь салбар хороотой хамтран Дархан-Уул аймгийн ахмадын спортын наадмыг жил бүр уламжлал болгон спортын 6 төрөл /дартс, граунд гольф, софт волейбол, шатар, ширээний теннис, бадминтон/ - өөр амжилттай зохион байгуулдаг. Тэмцээнд 4 сумдын 21 багийн 380 гаруй тамирчид 2 насны ангилалд өрсөлдөж багийн нийлбэр дүнгээр Дархан сумын 8 дугаар баг ТЭРГҮҮН байр, Дархан сумын 10 дугаар баг ДЭД байр, Дархан сумын 16 дугаар баг ГУТГААР байранд шалгарлаа. Тэмцээний зардалд улсын төсвөөс 4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Биеийн тамираар тогтмол хичээллэгч ахмадуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор БТСГ-ын спорт зааланд 1,3,5 өдөр, Хуучин Дарханы спортын ордонд 2,4 өдрүүдэд | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | өдөрт 2 цаг үнэ төлбөргүй хичээллэж байна.<br>**Үр дүн:** Дархан-Уул аймагт 55-аас дээш насны 13114 ахмадуудаас<br>- 2021 онд 550 хүн<br>- 2022 онд 620 хүн<br>- 2023 онд 650 хүн<br>- 2024оны эхний хагас жилийн байдлаар 700<br>орчим болж биеийн тамираар хичээллэх ахмад настнуудын тоо нэмэгдсэн.<br>Мөн ахмадууд хөнгөн атлетик, дартс, граунд гольф, софт волейбол, бадминтон, ахмадын нийтийн бүжиг, хөнгөн атлетик зэрэг спортын төрлөөр Улсын аварга шалгаруулах тэмцээнд тогтмол оролцож багаараа медальт байранд шалгарсан амжилтыг үзүүллээ. | |
| 34 | 1.2.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд “Бид хамтдаа” спортын арга хэмжээг зохион байгуулна. | 2021-2024 | НБХ | 4.0 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын наадамд 60 орчим хүн оролцд.ог | 2 хувиар нэмэгдүүлнэ. | ОНТ 1.0 | - | - 2021 онд “ТОКИО-2020” Паралимп зуны XVI олимпийн их наадамд Монгол улсаа төлөөлөн оролцсон тамирчин Д.Саруултөгсд ОНТ-өөс 3.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Ковид-19 цар тахалтай холбоотой олон нийтийг хамарсан тэмцээн уралдаан зохион байгуулаагүй.<br>- 2022 онд “Бид хамтдаа” уламжлалт арга хэмжээний хүрээнд ”Пара хөнгөн атлетикийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд спортын 7 төрөлд 68 тамирчин оролцож аваргуудаа тодруулсан. МБАТ-ний спортын XV наадмын шигшээ тэмцээний пара спортын төрөлд хөнгөн атлетик, пара жүдо төрлөөр 2 алт, 2 мөнгө, 4 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 3 -р байрт шалгарсан бөгөөд өмнөх суурь түвшинтэй харьцуулахад 13 хувиар өссөн байна.<br>- 2023 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд жил бүр уламжлал болгон явагддаг “Бид хамтдаа” арга хэмжээний хүрээнд ”Пара хөнгөн атлетик, нисдэг таваг, дартс гэсэн 3-н төрлөөр насанд хүрэгч, өсвөр үе гэсэн 2 ангиллаар зохион байгуулж 70 гаруй хөгжлийн бэрхшээлтэй | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | иргэд оролцож улсын төсвийн 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Пара хөнгөн атлетикийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон 20 тамирчинд ОНТ 2 сая, ХБНГУ-д болсон Тусгай олимпын дэлхийн зуны наадмын сагсан бөмбөгийн төрөлд оролцож буй 2 тамирчны замын зардалд 2 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.<br>Дархан сумын VII цэцэрлэгтэй хамтран Тусгай хэрэгцээт хүүхэд багачуудын дунд "Би чадна" спорт өдөрлөг зохион байгуулж хүүхэд багачуудын бие бялдрын боловсролыг дэмжихэд шаардагдах 700 мянган төгрөгийн хэрэглэл материалын дэмжлэг үзүүллээ.<br>-2024 оны эхний хагас жилийн байдлаар Дархан-Уул аймгийн 7 цэцэрлэгтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй дауны хам шинж, аутизмтай 50 хүүхдүүдийн дунд “Би чадна” урлаг, спортын уралдаан тэмцээнд 150 гаруй хүүхдүүд, эцэг, эх багш нар оролцсон. Биеийн тамир, спортын газар болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран “Тэгш хөгжье” спортын 5 төрөлт тэмцээнд 73 хүүхэд насанд хүрэгчдийн хамруулж, медаль өргөмжлөлөөр шагнаж урамшууллаа. Тусгай олимпын хорооноос сургагч 5 багш нар сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын 150 багш нарт дауны хам шинжтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах заавар онол практикийн 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Дархан-Уул аймгийн хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчид хүүхэд насанд хүрэгчдийн дунд Пара хөнгөн атлетикийн гүйлт, зээрэнцэг, бөөрөнцөг,тэргэнцэртэй уралдаанд 50 гаруй тамирчдад шалгарсан медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшууллаа. Ахмад настны дунд софт волейболын нээлттэй аймгийн аварга шалгаруулах | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тэмцээн зохион байгуулагдаж 3 насны ангилалд 250 тамирчин оролцсон.<br>**Үр дүн:** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулсан арга хэмжээнд оролцогчдын тоо 2,5-4,5 хувьд хүрч 2 хувиар өссөн байна. /4500 орчим хүнээс 200 гаруй хүн / | |
| 35 | 1.2.1.2. Хуучин Дарханд Спортын ордон шинээр барьж байгуулна. | 2021-2022 | | 3 тэрбум | Нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнөөр тогтмол хичээллэгдийн тоо 23150 | Спортын ордонг ашиглалтад оруулсан байна | 3,3 тэрбум | 3,091.6 | Дархан сумын Өргөө багийн нутаг дэвсгэрт 1816.5м2 талбай бүхий 2 давхар Спортын ордоны барилга 2022 онд шинээр ашиглалтад оруулж үйл ажиллагаа хэвийн явагдаж байна<br>**Үр дүн**: Дархан сумын 1, 2 , 3, 4, 5, 6, 7, Өргөө багийн иргэд жилийн 4-н улиралд спортоор хичээллэж байна. | 100% |
| 36 | 1.2.1.3. Гэр бүл, иргэдийн оролцоотой тэмцээн уралдаан зохион байгуулна. | 2021-2024 | НБХ | 1.2 сая | Гэр бүлийн марафон гүйлтийн тэмцээнийг 2019 онд зохион байгуулж, 250 хүн оролцож, эхний 3 байрыг шалгаруулан урамшуулсан. | 1,5 хувь | ОНТ 300 мянга | - | Гэр бүл, иргэдийн бие бялдрын хөгжлийг дэмжих, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх зорилгоор ”Илүүдэл жингүй эртэч Монгол” аяны хүрээнд, цасны баяр, ажлын байрны дасгал, өглөөний дасгал, завсарлагааны дасгал, дугуйн баяр, дугуйтай Дархан арга хэмжээ, тамирчдын өдөр зэрэг 5 төрлийн арга хэмжээнд иргэн, гэр бүл, хамт олныг хамруулсан арга хэмжээг жил бүр зохион байгуулж байна.<br>- 2021 онд 4 төрлийн арга хэмжээнд нийт 683 хүн шинээр оролцсон нь өмнөх онтой харьцуулахад 1,6%-иар нэмэгдсэн.<br>- 2022 онд 3 төрлийн арга хэмжээнд 41 байгууллагын 1162 албан хаагч, албан хаагчдын гэр бүлийг татан оролцуулж 22 гэр бүлийн 66 тамирчин хамрагдсан нь оролцоог 1 хувиар нэмэгдүүлсэн.<br>- 2023 онд шинээр 7 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 10120 орчим хүн хамрагдаж оролцоог 5%-иар нэмэгдүүлсэн. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Улсын болон орон нутгийн 27,7 сая төгрөгийг зарцуулсан.<br>2024 онд Дархан-Уул аймгийн явган алхалтын холбооноос гэр бүл ард иргэдийг уриалан долоо хоног бүрийн бямба гаригт тогтмол алхаж хэвшээд байна. Явган алхалтын холбоо нь 200 гаруй идэвхтэй алхагчтай бөгөөд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран эхний хагас жилийн байдлаар 21 удаагийн алхалт зохион байгуулж давхардсан тоогоор 800 хүн хамрагдлаа.<br>**Үр дүн:** Гэр бүл, иргэдийн оролцоотой тэмцээн уралдаан зохион байгуулж хэвшсэн. Оролцоо 4 жилийн хугацаанд 5 хувиар нэмэгдсэн байна. | |
| 37 | 1.2.1.4. Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцож буй тамирчдад дэмжлэг үзүүлнэ. | 2021-2024 | НБХ | 400. | 2020 онд залуучуудын өвлийн олимпод биатлон төрлөөр 1 тамирчин амжилттай оролцсон. | Уралдаан тэмцээний зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. | ОНТ 100.0 | 9,5 | Олимп, Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцож буй 10-15 тамирчинд нийт 49,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Үүнд:<br>2022 оны насанд хүрэгчдийн Дэлхийн АШТ-с хүрэл медаль хүртсэн Н.Наранхүүд 3 сая төгрөгөөр урамшуулсан, ХАНЖОУ-2022 Дархан-Уул аймгаас 6 спортын төрөлд 14 тамирчид улсын шигшээ багт шалгаран оролцож сагсан бөмбөгийн 3х3 төрөлд Болорцэцэг, Чөлөөт бөхийн тамирчин Н.Насанбуян нарт аймгийн ЗДТГ-аас тус бүрт 2 сая нийт 4 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.<br>2022 онд шилдэг холбоогоор шалгарсан Чөлөөт бөхийн холбоо, Хоккейн холбоо, Шатрын холбоонд тус бүр 10 сая нийт 30 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.<br>Muugii dance клубын тамирчин С.Мөнхцэцэг, О.Жамц Англи улсад зохион байгуулагдсан Дэлхийн аварга шалгаруулах хосын бүжгийн төрөлд оролцоход 2,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.<br>БНСУ-д ахмадын зүүн Азийн наадмын волейболын төрөлд 2 ахмад тамирчин тус | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | бүр 500.0 мянган төгрөг нийт 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.<br>Өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах тэмцээнд аймгаа төлөөлөн оролцсон тамирчин О.Цэцэнбилэг, багш С.Энхбаяр нарт 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.<br>Оюунлаг оюуны ундраа ТББ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 5 сая, Эрүүл монгол хүн сэдэвт бүжгийн наадамд оролцсон 29-н тамирчдад 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.<br>2021 онд Чөлөөт бөхийн U23 насны ДАШТ 1-хүрэл,<br>2022 онд Чөлөөт бөхийн Насанд хүрэгчдийн ДАШТ хүрэл, Чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн Ази тивийн АШТ 2-мөнгө 1-хүрэл, Чөлөөт бөхийн U15 насны Ази тивийн АШТ-с 1-хүрэл, 1-Хүрэл, Самбо бөхийн ДАШТ-с 1-мөнгө, Самбо бөхийн Ази тивийн АШТ-с 1-мөнгө<br>Шатрын Өсвөр үеийн 10 насны ангилалд ДАШТ-д 1-хүрэл мөн багийн Ази тивийн АШТ-д хүрэл,<br>2024 онд жүдо бөхийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль хүртсэн Б.Анхзаяад 3сая төгрөг дасгалжуулсан багш Д.Балжиннямд 1сая төгрөг, Чөлөөт бөхийн залуучуудын Ази тивийн аваргаас хүрэл медаль хүртсэн 1сая төгрөг, самбо бөхийн Өсвөр үеийн ази тивийн аваргаас хүрэл медаль хүртсэн О.Ариунсайханд 1 сая төгрөг, Ази тивийн чөлөөт бөхийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээнээс Б.Ганцэцэг хүрэл хүртэж 1 сая төгрөгийг тамирчдад дэмжлэг үзүүлээд байна.<br><br>**Үр дүн**:<br>2023 онд ХАНЖОУ-2022 Азийн наадмаас мөнгө -1, хүрэл-1, Пара хөнгөн атлетик төрөлд мөнгө-1 хүртсэн. Мөн Тив, дэлхийн тэмцээн буюу Зүүн азийн залуучуудын наадмаас мөнгө-3 хүрэл-8, Залуучуудын Ази тивийн АШТ-с мөнгөн медаль-1, 23 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | насны Ази тивийн АШТ-д мөнгө-1, хүрэл-1, насанд хүрэгчдийн Ази тивийн АШТ-д хүрэл-1, залуучуудын Дэлхийн АШТ-ээс мөнгө-1 Азийн цомын АШТ 1-хүрэл медаль хүртсэн амжилтыг тус тус үзүүллээ.<br>2024 онд Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 1 хүрэл, залуучуудын Азийн аваргаас 1 хүрэл, өсвөр үеийн азийн аваргаас 1 хүрэл медаль хүртээд байна. | |
| 38 | 1.2.1.5. Өвлийн спортыг хөгжүүлэн, материаллаг баазаар хангаж, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ | 2021-2024 | НБХ | - | Өвлийн спортын ордны барилгын зураг төсөв хийгдсэн байна. | Баг тамирчдыг бэлтгэл сургуулилтыг чанартай хийх, иргэд өвлийн улиралд агаар салхинд гарч, спортоор хичээллэх боломж нөхцөлөөр хангагдана | - | - | Дархан-Уул аймгийн Хонгор суманд Монголд анх удаа агаарын дугуйг төр хувийн хэвшлийн байгууллагын оролцоотой хийж хэрэгжүүлсэн. Мөн цана чаргаар гулгах дугуй болон мотцикл зэргийг оруулж ирэн цанын бааз байгуулан 3 га газрыг шийдвэрлэн ажилласнаар өвлийн спортыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.<br>Өвлийн спортыг хөгжүүлэхээр улсын болон бүсийн чанартай уралдаан, тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулсан. Үүнд<br>- “Болд” сангийн нэрэмжит тэмцээнд 7 багийн 100 тамирчид, МХХ цомын төлөө U-12 насны аварга шалгаруулах 5 багийн 70 тамирчид, Өсвөр үеийн хоккейчдын 14 насны улсын аварга тэмцээнд 6 багийн 80 тамирчид оролцсон байна.<br>- Орхон аймагт зохион байгуулагдсан өвлийн XVI наадамд гүйлтийн цана, хоккей төрлөөр 50 тамирчин оролцож орон нутгаас 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Өвлийн спортыг сурталчлан таниулах зорилгоор “Мөнгөн өвөл-2023” цасны баярыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан.<br><br>- 2021 онд өвлийн биеийн тамир спортын 15 арга хэмжээнд 2100 хүн харагдаж 1,5 сая төгрөг зарцуулсан.<br>- 2022 онд өвлийн биеийн тамир спортын 19 арга хэмжээнд 2500 | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хүн харагдаж 2,5 сая төгрөг зарцуулсан.<br>- 2023 онд өвлийн биеийн тамир спортын 26 арга хэмжээнд 2800 хүн харагдаж 8 сая төгрөг зарцуулсан байна. Өвлийн спортыг хөгжүүлэх зорилгоор Хонгор суманд 3 га газрын асуудлыг хувийн хэвшлийн байгууллагад шийдвэрлэн дэмжлэг үзүүлснээр Монголд анх удаа агаарын дугуй, цана чаргаар гулгах дугуй болон мотцикл зэргийг оруулж цанын бааз байгуулсан. Мөнгөн өвөл-2023” цасны баярыг аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт 23 байгууллагын 2000 орчим хүн хамрагдсан.<br>Орхон аймагт зохион байгуулагдсан өвлийн XVI наадамд гүйлтийн цана, хоккей төрлөөр оролцож 2 алт, 1 мөнгө медаль хүртсэн амжилтыг үзүүллээ.<br>2024 онд Өвлийн спортыг хөгжүүлэхээр улсын болон бүсийн чанартай уралдаан тэмцээнийг орон нутагтаа зохион байгууллаа. Үүнд:<br>U-12 насны аварга шалгаруулах 5 багийн 70 тамирчид, Өсвөр үеийн хоккейчдын 16 насны улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 дүгээр байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн.<br>Хоккейн ЛИГ-ийн тэмцээнд “Дархан баг” 1-р байр, “Шарын гол” баг 3-р байранд шалгарлаа.<br>Мөн Од сургуулийн дэргэдэх Хоккейн холбооны талбай, БТСГ-ын хоккейн талбай, шинээр “Миний монгол цэцэрлэгт хүрээлэн”-д мөсөн гулгуурын талбайн үйл ажиллагааг тогтмолжуулан өвлийн улиралд давхардсан тоогоор 6000 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Өвлийн спортыг дэмжих тухай” 27 дугаар зарлиг, Орчин цагийн биеийн тамир хөгжсөний 100 жилийн ой, | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Дархан-Уул аймагт Биеийн тамир, спортын газарт үүсч хөгжсөний түүхт 60 жилийн ойг тохиолдуулан Дархан-Уул аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд зарлагдсан “Мөнгөн өвөл-2024” цасны баярын арга хэмжээнд идэвхтэй хамрагдан албан хаагчдынхаа эрүүл мэндийг дэмжин ажиллаж, тайлан мэдээллээ ирүүлсэн нийт 29 байгууллагын 2500 орчим хүн хамрагдсан. **Үр дүн**: 2021-2024 онд нийт 9500 хүн хамрагдаж, арга хэмжээнд 17 сая төгрөг зарцуулсан. 4 жилийн хугацаанд өвлийн спортын биеийн тамирын арга хэмжээнд хамрагдагсад **800** хүнээр буюу **5** хувиар өссөн байна. | |
| **1.2.2 Монгол үндэсний уламжлалт спортыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.** | | | | | | | | | | |
| 39 | 1.2.2.1. Үндэсний спортын наадамд тамирчдыг амжилттай бэлтгэн оролцуулна. | 2021-2024 | НБХ | 13.0 | 2018 онд Үндэсний спортын наадамд манай аймгийн тамирчид амжилттай оролцож 6-р байранд шалгарсан. | Баг тамирчдыг бэлтгэл сургуулилтыг чанартай хийх боломж нөхцөлөөр хангана | 10.0 | УТХО 600 мян | Монголын хүүхдийн спортын VII наадмын анхан шатны тэмцээнийг 2023 оны 03 сарын 1-нээс 05 сарын 01-ны хооронд спортын 21 төрлөөр зохион байгуулж тэмцээнд 23 сургуулийн 3500 гаруй тамирчид оролцож багийн нийлбэр дүнгээр А.Нарантуяа захиралтай ОИ, 2-р байранд Баярбилэг захиралтай Од, 3-р байранд Д.Дэлгэрбаяр захиралтай 4-р сургууль тус тус шалгарлаа. Анхан шатны тэмцээнээс шалгарсан 20 спортын төрлийн 236 тамирчныг Баянхонгор аймагт 6 дугаар сарын 19-29-ны хооронд зохион байгуулагдсан шигшээ тэмцээнд амжилттай оролцож 3 дугаар байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн. Тэмцээнд амжилт гарган медальт байранд шалгарсан нийт 61 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. 2024 онд үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан оюутны спортын наадмын аймаг орон нутагтаа 8 төрлөөр амжилттай зохион байгуулж 7 сургуулийн 1000 гаруй оюутан хамрагдлаа. **Үр дүн:** 2023 онд энэхүү амжилтаа ахиулан 12 алт, 14 мөнгө, 8 хүрэл медаль | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хүртэн 21 аймгаас 3-р байранд шалгарсан амжилтыг үзүүллээ. | |
| 40 | 1.2.2.2. “Өсвөрийн шигшээ баг”-ийн тоог нэмэгдүүлнэ. | 2021-2024 | НБХ | - | “Өсвөрийн шигшээ баг”-ийг Засаг даргын захирамжаар байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | “Өсвөрийн шигшээ баг”-ийн тоо 15, амжилт 0,5 % ахина | - | - | 2021 онд 98 алт, 10 мөнгө, 159 хүрэл нийт 364 медаль хүртсэн<br>2022 онд 180 алт, 225 мөнгө, 328 хүрэл нийт 733 медаль хүртсэн<br>2023 онд 212 алт, 231 мөнгө, 346 хүрэл медаль хүртсэн<br>2024 онд “Өсвөрийн тамирчдыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Засаг даргын дэргэдэх “Өсвөрийн шигшээ баг”-ийг 17 төрөл болгон 5 төрлөөр нэмэгдүүлэн 250 тамирчинд /140 хөвгүүд, 110 охид/-ыг албан ёсоор бүртгэж батламж олгон тэмцээн уралдаанд оролцоход орон нутгаас дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>**Үр дүн:** 17 төрлөөр 250 гаруй тамирчид өсвөрийн шигшээ багт бэлтгэл хийж байна. Энэ онд Хөнгөн атлетик, сагсан бөмбөг, чөлөөт бөх, талбайн теннис, байт харваа, жүдо бөх , хөл бөмбөг бокс зэрэг спортууд өсвөр үеийн УАШТ-д багаараа медальт байранд шалгарлаа.<br>Эхний хагас жилийн байдлаар тив, дэлхийн тэмцээнээс 2 хүрэл, олон улсын улсын чанартай тэмцээнээс өсвөрийн тамирчид нийт 412 медаль хүртэж амжилтаа ахиулж чадлаа. | 100% |
| 41 | 1.2.2.3. Зурхайн зогсоолыг хийнэ. | 2021-2021 | НБХ | ОНТ 3.0 | Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнд сурын асар байгуулагдсан байна. | Зурхайн зогсоолын бүтээн байгуулалт хийгдсэн байна | - | - | Орон нутгийн төсвийн 19,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Зурхайн зогсоолыг шинээр хийж ашиглалтад оруулլаа. | 100% |
| **1.2.3 Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж, спортын барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 42 | 1.2.3.1. Спорт цогцолборын барилгын ажлыг дуусгана. | 2021-2024 | НБХ | Улсын төсөв 2.0 тэрбум | - | Барилгын ажлыг дуусгана. | - | - | Дархан-Уул аймгийн Дархан сумын 14 дүгээр багт улсын төсвийн 27.8 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Спорт цогцолбор” | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | баригдаж байна. Тус цогцолбор нь 20 мянган м/кв талбайтай, нийт 5 блокоос бүрдэнэ<br>Шинээр сүндэрлэх “Спорт цогцолбор” нь 2200 хүний суудалтай спорт заал, олон улсын стандартад нийцсэн 5 замтай 25 метрийн усан бассейн, тамирчдын бэлтгэлийн өрөө, хувцас солих өрөө, бүх төрлийн спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, бэлтгэл хийх танхимуудтай, тамирчдад зориулсан зочид буудал, зоогийн газар, хурлын танхимтай байх юм. Цогцолбор бүрэн ашиглалтад орсноор олон улсын чанартай уралдаан тэмцээнүүдийг орон нутагтаа зохион байгуулах бүрэн боломж нээгдсэн. | |
| 43 | 1.2.3.2. Хөл бөмбөгийн талбайн барилгын ажлыг дуусгана. | 2021 | НБХ | ОНТ 100.0 | Барилгын ажил дуусаж, ашиглалтад хүлээн авсан байна. | -- | | 1.5 тэрбум | Улсын төсвийн 1.5 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймгийн Дархан сумын 14 дүгээр багт байрлах “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнд нийт 8350м2 талбайд олон улсын стандартад нийцсэн хөл бөмбөгийн талбай байгуулагдсан. Тухайн талбайн гүйлтийн зам нь 2515м2, бетон талбай нь 2116 м2, үзэгчдийн суудал болон индэр нь 524 м2. | 100 |
| 44 | 1.2.3.3. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засварын ажлыг хийнэ. | 2021-2022 | НБХ | ОНТ | Төв цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилт, их засварын ажлыг хийнэ. | - | - | - | Дархан сумын 3 дугаар багт байрлах Төв цэнгэлдэх хүрээлэнг 4 улирлын турш байнгын үйл ажиллагаатай болгон шинэчлэхээр “Мөрөөдлийн талбай” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд төв цэнгэлдэх хүрээлэнг засварлах тендэрийг зарлах бэлтгэл ажил хийгдэж байна. | 0% |
| 45 | 1.2.3.4. Явган хүний болон унадаг дугуйн замын ажлыг хийнэ. | 2021-2024 | НБХ | 1,063.7 | Явган хүний зам 25000 км Унадаг-дугуйн зам 0 км | Явган хүний болон унадаг дугуйн замын ажлыш үргэлжлүүлнэ | ОНТ 100.0 | 1.299.9 | 2021 онд ОНХС-ийн 619,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дугуйн болон явган хүний замын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>2022 онд 1, 2 дугаар багийн тосгоны урд далангаар 2 км, хуучин дарханаас шинэ Дарханы төв зам дагуу 3,2 км зам хийгдсэн.<br>2023 онд шинэ хороололын 16 байрнаас шинэ хороололын арын зам-DBS уулзвараас– Аюулгүйн тойрог хүртэл 2,8 км, Соёл амралтын Дархан-60 цогцолборт 1,58 км, Дархан сумын 5,6 баг Гэгээ дэлгүүр хүртэл 0,85 км, 1,3,5 баг 6 | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | буудлаас МСҮ-ийн хүртэл 1,1км, 1-8 багийг холбосон 0,8 км замыг тавьсан.<br>2024 онд Мобикомын уулзвараас – онгоцны буудал хүртэл 2,7 км, АШУИС-аас ШУТИС 1 хүртэл 0,7 км, дугуйн замыг тус тус энэ онд хийхээр төлөвлөсөн.<br>**Үр дүн:** Нийт 19,13 км явган болон дугуйн зам хийгдсэн. | |
| 46 | 1.2.3.5. Хөл бөмбөгийн талбайн ажлыг хийнэ. /Шарын гол суманд/ | 2021-2023 | НБХ | 1,500.0 | Хөл бөмбөгийн газрын асуудал шийдэгдсэн байна | Стандартад нийцсэн хөл бөмбөги йн талбай ашиглал тад оруулна | УТХО 260.0 | 260.0 | Шарын гол сумын төвд хуучин хөл бөмбөгийн талбайг түшиглэн орчин үеийн стандартад нийцсэн хөл бөмбөгийн талбай шинээр байгуулах ажлыг “Уран минж” ХХК гүйцэтгэлээ. Тус хөл бөмбөгийн талбай нь 15966м2 талбайд тохижилтын ажил хийгдэнэ. 2022 онд төлөвлөсөн хөл бөмбөгийн талбайн хашаа барих ажлыг 100 хувьтай.<br>Үр дүн: 2022 онд төлөвлөсөн хөл бөмбөгийн талбайн хашаа барих ажил 100 хувийн гүйцэтгэлтэй | 100% |
| **1.3. БОЛОВСРОЛ** | | | | | | | | | | |
| **1.3.1. Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулна.** | | | | | | | | | | |
| 47 | 1.3.1.1. ЕБС-иудын ахлах ангийн сургалтын чанарыг сайжруулах зорилгоор бүтцийг өөрчилнө. | 2021-2023 | НБХ | - | Гүнзгийрүүлсэн сургалттай сургууль-4 | - | - | - | Ерөнхий боловсролын хууль шинээр батлагдсантай холбоотой ахлах ангийн сурагчид мэргэжлийн чиглэлээр сонгон суралцах, анги бүлэг нээж ажиллаж байна. Тухайлбал: Дархан-Уул аймгийн 18-р сургууль төмөр замын анги нээгдэж, сурагчдыг бэлтгэх, Од цогцолбор сургууль нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох судалгаа авч 5 чиглэлээр сонгоны бүлэг гарган хичээллэж байна.<br>**Үр дүн:** Ахлах ангийн сургачид өөрсдийн хүссэн мэргэжлээ эзэмшиж суралцах нөхцөл бүрдсэн. | 100% |
| 48 | 1.3.1.2. PISA үнэлгээний туршилт болон үнэлгээнд хамрагдана. | 2021-2022 | НБХ | - | - | - | - | - | Сурагчдын мэдлэг чадварыг үнэлэх олон улсын PISA үнэлгээ 2022 оны 4 дүгээр сард БҮТ-өөс цахимаар зохион байгуулж ЕБ-ын 6 сургууль /1, 2, Од цогцолбор, Оюуны ирээдүй цогцолбор, 14, Цайхун/, Дархан Политехникийн коллеж, Дархан-Өргөө ПТК-ийн 15 настангууд буюу нийт 296 сурагчид хамрагдсан нь Монгол улсаас хамрагдсан суралцагчдын 4 хувийг | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | эзэлж байна, Олон улсын үнэлгээний зохион байгуулалтад давхардсан тоогоор 16 сургалтын менежер, 15 мэдээлэл зүйн багш хамрагдлаа.<br>Судалгааны үр дүнгээр Дархан-Уул аймаг улсын хэмжээнд Математикийн судлагдахуун 419 оноо буюу 6-т, Унших чадвар 380 оноогоор 6 дугаарт тус тус эрэмбэлэгдэж байна. | |
| **1.3.2. Шинээр барих, өргөтгөх замаар цэцэрлэг, сургуулийн тоог нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ** | | | | | | | | | | |
| 49 | 1.3.2.1. Өргөө багт шинээр цэцэрлэг барьж ашиглалтад оруулна. | 2021-2022 | НБХ | 1.1 тэрбум | Барилгын ажлын гүйцэтгэл 40% | Үйл ажиллагаа эхэлсэн байна | 200.0 | 1.1 тэрБум 200.0 | 31 дүгээр цэцэрлэг ашиглалтад орж, 4 бүлэгт 120 хүүхэд хамрагдаж, 20 багш ажилтан, сургуулийн өмнөх боловсрол олгож, үйл ажиллагаагаа тогтмолжсон.<br>Үр дүн: 31 дүгээр цэцэрлэг ашиглалтад орж үйл ажиллагаа 100% жигдэрсэн. | 100 |
| 50 | 1.3.2.1. Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийг өргөтгөнө. | 2021-2023 | НБХ | 800.0 | | | | 408.6 | 2021 онд Өргөө багт 1,1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 100 хүүхдийн ортой 31 дүгээр цэцэрлэг шинээр,<br>2022 онд УТХО 800.0 сая төгрөгийн санхүүжилтээр Орхон сумын 9 дүгээр цэцэрлэгийн 75 ортой өргөтгөлийн барилга баригдаж ашиглалтад орсноор 3 бүлэг, 75 хүүхэд хүлээн авах хүчин чадал нэмэгдэж, нийт 9 бүлэгт 196 суралцагч хамрагдсан.<br>2023 онд Хонгор сумын Салхит багт 100 ортой цэцэрлэг УТХО 2.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй баригдаж, 2024-2025 оны хичээлийн жилд 4 бүлэг 100 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа эхэлсэн.<br>Үр дүн: 2021-2024 онд нийт цэцэрлэгийн 1 өргөтгөл, 2 цэцэрлэгийн барилга шинээр ашиглалтад орж, СӨББ-ын хүүхдийн хамрагдалт 95%-д хүрсэн. | 100 |
| 51 | 1.3.2.2. 15 дугаар багт ахлах сургуулийг ашиглалтад оруулна. | 2021-2024 | НБХ | 7.7 тэрбум | Зураг төсөв хийгдсэн. | Үйл ажиллагаа эхэлсэн байна. | - | | Азийн хөгжлийн банкны 10.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 15 дугаар багт 960 хүүхдийн суудалтай сургуулийн барилга баригдан, аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/341 дүгээр захирамжаар 2024 оны Дархан сумын Ерөнхий боловсролын “31 дүгээр сургууль” нэршил олгосон. 2024 оны 09 дүгээр сард | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хичээлийн нээлт хийж үйл ажиллагаа эхэлсэн.<br>**Үр дүн**: 960 хүүхдийн суудалтай сургууль ашиглалтад орж үйл ажиллагаа 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлсэн. | |
| 52 | 1.3.2.3. 4 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулна. | 2021-2024 | НБХ | 5.2 тэрбум | Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 800,0 төгрөг зарцуулагдсан. 18% | Сургалтын стандарт шаардлага хангагдсан байна. | - | - | 2022 онд 4 дүгээр сургуулийн 480 хүүхдийн суудалтай сургуулийн барилгыг УТХО 6,3 тэрбум төгрөгийн өртгөгтэйгээр баригдаж, бүрэн ашиглалтад орсон. Сургуулийн өргөтгөл ашиглалтад орсноор 20 бүлэгт 658 гаруй хүүхэд суралцаж, 3 ээлжээр хичээллэж байсан сургууль 2 ээлжээр хичээллэдэг болсон.<br>9 дүгээр сургуулийн өргөтгөл 320 суудалтай барилгыг УТХО-р 7.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Дугаар 10/2024-Д комиссын дүгнэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>**Үр дүн**: 2 сургуульд өргөтгөл хийгдэн 800 суудал нэмэгдэж сургалтын стандарт шаардлага хангагдсан. | 100% |
| 53 | 1.3.2.4. 5 настай хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах, СӨББ-ын хамран сургалтыг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | НБХ | - | СӨББ-ын хамран сургалт 88.1 хувь<br>5 настай хүүхдийн хамрагдалт 98.9 хувь | СӨББ-ын хамран сургалт 93%<br>5 настай хүүхдийн хамрагдалт 100%-д хүрсэн байна. | - | - | 2021 онд 38 цэцэрлэгт 5827 хүүхэд буюу СӨБ-д хамрагдалт 89%, 5 настай хүүхдийн хамрагдалт 96%-тай,<br>2022 онд 40 цэцэрлэгт 7956 буюу СӨБ-ын хамран сургалт 92%, 5 настай 99.2%-тай,<br>2023 онд 38 цэцэрлэгт 8246 буюу СӨБ-ын хамран сургалт 95%, 5 настай 99.2%,<br>2024 онд 38 цэцэрлэгт 8275 үүнээс 5 настай 2335 хүүхжд хамрагдаж, 5 настай СӨБ-д хамрагдалт 97.2%-тай байна.<br>**Үр дүн:** СӨББ-уудын хамран сургах тойргийг шинэчлэн тогтоосон, хамран сургалт 95%-тай, үүнээс 5 настай хүүхдийн хамрагдалт 97.2%-тай байна. | 100% |
| 54 | 1.3.2.4. Сургуулийн өмнөх насны 5 настай хүүхдийн сургуульд | 2021-2024 | НБХ | - | 2020 онд онлайнаар 84.4% үнэлэгдсэн | 94-өөс доошгүй хувь нь сургуульд бэлтгэгдсэн байна. | - | - | Сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгаанд 2023- 2024 оны хичээлийн жилд төрийн 14 төрийн бус өмчийн 8 сургуулийн 72 бүлгийн 2377 сурагч 8 чиглэлийн 24 даалгаврыг хийж гүйцэтгэж хамрагдлаа. Уг судалгаа нь sub.eec.mn программ ашиглан явуулсан ба гүйцэтгэлийн хувь 73.39 хувьтай байгаа нь | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэгдсэн байдлыг үнэлнэ. | | | | | | | | улсын дундажаас 3.17 хувиар, орон нутгийн дундажаас 3.59 хувиар илүү байна. Мөн Од, ОИЦ, 11 дүгээр сургуулийн 1 дүгээр ангийн 24 багш, 3 сургалтын менежер, тухайн сургуулиас түүврийн аргаар сонгогдсон 200 сурагчийн эцэг эх, асран хамгаалагч мөн 26 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, давхардсан тоогоор 156 бүлгийн багш asuulga.eec.mn системд холбогдон сургалтын орчин, арга зүйн чиглэлээр асуулга судалгаанд хамрагдсанаар хойшид анхаарах зүйл болон зөвлөмжид тусгагдах боломж бүрдсэн | |
| 55 | 1.3.2.5. 7 дугаар цэцэрлэгийн бүлгийн тоог нэмэгдүүлнэ. | 2021-2024 | НБХ | 2.0 тэр-бум | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 2 бүлэг хичээллэж байна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд 100% хамрагдсан байна. | 1,0 | 200,0 | 14 дүгээр багт байрлах 7 дугаар цэцэрлэг нь 2021 онд “Сонсголгүйн боловсрол” ТББ-ын 26,0 сая төгрөгийн санхүүжилтээр сонсголын бэрхшээлтэй болон аутизмтай хүүхдийг хамруулах “Тэмүүлэл-3” бүлэгтэй болж, тусгай хэрэгцээт бүлгийн тоо нэгээр нэмэгдсэн<br>2022 онд Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн онцлогт тохирсон сургалтын орчны стандартад нийцсэн 3 бүлгийн өргөтгөлийн барилгын ажил эхэлсэн бөгөөд гүйцэтгэл 60%-тай байна.<br>2023 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалт үйл ажиллагаа сэргээн заслын эмчилгээ үйлчилгээг тасалдуулахгүй, тэгш хамран сургах зорилгоор 88,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Зулзагын гол”-ын хүүхдийн зуслангийн 8-р байранд 50 ортой “Зуны зуслан цэцэрлэг”-ийг нээн ажиллуулж, 72 хүүхэд сэргээн засах үйл ажиллагаанд хамрагдсан. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан тоглоом төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 12,3 сая төгрөгийн санхүүжилтээр Гадна талбайн тохижилт, тоглоомыг байршуулсан.<br>2024 онд “Зуны зуслан цэцэрлэг”-т 5 ээлжинд 80 хүүхэд, 55 эцэг эх, нийт 135 хүн хамрагдсан байна. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | **Үр дүн**: Тусгай хэрэгцээт 1 бүлэг нээсэн. УТХО-р 7-р цэцэрлэгийн 100 ортой өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл 60%-тай үргэлжилж байна. | |
| **1.3.3. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн орчныг сайжруулах, багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах төсөл хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 56 | 1.3.3.1. “Гоё цэцэрлэг” төсөл хэрэгжүүлнэ. | 2023-2024 | НБХ | 400.0 | Төсөл хэрэгжүүлэх цэцэрлэгийг сонгож, бэлтгэл хангагдсан байна | Гэр хорооллын болон сумдын цэцэрлэгийн орчин нөхцөлийг сайжруулна. | 200.0 | 79.9 | “Гоё цэцэрлэг” төслийн хүрээнд сургалтын орчныг сайжруулах зорилгоор<br>**2021 онд**<br>**-**ОНТХО 48,3 сая төгрөг Өргөө багт цэцэрлэгийн барилгын гадна тохижилт<br>**2022 онд**<br>-ОНТХО 166,2 сая төгрөгөөр 27, 9, 10–р цэцэрлэгт гадна талбайн тоглоом, хүүхдийн ор цагаан хэрэглэл,<br>-ОНТХО 1,073.7 төгрөгийн санхүүжилтээр 4,5,7,10,12,13,23,25,15-р цэцэрлэгүүдийн фасад засвар, цахилгаан засвар, халаалтын засвар<br>**2023 онд**<br>-ОНТХО, ОНХС 102.6 сая төгрөгийн санхүүжилтээр 1,4,5,8,10,13,11,15,18,25,26-р цэцэрлэгүүдийн дуу хөгжим, тоглоом, гал тогооны тоног төхөөрөмж<br>-ОНТХО 200.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14,25,28-р цэцэрлэгүүдийн шугам хоолой,дулаан, барилгын хүчитгэлд<br>-ОНХС 11,4 сая төгрөгийн санхүүжилтээр 8, 27-р цэцэрлэгт “Хөгжимчин багачууд төсөл”<br>-ОНХС 20.0 сая 6-р цэцэрлэгийн гадна тохижилт<br>-ОНХС 20,0 сая төгрөг 9-р цэцэрлэгийн дээвэр засварын материал<br>ОНХС-с 73.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 30 дугаар цэцэрлэгийн дээвэрт иж бүрэн засвар хийгдсэн.<br>ОНХС 14,1 сая төгрөгийн санхүүжилтээр 27-р цэцэрлэгт “Бидний цэцэрлэг миний хөгжил” төсөл,<br>19,5 сая төгрөгийн санхүүжилтээр 7-р цэцэрлэг зуны зуслангийн тохижилтод | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 21-р цэцэрлэгт “Хүүхэдтэйгээ хамт тоглоё” төсөл<br>30-р цэцэрлэгт “Эрүүл чийрэг хүүхэд төсөл”<br>-23-р цэцэрлэгийн засвар 4,4 сая<br>-Дархан сумын алслагдсан багт байрлах 3 дугаар цэцэрлэг нь том хүний суултууртай, халуун усгүй, цахилгааны асуудалтай байсныг Гүүд нэйборс ОУ-ын ТББын 70,0 сая төгрөгийн санхүүжилтээр 3 төсөл хэрэгжин засварласан.<br>2024 онд<br>-ОНХС 223.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 22-р цэцэрлэгийн дээврийн засвар<br>-ОНХС 73.8 сая төгрөг 30-р цэцэрлэгийн дээвэр засвар<br>-ОНХС 77.3 сая төгрөгийн санхүүжилтээр 5-р цэцэрлэгийн биеийн тамирын заалны засвар<br>**Үр дүн: 2021-2024 онд нийт 25 цэцэрлэгийн орчин нөхцөлийг сайжруулах төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.** | |
| 57 | 1.3.3.1. “Гоё сургууль” төсөл | 2022-2023 | НБХ | 400.0 | | Гэр хорооллын болон сумдын сургуулийн орчин нөхцөлийг сайжруулна. | 200.0 | 700.0 | Гоё сургууль төсөл, Боловсрол-2032 хөтөлбөрийн хүрээнд:<br>**2021 онд** алслагдсан багт байрлах сургуулиудын дээвэр засварын ажил УТХО-р хийгдсэн. 1 дүгээр сургууль 57.6 сая төгрөг, 93.3 сая 15 дугаар сургуульд хийгдсэн<br>**2022 онд** ЕБС-иудын анги танхим, багш нарын өрөөний тохижилт, тоног төхөөрөмж УТХО 640,0 сая, 17 сургуулийн 19 танхимыг УТХО 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр сургалтын тоног төхөөрөмж, Дархан сумын 1 дүгээр сургууль ОНТ 235 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар,<br>**2023 онд** 12-р сургуулийн Японы Өвсний үндэс, АХБ 800.0 сая, Дархан сумын ОНХС-ийн 27.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гадна пасад, орны тохижилт, засвар шинэчлэлийн ажлууд хийгдсэн. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ОНТ-ийн 377,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар:<br>- 1-р сургуулийн спорт заал 200.0 сая ОНТ<br>- Шарын гол сумын 6-р сургуулийн спорт зал 102.1сая /ШГ сумын ОНХС/, ОНХС 1,0 сая “Аялгуут хонх төсөл”<br>- 4 сургуулийн урлаг заалны тохижилт Лед дэлгэц 70,0 сая<br>Ерөнхий боловсролын нийт 9 сургууль /1,4,12,15,18, Хонгор сумын 11,14, Орхон сумын ЕБС/-ийн сурагчийн ширээ, сандлыг Улсын болон ОНТ-ийн 639.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинэчиллээ.<br>15 дугаар сургуулийн спорт заалны засварын ажилд 84.7 сая төгрөг, ОИЦ сургуулийн дотуур байрны засварын ажилд шаардагдах материал худалдан авах ажилд 140.0 сая төгрөг зарцуулсан.<br>ОНТ-ийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ОИЦ, Од цогцолбор, 16-р сургуулийн ариун цэврийн өрөө, шүршүүрийн өрөөний засвар, гадаадын төслөөр 15-р сургуулийн 00 засварласан. ОНТХО-р Од сургуулийн А байрны спорт заалны иж бүрэн засварыг 228.1 сая төгрөгөөр засварласан.<br>**2024 онд**<br>1 дүгээр сургуулийн урлаг заалны их засварыг ОНТХО 250.0 сая төгрөгийн санхүүжилтээр иж бүрэн засварласан.<br>Шарын гол сумын 2-р сургуулийн урлаг заалны их засвар ОНТХО 20.0 сая,<br>ОНТХО 503.8 сая төгрөгийн санхүүжилтээр Оюуны ирээдүй сургуулийн Б байрны гадна талбайн тохижилтыг төгрөгийн санхүүжилтээр иж бүрэн тохижуулсан.<br>9 дүгээр сургуулийн спорт заал засвар ОНТХО 550 сая<br>Хонгор сумын 11,14 дүгээр сургуулийн дээвэр, хаалга цонх, ангийн самбар засварын ажилд ОНТХО 200.0<br>1, 9 дүгээр сургуулийн урлаг заалны тоног төхөөрөмж УТХО 1,0 тэрбум | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Сургуулийн гаднах автозогсоол ОИ, Од Б байрны автозамын шинэчлэлт ОНТХО 1.3 тэрбум<br>**Үр дүн:** 2021-2024 онд Орон нутгийн төсвийн 3.0 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалтаар ЕБС-д 13 төсөл хэрэгжиж хүүхдийн сурах таатай орчныг бүрдүүлэн ажиллаж байна. | |
| 58 | 1.3.3.2. Ерөнхий боловсролын сургуулиудад үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | НБХ | 65.0 | Тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. | Төрийн өмчийн бүх сургуульд хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлнэ | - | - | Төрийн өмчийн 15, төрийн бус өмчийн 7 нийт 22 сургуулийн 1-5 дугаар ангийн 12163 сурагч үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна. Үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлж байгаа 22 сургуулийн 17 сургууль түрээсээр, 5 сургуульд хоол үйлдвэрлэл үйлчилгээг хэрэгжүүлж байна.<br>Үдийн хоол хөтөлбөрийг Од цогцолбор сургуульд стандартад нийцсэн гал тогоог жишиг байдлаар хэрэгжүүлэхээр 2020 онд гал тогооны тоног төхөөрөмжид 65,0 сая төгрөг, 2021 онд гал тогооны сантехник болон цахилгааны засварт 4,1 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн.<br>2022 онд Дархан сумын 9 дүгээр сургууль 40,0 сая төгрөг, Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулийн Б байр 50,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж татан авсан .<br>Орхон сумын 8-р сургууль хоол үйлдвэрлэх үйл ажиллагаа түрээсээр зохион байгуулах боломжгүй болсны улмаас Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн авч, хоол үйлдвэрлэлтэй холбоотой гал тогооны ажилчдын цалингийн асуудлыг шийдвэрлэсэн.<br>Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг өөрсдөө явуулах сургуулийн тоног төхөөрөмжийг БЕГ-аас үе шаттайгаар хангаж байна.<br>2024 онд Beyond Nutrition төслийн хүрээнд 2 цэцэрлэг 1 сургуульд 67,0 сая төг тоног төхөөрөмж, тогооч бэлтгэх сургалтаа хийлээ. Мөн 24 цэцэрлэгт аяга, таваг ариутгагч төхөөрөмжтэй болсон.<br>Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлийн 2023 оны 42 | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/165 дугаар захирамжаар сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн түүхий эд бүтээгдэхүүн чанар аюулгүй байдал, хүнсний хангамжийн асуудал хариуцах чиг үүрэг бүхий “Эрүүл хүнс-Тэнцвэртэй хооллолт” төслийн нэгжийг Боловсрол, шинжлэх ухааны газрын дэргэд байгуулсан.<br>Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийг Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 2 өдрийн А/166, А/559/222 дугаар хамтарсан тушаалын хэрэгжилтийг ханган нормын дагуу: ерөнхий гэрээ зарлуулах саналыг холбогдох газарт хүргүүлсэн. | |
| 59 | 1.3.3.3. Цахим сургалтын орчныг бүрдүүлж, онлайн хичээл бэлтгэх | 2021-2024 | НБХ | 40.0 | 27 ЕБС, 39 СӨББ интернэтэд холбогдсон. Цахим хичээл бэлтгэх орчин, техник хэрэгслийн хүрэлцээ хангамж хангалтгүй түвшинд байгаа | Цахим удирдлагын системийг хөгжүүлж, цахим сургалт явуулах материаллаг орчныг сайжруулан багш нарыг чадавхжуулна. | 10.0 | 40,0 | **2021 онд** цахим сургалт явуулах материаллаг орчныг 90.4 сая төгрөгөөр 4 байгуулагад бүрдүүлсэн, 14 сургуулийн интернетийн хурд нэмэгдсэн. ЕБС, СӨБ-ын 1615 багшийг чадавхижуулах 2 удаагийн сургалтад хамрагдсан.<br>**2022 онд** УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлангийн дэмжлэг, Good Neighbors Mongolia ОУТББ-ын хөрөнгө оруулалтаар “Од” цогцолбор сургууль хосолсон сургалтын арга зүйг нэвтрүүлэх зорилгоор “Цахим студи” байгуулж, 22 дугаар цэцэрлэг цахим сургалтын удирдлагын “Их нүүдэл” систем, Дархан-Өргөө политехник коллеж “Moodle” цахим сургалт удирлагын системүүдийг ашиглан хөгжүүлж, цахим сургалт явуулах орчныг сайжруулсан. 1 студи байгуулж, 3 сургууль, 1 цэцэрлэгт цахим удирдлагын систем нэвтрүүлсэн. 1156 багшийг чадавхжуулсан.<br>**2023 онд** 26 ЕБС, 39 СӨББ интернетэд холбогдсон. Дархан-Уул аймгийн хэмжээнд Боловсролын нэгдсэн сүлжээний 20 төхөөрөмж байршсан. Хонгор сумын Салхит багийн 11 дүгээр сургуулийн хичээлийн байр болон Багш | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөгжлийн төвд шилэн кабель татаж ашиглалтад оруулсан. **2024 онд** Шинээр ашиглалтад орсон 31-р сургуулийн шилэн кабелийн холболтыг хийн БНС-нд холбов. **Үр дүн:** Дархан-Уул аймгийн төрийн өмчийн сургуулиуд болон БШУГазар “Боловсролын нэгдсэн сүлжээ”-нд холбогдож төлбөргүй интернет ашигласанаар сурагчид цахим хичээлүүд /математик-эдүтэн, англи хэл-пийрсон/ болон, мэдлэ цахим сургуульд суралцах боломжоор бүрэн хангагдсан бол багш нар Оффис 365, google chrome үнэ төлбөргүй ашиглах эрхтэй болсноор цахим сургалт явуулах, бие даан чадавхижих боломжууд бүрдсэн. | |
| 60 | 1.3.3.3. Цахим даалгаврын санг баяжуулан сургалтын цахим хэрэглэгдэхүүний ашиглалтыг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | НБХ | 14.0 | Цахим даалгаврын сан дахь даалгаврын тоо 11300 байгаа. | Цахим даалгаврын сангийн даалгавар 30000, хэрэглэгдэхүүний 60% нь цахим болно. | | - | Цахим даалгаврын сан бүхий www.edu-test.mn цахим хуудсыг 2019 онд ашиглалтад оруулж,<br>2021 онд Цахим даалгаврын санд 21000, 2022 онд 11678, 2023 онд 24048 даалгавар оруулж эхэлсэн бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилээс Боловсролын Ерөнхий газрын medle.mn шинээр нээгдсэн сайтад аймгуудаас сонгогдсон багш нар цахим даалгавар байршуулж байна. Дархан-Уул аймгаас ээлжит хичээлийн цахим контентын санд Бага анги: 1 дүгээр ангийн монгол хэлний 12 нэгжийн 97, математикийн хичээлийн 6 нэгжийн 32 цаг Дунд болон ахлах: - Монгол хэл 2 нэгж-16, Уран зохиол 1 нэгж 8 цаг нийт 9 багш 24 цагийн хичээлийг байршуулаад байна.<br>Сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулж, УТХО 1,7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр төрийн өмчийн 17 сургуулийн 19 танхим цахим болсон. ЕБС-ийн багш нарыг компьютержуулах хөтөлбөр амжилттай хэрэгжиж, төрийн өмчийн 14 сургуулийн 801 багш компьютер хангагдсан.<br>Үр дүн: Цахим сан дахь даалгавар байршуулсан тоо 24048, сургалтын хэрэглэгдэхүүний 45% нь цахим болсон. | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 61 | 1.3.3.4. “Чадварлаг багш” төсөл хэрэгжүүлнэ. | 2021-2024 | НБХ | 40.0 | Чадварлаг баг байгуулагдсан. | Төслийн үр дүн 90%-д хүрсэн байна. | 10,0 | ОНТ 49.1 | “Чадварлаг багш” төсөл 3 үе шаттай хэрэгжиж байна. Тайлант хугацаанд<br>**2021 онд** аймгийн Засаг даргын захирамжаар “Чадварлаг багш” төслийг боловсруулан батлуулсан.<br>**2022 онд** 1500 гаруй багшийг 3 төрлийн сургалтад хамруулж, төслийн хэрэгжилт 50%-тай байна.<br>**2023 онд** Залуу багш нарт зөвлөн туслах ажлын хүрээнд МХБ-ийн Зөвлөх, Ментор багш нарын оролцоог нэмэгдүүлж 1674 багшид арга зүй, мэдлэг чадвар олгох 32 удаагийн сургалт зохион байгуулсан. “Багшийн хөгжлийн явцыг үнэлэх зөвлөл”-ийг МУ-ын зөвлөх зэрэгтэй 53 багшийн бүрэлдэхүүнтэй байгуулсан.<br>ЭЕШ-д бэлтгэсэн сурагч нь амжилт гаргасан багш нарыг урамшуулж 2021 онд 5 багшид 2,5, 2022 онд 10 багшид 10,0, 2023 онд 23 багшид 20,0 нийт 32,5 сая төгрөгийг 38 багшид урамшуулал, ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдыг ЭЕШ-д бэлтгэх давтлагыг 2021 оноос 3 удаа зохион байгуулж, хичээл заасан багшид 6,6 сая төгрөгийн урамшуулал тус тус олголоо.<br>Англи хэлний багш нарыг чадвахжуулах, IELTS шалгалтад бэлтгэхэд 20 багшийг сонгон шалгаруулж, 3 сарын сургалт зохион байгуулан, сургалтын төлбөрийн 70% буюу нийт 10,0 сая төгрөгийн дэмжлэгийг ОНТ-с үзүүлсэн.<br>2024 онд Байгалийн шинжлэх ухааны хичээлийг заах арга зүйг дээшлүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын боловсролын Их сургуулийн “Гарааны инновацид суурилсан сургалтын хэрэгсэл” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу Япон-Монголын эрдэмтдийн хамтарсан бүтээл, Монгол Улсын Оюуны өмчийн газрын зохиогчийн эрхийн гэрчилгээгээр баталгаажсан физикийн туршилтат хичээлийн иж бүрдэл хэрэглэгдэхүүнийг ерөнхий боловсролын 19 сургуульд 78 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | багц физикийн туршилтат хичээлийн хэрэглэгдэхүүнийг ОНТ 117,0 сая төгрөгийн санхүүжилтээр олгосон.<br>“Полиглот боловсролын төв”-тэй хамтран хэл согог засалч бэлтгэх сургалтад ЕБС, СӨББ-ын 23 багш хамрагдсан.<br>Англи хэлний багш нарыг чадавхжуулахад “Чадварлаг залуус ирээдүй ТББ-тай хамтран “Beyond program” төслийг хэрэгжүүлэхэд 20.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>**Үр дүн:** 2021-2024 оны арга хэмжээний хэрэгжилт 100%-тай байна. | |
| 62 | 1.3.3.4. Сурлага, урлаг, спортоор амжилт гаргасан багшийг урамшуулан дэмжинэ. | 2021-2024 | НБХ | 60.0 | ЭЕШ-д 800 оноо авсан 5 сурагч, бэлтгэсэн 5 багшийг урамшуулсан. | - | 15.0 | ОНТ 2.0 сая | Элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан багш сурагчдыг урамшуулсан. Үүнд:<br>2021 онд 20 сурагч, 5 багш 23,5 сая<br>2022 онд 30 сурагч, 6 оюутан, 10 багш 54.5 сая<br>2023 онд 42 сурагч, 13 оюутан, 23 багш 89,0 сая 2024 онд 38 сурагч, 31 оюутан, 17 багш, 99.500 төгрөгийн урамшуулал, тэтгэлэг олгосон байна.<br>Мөн улсын олимпиадад амжилт гаргасан сурагч, 48 улирал дараалан А үнэлгээтэй суралцсан сурагчдад аймгийн Засаг дарга хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн урамшууллаа.<br>Үр дүн: ЭЕШ-д амжилт гаргасан нийт 150 суралцагч, 55 багшид 266.5 сая төгрөгийн урамшуулал, тэтгэлэг олгосон байна | 100 |
| | | | | | | | | | сумаас 10 нийт 34 иргэн хамруулан ХЭДС -аас 4,8 сая төгрөгнийг зарцуулсан.<br>**2023 онд** Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд олон улсын хөдөлмөрийн байгууллагын "In business" модуль сургалтыг залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвд Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран 15-34 насны 60 залуусыг хамруулж, ХЭДС-аас 4,8 сая төгрөг зарцуулж, бизнес, санхүү, төлөвлөлтийн мэдлэг олгосон.<br>**2024 онд** Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааны Залуучуудын сургалт зөвлөгөө арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон улсын хөдөлмөрийн байгууллагын "In business" модуль сургалтыг 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>**Үр дүн**: Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Модуль 3 удаагийн сургалтад 134 иргэнийг хамруулж ХЭДС-аас 9,6 сая төгрөг зарцуулсан байна. | |
| 87 | 1.5.5.3. "Ажлын байран дээр дадлагажуулах туршилтын төсөл"-д их, дээд сургууль, коллеж төгсөгчдийг хамруулна. | 2021-2024 | НБХ | 20 иргэн 8,0 | 16 иргэнд 7.6 сая төгрөг олгосон. | 20 иргэн | | ХЭДС 5,4 сая төгрөг | **2021 онд** "Ажлын байран дээр дадлагажуулах туршилтын хөтөлбөр"-т 20 залуучуудыг хамруулж гэрээний дагуу Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслөөс 5,4 сая төгрөгийн урамшуулал олгосон.<br>**2022 онд** Их дээд сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагыг төгссөн, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гаргаж, ажил эрхлээгүй 42 төгсөгчдийг гэрээний дагуу төсөлд хамруулсан.<br>**2023 онд** Их дээд сургууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөх ангийн 51 оюутныг хөдөлмөрт бэлтгэх, ажлын дадал туршлага эзэмшүүлэх сургалтад хамруулж, ажлын байранд дадлагажуулах, байнгын ажлын | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байраар хангах арга хэмжээг орон нутгийн томоохон үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болох “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК, УБТЗ-ын “Дархан татах хэсэг”, “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК, “Дархан хүнс” ХК-тай хамтран зохион байгуулсан **2024 онд** Засгийн газраас болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр батлан хэрэгжүүлэх хөтөлбөрийн Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын сурагцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулах дэмжлэг үзүүлэх арга хэмжээг шийдвэр гарсан тухай бүрд зохион байгуулна. **Үр дүн:** Сургалтад их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, төгсөх анги, төгсөгчдийн нийт 113 иргэнийг хамруулж 5,4 сая төгрөгийн урамшуулал олгосон. | |
| 88 | 1.5.5.3. Төслийн хүрээнд аж ахуй нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллана. | 2021-2024 | НБХ | - | - | 5 ААНБ | - | 1.2 сая төгрөг | **2021 онд** “Ажлын байран дээр дадлагажуулах туршилтын төсөл”-ийн хүрээнд ХХҮГазар, “Бурхат ган ширэм” ХХК, “Өгөөж гурил” ХХК, “Өнө өсөх” ХХК, “Топ кидс” ХХК, “КСВ” телевиз,“Хүслийн цамхаг” ХХК зэрэг төрийн болон хувийн хэвшлийн 7 байгууллагатай гэрээ байгуулж ажилласан. **2022 онд** “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-тай гэрээ байгуулан арга хэмжээг сурталчлах ажлыг Дархан сум, Шарын гол сумдад зохион байгуулж, нийт 84 ажил олгогчдыг хамруулж, 1.2 сая төгрөг зарцуулсан. **2023 онд** Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх “Залуучуудын хөгжлийн төв”, Дархан-Уул аймгийн “Уул уурхай эрчим хүчний политехник коллеж”, Дархан-Уул аймаг дахь политехник коллеж, “Дархан-Өргөө политехник коллеж” зэрэг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудтай хамтран гагнуурчин, сантехникч, оёдолчин мэргэжлээр төгссөн 16 залууг бүлэг болгон | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | "Дундын оффис"-ийн байр, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах 3 талт гэрээ байгуулан дэмжлэг үзүүлж өөрөө өөртөө ажлын байр бий болгох боломжийг бүрдүүлэн ажилласан. **2024 онд** Засгийн газраас болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр батлан хэрэгжүүлэх хөтөлбөрийн Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын сурагцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулах дэмжлэг үзүүлэх арга хэмжээг шийдвэр гарсан тухай бүрд зохион байгуулж байна. **Үр дүн:** Төслийн хүрээнд 13 ААНБ-тай гэрээ байгуулан ажилласан байна. | |
| **1.5.6. Оюуны хөдөлмөр, аялал жуулчлалыг дэмжсэн цахим худалдаа, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 89 | 1.5.6.1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | НБХ | ХЭДСан, ЖДҮДТөв | Онлайн худалдааны сайт, Дархан шоп 46,0 сая төгрөг | 125 нэр төрөл | ХЭДС 13.000. | **13.0** | **2021 онд** Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн бараа бүтээгдэхүүнээ борлуулахад дэмжлэг үзүүлж, борлуулалтын цэгийг ажиллуулах зорилгоор 2021 онд Дархан-Уул аймгийн "Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв"-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, 99 иргэний 150 нэр төрлийн 370 гаруй бараа бүтээгдэхүүнийг худалдаалж, 6,0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн. **2022 онд** Найрамдал талбайн худалдааны гудамжинд 140 иргэний бараа, бүтээгдэхүүн худалдаалж, 283.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч 59 иргэн 36.5 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн худалдаалж, ХЭДС-аас 13.0 сая төгрөг зарцуулсан. **2023 онд** Хувиараа хөдөлмөр эрхлэгч, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ борлуулахад дэмжлэг үзүүлэх, сурталчлан таниулах, борлуулалтын цэгийг ажиллуулах зорилгоор Дархан-Уул аймгийн "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв", "Дарханд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо" ГҮТББ-тай | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хамтран ажиллах гэрээ байгуулж, 82 нэр төрлийн 398 ширхэг бараа бүтээгдэхүүн сурталчлан 24.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн.<br>-“Хөдөлмөрийн яармаг-2023” арга хэмжээнд “Дарханд үйлдвэрлэв” дэлгүүр, хувиараа үйлдвэрлэл эрхэлдэг 25 иргэнийг хамруулж, 50 нэр төрлийн 136 ширхэг бараа, бүтээгдэхүүнийг худалдаж 6,8 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.<br>**2024 онд** Хувиараа хөдөлмөр эрхлэгч, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ борлуулахад дэмжлэг үзүүлэх, сурталчлан таниулах, борлуулалтын цэгийг ажиллуулах зорилгоор “Дарханд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо” ГҮТББ-тай 4,600,000 төгрөгийн хамтран ажиллах гэрээ байгуулж, 3 дугаар улиралд гэрээг дүгнэн санхүүжилт олгоно.<br>Иргэн, аж ахуй эрхлэгчдэд олгох санхүүгийн дэмжлэг, жижиг зээлд хамрагдсан 8 иргэний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулах борлуултыг дэмжих зорилгоор орон нутгийн 2 телевизтэй 11,500,000 төгрөгийн гэрээ байгуулан ажилласан.<br>**Үр дүн:** 331 иргэний 292 нэр төрлийн 1120 ширхэг бараа бүтээгдэхүүний 85,6 сая төгрөгийн борлуулалт хийсэн. | |
| 90 | 1.5.6.2. Цахим, зайн ажлын байрыг дэмжиж санхүүгийн дэмжлэг олгоно. | 2021-2024 | НБХ | ХЭДСан, ЖДҮДТөв | Онлайн худалдааны сайт, Дархан шоп 46,0 | 50 ААНБ иргэн | - | ХЭДС 16.6 сая төгрөг | **2021 онд** Жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжин 15 иргэн аж ахуйн нэгжид 7,2 сая төгрөгийн ажлын байрны дэмжлэг үзүүлж ажилласан. Дарханд үйлдвэрлэв дэлгүүрээр дамжуулан 95 аж ахуй нэгж, иргэний бараа бүтээгдэхүүнийг борлуулах ажилд дэмжлэг үзүүлсэн. Эмэгтэйчүүдэд зориулсан цахим сургалтанд 84 эмэгтэй хамрагдсан.<br>**2022 онд** “Цахим ур чадварыг хөгжүүлэх, нягтлан бодогч, бүртгэлийн туслах ажилтан мэргэжил эзэмшүүлэх цахим | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | болон танхимын хосолсон сургалтыг “Сонор эдүкэйшн” сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж, ажил хайж байгаа, ажилгүй эмэгтэйчүүд, цахимаар болон зайнаас ажиллах хүсэлтэй, гэртээ бага насны хүүхдээ асран хүмүүжүүлж буй 30 эмэгтэйг хамруулж, 10 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан.<br>Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Хүүхэд харах үйлчилгээний төв шинээр байгуулах төсөлд 10.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 3 байнгын ажлын байр бий болгосон.<br>**2023 онд** Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадвар олгох сургалт арга хэмжээнд гэрээс зайнаас болон цахимаар ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор хөдөлмөрийн харилцаа, мэргэжлийн суурь болон цахим ур чадварыг богино хугацаанд эзэмших сургалтад ажилгүй хөдөлмөрийн насны 30 эмэгтэйчүүдийг хамруулсан.<br>-Цахим хөгжил харилцаа холбооны яам, “Найрамдал” төслийн баг, “Shoppy”, “Zary.mn” цахим дэлгүүр, “PickPack” хүргэлтийн байгууллагуудтай хамтран цахим худалдаа эрхэлдэг, эрхлэх хүсэлтэй 120 иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын хөдөлмөр эрхлэлт, бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Дархан-Уул аймгийн цахим худалдааны шинэ гарцыг тодорхойлох нь” уулзалт арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.<br>**2024 онд** Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор бүтээгдэхүүнийг нь онлайнаар сурталчлах зорилгоор “Дарханд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо” ГҮТББ-тай 4,600,000 төгрөгийн хамтран ажиллах | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | гэрээ байгуулсан бөгөөд 3 дугаар улиралд гэрээг дүгнэн санхүүжилт олгоно.<br>Иргэн аж ахуй эрхлэгчдэд олгох санхүүгийн дэмжлэг, жижиг зээлд хамрагдсан 8 иргэний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан таниулж, борлуултыг дэмжих зорилгоор орон нутгийн 2 телевизтэй 11,500,000 төгрөгийн гэрээ байгуулан ажилласан.<br>Санхүүгийн дэмжлэгийг онлайнаар олгох “Финтек” богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 14 иргэнтэй гэрээ хийж 6,800,000 төгрөгийн зээл олгосон.<br>**Үр дүн:** Хүний тоо 172, ХЭДС-аас 39.500.00 төгрөг зарцуулсан. | |
| **1.5.7. Хүүхэд, залуучууд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төрөлжсөн төвүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.** | | | | | | | | | | |
| 91 | 1.5.7.1. Хүүхэд хөгжлийн ордны дугуйлангийн багш нарын хөтөлбөр, арга зүйд хяналт тавих, сургалтын орчинг сайжруулна. | 2021-2024 | НБХ | 4.0 | 14 багш, 14 төрлийн дугуйлан | Дугуйлангийн төрлийг нэмэгдүүлнэ. | 1.0 | Төсөл 2.9 сая төгрөг | Хүүхэд хөгжлийн ордонд 2021-2023 онд 16 төрлийн дугуйлангийн 20 багштай гэрээ байгуулж, Хүүхэд хамгааллын жилийн хүрээнд 2022 онд 100%, 2023 онд эхний 3 сар түрээсийг чөлөөлсөн.<br>2021 онд Хонгор сумын салхит багт 4 төрлийн дугуйлангийн салбарыг нээн ажиллуулж 72 хүүхэд хамруулж, ордны багш нарыг чадавхжуулах зорилгоор УБ хотод Монголын хүүхдийн ордон, Урлан бүтээх төв, Хөгжим бүжгийн коллеж зэрэг газарт сайн туршлага судлууллаа.<br>2022 онд ардын дууны ангид даралтад хөгжим, явуулын спикер, микрофон, 2023 онд LED дэлгэц, хөгжим, аппаратур шинээр суурилуулан дотор тохижилтын ажил, бүжгийн өрөөний хөшиг шинээр хийж, гадна орчныг сайжруулах зорилгоор сүүдрэвч, пасад, сандал будах гэх мэт ажлуудыг аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан болон өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан нийт 37,4 сая төгрөгийн засвар тохижилтын ажлыг хийж, сургалтын орчин нөхцөлийг сайжруулсан.<br>2023 оны 3-р сард Хүүхэд хөгжлийн ордны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | шалгалтаар илэрсэн 5 зөрчлийг арилгасан.<br>Төсөв: Дархан-Уул аймгийн орон нутгийн хөгжлийн сан 25,8 сая төгрөг<br>Дархан сумын орон нутгийн хөгжлийн сан 9,6 сая төгрөг<br>Өөрийн орлого: 2,0 сая төгрөг, нийт 37,4 сая төгрөг<br>2024 оны хагас жилийн байдлаар 17 багштай хамтран ажиллах болон түрээсийн гэрээ байгуулан, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, 3 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, арга зүйгээр ханган ажилласан.<br>**Үр дүн. Хяналт шалгалт зохион байгуулж гарсан зөрчлийг арилгасан. Сургалтын хэрэглэгдэхүүн нэмэгдүүлж, гадна дотор засал, урлагийн зааланд шинэ тоног төхөөрөмж суурилуулж хүүхдийн хөгжих эрхийг ханган ажилласан.** | |
| 92 | 1.5.7.2. Залуучуудын хөгжлийн төвд Америкийн соёл мэдээллийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна. | 2021-2024 | НБХ | 12.0 | Нийт залуучуудын 45 хувьд үйлчилгээ үзүүлсэн. | Нийт залуучуудын 46.30 хувьд хүрч, үйлчилсэн байна. | - | ОНТ 8.0 сая | Америкийн соёл мэдээллийн төв 2021 онд байгуулж, 2 хөтөлбөрт 65 хүнийг хамруулж, үлдэгдэл засвар тавилга тохижилтын ажилд 38.544.000 төгрөг зарцуулсан.<br>2022 онд англи хэлний анхан, дунд шатны сургалт, ярианы клубүүд ажиллуулж зөвлөгөө мэдээлэл, визний мэдээллийг тогтмол нээлттэйгээр хүргэн нийт 11 хөтөлбөр, 2 төсөл, 364 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 5282 өсвөр залуучуудад хүрч ажилласан.<br>2023 онд хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан 16 төрлийн 90 удаагийн хөтөлбөрийг зохион байгуулсан.<br>Англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих зорилготойгоор “Call for you” хөтөлбөрт 120 өсвөр үеийн залуучууд бүртгүүлснээс 3-н шатны шалгаруулалтаас 25 хүнийг сонгох англи хэлний мэдлэг болон хувь хүний хөгжлийг дээшлүүлэв. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Дархан-Уул аймгийн Засаг даргын ивээл дор Junior Empower Program хөтөлбөрт нийт 90 сурагч бүртгүүлж, сонгон шалгаруулалтаар 15 сурагч сонгогдож хувь хүний хөгжил, гадаад суралцах талаарх мэдлэг болон сайн дурын ажил хийх талаар мэдлэгээ нэмэгдүүлэв.<br>SIP-2 хөтөлбөрийг хэрэгжүүлж 8 дадлагажигч, 5 төгсөгч нийт 15 өсвөр үеийн залуучууд 6 сарын хугацаатай ажиллуулж байна.<br>**Үр дүн**: Соёл мэдээллийн төвийн үйл ажиллагаа тогтмолжиж, нийт залуучуудын 13976 залуу буюу нийт залуучуудын 46,3 хувьд хүрч үйлчилсэн. Сургалтын орчин нөхцөлийг сайжруулахад 82.377.350 төгрөг, системийн тусгаарлах өрөөг 3.710.300 төгрөгийг АНУ-ын элчин сайдын яамнаас нийт 228.028.843 төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. | |
| 93 | 1.5.7.3. Ахмадын хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна. | 2021-2024 | НБХ | 600,6 | Ахмадын хөгжлийн төв төсөвт байгууллагыг байгуулсан байна. | Ахмадын төвийн үйл ажиллагаа тогтмолжсон байна. | | 116.9 сая төрөг | Ахмадын Хөгжлийн төв нь 2024 онд давхардсан тоогоор 6586 ахмад настанд 48442 төрлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнээс:<br>○ 5 өдрийн багц үйлчилгээнд 4483 хүн 48442 төрлийн үйлчилгээнд,<br>○ 1 өдрийн багц үйлчилгээнд 147 хүн 13871 төрлийн үйлчилгээнд<br>○ Бусад үйлчилгээнд 1956 хүн хамрагдсан.<br>2024 оны байдлаар эрүүл мэндийн сэргээн засах тусламж үйлчилгээ 34571 ахмад настан хамрагдаад байна Үүнээс:<br>○ Бариа засалд – 9639 хүн<br>○ Физик эмчилгээнд – 11499 хүн<br>○ Хөдөлгөөн засалд – 10363 хүн<br>○ Хөдөлмөр засалд – 274 хүн<br>○ Алжаал тайлах үйлчилгээ, гоо сайханд – 932 хүн<br>○ НЭМ-ийн сургалтад – 932 хүн<br>• Тэгш хамруулах боловсролын СЗТҮ-нд давхардсан тоогоор 13871 нэр төрлийн үйлчилгээг үзүүлсэн<br>○ Урлал засалд - 3718 хүн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ○ Урлаг засалд - 3364 хүн<br>○ Тоглоом засалд – 1864 хүн<br>○ Усан засалд - 3669 хүн<br>○ Хувь хүний хөгжлийн сургалтад – 922 хүн<br>○ Соёл, спортын арга хэмжээнд – 246 хүн<br>• Нийгмийн хөгжлийн сэргээн засах тусламж үйлчилгээнд давхардсан тоогоор 6586 нэр төрлийн үйлчилгээг үзүүлсэн<br>○ Лавлагаа мэдээллийн үйлчилгээ – 340 хүн<br>○ Номын сангийн үйлчилгээнд 3202 хүн<br>○ Сэтгэл зүйн зөвлөгөөнд 304 хүн<br>▪ Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сургалт- 922 хүн<br>▪ Стрессийг бууруулах үйл ажиллагаа- 34 хүн<br>○ Чадавхжуулах сургалтад – 1370 хүн<br>▪ Монгол бичиг - 424 хүн<br>▪ Иог – 733 хүн<br>▪ Нэхмэл – 129 хүн<br>▪ Компьютер – 28 хүн<br>▪ Англи хэл – 56 хүн<br>**Бусад үйл ажиллагаа: /2021-2024 онд/**<br>○ Аймгийн Засаг дарга Б.Азжаргалын санаачилсан "Иргэний индэр-Ахмадаа сонсъё" уулзалт, өдөрлөгийн үеэр нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, нийт 850 гаруй иргэнд байгууллагаа сурталчлан таниулж, 300 гаруй ахмад настанд тусламж үйлчилгээ үзүүлэн ажилласан.<br>○ Иргэдээс гарсан санал, жилийн ажлын төлөвлөгөөнд туссаны дагуу байнгын асаргаатай ахмад настанд гэрээр үйлчлэх ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ-г эхлүүлсэн. 2023 оны 06 дугаар | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | сараас 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 940 ахмад настанд хүрч үйлчлээд байна.<br>УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлангийн санаачилж, дэмжсэн “Эрүүл, идэвхтэй, оролцоотой амьдрал” хөтөлбөрийг 2022 оноос эхлэн жил бүр уламжлал болгон /3 жил дараалан/ зохион байгуулж байна.<br>Уг хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Хүний хөгжлийг дэмжих зорилтуудыг хэрэгжүүлэх, ахмад настны дунд эрүүл, идэвхтэй, оролцоотой амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, тэдний амьдралын чанарыг дээшлүүлэх боломж, нийгмийн хэвшмэл ойлголт, үнэлэмж, тулгамдаж буй сорилт бэрхшээл, гарц шийдлийг хамдаа тодорхойлох зорилготой.<br>“Эрүүл, идэвхтэй, оролцоотой амьдрал” хөтөлбөрийн хүрээнд дараахь 5 багц ажлыг нээлт, хаалтын хамт төлөвлөн хэрэгжүүлэв.<br>Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, "Ахмадын хөгжлийн төв" хамтран "Ахмад настны эрхийг дээдэлье" төслийг 2 жилийн хугацаанд хэрэгжүүлээд амжилттай өндөрлөлөө. Төсөл хэрэгжих хугацаанд тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудад ажиллаж байсан туршлагатай ахмадуудын Зөвлөх багийг байгуулж, 26 баг бүрт сургагч багшийг бэлтгэн, төвөөр үйлчлүүлсэн 5795 ахмад настанд 300 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан ба оны төгсгөлд сүүлийн шат болох 4 сумын 26 багт хүрч ажиллах зорилтоо биелүүлж нийтдээ 1500 орчим ахмад настныг нээлттэй өдөрлөгтөө урин оролцуулсан. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | **Төсөл хөтөлбөр:**<br>Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Азийн Хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээг шинэлэг хэлбэрээр үзүүлэх нь” төсөл нь 2021-2024 оны 12 сар хүртэл үргэлжилнэ. Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>○ Эмнэл зүйн протокол боловсруулах – 13 удаа<br>○ Эрх зүйн бичиг баримт, стандарт боловсруулах, санал өгөх – 5 удаа<br>○ Бусад сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөө, уулзалт<br>○ Танхимаар – 8 удаа<br>○ Цахимаар - 19 удаа<br>○ Техник туслалцаа /50 сая төгрөг/-ний 21 төрлийн тоног төхөөрөмж<br>○ Гериатр сувилагч бэлтгэх – 2 хүн сурч төгссөн<br>**Хамтын ажиллагааны чиглэлээр**<br><br>Тус төвд дутагдалтай байгаа Хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалчийг бэлтгэх, хөгжингүй улс орнуудын мэргэжилтнүүдээс суралцах зорилгоор Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайка /JIKA/-д хандаж мэргэжилтэн урьсан. 2 жилийн хугацаатайгаар Сайн дурын ажилтнаар хөдөлгөөн засалч, асаргааны ажилтан Такахаши Хитоми 2024 оны 6-р сарын 15-ны өдөр ирээд ажиллаж байна. Тэрээр анагаах ухааны бакалаврын зэрэгтэй, спортын эмчилгээнд суралцсан, ахмад настныг асран сувилах тусгай эрх бүхий ажилтан юм.. Энэхүү хамтын ажиллагаа нь мэргэжилтнүүд хоорондоо харилцан туршлага солилцох, байгууллага хоорондын хамтын ажиллагааны эхлэл болж байгаагаараа онцлогтой.<br>Цаашид Ахмадын хөгжлийн төв ОНӨУТҮГ нь хөгжингүй улс орнуудын | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | жишгээр ахмад настанд үзүүлэх төрийн үйлчилгээг шинэ түвшинд гаргаж, ахмад настанд цогц үйлчилгээ үзүүлэх “Идэвхтэй насжилтыг дэмжих төв” болон хөгжих зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.<br>**Үр дүн:**<br>2021-2024 онд төвдөө суурилсан үйлчилгээнд давхардсан тоогоор 36106 ахмад настанд 184729 нэр төрлийн үйлчилгээг үзүүлсэн.<br>Гэрийн асаргаа, тусламжийн үйлчилгээг 2023 онд 4 сум 26 багийн 741 ахмад настан, 2024 онд дуудлагаар 51, төлөвлөгөөт 182 ахмад настан буюу нийт 974 ахмад настанд хүрч үйлчилсэн. | |
| 94 | 1.5.7.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчинг бүрдүүлнэ. | 2021-2024 | НБХ | - | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын зураг хийгдсэн. | Барилга ашиглалтад орсон байна. | Улсын төсөв | Улсын төсөв | Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, нийгмийн оролцоог бэхжүүлэх чиглэлээр “Азийн хөгжлийн банкны 4,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийн барилгын ажлыг 2021 онд эхлүүлэн, 2023 оны 09 дугаар сард бүрэн ашиглалтад орж, улсын комисс хүлээн авсан. Хөгжлийн төв нь 31 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр батлагдаж, 14 боловсон хүчнийг төслийн нэгж болох ХНХЯ-аас төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хэл засалч, нийгмийн ажилтан, хөдөлгөөн засалч, технологич чиглэлээр мэргэшүүлэн сургасан.<br>Тайлант хугацаанд 163 нэр төрлийн 1,129,429,700 төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авсан<br>**Үр дүн:** Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээний чанар сайжирч, ээлтэй орчин, хүртээмжтэй орчин бий болж, нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжоор хангагдсан. | 100% |
| **1.5.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 95 | 1.5.8.1. Төрийн болон төрийн бус байгууллагууд ын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц гарцыг сайжруулж, нэмэгдүүлнэ. | 2021-2024 | НБХ | - | - | 10 ААНБ | - | - | **2021 онд** 93 төрийн болон төсөвт, аж ахуй нэгж байгууллагад албан бичиг хүргүүлж судалгаа авч ажилласан.<br>Шинэ алхам сургууль, цэцэрлэг, Болор талст ХХК, Хишиг хүнсний дэлгүүр, Арцат Алтайн уулс ХХК, Цайхун сургууль, Цанид эмнэлэг орц гарцыг шинээр хийж, АЗДТГ, Дархан сумын ЗДТГ ОУ-ын худалдааны төв хөгжлийн бэрхшээлтэй хүний авто машины зогсоолыг стандартад нийцүүлэн хийсэн. Дархан сумын орон нутгийн төсвөөс 3,0 сая төгрөг зарцуулсан.<br>**2022 онд** 95 ААНБ-т албан бичиг хүргүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд ХБИргэдэд зориулсан Ариун цэвэр, эрүүл ахуйн зориулалтын өрөөтэй 27, гадна дотор орчинд хБИ-ны зориулалтын зам талбайтай 104 албан байгууллага байна.<br>**2023 онд** Тайлант хугацаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8.9.10 дугээр зүйлийн хэрэгжилтийг хангах талаар Боловсрол шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГазар, ГХБХБГазар, АМУмолл худалдааны төв, Дархан зам тээвэр ОНӨААТҮГазар нийт 10 байгууллагад дэд бүтэц хүртээмжийг сайжруулах талаар хяналт хийж, зөвлөмж хүргүүлсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 5 тэмдэг тэмдэглэгээ, сургуулийн орчмын эрсдэл өндөртэй Од цогцолбор, 15 дугаар сургуулийн ойролцоох явган хүний гарцын тэмдэг тэмдэглэгээ, 17 дугаар хорооллын зам тээврийн эрсдэлтэй явган гарцад Гэрэл дуут дохиотой “Ухаалаг гарц”-ийг Дэлхийн зөнгийн санхүүжилтээр Лед Сити ХХК-тай хамтран хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих хүртээмжтэй ээлтэй орчныг бүрдүүлсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчих орц гарц, ариун цэврийн өрөө болон хүртээмжийг сайжруулах зорилгоор | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нийтийн зориулалттай шинээр ашиглалтад орсон 8, үйл ажиллагаа явуулж байгаа өргөтгөл хийгдсэн 4, нийт 12 байгууллагад хяналт шалгалт хийж зөвлөмж хүргүүлж ажилласан.<br>**2024 онд** Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8,9,10 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран 3 байгууллагын дэд бүтцийн хүртээмжид хяналт хийж, 3 заалт бүхий зөвлөмж өгсөн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэн зорчих орц гарц, ариун цэврийн өрөө болон хүртээмжийг сайжруулах зорилгоор нийтийн зориулалттай шинээр ашиглалтад орсон 2, үйл ажиллагаа явуулж байгаа өргөтгөл хийгдсэн 3, нийт 5 байгууллагад хяналт шалгалт хийж зөвлөмж хүргүүлж ажилласан.<br>**Үр дүн:** 2021-2024 онд давхардсан тоогоор 281 байгууллагад хяналт шалгалт хийж, зөвлөмж хүргүүлж, 5 тэмдэг тэмдэглэгээ, 31 аж ахуй нэгж байгууллага шинээр стандартын дагуу орц гарц, дэд бүтэц хүртээмжийг бий болгож,. хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих ээлтэй орчин бүрдсэн. | |
| 96 | 1.5.8.2. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | НБХ | 800 ХБИ, ахмадууд 500,0 | 200 ХБИ, Ахмад 124.0 | 50 ахмад | ХЭД С 128.2 | ХЭДС 163.8 | **2021 онд** “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 34 иргэний ирүүлсэн төслөөс 13 төслийг дэмжиж 27,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 19 байнгын ажлын байр бий болсон. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах арга хэмжээнд 53 ахмадын ирүүлсэн төслөөс 51 ахмад хамрагдаж 14.280.0 төгрөгийн урамшууллыг олгосон. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ОНОТХҮ-ны бүлгийн төсөлд 2021 онд 7 ахмад настны 6,2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.<br>**2022 онд** Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 116 иргэний төслийг хүлээн авч, хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдал, ур чадварын үнэлгээ буюу профайлингийн үйлчилгээнд хамруулсан. Сонгон шалгаруулалтыг нээлттэйгээр зохион байгуулж, ахмадын зөвлөх үйлчилгээнд 55 ахмад, санхүүгийн дэмжлэгт 28 ахмад, хүүхэд хамгаалагч төсөлд 2 ахмадыг хамруулж, нийт 163,8 сая төгрөг зарцуулсан.<br>**2023 онд** Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа”-ны хүрээнд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 25 төслийн 41 ахмадад 14.7 сая төгрөгийн урамшуулал олгосон.<br>-Хүүхэд хамгаалагч үйлчилгээнд хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, хамгаалах зорилгоор 1 ахмад мэргэжилтэн хамрагдаж, холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулж, төлөвлөгөөний дагуу хяналт тавин ажиллаж 1 хүүхэд хамгаалагчид 1.1 сая төгрөгийн урамшуулал олгосон.<br>-Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 98 ахмадын ирүүлсэн төслөөс 31 төслийг шалгаруулан 120.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 46 иргэний байнгын ажлын байр бий болсон.<br>**2024 онд** Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан “Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа”-ны хүрээнд:<br>-Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 32 ахмадтай гэрээ байгуулж 23,0 сая төгрөгийн урамшуулал олгосон. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Хүүхэд хамгаалагч үйлчилгээнд 1 ахмадыг хамруулж, 792,000 төгрөгийн урамшуулал олгосон.<br>Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 94 ахмадын ирүүлсэн төслөөс 55 төслийг шалгаруулан 400,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 81 байнгын ажлын байр бий болсон.<br>**Үр дүн:** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 264 ахмадын төсөлд 770.8 сая төгрөг зарцуулж,260 байнгын ажлын байр бий болсон. | |
| 97 | 1.5.8.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | НБХ | | | 200 ХБИ, ахмад | 125.0 | 146.1 | **2021 онд** 50 хувь эргэн төлөх нөхцөлтэй Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 66 иргэний ирүүлсэн төслөөс 23 төслийг дэмжиж 60,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 25 байнгын ажлын байр бий болсон.<br>-Хөгжлийн бэрхшээлтэй 13 иргэн байнгын ажлын байраар хангагдсан байна.<br>-Халамжаас Хөдөлмөрт аймгийн дэд хөтөлбөрийн танилцуулга, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх ганцаарчилсан болон бүлгийн сургалтад 41 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан.<br>**2022 онд** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд аж ахуй эрхлэлтийн сургалтад 83 иргэнийг хамруулж, 2,1 сая төгрөгийг зарцуулсан.<br>Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 28 төслийг шалгаруулан 144,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, 44 иргэний байнгын ажлын байр бий болсон.<br>**2023 онд** Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-ний хүрээнд: Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 98 иргэний ирүүлсэн төслөөс 27 төслийг шалгаруулан 176.0 сая төгрөгийн | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | санхүүгийн дэмжлэг олгож 42 иргэний байнгын ажлын байр бий болсон.<br>-Нэмэлт санхүүжилтээр ирсэн 176.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний Ерөнхий газрын даргын 2023 оны А/224 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй болон, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд олгохоор сонгон шалгаруулалтыг зарлан, мэдээлэл хүргэж цахим бүртгэлд хамруулан ажиллаж байна.<br>**2024 онд** Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-ны хүрээнд: Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 92 иргэний ирүүлсэн төслөөс 31 төслийг шалгаруулан 248.000.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 46 иргэний байнгын ажлын байр бий болсон<br>**Үр дүн:** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэмжих үйл ажиллагаанд 192 иргэнийг хамруулан 181 байнгын ажлын байр бий болж, ХЭДС-аас 630.1 сая төгрөг зарцуулсан | |
| **1.5.9. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 98 | 1.5.9.1. Хүүхэд хөгжлийн ордны дугуйлан, секцийн төрлийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | НБХ | 4.0 | 14 төрлийн дугуйланд 400 хүүхэд | Хүүхэд хамрагдалтыг 5% нэмэгдүүлнэ. | | | Хүүхэд хөгжлийн ордны дугуйланд 2021 онд 19 төрлийн дугуйланд 944 хүүхэд, 2022 онд 3365 хүүхэд, 2023 онд 3596 хүүхэд, 2024 онд 1648 суралцсанаас зорилтот бүлгийн 2021 онд 12, 2022 онд 56, 2023 онд 58 хүүхэд, 2024 онд 10 хүүхдийг үнэ төлбөргүй хамруулсан.<br>2021 онд Хөл хорионы дэглэмийн хугацаанд хөгжлийн үйлчилгээг тасралтгүй хүргэх зорилгоор Хүүхэд хөгжлийн ордны 3 багш, 2 төрлийн (дуу, төгөлдөр хуур) алсын зайн сургалтын ном хэвлүүлж нийт 35 хүүхдийг алсын зайнаас суралцах нөхцөлөөр хангаж, 2022 онд 18 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 4500, 2023 онд 14 төрлийн арга хэмжээнд давхардсан тоогоор 4600 гаруй | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүүхэд хамрууллаа. 2024 онд 1648 хүүхэд суралцаж байгаагаас урлаг, уран сайхны чиглэлээр 1186, оюун ухааны чиглэлээр 462 хүүхэд хамрагдсан байна. Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, дэмжих зорилгоор 15 төрлийн дугуйлан тус бүр тайлан тоглолтоо хийснээс гадна Залуучууд театрын их танхимд 29 төрлийн номерт 310 хүүхдийг оролцуулсан нэгдсэн тайлан тоглолтыг зохион байгуулсан.<br>Улсын чанартай тэмцээнд 2022 онд 3 төрлийн тэмцээнд 7 хүүхэд, 2023 онд 8 төрлийн тэмцээнд 31 хүүхэд, 2024 онд Улсын чанартай 6 төрлийн тэмцээнд 39 хүүхэд оролцож амжилт үзүүллээ.<br>**Үр дүн:** 2021 онд 1562 хүүхэд, 2022 онд 3365 хүүхэд, 2023 онд 3596 хүүхэд, 2024 онд 1648 хамрагдсан нь 2021 онд 2,1 дахин, 2023 онд 7%-аар нэмэгдсэн байна. 2024 онд хөгжлийн үйлчилгээнд 1648 буюу нийт хүүхдийн 4,2 хувийг хамруулсан. 2022 онд ардын дуу, зураг, 2023 онд драм, хийл хөгжим 2024 онд Үкүлэлэ хөгжим нийт 5 дугуйлан тус тус нэмэгдсэн. | |
| 99 | 1.5.9.2. Хүүхэд, өсвөр үеийнхэнд хүмүүжил төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | НБХ | 8.0 | Хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд 500 хүүхэд хамруулсан. | Хөгжлийн үйлчил-гээнд хамрагд-сан хүүхдийн тоо өмнөх оноос 10%-иар нэмэгдүүлнэ. | 2.0 | УТ 1,9 | -Хүүхэд хөгжлийн ордноор 2021 онд 944 хүүхэд, 2022 онд 3365 хүүхэд, 2023 онд 3596 хүүхэд, 2024 онд 1648 дугуйланд хамрагдсан.<br>-Төр болон хувийн хэвшлийн дэргэдэх 2022 онд 29 дугуйлан, сургалтын төвд 3398 хүүхэд, 2023 онд 30 дугуйлан, сургалтын төвд 3796 хүүхэд хамрагдсан.<br>-Сургуулийн дэргэдэх 2022 онд урлаг, спорт, оюун ухаан, оролцооны 49 клубт 9000 гаруй хүүхэд, 2023 онд 53 клубт 9200 гаруй хүүхэд, 2024 онд 48 клубт 7200 гаруй хүүхэд хамрагдсан.<br>- “Зулзагын гол” хүүхдийн зусланд 2022 онд 536 хүүхэд, хөнгөлөлтэй 21, эрсдэлт нөхцөлд байгаа 3, асрамж халамжийн төвийн 5 хүүхэд үнэ төлбөргүй, 2023 онд 1593 хүүхэд, үнэ төлбөргүй 65, эрсдэлт нөхцөлд байгаа 2, хөгжлийн бэршээлтэй 75, нийт 142 хүүхдийг үнэ төлбөргүй, 2024 онд 2290 хүүхэд, зорилтод бүлгийн 500 хүүхэд, хөгжлийн бэршээл<br>тэй 76, нийт 98 хүүхдийг үнэ төлбөргүй амраах хөгжих, амрах эрхийг хангасан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2021 онд “Сайн туршлагыг түгээе” нэвтрүүлгийг бэлтгэн цахим хуудас болон орон нутгийн телевизээр түгээн сайн туршлагыг сурталчилсан нэвтрүүлэг-3, видео-4, 2022 онд Хүүхдийн үзэл бодол, дуу хоолойг сонсох зорилгоор “Хүүхдээ сонсъё” QR кодыг ЕБ-ын 26 сургууль, коллежид шинээр байршуулж, 106 санал, хүсэлт, 2023 онд ЕБ-ын 26 сургуулийн 910 хүүхдээс санал хүсэлтийг авч, холбогдох удирдлагуудад нь хүргүүлж шийдвэрлэлтийг хангуулан ажиллалаа.<br>Хүүхэд өсвөр үеийнхний амралт чөлөөт цаг, хөгжих, оролцох нөхцөл боломжийг бүрдүүлж, спорт, урлаг, төслийн уралдаан, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, чуулган гэх мэт үйл ажиллагаанд 2021 онд 45 цахим, танхим хосолсон арга хэмжээнд 5367 хүүхэд, 2022 онд 8 төрлийн арга хэмжээнд 11,717 хүүхэд, 2023 онд 25 төрлийн арга хэмжээнд 18,185 хүүхдийг хамруулсан. 2023 онд Дархан-Уул аймгийн Хүүхдийн Зөвлөл “Үндэсний шилдэг Хүүхдийн Зөвлөл”-өөр шалгарсан. 2024 онд уулзалт хэлэлцүүлэг чуулганд 1624 хүүхдийг, амьдрах ухаан, нөхөн үржихүйн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 1300 хүүхдийг, нийт 12 төрлийн үйл ажиллагаанд 4572 хүүхдийг оролцуулсан.<br>2024 онд Хүүхдийн зуслангийн багш нарыг чадавхжуулах сургалтад 18 багш, хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 442 насанд хүрэгчийг оролцуулсан.<br>**Үр дүн: Хөгжлийн үйлчилгээнд давхардсан тоогоор 2021 онд 5367 хүүхэд буюу нийт хүүхдийн 14,5%, 2022 онд 11,717 хүүхэд буюу нийт хүүхдийн 31,2% буюу өмнөх оноос 23,4 дахин их, 2023 онд 18,185 хүүхэд буюу нийт хүүхдийн 55% хамрагдаж, өмнөх оноос 1,5 дахин их, 2024 онд 11,772 буюу нийт хүүхдийн 30,1 хувийг хамруулсан.** | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | **Төсөв: Улсын төсөв: 31,1 Аймгийн ЗДТГ-аас: 1,8 сая ОУБ: 11,7 сая, нийт 34,4 сая төгрөг** | |
| 100 | 1.5.9.3. Жил бүр оны онцлох хүүхэд, Шилдэг гэр бүл, Манлайлагч залуу тодруулж алдаршуулна. | 2021-2024 | НБХ | 16.0 | Жил бүр “Оны онцлох хүүхэд”, Шилдэг гэр бүл шалгаруулж тогтмолжсон. | Гэр бүл 6, Хүүхэд 10, Залуучууд 6 | - | - | 2021 онд 6 номинациар, 2022 онд /хэрэгжээгүй/, 2023 онд 6 номинациар 6 гэр бүлийг “Оны шилдэг гэр бүл”-ийг шалгаруулан, урамшуулж, олон нийтэд сурталчилсан.<br>Хүүхдийн хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах хүрээнд 2021-2023 онд мэдлэг, чадвар, авьяас, хичээл зүтгэлээрээ тэргүүлэн сурлага, спорт, урлаг болон бусад төрлөөр амжилт гарган манлайлсан сурагчдыг “Оны онцлох хүүхэд” 9 номинацид шалгаруулж, 2021, **2022** онуудад 2 төрөл шалгаран, **2023** онд 4 номинацид 5 хүүхэд Монгол Улсын “Оны онцлох хүүхэд”, 9 номинацид 10 хүүхэд, 1 анги хамт олон аймгийн “Оны онцлох хүүхэд”-ээр шалгарсан. **2024** оны “онцлох хүүхэд”-ийг 12 сар шалгаруулна.<br>**Үр дүн: 2021 оны Спортын “Шилдэг сурагч” төрөлд, 2022 оны Байгаль хамгаалал, эрүүл аюулгүй орчны “Шилдэг сурагч” төрөлд, 2023 онд 4 номинацид 5 хүүхэд улсын онцлох хүүхдүүд шалгарсан.** | 100% |
| 101 | 1.5.9.4. “Зулзагын гол” хүүхдийн зуслангийн амралтын байрыг шинэчлэн тохижуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ. | 2021-2024 | НБХ | 250.0 | 5 дугаар байранд засвар хийсэн. | - | УТХО 5.0 | Өөрийн орлогоос 14.1 | 2021 онд Зулзагын гол хүүхдийн зуслангийн 5,6 дугаар байрыг ОНТ-ийн 192 сая төгрөг, 2022 онд 7, 8 дугаар байрыг ОНТ-ийн 346.6 сая төгрөг, 2023 онд ОНТ-ийн 700 сая төгрөгийн санхүүжүүлэлтээр задгай театрыг бүрэн шинэчилж, цайны газрын хуучин байрыг буулган зуны задгай талбай болгож, гадна талбайн засвар тохижилтын ажлыг өөрийн орлогоос 14,1 сая төгрөгийн засварлаж, гадаах хашааг сольж, Дэлхийн Зөн Дархан Хүүхдийн төлөөх орон нутаг төслийн 12,2 сая төгрөгийн санхүүжилтээр сагсан бөмбөгийн талбайн 300м2 орчин үеийн шалыг суурилуулж орчин нөхцөлийг сайжруулլаа.<br>“Хүүхэд хамгааллын жил” болгон зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 05-р сарын 02-ны өдрийн 01-А/119 тоот захирамжаар тусгай | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдэд зориулсан зуны нүүдлийн цэцэрлэгийг сэргээн засах эмчилгээ, үйлчилгээ, чийрэгжүүлэлт, танхимын сургалт, ганцаарчилсан сургалтыг 4 ээлжээр 93 хүүхэд хүлээн авснаас 75 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 18 ердийн хүүхэд, 72 эцэг эх, нийт 165 амрагчдын хөгжлийн хөтөлбөрт хамруулсан.<br>Төсөв: Улсын төсөв: 10,4 сая<br>Орон нутгийн төсөв: 1,2 тэрбум<br>Өөрийн орлого: 14,1 сая<br>ОУБ санхүүжилт: 12,2 сая төгрөг, нийт 1,2 тэрбум төгрөг<br>2024 оны хагас жилийн байдлаар 6,0 сая төгрөгийн санхүүжүүлэлтээр био нойлыг шинээр суурилуулж, гадна талбайн гэрэлтүүлэг болон засвар шинэчлэлийн ажилд 6,3 сая зарцуулсан. Энэ онд нийт 9 ээлжээр 2290 хүүхдийг хүлээн авч ажилласан. Улсын төсвөөс 12,3 сая төгрөг зарцуулсан.<br>**Үр дүн: Хөгжлийн бэрхшээлтэй зуны цэцэрлэг шинээр байгуулж**, **5, 6, 7, 8-р байр засварлаж, задгай театр, гадаа хашаа шинээр сольж, зуны задгай талбай, сагсан бөмбөгийн талбай, био нойлыг шинээр засварлаж хүүхэд амрах ая тухтай орчин бүрдүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гал тогооны тоног төхөөрөмжүүдийг шинэчилч, 60ш хүүхдийн ор шинээр нийлүүлж тав тухтай орчинг бүрдүүдэн ажилласан.** | |
| **1.5.10. Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, гэр бүл дэх хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах үйл ажиллагааг сайжруулна.** | | | | | | | | | | |
| 102 | 1.5.10.1. “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг дэмжиж, хамгааллын тусламж шуурхай үзүүлнэ. | 2021-2024 | НБХ | 22.0 | Мэдээллийн нэгдсэн сан байхгүй | Хамгааллын үйлчилгээг нийт хүүхдийн 6.5 хувиар хүргэж мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ. | УТХО 6.0 | Улсын төсвөөс 1,6 Щвейцарийн хөгжлий | Дархан-Уул аймгийн Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумын 26 хамтарсан баг 2021 онд 184 кейс, 2022 онд 322 кейс, 2023 онд 193 кейс, 2024 оны хагас жилийн байдлаар 56 кейс нийт 755 кейстэй ажиллаж, 971 хүүхдэд, 730 насанд хүрэгчдэд гэр бүл, хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэн ажилласан байна. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | н агентлаг НҮБ-ийн хүн амын сангаас 19.0 | Үйлчилгээний төрлөөр авч үзвэл: 327 хүүхдэд эрсдэлийн үнэлгээ хийж, хамтарсан баг 203 удаа хуралдаж, сэтгэл зүйн үйлчилгээг 419 удаа, эрх зүйн туслалцаа 365 удаа, холбон зуучлах үйлчилгээг 380 удаа, дэмжих үйлчилгээг 375 удаа, гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээг 187 удаа тус тус үзүүлсэн байна.<br>2022 оноос эхлэн **“Нийгмийн ажилтны мэдээллийн сан”** нэгдсэн программ ашиглалтад орж, хамтарсан багийн нарийн бичиг кейс файлаа шивж оруулан бүртгэж, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна.<br>**-** 2022 онд Шуурхай тусламжийн үйлчилгээ, Гэр бүлийн болон гэр бүлээс тусдаа орчинд нөхөн сэргээх үйлчилгээг 117 кейс буюу 183 хүүхдэд үзүүлж, хамтарсан багийн кейс шийдвэрлэлтэд 3,385,676 төгрөгийн санхүүжилт олголоо.<br>- 2023 онд Шуурхай тусламжийн үйлчилгээ, Гэр бүлийн болон гэр бүлээс тусдаа орчинд, нөхөн сэргээх үйлчилгээг 223 кейс буюу 302 хүүхдэд үзүүлж, хамтарсан багийн кейс шийдвэрлэлтэд 7,115,815 төгрөгийн санхүүжилт олголоо.<br>- 2024 онд Шуурхай тусламжийн үйлчилгээ, Гэр бүлийн болон гэр бүлээс тусдаа орчинд, нөхөн сэргээх үйлчилгээг 120 хүүхдэд үзүүлж, хамтарсан багийн кейс шийдвэрлэлтэд 7,5 төгрөгийн санхүүжилт олгосон.<br>**-** 2022 Урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүрээнд сургалт, нөлөөллийн 87 удаагийн арга хэмжээнд 3407 иргэнийг хамруулсан байна.<br>- 2023 онд Урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүрээнд сургалт, нөлөөллийн 27 удаагийн арга хэмжээнд 643 иргэнийг хамруулсан байна.<br>- 2024 онд Урьдчилан сэргийлэх үйлчилгээний хүрээнд сургалт, нөлөөллийн 35 удаагийн арга хэмжээнд | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 3120 иргэнийг хамруулж мэдлэг ойлголтыг нэмэгдүүллээ.<br>ХНХЯ болон Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын хүн амын сангийн 19 сая төгрөгийн санхүүжилтээр "Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь" төслийн хэрэгжилтийн хүрээнд Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, сургалтад Дархан, Орхон, Хонгор, Шарын сумдын 26 хамтарсан багийн 104 гишүүд хамрагдсан.<br>Хараа хяналтгүй 6 хүүхдэд эрсдэлийн үнэлгээ, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийж хамтарсан багаар ажиллаж, хөгжлийн үйлчилгээ 3, гэр бүлийг дэмжих үйлчилгээнд 2 хүүхдийг тус тус хамруулж хяналтад авч хариу үйлчилгээ үзүүлэв.<br>Аймгийн ИТХ-с 26 Хамтарсан багийн кейс шийдвэрлэлтэд 10.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон.<br>**Үр дүн:**<br>**2021 онд 184 кейс, 2022 онд 322 кейс, 2023 онд 193 кейс, 2024 оны хагас жилийн байдлаар 56 кейс нийт сүүлийн 4 жилд 755 кейс бүртгэснээс 731 кейс шийдвэрлэж, 24 кейс шийдвэрлэх шатанд буюу шийдвэрлэлт 96,8%-тай байна.**<br>**Сургалт, нөлөөллийн арга хэмжээг 2021 онд 5580 хүнд, 2022 онд 6702 хүнд, 2023 онд 3341 хүнд, 3120 хүнд нийт сүүлийн 4 жилийн байдлаар 18,743 хүнд зохион байгуулсан.**<br>**Хүүхэд хамгааллын үйлчилгээг 2021 онд 5764 хүүхдэд, 2022 онд 1954 хүүхдэд, 2023 онд 3534 хүүхдэд, 2024 онд 3176 хүүхдэд тус тус үзүүлсэн нь 2021 онд хүүхэд хамгааллын үйлчилгээг нийт хүүхдийн 15,1%-ийг, 2022 онд 5,2%-ийг, 2023 онд 9,3%-ийг, 2024 онд 8,6%-ийг тус тус хамруулсан байна.** | |
| 103 | 1.5.10.2 Хүүхдийг осол | 2021-2024 | НБХ | 22.0 | 688 эцэг эх, | Осол гэмтлээс урьдчилан | | | 2021 онд Би хариуцлагатай аав, ээж аян, | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгч, олон нийтэд сургалт сурталчилгааны ажил зохион байгуулна. | | | | асран хамгааламгч | сэргийлэх нөлөөллийн ажилд оролцоог 1 дахин нэмэгдүүлнэ. | | | Онцгой нөхцөл байдлын үед сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой бага насны хүүхдийг харгалзах хүнгүй үлдээхгүй байх ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 35 төрлийн зөвлөмж постер, 55 төрлийн шторк байршуулсан. **Миний гэр аюулгүй орчны судалгаа 2461 хүн хамруулсан.**<br>2022 онд "Хүүхэд хэсэгчилсэн арга хэмжээ", "Нэгдүгээрт шалга аян", "Сурагчийн аюулгүй байдал" зэрэг арга хэмжээнд 2400 хүүхэд, "Эрсдэлээс өөрийгөө хамгаалах арга зүй" номыг 1000 багшид түгээж, "Үе тэнгийн дээрэлхэлт арт терапи" төслийг хэрэгжүүлэн 2140 хүн хамруулсан.<br>2023 онд Хараа хяналт нэгдсэн арга хэмжээ Дархан, Хонгор, Шарын гол, Орхон сумын 317 өрхийн 747 эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийн гэрээр эргэн хяналт хийж эрсдэлийн түвшин тогтоож шуурхай тусламжийн багц 120 өрхөд олголоо.<br>Дархан Уул аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газартай хамтран үер усны болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Хараа гол орчмоор завьт эргүүлд нийт 5 удаа хийж 250 иргэн 120 хүүхдэд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх гарын авлага тарааж мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.<br>Миний гэр аюулгүй орчин эрсдэлийн үнэлгээнд 185 өрхийн 545 иргэн оролцсон. "Аврагч мазаалай" "Би Найзыгаа шоглодоггүй", "Электрон тамхины хор уршиг", "Цэвэр цүнх үзлэг" сэдэвт сургалтад 9704 сурагч, 229 багш, 558 эцэг эх хамруулсан.<br>Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 41 зөвлөмж постер,10 шторк бэлтгэн түгээсэн.<br>2024 онд аймгийн хэмжээнд байдаг 26 байршлын 500 гаруй тоглоомын талбай, олон нийтийн газрууд, хуучны орон | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | сууцны 158 орцны цонхны хаалт, хамгаалалтын аюулгүй байдалд, ЕБ 15 сургууль, СӨБ-ын 20 цэцэрлэгийн гадаад орчин, хүүхдийн тоглоомын талбайд хяналт шалгалтыг зохион байгуулж газар дээр нь зөрчлийн арилгуулан, холбогдох байгууллагуудад нь зөвлөмж хүргүүлсэн.<br>Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, газар болон бусад байгууллагуудтай хамтран Хараа голын эргээр завьт болон явган эргүүлийг 34 удаа гарч, 1800 ширхэг зөвлөмжийг иргэдэд хүргэснээр амь эрсэдсэн эрүүл мэндээрээ хохирсон талаарх дуудлага мэдээлэл бүртгэгдээгүй, насанд хүрэгч 2, бага насны 5 хүүхдийг амь насны хүүхдийн амь насыг аварсан.<br>Зам тээврийн осол удаа дараалан үйлдэгдэж буй 7 эмзэг цэгийг тодорхойлон Дархан сумын нутагт 5, шарын гол сумын нутагт 2 анхааруулах самбар байршуулан ажилласан.<br>Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 17 зөвлөмж постер, 2 шторк бэлтгэн түгээсэн<br>2024 онд Хараа хяналт нэгдсэн арга хэмжээ Дархан, Хонгор, Шарын гол, Орхон сумын 150 өрхийн 392 эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийн гэрээр эргэн хяналт хийж эрсдэлийн түвшин тогтоож шуурхай тусламжийн багц 100 өрхөд олголоо.<br>Миний гэр аюулгүй орчин эрсдэлийн үнэлгээнд 150 өрхийн 400 иргэн оролцсон.<br>**Үр дүн: Сүүлийн 4 жилд эрсдэлээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ 5 удаа, аян 2 удаа, төсөл 1 удаа, ном 1, сургалт 4, аюулгүй орчин үнэлгээ 4 удаа тус тус зохион байгуулж,**<br>**7120 эцэг эх, асран хамгаалагч, 10,963 хүүхэд хамруулсан. Эцэг эх асран хамгаалагчдын оролцоог 9,4 дахин нэмэгдүүлсэн байна.** | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 104 | 1.5.10.3. Байгууллагын эцэг эхийн зөвлөлийг чадавхжуулах үйл ажиллагааг сайжруулна. | 2021-2024 | НБХ | 8.0 | 166 байгууллага | Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангахад байгууллага, иргэн бүрийн оролцоо, хамтын ажиллагаа нэмэгдсэн байна. | | | Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого”-ийн хэрэгжилтийн хүрээнд аймгийн төр, хувийн хэвшлийн байгууллагад хүүхэд хамгааллын бодлогыг өөрсдийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллах мөн “Эцэг эхийн зөвлөл” байгуулах чиглэл хүргүүлэн, сургалт нөлөөллийн ажлуудыг шат дараалалтай зохион байгуулж, байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласны **үр дүнд:**<br>Дархан-Уул аймгийн хэмжээнд 2019 онд төр, хувийн хэвшлийн 84 аж ахуйн нэгж, 2020 онд 81 аж ахуйн нэгж, 2021 онд 2 аж ахуйн нэгж, 2022 онд 5 аж ахуйн нэгж нийт **172** /Үүнээс: 60 төрийн байгууллага, 47 аж ахуйн нэгж, 65 сургууль цэцэрлэг/ **байгууллага аж, ахуйн нэгж** “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг хэрэгжүүлэн “Эцэг эхийн зөвлөл” байгуулан сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, 2022 онд Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн газар, 21-р цэцэрлэг, Биеийн тамир, спортын газар, Залуучууд театр, 16-р сургууль, Стандарт хэмжилзүйн хэлтэс 2023 онд Татварын хэлтэс, Политехникийн коллеж, Шүүхийн шинжилгээний алба, Дархан сумын ЗДТГ, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар 2024 онд 31 байгууллага **нийт 44** байгууллага, өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хүүхдийн өрөөг тохижуулан, 5 байгууллага хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөөтэй, 2 байгууллага суултууртай болж хүүхдэд ээлттэй орчныг бий болголоо.<br>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 17-ний өдрийн 1-10/657 тоот албан бичиг хүүхдийн “Мэндэлсэн өдөр”-өөр цалинтай чөлөө олгох уриалгад 69 байгууллага, аж, ахуйн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | нэгж нэгдэн “Байгууллагын дотоод журам”-д тусган хэрэгжүүлж **289** албан хаагч **450** хүүхдийн мэндэлсэн өдрөөр цалинтай чөлөө авсан байна.<br>Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалт “..ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ” гэх заалтын хүрээнд бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд сургууль цэцэрлэгт хүргэж өгөх авах, эргүүлд гарах, эцэг эхийн хуралд оролцох зэрэг цагийг зохицуулсан 65 байгуулга, 1**564** алба хаагч уян хатан цагаар ажилладаг.<br>**Үр дүн: Нийт 172 байгууллага эцэг эхийн зөвлөл байгуулж, 44 байгуулга хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, 289 албан хаагч хүүхдийнхээ мэндэлсэн өдрөөр цалинтай чөлөө авч, 1564 алба хаагч уян хатан цагаар ажиллаж байна.** | |
| 105 | 1.5.10.4. “Хүний хөгжил” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021-2024 | НБХ | - | 90% | 90% | - | - | АймгийнЗзасаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Нийгмийн бодлогын чиглэлээр үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгагдсан Хүний хөгжил дэд хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт, 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн чиглэлээр 13, боловсролын чанарыг сайжруулахад 10, амьжиргааны чадавхийг дээшлүүлэх чиглэлээр 10, хотын соёлыг хөгжүүлэх, хэвшүүлэх чиглэлээр 11 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Хөтөлбөрийн хэрэгжилт 96,5%-тай байна. | 100% |
| 106 | 1.5.10.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ". | 2021-2022 | НБХ | ОНТ, 7.0 | | Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 90%-д хүрсэн байна | - | - | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 91 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөр”-ийг батлан 2022 онд хэрэгжүүлж дууссан.<br>2022 онд Аймгийн Засаг даргын 01-А/342 дугаар захирамжаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн салбар хороог шинэчлэн, аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан 19 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 130 | 2.2.1.4. Үнэт металлын сорьц тогтоох лабораторийн үйл ажиллагааг тогтвортой явуулж, материаллаг баазыг бэхжүүлэн, тоног төхөөрөмжийг шинэчилнэ. | 2021-2024 | ХБТХОХ | 27.0 | Алт олборлогч 9 иргэн, 4 аж ахуй нэгж, байгууллага, 3 төрийн байгууллагад давхардсан тоогоор 332 удаагийн үйлчилгээ үзүүлсэн | 500,0 кг үнэт металл хайлан, сорьц тогтооно | 0.0 | 0.0 | 2021 онд алт олборлогч 4 аж ахуй нэгж, 9 иргэн, 3 төрийн байгууллагад давхардсан тоогоор 332 удаагийн үйлчилгээ үзүүлж, 343 ш гулдмай буюу нийт 663,1 кг орчим үнэт металлын хайлш хайлснаас 658,3 кг орчим үнэт металлд сорьцын баталгаа олгосон.<br>2022 онд төрийн 1 байгууллага, алт олборлогч 15 аж ахуйн нэгж, 21 иргэнд давхардсан тоогоор 689 удаагийн үйлчилгээ үзүүлж, 1004 ш гулдмай хайлж, 2973 кг үнэт металлын хайлш хайлснаас 2945 кг үнэт металлд сорьцын баталгаа олгосон.<br>2023 онд алт олборлогч 13 аж ахуй нэгж, 17 иргэнд давхардсан тоогоор 632 удаагийн үйлчилгээ үзүүлж, 774 ш гулдмай буюу нийт 1974.7 кг үнэт металлын хайлш хайлснаас 1960.1 кг үнэт металлд сорьцын баталгаа олгосон.<br>2024 онд алт олборлогч 8 аж ахуйн нэгж, 12 иргэнд 158 удаагийн үйлчилгээ үзүүлж нийт 495.6 кг үнэт металлын хайлш хайлснаас 197 ш алтан гулдмай буюу 489.7 кг үнэт металлын хайлшинд сорьцын баталгаа олгож улсын төсөвт 125 сая төгрөг төвлөрүүллээ.<br>**Үр дүн: 2021-2024 оны Хөтөлбөр хэрэгжих хугацаанд давхардсан тоогоор 50 аж ахуй нэгж, 72 иргэнд давхардсан тоогоор 1980 удаагийн үйлчилгээ үзүүлж, 2548 ш гулдмай буюу нийт 6573,4 кг үнэт металлд сорьцын баталгаа олгож, үйлчилгээний хөлс болох 1,209,4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажиллалаа.** | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 09 дүгээр сарын 05-ний өдрийн 275 дугаар тогтоолоор Дархан-Уул аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэст “Төвийн бүсийн сорьц тогтоох лаборатори” байгуулагдаад 6 дахь жилдээ үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. СХЗГ-ын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/36 тоот тушаалаар хэлтсийн бүтэц орон тоо шинэчлэн батлагдаж, тус лабораторид 1 химич, 1 алт хайлагч нэмэгдэж, нийт 5 ажилтантай боллоо.<br>2023 оны 10-р сарын 31-ний байдлаар алт олборлогч 13 аж ахуй нэгж, 17 иргэнд давхардсан тоогоор 632 удаагийн үйлчилгээ үзүүлж, 774 ш гулдмай буюу нийт 1974.7 кг үнэт металлын хайлш хайлснаас 1960.1 кг үнэт металлд сорьцын баталгаа олгож, үйлчилгээний хөлс болох 360.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 88%-иар биелүүлэн ажиллаж байна.<br><br>**Үр дүн:** 2021-2023 оны Хөтөлбөр хэрэгжих хугацаанд давхардсан тоогоор 37 аж ахуй нэгж, 55 иргэнд давхардсан тоогоор 1822 удаагийн үйлчилгээ үзүүлж, 2351 ш гулдмай буюу нийт 6083.7 кг үнэт металлд сорьцын баталгаа олгож, үйлчилгээний хөлс болох 1,084,4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажиллалаа. | |
| **2.3. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭР** | | | | | | | | | |
| **2.3.1. Хөнгөн ба хүнсний үйлдвэрлэлийг кластер хэлбэрээр хөгжүүлж, импортыг орлох, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ.** | | | | | | | | | |
| 131 | 2.3.1.1. Махан бүтээгдэхүүн, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн орон нутгийн хэрэгцээг хангана. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | - | Махан бүтээгдэхүүн 1.9%, сүүн бүтээгдэхүүн 1.9%, гурил 3.2 дахин их, гурилан бүтээгдэхүүн 18.7%, хангана | Махан бүтээгдэхүүн 2.1%, сүүн бүтээгдэхүүн 2.0%, гурил 3.0 дахин их, гурилан бүтээгдэхүүн 18.7% хангана. | 0.0 | 0.0 | Жил бүрийн 3-4-р сард тухайн жилийн хүнсний хэрэгцээ, өмнөх оны үйлдвэрлэлтээр хүнсний хангамжийг тооцож, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хүнсний тэнцлийг тооцож, саналын хамт ХХААХҮЯ-д ХХААГ-ын 2021 оны №186 албан бичгээр хүргүүлсэн. 2022, 2023, 2024 онд цахимаар 21 аймгийн мэргэжилтнүүдэд “Хүнсний аюулгүй байдал тооцох аргачлал” сэдвээр мэдээлэл хийж, чиглүүлэн ажиллаа. Малчид, фермер эрхлэгч, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, хүнсний боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч, махны салбарынхан-/малчин, ченж, үйлдвэр, худалдаа/-тай ХХААГ-ын дарга үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсээр тогтвортой хангах асуудлаар уулзалтыг тус тус шат дараатай хийж, дэвшүүлсэн санал хүсэлтийг ХХААХҮЯ-д уламжиллаа. ХХААХҮЯ, ТХААГ, Хөгжлийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | шийдэл ТББ, ХХААГ, БШУГ хамтран “Ерөнхий гэрээ байгуулах арга зүй” сэдэвт сургалтад 35 үйлдвэрлэгч, 35 боловсролын байгууллагын эрхлэгч, захирал нарт, “Тохирлын гэрчилгээ олгох арга зам, гэрчилгээ олгох” сэдвээр сургалт зохион байгуулж, 17 үйлдвэрлэгчид мэдлэг олгож, чадавхижуулсан.<br>Хүнсний хувьсгал хөдөлгөөний хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжих эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн хүнсний боловсруулах үйлдвэрийн 12 аж ахуйн нэгжид 47.52 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсний үр дүнд стандартын шаардлагад нийцсэн ажлын байр, техник, технологийн шинэчлэл хийж, бүтээгдэхүүний чанар сайжирч, нэр төрлийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүллээ. Хүн амд шаардлагатай махны нөөцийн тооцоо хийж, мал төхөөрөх, ангилан савлах, боловсруулах 7 үйлдвэр, цех зоорилсон махтай 11 иргэн, мал-мах бэлтгэгч 115 иргэн, “Тээвэр Дархан” ХХК-ийн Хүнсний захын махны тасгийн ажилтан нартай хамтран ажиллаж, махны нөөц, нийлүүлэлтийн сүлжээг нарийвчлан судалж, махаар тасралтгүй хангасан. Мал мах бэлтгэгч 92 иргэн жилд 972.4-1050 тн малын мах буюу жилийн хэрэгцээт махны 16.6-17.9%-ийг зах зээлд нийлүүлж, тогтвортой хангалаа. Хаврын улирлын махны хэрэгцээг хангах ажлын хүрээнд орон нутгийн төсвөөр 2021 онд 100 тонн, 2022 онд 200 тонн, 2023 онд 130 тонн, 2024 онд 140 тонн махны нөөц бүрдүүлж, сонгон шалгаруулалтад тэнцсэн ннөцийн мах бэлтгэн нийлүүлсэн аж ахуйн нэгжид урамшуулал хэлбэрээр санхүүжилтийг олгосон. 2024 оны хаврын улирлын 3 сарын хэрэгцээт махны 14.9 хувийг хангаж, махны хомсдол үүсээгүй.<br>Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу 11-р сараас 4-р сар хүртэлх хугацаанд Дархан цасхан сүү ХХК, Эко милк ХХК 2022-2023 онуудад нийт 27 малчнаас 24.6 мян.л сүү, 2023-2024 онд “Дархан цасхан сүү” ХХК 2023-2024 онд 26 малчнаас 24.5 мян.л сүү авч, 5 сарын хэрэгцээт сүүний 1.6 хувийг нийлүүлж, өвлийн улиралд малын сүүгээр | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | тогтмол хангасан малчдад холбогдох журмын дагуу урамшуулалд хамруулсан. Гурилын үйлдвэрүүдэд 43.0 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн дэмжлэгийг үзүүлснээр жилд 650.0 мян.тн үр тариа тээрэмдэх хүчин чадалтай 3 гурилын үйлдвэрт дотоодын болон импортын улаанбуудайн нөөц хангалттай бүрдүүлж, тасралтгүй ажиллаж, гурилаар 4-5 дахин их хангах хэмжээний үйлдвэрлэл явуулсан. Улаанбаатар, Эрдэнэт, Сэлэнгэ аймаг руу төмөр замаар 1-2 өдөрт 3-6 вагон ачилт хийж, баруун, зүүн аймгуудад тээврийн хэрэгслээр түгээлт хийн нийлүүлэгдсээр байна. Гурилын агуулах дүүрч, 2024 оны хаврын улиралд 1.0-1.5 сар үйлдвэр сул зогсолт хийж, технологийн засвар үйлчилгээ хийсэн.<br>Талх, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 17 аж ахуйн нэгж, 26 иргэн үйлдвэрлэл явуулж байна. Хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгийг 7 аж ахуйн нэгжид үзүүлснээр 3 нь ажлын байрыг стандартад нийцүүлж, 4 нь технологийн шинэчлэл хийж, бүтээгдэхүүний чанарыг сайжрууллаа.<br>Мал аж ахуйгаас хүнсэнд хэрэгцээлсэн махны хэмжээ 45 тонноор буюу 6.7%-аар өсч, 4892 тонн мах бэлтгэн 83.3%-ийг хангасан. Жилд 104841 толгой мал төллөж, 6586.5 мян.л сүү бэлтгэн, аймгийн хэрэгцээт сүүнийхээ 62.6 хувийг хангасан.<br>Шувууны аж ахуй эрхлэгч 2 ААН 11000 өндөглөгч тахианаас сард 250.0-270.0 мянган ширхэг өндөг нийлүүлж, хэрэгцээт өндөгний 25-35 хувийг хангаж байна. Туслах аж ахуйгаас жилд 0.76 тн шувууны мах, 19.0 тн гахайн мах бэлтгэн нийлүүлсэн байна.<br>Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл мах, махан бүтээгдэхүүнээр 5.4 %, /нөөцийн мах 130 т орсон/, сүү, сүүн бүтээгдэхүүнээр 1.1%, гурилаар 4.6 дахин их, гурилан бүтээгдэхүүнээр 25.4%-ийг хангасан.<br>**Үр дүн:** Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 4 жилийн дундаж үзүүлэлтээр: Мах, махан бүтээгдэхүүнээр 3.07% /нөөцийн мах оруулаагүй/, сүү, сүүн бүтээгдэхүүнээр 1.7%, гурилаар 4.7 дахин их, гурилан бүтээгдэхүүнээр 23.3%-ийг тогтвортой хангаж байна.<br>Суурь онтой харьцуулахад /4 жилийн дундаж | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | үзүүлэлтээр/ мах, махан бүтээгдэхүүн 1.17%-аар, гурил 43.7%-аар, гурилан бүтээгдэхүүн 5%-аар өссөн ба сүүн бүтээгдэхүүн 0.2%-аар буурсан.<br>Мал мах бэлтгэгч 92 иргэн жилд 972.4-1050 тн буюу жилийн хэрэгцээт махны 16.7-17.9%-ийг зах зээлд нийлүүлж байна. Туслах аж ахуйгаас 0.76 тн шувууны мах, 1.5-2.5 сая ширхэг өндөг, 19.0 тн гахайн мах бэлтгэн нийлүүлж байна. | |
| 132 | 2.3.1.3. “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулна. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар | 100.0 | Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 30%-д хүргэнэ | Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 70%-д хүргэнэ.<br><br>/Засгийн газрын 2021 оны тогтоолоор хүчингүй болсон/ | 30.0 | - | Дархан-Уул аймаг гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөц, үлдэгдлийн мэдээг 56 хүнсний үйлдвэр, 311 хүнсний дэлгүүрээр нэгтгэн гаргаж, ХХААХҮЯ-д хүргүүлсэн ба 2024 оны сумдад чиглэл хүргүүлсэн. Бөөний худалдааны байгууллагуудын 70 ААН, иргэний судалгааг гаргаж, бөөний худалдааны 8 байгууллагын жилийн эхний 10 сарын нийлүүлэлт болон махны зоорь агуулах-13, төмс, хүнсний ногооны зоорь агуулах-19, хуурай хүнс -10, нийт 42 зоорь, агуулахын судалгааг гаргасан. Хүнс, хоол үйлдвэрлэл, худалдааны салбарын судалгааг шинэчилж, хүнсний үйлдвэрийн өнөөгийн байдлыг тодорхойлж, зохион байгуулсан сургалт, уулзалтуудаас гарсан саналын хамт ХХААХҮЯ, БШУЯ-д уламжилсан.<br>ХХАА-н салбарын бизнесийн орчин ба санхүүжилтийн боломж”, зохистой дадал нэвтрүүлэх, хүнсний зориулалтын бус хуванцар сав, түүний тэмдэг, тэмдэглэгээ, зохистой хэрэглээг нэмэгдүүлэх, хоол хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн агууламжийг нэмэгдүүлэх, тохирлын үнэлгээ хийлгэх, баталгаажуулах, стандарт мөрдөх сэдвүүдээр үе шаттайгаар уулзалт, сургалт зохион байгуулж, 2021-2024 онд нийтдээ давхардсан тоогоор 1460 хүнийг хамруулж, мэдлэг олгож, чадавхижуулсан. Гурил, гурилан бүтээгдэхүүн, махан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоог Улаанбаатар, Дархан, Сэлэнгэ, Хөвсгөл аймаг руу нийлүүлэлт хийж, Хөвсгөл, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Сэлэнгэ, Булган аймгаас малын мах татаж, махны нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн. Бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Худалдааны гудам”-ыг байгуулж, улирлын чанартай үзэсгэлэн худалдаануудыг зохион байгуулж, 2022 онд 153.5 сая.төг, 2023 онд 64.0 сая.төг-ийн борлуулалт хийсэн.<br>Нийтийн орон сууцны 1-р давхарт хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ үзүүлдэг 12 байгууллага, хүнсний боловсруулах 17 үйлдвэр, газар тариалангийн талбайд тариалалт, хураалтын үйл ажиллагаатай танилцаж, 14 байгууллагын үйл ажиллагааг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага болон цахимаар олон нийтэд сурталчилсан.<br>**Үр дүн:** 2021-2024 онд нийт 1460 /давхардсан тоогоор/ ажилтанд мэдлэг олгож, чадавхижуулсан. 14 байгууллагын үйл ажиллагааг нэвтрүүлэгээр сурталчилсан. ОУ стандарт нэвтрүүлсэн хүнсний 4 үйлдвэртэй болж, малын мах, дулааны аргаар боловсруулсан амх экспортолсон. Адра төсөлд 10 хоршоо хамруулж, хамтын баталгаажуулалтын байгууллага байгуулснаар органик зөгийн бал, төмс, хүнсний ногоог баталгаажууллаа. | |
| 133 | 2.3.1.4. Хүнсний үйлдвэрүүдэд чанарын менежментийн стандартыг нэвтрүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангана. | 2021-2024 | ХБТХОХ, Стандарт, хэмжил зүйн хэлтэс | 10,0 | MNS CAC/RCP 1:2003 (HACCP) -2 ААНБ, MNS ISO 9001:2016, MNS CAC/RCP1:2003 (HACCP), MNS ISO 22000:2019-1 ААНБ | Сургалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх-2 Улаанбаатар гурил нэвтрүүлнэ. | 3.0 | - | Гурилын үйлдвэрүүдэд импортлогч орны хорио цээрийн шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт хийх удирдамжийн дагуу МХЕГ, ХХААХҮЯ, гурил үйлдвэрлэгчдийн холбоо хамтарсан ажлын хэсэгтэй ХХААГ хамтран ажиллаж, Өег гурил ХХК, Өгөөж гурил ХХК, Улаанбаатар гурил ХХК, Дархан гурил тэжээл ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөгөө өгч ажилласан. ШУТИС-ны ДаТСургууль санаачлан 2022 оны 11 сард зохион байгуулсан HACCP стандартыг хэрэгжүүлэх онол, дадлага хосолсон болон үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадлын мэдлэг олгох сургалтад хүнс үйлдвэрлэгч “Дархан хүнс “ХК, “Мах сервис “ХХК, “Мөнх дэгжих гал” ХХК, “Дархан баялаг” цехийн 4 ажилтан хамрагдаж, | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгаа нь нийт менежментийн тогтолцоо нэвтрүүлсэн байгууллагын 17.6%-ийг эзэлж байна. | | | | мэдлэгээ дээшлүүлэв. Орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудад менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Стандарт хэмжилзүйн газар, аймгийн ЗДТГ-тай хамтран MNS ISO 9001:2016 "Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага" стандартын сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад эрчим хүч, эрүүл мэнд, барилга, боловсрол, хүнсний салбарын MNS ISO 9001:2016 "Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага" стандартыг хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр зорин ажиллаж буй 31 байгууллагын чанар хариуцсан 67 ажилтан хамрагдаж, гэрчилгээгээ гардан авлаа. Стандарт нэвтрүүлэх ажлыг 2-4 жилийн хугацаанд бэлтгэл хангуулан ажилласнаар аймгийн хэмжээнд ISO 9001 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн байгууллага-23, HACCP тогтолцоог нэвтрүүлсэн байгууллага-2, “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 45001 стандартыг нэвтрүүлсэн байгуулага-4, Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001 стандартыг нэвтрүүлсэн байгууллага-2, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000 стандартыг нэвтрүүлсэн байгууллага-2, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO/ IEC 27001 стандартыг нэвтрүүлсэн байгууллага-1, Боловсролын байгууллагын чанарын менежментийн тогтолцоо ISO 21001 стандартыг нэвтрүүлсэн байгууллага-1 үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс: Хүнсний үйлдвэрүүд чанарын менежментийн стандартыг нэвтрүүлэхээр бэлтгэл ханган мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч ажилласнаар “Улаанбаатар гурил” ХХК, Өег гурил ХХК баталгаажуулалтын аудит хийлгэсэн. “Дархан эрдэнэ мах комбинат” ХХК HACCP, ISO22000, Дархан меат фүүдс ХХК HACCP, ISO 22000 стандартын Сертификатын хугацаагаа дахин сунгуулаа. Улаанбаатар гурил ХХК, Өег гурил ХХК, Дархан эрдэнэ мах комбинат ХХК зэрэг 3 үйлдвэрийг улсын хэвлэл мэдээллийн байгууллага, Хүнсний хувьсгал хөтөлбөрөөр болон цахимаар үйл ажиллагааг сурталчилсан. Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлийн сургалт мэдээллийг | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | жил бүр тогтмол явуулснаар менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн байгууллага нэмэгдэж байгаа бөгөөд Өег гурил ХХК HACCP тогтолцоог нэвтрүүлэхээр СХЗХ-т хүсэлт өгсний дагуу аудит хийгдэж байна. Жүр үр ХХК нь HACCP нэвтрүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.<br>**Үр дүн:**2021-2024 онд Улаанбаатар гурил ХХК ISO 9001, HACCP тогтолцоог, Дархан меат фүүдс ХХК, Дархан эрдэнэ мах комбинат ХХК HACCP, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн гэрчилгээжсэн. Аймгийн хэмжээнд MNS ISO 9001:2016 "Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага" стандартыг нэвтрүүлсэн 35 байгууллага үйл ажиллагаа явуулж байна.<br>Чанар хариуцсан 84 ажилтанд сургалтыг үе шаттай зохион байгуулсан. Стандарт нэвтрүүлсэн 3 үйлдвэрийг улсын хэвлэл мэдээллийн байгууллага, Хүнсний хувьсгал тусгай дугаараар болон цахимаар үйл ажиллагааг сурталчилж ажиллаа. | |
| 134 | 2.3.1.5. Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийг жил бүр нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, ХХҮГ | 1150.0 - | Аймгийн хүн амын 4-6-р сарын малын махны хэрэгцээний 22% буюу 200 тонн нөөц бүрдүүлж нийлүүлсэн. | Хаврын улирлын хэрэгцээт махны 15% | 300.0 | 205.0 | Аймгийн иргэдийн хаврын улиралд шаардлагатай махны тооцоог гаргаж, аймгийн ЗДТГ-т хүргүүлж хамтран ажилласнаар орон нутгийн төсвөөс жил бүр 300.0 сая.төг батлуулж уг хөрөнгөөр нөөцийн махны нийлүүлэлтийг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулан ажилласан. 2021-2023 онуудад зарласан сонгон шалгаруулалтаар "Дархан эрдэнэ мах комбинат" ХХК шалгарч хамтран ажилласан. Энэ хүрээнд Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг мал, махны бэлтгэл, байршуулсан, хадгалсан байдал, гарал үүсэл, махны нэр, төрөл, чанар, эрүүл ахуй, аюулгүй байдалд газар дээр нь хяналт тавьж, хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт гаргасан. Худалдан борлуулах маханд нь QR код бүхий магадлан шинжилгээний цахим гэрчилгээ олгосон ба гарал үүслийг хянах гар утасны аплекешин программ ашиглалтанд оруулсан. 2021 онд үхрийн мах 30.0 тонн, хонины мах 65.0 тонн, ямааны мах 5.0 тонн, нийт 100.0 тонн, 2022 онд үхрийн мах 60.0 тн, хонины мах 120.0 тн, ямааны мах 20.0 тн, нийт 200.0 тн, 2023 онд үхрийн мах 65.0 тонн, хонины мах 58.5 тонн, ямааны мах 6.5 тонн, нийт 130.0 тонн, 2024 онд | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | үхрийн мах 63.0 тн, хонины мах 70.0 тн, ямааны мах 7.0 тн, нийт 140.0 тн, 2021-2024 онд нийт 570 тонн мах нийлүүлсэн. Нөөцийн махыг 2021онд III/15-Y/01 хүртэл 1.5 сарын хугацаанд, 2022 онд III/01-YI/30 хүртэл 4 сарын хугацаанд, 2023 онд III/15-Y/31 хүртэл 2.5 сарын хугацаанд, 2024 онд III/15-YI/15 тус тус нийлүүлж, борлуулалтыг 40-59 хүнсний дэлгүүрээр хийсэн. Нөөцийн мах жижиглэн савласан 1.0 кг махны үнэ: 2021 онд үхэр 8.8, хонь 7.5, ямаа 6.5 мян.төг ба зах зээлийн үнээс кг тутамд үхрийн мах 5.5-6.7, хонины мах 4.5-5.0, ямааны мах 4.0-4.5 мян.төг-ний хямд байсан. 2022 онд үхэр 9.5, хонь 8.5, ямаа 7.5 мян.төг ба зах зээлийн жижиглэнгийн үнэтэй харьцуулахад кг тутамд үхрийн мах 3.5-6.0, хонь 3.5-5.5, ямаа 2.0 мян.төг-өөр хямд үнээр борлуулсан. 2023 онд үхрийн ястай мах 9.2, хонины ястай мах 8.2, ямааны мах 7.2 мян.төг, 2024 онд үхрийн ястай мах 10.8, хонины ястай мах 9.0, ямааны мах 7.5 мян.төг ба зах зээлийн жижиглэнгийн үнэтэй харьцуулахад кг тутамд үхрийн мах 4.2-6.2, хонины мах 3.5-4.0, ямааны мах 2.0 мян.төг-өөр хямд үнээр тус тус худалдан борлууллаа.<br>Хаврын улиралд шаардлагатай хэрэгцээт махны 2021 онд 1.5 сарын хэрэгцээт махны 21.9 хувийг, 2022 онд 4 сарын хэрэгцээт махны 16.1 хувийг, 2023 онд 2.5 сарын хэрэгцээт махны 16.7 хувийг, 2024 онд 3 сарын хэрэгцээт махны 14.9 хувийг нөөцийн махаар хангасан.<br>Гэрээг дүгнэж аж ахуйн нэгжид 1.0 кг тутамд 2021 онд 500 төг, 2022 онд 1000 төг, 2023 онд 1500 төг, 2024 онд 2000 төгрөгөөр тохиролцож, урамшуулал хэлбэрээр санхүүжилтийг бүрэн олгосон. Ажлын хэсгийн бэлтгэл ажил, хяналтын үйл ажиллагаанд жил бүр 4.0-5.0 сая төгрөг шийдвэрлэснээс, хөндлөнгийн хяналтын зардлыг ХЭАХН НҮТББ-д гэрээний дагуу 2023 онд 2.5 сая.төг, 2024 онд 2.0 сая төгрөг олгосон байна.<br>Иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж, дэлгүүрийн нэр, байршлыг орон нутгийн иргэдэд Дархан-Уул аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон ЖДҮ Дархан facebook цахим хаягаар, DBS, TV12 орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар олон нийтэд сурталчилж ажиллав.<br>Стратегийн хүнсний нөөц бүрдүүлэх, зарцуулах | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | журмын дагуу явцын мэдээг ХХААХҮЯ-д 14 хоног тутамд буюу 6 удаа албан бичгээр хүргүүлж, 2025 оны хаврын улиралд шаардагдах махны тооцоог гарган, саналаа аймгийн ЗДТГ-т албан бичгээр хүргүүлсэн.<br>**Үр дүн:** Хаврын улиралд нөөцийн мах нийлүүлэх нийслэлийн тендерт 2023 он хүртэл хугацаанд Дархан меат фүүдс ХХК нийлүүлсэн. Дархан-Уул аймагт сонгон шалгаруулалтад Дархан эрдэнэ мах комбинат ХХК оролцож, хаврын улиралд нөөцийн махаар 2021 онд 100.0 тонн, 2022 онд 200.0 тонн, 2023 онд 130.0 тонн, 2024 онд 140 тонн нийлүүлж, хэрэгцээт махны 14.9-16.7 хувийг хангасан. Энэ нь өвлийн улиралд “Идэш арга хэмжээ”-г хэрэгжүүлсний үр дүнд айл өрхүүд идэш бэлтгэн нөөцөлсөн нь махны нөөц бүрдүүлэх хувь хэмжээг бууруулах үндэслэл болсон. 2025 онд нийлүүлэлт, борлуулалтын явц, хэрэглээнд үндэслэн 100-120 тонн мах нөөцлөх санал хүргүүлсэн. | |
| | | | | | Үйлдвэрт сүү 2.0 т, улаанбуудай 36.0 мян.т буюу 25.0 мян.т гурилын нөөцтэй. Буудайн үрийн нөөц 1450 т | Сүү 2.6 тн улаан буудай 30.0 мян.тн буюу 22 мян.т гурилын нөөц, Буудайн үрийн нөөц 1680 тонн | - | Аж ахуйн нэгжийн хөрөнгө | Үйл ажиллагаа явуулж буй хоногт 650 тонн үр тариа тээрэмдэх хүчин чадалтай гурилын 3 үйлдвэр намрын ургац хураалтаас 4 жилийн дунджаар нийт 42.0-55.0 мян.тн буудайн хүлээн авч, 31.56 мян.т гурил үйлдвэрлэж, аймгийн хүн амын жилийн хэрэгцээт гурилаар 4.5 дахин их хэмжээний гурил үйлдвэрлэсэн. Үйлдвэрлэлтээр суурилагдсан хүчин чадлын ашиглалт 20 хувьтай. Импортын болон дотоодын улаан буудайн харьцаагаар чанаржуулан гурил үйлдвэрлэлтийг хэвийн явуулж, Улаанбаатар хот болон бусад аймгуудыг гурилаар хангаж байна. Оны эцэст дунджаар 33.0 мян.т улаанбуудайн үлдэгдэл нөөцтэй. Бэлэн бүтээгдэхүүний агуулахад гурил 2024 оны эхний хагас жилд дүүрч, үйлдвэрлэл 1-1.5 сарын хугацаанд сул зогсолт хийсэн. Үр тарианы агуулахын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр 2024 онд Өег гурил 10000 мян.т-ын багтаамжтай ангор шинээр барьж байна.<br>Үйл ажиллагаа явуулж буй 6 сүү боловсруулах үйлдвэрт 3 жилийн дунджаар жилд 3.8.тн-4.0 тн хуурай сүүний нөөцтэй, 2.7-3.0 мян.л шингэн сүүний эргэлттэй байна. Сүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлж, нөөц бүрдүүлэх, хадгалалтын горимыг мөрдүүлэхээр хөнгөлөлттэй зээлд хамрагдсанаар Дархан | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | цасхан сүү ХХК-д хөргүүртэй агуулах 1-ийг ашиглалтад оруулж, Эко милк ХХК-д ажлын байр, Ариун эх цацал ХХК, Одод бест милк ХХК-д техник, технологийн шинэчлэл хийсэн. Сүүний үйлдвэр 26 малчинтай гэрээ байгуулж, өвлийн улирлын сүүний нөөцийг нэмэгдүүлж, 24.5 мян.литр сүү хүлээн авч хамтран ажилласан.<br>Хаврын тариалалтанд шаардагдах буудайн үрийн нөөцийг 2021 онд 1.77 мян.т, 2022 онд 1.93 мян.т, 2023 онд 1.84 мян.т буудайн үр нөөцөлсөн. Дутагдаж байгаа үрийн тооцоо хийж, ХААДС-аас гэрээ байгуулан тариалан эрхлэгчдэд нийлүүлж, 2024 оны тариалалтыг хэвийн явуулсан ба үрийн хянан баталгаа хийж, жилд дунджаар 1.7-.1.9 мян.тонн, үрийн нөөц бүрдүүлэн ажиллаж байна.<br>**Үр дүн:** Улаан буудайн үлдэгдэл 33.0 мян.т буюу гурил 23.0 мян.т, 4.2 мян.т хуурай сүүний байнгын нөөцтэй. 2024 оны эхний хагас жилд гурилын агуулах дүүрсэн, илүүдэл гурилыг Улаанбаатар хот болон бусад аймгуудад нийлүүлж байна. Хаврын тариалалтад дунджаар 1.7-1.9 мян.т үрийн нөөц бүрдүүлж, хаврын тариалалтыг хэвийн явуулсан. | |
| 135 | 2.3.1.6. Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа шинжилгээнд суурилан, газар тариалангийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | 150.0 | УГТХ-с судалгаанд суурилсан “Бордоо” төслийг хэрэгжүүлсэн | УГТХ-с гаргасан 2-оос доошгүй шинэ нутагшсан сорт, зөвлөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ. | 50.0 | 0.0 | МУЗГ-аас хэрэгжүүлж буй “Хүнсний ногоо”, “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрүүд зэрэг хууль, эрх зүйн баримт бичгүүдийн заалт, зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “Төр, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлж, судалгааны ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх”-ээр тусгагдсан ба Монгол орны газар тариалангийн салбарыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ судалгаа, үйлдвэрлэл хосолсон үйл ажиллагааг УГТХ-тэй хамтран 2021-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн амжилттай хэрэгжиж дараах бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлээд байна. Үүнд: Улаан буудайн судалгаа үр үйлдвэрлэл 573.4 га-д хийж 609.3 тн ургац хурааснаас нутагшсан 5 сорт, эрт болцтой Дархан-131 сортын 10 тн үр, Дархан-160 сортын 2 тн, дунд болцтой Дархан-166 сортын 23 тн, Дархан-34 сортын 18 тн, дунд оройн болцтой Дархан-144 сортын 379 тн үр буюу нийт 432 тн элит үрийг үйлдвэрлээд байна. | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | ·Арвайн Шимт, Бурхант-1 сор, Тритикале-н үр нийт 16.8 тн<br>·Буурцагт таримлын Шар буурцагын 8,0 т, вандуйн 18.0 тн үр<br>·Төмсний Солист, Гала, Куарта сортуудын 123.5 тн элит үр үйлдвэрлэв.<br>·Гала, Солист, Куарта, Импала сортын бичил ургамлыг инвитро нөхцөлд гарган авч, тэдгээрийг хүлэмжид тариалж 60188 бичил булцуу хураан авав.<br>·Хүнсний ногооны 6 нэр төрлийн таримлын 8 сортын эх ургамал 5.5 тн, 3920 кг үрийг тус тус, хүнсний ногооны 7 төрлийн үр - 411.5 кг үр,<br>·Хүлэмжийн лооль-22500 ш, амтат чинжүү-8600 ш, Бэсрэг жимст лооль- 28500 ш үрийг тус тус үржүүлэв<br>·Хүрээлэнгийн жимсний секторт 3 төрлийн таримлын 6025 ш суулгац, Увсын салбарт 4 төрлийн таримлын 11900 ш суулгац, Генбанкийн секторт хөх далан хальсны 1000 ширхэг суулгац, нийт 18925 ш суулгац үйлдвэрлэв.<br>Дархан Ризо био шингэн бордоо 80 тн, Ризобактерийн хуурай бордоо 1000 кг-ыг тус тус үйлдвэрлэж тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд нийлүүлж, хөрсний үржил шимийг сайжруулах га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд хамтран ажилласан.<br>УГТХ-тэй хамтран 2021-2023 онд газар тариалангийн салбарт баримтлах бодлого, чиглэл, зөвлөмжийг хүргүүлэн таниулахаар “Тариаланчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан.<br>“Таримал ургалын үр үйлдвэрлэлийн тогтолцоог хөгжүүлэх боломж”-ийн талаар нээлттэй хэлэлцүүлгийг 2024.05.13-ны өдөр зохион байгуулсан. УГТХ мэдээлэл хийж, Улсын хэмжээнд сорт сорилын төв 4-ийг байгуулах хэрэгцээ шаардлага байгаа талаар ХХААХҮЯ-д саналаа уламжилсан. Жилд 350-380 мян.га-д буудай тариалж, 55-65 мян.тн үр үйлдвэрлэж байна. 1.0 тонн үр 6250 мян.төг-ний өртгөөр бүтдэг тооцоо гарсан. Нутагшсан сортын эх үр, супер элит үр үйлдвэрлэлийг Хонгор суманд 1000 га талбайд гүйцэтгэж байна.<br>**Үр дүн:** Нийт 4 жилийн хугацаанд УГТХ-д буудайн 5 сорт, арвайн 3 сорт, буурцагт таримлын 2 сорт, төмсний 3 сорт, хүнсний | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ногооны 6 нэр төрлийн 8 сорт, хүлэмжний лоолийн 3 сорт, жимс жимсгэний 3 нэр төрлийн 12 сортын үр үржүүлэг, цуглуулга судалгааны ажил хийгдсэн байна. Нутагшсан сортын эх үр, супер элит үр үйлдвэрлэлийг Хонгор суманд 1000 га талбайд гүйцэтгэж байна. | |
| 136 | 2.3.1.7. “Атрын IV аян” тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулж, үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | 650.0 | ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-118 тушаалаар “Атар-4” тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. | 50%-д хүрсэн байна. | 200.0 | 1140.0 | Хөрсний үржил шимийг хамгаалах, нөхөн сэргээх, үр сортын болон техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, мал аж ахуйг газар тариалантай зөв хослуулах замаар хөрсний үржил шимийг сайжруулж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариаланг хөгжүүлж, дотоодын хүнсний хэрэгцээг тогтвортойгоор бүрэн хангах зорилгоор "Атар-4" аймгийн дэд хөтөлбөрийг 2021-2024 он хүртлэх хугацаанд 6 зорилт 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 56 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 3.9 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдах бөгөөд эхний ээлжинд уг хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ-наас 890.0 сая.төг-ийн өртөг бүхий 10 ширхэг төмс, хүнсний ногооны иж бүрдэл техникийг зээлийн нөхцөлтэйгөөр хүлээн авч “Хөдөө аж ахуйн техникийн үйлчилгээний дундын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулан 2 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч 2022 онд Орхон суманд ажиллах үеэр техник үйлчилгээний дундын төвийн үйл ажиллагаа болон цаашид шаардагдах тоног төхөөрөмжийн судалгааг танилцуулснаар аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-аас ХБНГУ үйлдвэрлэсэн Weremczuk маркийн Лууван хураах комбайныг нэг бүрийг нь 288.7 сая.төг-өөр 2 иж бүрдлийг 2022, 2023 онуудад худалдан авч, ургац хураалтын ажилд хөнгөлөлттэй түрээсийн нөхцөлөөр ашиглуулж байна. 2023-2024 онуудад “Шинэ хөдөө төсөл”-ийг орон нутгийн түвшинд зохион байгуулж 3.0 тэрбум төгрөгөөр газар тариалангийн салбарт техник тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.<br>Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг хадгалах зоорины аж ахуйн хангамжийг нэмэгдүүлэхэд 1.2 тэрбум төгрөг зарцуулснаар | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | төмс, хүнсний ногооны зоорины багтаамж 2008 онд 6.0 мянган тонн байсан бол 2023 оны байдлаар 10.9 мянган тонн-д хүрч зоорины хангамжийг 60%-д хүргэсэн байна.<br>Монгол Улсын Засгийн газраас хөдөө аж ахуйг дэмжих хөнгөлөлттэй зээлийн төрлийг нэмэгдүүлэх зорилгоор газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих 2 жилийн хугацаатай, жилийн 6%-ийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг арилжааны 5 банкаар дамжуулан олгож эхэлсэн бөгөөд манай аймгаас нийт 2022 онд 107 аж ахуйн нэгжид 12.1 тэрбум төгрөг, 2023 онд 277 тариаланч 61.4 тэрбум төгрөгийн зээлд хамрагджээ.<br>ХХААХҮ-ийн Сайд, Сангийн сайдын 2022 оны А/218, А/146 дугаар хамтарсан тушаалаар “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох” журмын дагуу хүнсний ногооны урамшуулалд 2022 онд 129 аж ахуйн нэгж, иргэн 268.7 сая.төгрөг, 2023 онд 253 аж ахуйн нэгж, иргэн 2.5 тэрбум төгрөг, 2024 онд 317 аж ахуйн нэгж, иргэн 715.0 сая.төгрөгийн мөнгөн урамшуулал, 2024 оны урамшуулал олголт үргэлжилж байна.<br>2023 оны ургацаас улаанбуудайн урамшуулалд 29 аж ахуйн нэгж, иргэн 556.1 сая. төгрөгний урамшуулал авсан.<br>2024 онд ХХААХҮ-ийн Сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 14120 га-д үр тариа, 398 га-д төмс, 1550 га-д хүнсний ногоо, 3100 га-д тосны ургамал, 850 га-д малын тэжээл, 190 га-д жимс жимсгэнэ, нийт 20218 га-д тариалалт хийж, 20473 тонн буудай, 4774 тонн төмс, 34438 тонн хүнсний ногоо, 1550 тонн тосны ургамал, 2125 тонн малын тэжээл, 70 тонн жимс жимсгэнэ, нийт 63430 тонн ургац хураан авах зорилтыг дэвшүүлсэн.<br>Энэ жил урьдчилсан байдлаар 15689 га-аас 18755 тонн улаан буудай хураан авах төлөвтэй байна. Үүнээс 1805 тонныг нь ирэх оны тариалалтад,1500 тонныг нь үрийн нөөцөд, 1494 тонныг тэжээлд, 13881 тонныг гурилын үйлдвэрлэлд нийлүүлэхээр урьдчилсан байдлаар төлөвлөөд байна. Төмс 365 га-аас 4016,1 тонн буюу га-аас 110 цн, хүнсний ногоо 2063.2 га-аас 29916.4 тонн буюу га-аас 145 цн, тосны ургамал 2924.5 га-аас 818.9 тонн буюу | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | га-аас 2.8 цн, малын тэжээл 671 га-аас 1206.9 тонн буюу га-аас 18 цн ургац хурааж авах урьдчилсан тооцоог гаргалаа.<br><br>**Үр дүн:** Газар тариалангийн салбарт улс, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээр нийт 77.26 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтууд нь зохих үр дүнгээр ургац хураах техникийн 75%, зүтгэх хүчний техникийн 65%, механикжуулалтын түвшингийн 40%-ийг бүрэн шинэчилж, 2020 онтой харьцуулахад тариалсан тариалсан талбай 853.6 га-аар, хураан авсан ургац 9895.4 тн-оор өссөн байна. | |
| 137 | 2.3.1.8. “Хүлэмж” төслийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж, тариалалтын талбайг жил бүр нэмэгдүүлнэ. | 2022-2024 | ХБТХОХ,, Хүнс, хөдөө аж ахуйн газар | 615.0 | 148 аж ахуйн нэгж, иргэн 22498 $м^2$ талбайд хүлэмжийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. | Тариалсан талбай 6000 $м^2$-гаар нэмэгдүүлнэ. | 205.0 | 0.0 | Орчин үеийн дэвшилтэд техник, технологид тулгуурласан үйлдвэрлэл, сургалт, судалгаа, үрслэгээ бойжуулалт, хадгалалт, борлуулалтын сүлжээ бүхий жилийн дөрвөн улиралд ажиллах “1 га хүлэмжийн цогцолбор аж ахуй” төслийг боловсруулан 2021.06.24-ний өдрийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан төсөл дэмжигдсэн. Монгол улсын Ерөнхийлөгч ажиллах үеэр хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулахад шаардагдах 31.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын саналыг танилцууллаа. ХХААХҮЯ-ны захиалгаар Орхон суманд нийт 50000 $м^2$ талбайд өвлийн хүлэмжийн аж ахуйн цогцолбор байгуулахаар шийдвэрлэж, барилгын зураг төсвийг "Скэч" ХХК нь шилэн болон нарлаг хүлэмжийн цогцолбор аж ахуйн зураг төсөл, төсөв, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. 2024 онд хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг 14520 м2-р нэмэгдүүлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаснаас Шинэ хөдөө төслийн хүрээнд 82 ширхэг буюу 9840 м2 хүлэмжийг аймгийн Засаг даргын 2023 оны 01А/325 дугаар захирамжаар батлагдсан хүлэмж төсөлд хамрагдах иргэн, хуулийн этгээдэд тавигдах шалгуур олгох түр журмын дагуу Орхон суманд 33, Дархан суманд-11, Шарын гол суманд-8, Хонгор суманд 13, Орон нутгийн өмчийн газар 17 хүлэмжийг хүлээлгэн өгсөн байна. Дээрх нийлэг хальсан хүлэмж шинээр ашиглалтад орсноор шинээр 9840 м2-р нэмэгдэж нийт 32338 м2 талбайд хүлэмжийн аж эрхлэн явуулах боломжийг бүрдүүллээ.<br>ЖДҮХС-аас 2 аж ахуйн нэгжид 68 сая, ХХС-аас 1 аж ахуйн нэгжид 45 сая.төг-ийн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дэмжлэгүүдийг үзүүлсэн. НҮБ-ын ХААБ-тай хамтран "Их мориг" ХХК-д 1200 м2 талбай бүхий 1 тэрбум төгрөгний өртөгтэй орчин үеийн шаардлага хангасан гидропоник бүрэн автомат өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуйг байгуулахаар тендерт "Бат хүлэмж" ХХК шалгарч, зураг төсвийн дагуу барилгын ажлыг гүйцэтгэж байна. Энэхүү цогцолбор 2025 онд ашиглалтад орно.<br>**Үр дүн:** ЖДҮДС болон "Шинэ хөдөө" төслийн хүрээнд нийт 537.0 сая.төг-ийн хөрөнгө оруулалт хийгдсэн ба 9840 $м^2$ талбай бүхий 82 хүлэмжийг сумдаар дамжуулан олгосон нь нийт 32338 м2 талбайд хүлэмжийн аж эрхлэн явуулах боломжийг бүрдүүллээ. | |
| 138 | 2.3.1.9. Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээ, судалгаанд түшиглэн га-аас авах ургацын хэмжээ, тэжээллэг чанарлаг байдлыг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | 500.0 | УГТХ-тэй хамтран "Дархан үр" дэд хөтөлбөр, "Бордоо" төслийг хэрэгжүүлсэн. | Буудайн 2 цн/га, төмс 10-15 цн, хүнсний ногоо 20 цн-р нэмэгдүүлнэ. | 150.0 | 2.5 | Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд "Төр, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлж, судалгааны ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх"-р тусгагдаж энэхүү ажлын хүрээнд УГТХүрээлэнтэй 2021-2025 он хүртэл хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд эрдэм шинжилгээний байгууллагын судалгаанд үндэслэсэн 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Энэхүү ажлын хүрээнд 2021-2023 оны газар тариалангийн салбарт баримтлах бодлого, чиглэл, зөвлөмжийг хүргүүлэх таниулах зорилтын хүрээнд УГТХ-тэй хамтран "Тариаланчдын зөвлөгөөн"-ийг зохион байгууллаа. Мөн хөрсний үржил шимийг сайжруулах га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах Дархан "Ризо био шингэн бордоо"-г 80 тонн, Ризобактерийн хуурай бордоо 1000 кг-ыг тус тус үйлдвэрлэж тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд нийлүүлээд байна.<br>Үр тариа, төмс, хүнсний ногооны хянан баталгааг УГТХүрээлэнтэй хамтран жил бүр тогтмол зохион байгуулсанаар тариалалтыг чанарын шаардлага хангасан үрээр тариалах нөхцөл бүрдсэн байна.<br>Ургамал газар тариалангйн хүрээлнд тайлант онуудад нийт буудайн 5 сорт, арвайн 3 сорт, буурцагт тармлын 2 сорт, төмсний 3 сорт, хүнсний ногооны 6 нэр төрлийн 8 сорт, хүлэмжний лоолийн 3 сорт, жимс жимсгэний 3 | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нэр төрлийн 12 сортын үр үржүүлэг, цуглуулга судалгааны ажил хийгдсэн байна.<br>БНСУ, Найрамдал төсөл хамтран хоолны хог хаягдлаар органик бордоо үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг хэрэгжүүлж, Дархан-Уул аймаг дахь ХААИС-ийн Инчеон Инновацийн Био бордооны лабораторит хүлээлгэн өгч нээлт хийлээ. Үүнээс гадна цахилгаан машины хаягдал батарейг ашиглан цахилгаан нөөцөлж, цахилгаанаар хангах батарейг БНСУ анхдагчаар үйлдвэрлэж, сурталчиллаа. Энэ нь нарны зайн эх үүсвэрээр бол 2 цагт цэнэгээ хураана, цахилгаанаар цэнэглэхэд 1 цагт цэнэгээ хурааж, 2 өдрийн турш 220Вт-д ашиглах боломж бүрлдүүлсэн..<br>**Үр дүн:** 2020 оны гүйцэтгэлтэй харьцуулахад буудайн ургац 3.6 цн/га-аар, хүнсний ногоо 43.0 цн/га-аар, малын тэжээл 6.8 цн/га-аар нэмэгдсэн дүнтэй байна. Жил бүр 1900-2120 тонн буудайн үр буюу нийт шаардагдах үрээ бүрэн нөөцөлсөн байна. 100 кг хоолны хог хаягдлаар органик бордоог үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг ХААИС-ийн Инчеон Инновацийн Био бордооны лабораторит хүлээлгэн өгсөн. | |
| **2.3.2. Мал аж ахуй, туслах аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | |
| 139 | 2.3.2.1. Мал, амьтны гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ, боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | 150.0 | Сургалт, аялалд 2 хоршооны 400 гаруй гишүүд, махны 2 үйлдвэр, хамрагдсан. Мал амьтны гаралтай түүхий эдийн худалдааны төв Хонгор, Шарын гол суманд ажиллаж, нийт 120722 | Загвар хоршоодыг дэмжиж ажилласан байна. | 50.0 | - | Аймгийн бизнес регистрийн санд нийт 123 хоршоо бүртгэлтэйгээс 68 хоршоог шинэчилсэн бүртгэлд хамруулж, хөгжлийн түвшний үнэлгээг хийж, 2022 оны “Хоршооны хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд сургалт 6, спортын арга хэмжээ 1, туршлага судлах ажил 1, үзэсгэлэн 1, цуврал нэвтрүүлэг 1 тус тус төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, нийт 35 хоршоодын төлөөлөл 130 гаруй иргэдийг хамрууллаа.<br>ХХААХҮЯ-ны ХҮБХЗГ-аас зохион байгуулсан “Мал төхөөрөх, арьс шир эсгэлтгүй хуулах технологи”, Хөгжлийн Шийдэл ОУБ-ын Best хөтөлбөр, Эко ноос ХХК хамтран “Малчдын хоршоо-Үндэсний үйлдвэр түүхий бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт” сургалтад малчин хоршоодын 33 төлөөлөл хамрагдлаа.<br>Японы Ядуурлыг бууруулах сангийн хөрөнгөөр Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл” /МОН 91:92/-ийн хүрээнд 2 хоршооны 70 өрхөд 10 удаагийн сургалт зохион байгуулж, | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ширхэг арьс шир, ноос 208 тн, 129,1 тн ноолуур бэлтгэсэн. | | | | 397 иргэнийг хамруулж, Улаанбаатар хотод хүнсний ногоо худалдаалах Шимт ногоо цэгийг 2 байршилд байгуулж, борлуулалтыг дэмжиж, Орхон суманд хүнсний ногоо савлах үйлдвэр, 600 тонн зоорийн аж ахуйн барилга баригдлаа. Адра ОУБ Сэлэнгэ, Дарханы гол бүст орон нутгийн брэнд гаргах төсөл хэрэгжүүлэх судалгааны ажилд зориулж мал аж ахуй, газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой 30 хоршоо, Жайка төсөл, ХАҮТ-тай хамтарсан “Хөдөө Аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөөг боловсруулах төсөл”-д Тэс-Оргил ХХК-ийн мэдээлэл, Загвар хоршоо болон хөгжих боломжтой 53 хоршоодын санхүүжилтийн хэрэгцээ шаардлагатай судалгааг ЖДҮГ-т, Загвар хоршоог дэмжих ажлын хүрээнд Хонгорын бахархал хоршооны мэдээллийг яаманд, малын арьс шир боловсруулах Хужирт Минж ХХК-ийн төслийн хүсэлтийг банкинд тус тус хүргүүллээ.<br>Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг үзэсгэлэн худалдаанаас Баянзөгий хоршоо Улсын "Шилдэг хоршоо", Мөнхөд үржих зөгий хоршоо аймгийн "Шилдэг хоршоо"-гоор тус тус шалгарлаа. Хонгор сумын Шийрийн шугуй хоршоо, Дархан сумын Дархан Сэлэнгийн 3 үеийн дундын буян хоршоод Хөдөө аж ахуйн биржийн итгэмжлэгдсэн агуулахын гэрээ байгууллаа.<br>2023 оны “Бизнесийн хөгжлийг дэмжих жил”–ийн хүрээнд Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран хоршоодыг дэмжих хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл олгох сургалтыг 6 удаа зохион байгуулж, Дархан сум 195, Орхон суманд 17, Шарын гол сум 15, Хонгор сум 35 нийт 272 иргэд, хоршооны гишүүд хамрууллаа. Аймгийн ЗДТГ, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран “Хөдөлмөр эрхлэлт хамтын ажиллагаа зөвлөгөөн”-д 80 өрхийн үйлдвэрлэгч оролцож, 5 хоршооны гишүүн 25 иргэн бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргаж, танилцууллаа.<br>ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлээс 2 хоршоонд 98.8 сая.төг, ХХС-ийн хөнгөлөлттэй зээлээс 4 хоршоонд 115.9 сая.төг-ийн санхүүжилт олгож, 25 ажлын байр хадгалагдлаа. Тахианы аж ахуйн Хермоны шүүдэр ХХК-д 40.0 сая.төг-ийн зээлийг ЗБДС-ийн зээлд хамруулан олголоо.<br>Европын холбооны санхүүжилттэй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | "Найрамдал" төслийн III зорилтын хүрээнд Европ-Дарханы инновац, энтрепренершип төвтэй хамтран “Уур амьсгалын нөхцөлд тохирсон ухаалаг газар тариалан ба агропренершип” чадавхижуулах талбайн дадлага буюу туршлага судлах аялалд 35 өрхийн хүнсний ногоо тариалагчид болон хоршоод, оролцож, газрын гүний дулаан ашигласан өвлийн хүлэмж барих аргачлал, ажиллах зарчим болон агро аялал жуулчлалтай танилцууллаа.<br>БНСУ-ын Кёнги аймагтай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд Орхон, Хонгор суманд “Загвар хоршоо байгуулах төсөл”-ийг ТЭЗҮ-ийн хамт хүргүүлсэн ч хариу ирүүлээгүй. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвд хоршоодын үйл ажиллагааг дэмжих, хоршоолох идэвх санаачилгыг нэмэгдүүлэх зорилготой зөвлөх өрөөг ажиллуулж, иргэд, хоршоодод мэдээлэл өгч эхэллээ.<br>Шинэ хоршоо хөдөлгөөний нээлтийн арга хэмжээ Улаанбаатар хотод 78, бүсийн хэмжээнд 600 малчид хоршоод, төрийн байгууллагын төлөөлөл оролцуулан зохион байгуулж, цахим сургалтад 4 сумын мэргэжилтнүүд болон 25 малчин, сумдаар сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд Шарын гол сум, Хонгор сумын 120 гаруй малчид, иргэдтэй уулзалт хийж, мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллав.<br>Аймгийн хэмжээнд 5 хоршооны 12 малчин 390.0 сая.төг-ийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, шинээр 45 мал аж ахуйн хоршоо байгуулагдлаа.<br>**Үр дүн:** Сургалт 26, спортын арга хэмжээ 1, туршлага судлах ажил 2, үзэсгэлэн 2, цуврал нэвтрүүлэг 1 хийж, нийт 829 иргэнийг хамруулж, 14 хоршоонд 844.7 сая төгрөгийн зээл олгосон. Шинэчилсэн бүртгэлд 68 хоршоог хамруулж, 2 хоршоонд үйлдвэр, зоорийн барилга баригдаж, хоршооны зөвлөгөө өгөх танхим шинээр нээгдлээ. Шинээр 45 хоршоо байгуулагдлаа. Арьс шир түүхий эд бэлтгэн нийлүүлэгч 12 иргэн, аж ахуйн нэгжийн 1200м3 агуулах, арьс шир боловсруулах 2 үйлдвэр ажиллаж байна. | |
| 140 | 2.3.2.2. Өндөр ашиг шимтэй малын үрээр | 2020-2024 | ХБТХОХ, | 1120.0 | Өндөр ашиг шитэй | Мах-сүүний чиглэлийн аж ахуйг түшиглэн цэвэр, | 2022 онд 250.0 | 2021 онд ОНХС | Малын үржлийн ажил үйлчилгээний чиглэлээр 2020, 2021 онуудад аймгийн ИТХ, ХХААГ, МУСҮТ-тэй хамтран ажиллах “Санамж бичиг”- | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | орон нутгийн малын үйлдвэр угсааг сайжруулна. | | Хүнс, хөдөө аж ахуйн газар | | малын үрээр Хонгор сум 364 Сэлэнгэ үхэр, Орхоны 285 үхэрт зохиомол хээлтүүлэг хийж, 38.3 сая төг зарцуулсан.<br><br>2020 онд 649 үхэр, 2021 онд 120 үхэр, 600 хоньд зохиомол хээлтүүлэг хийсэн байна. | эрлийз, өсвөр үржлийн мал бойжуулан төрөлжсөн үйлчилгээг үзүүлнэ. | сая.төг | 25.0 сая.төг | ийн хүрээнд үржлийн ажил, үйлчилгээг хамтран явуулсан. 2021-2023 онуудад махны чиглэлийн үхэр үржүүлэх “Загвар аж ахуй” байгуулах, суурьшлын бүс байгуулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлсэн. Аймгийн хэмжээнд малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэх чиглэлээр малын хээлтүүлэгчийг сайжруулах ажлыг эрчимжүүлэн Хонгор сумаас малын тоо толгойн албан татварын санхүүжилт 25.0 сая.төг-өөр Архангай аймгийн “Орхимжит хайрхан” ХХК мал үржлийн нэгж шалгарч, МУСҮТ-ийн Увс аймгийн Баяд хонины үржлийн цөм сүргийн аж ахуйгаас 40 толгой төлгөн хуц, 30 толгой Өлгийн улаан ухна 30 толгой, Хонгор сум малын тоо толгойн албан татварын 70.0 сая.төг-өөр Ангус бух-5, Эделбай хуц-5, Суффолк хуц 5-ыг авснаар үржилд сайжруулагчаар тус тус ашиглуулсан. Ноёнхонгорт үйл ажиллагаа явуулж буй “Түмэн Монгол Суффолк” компани МУСҮТ-тэй хамтран мах-ноосны Суффолк, Бершон, Арманов, Мериннос хонь үржүүлж 700 хонинд туршилтын журмаар мах-ноосны хонины үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн.<br>ХХААХҮ-ийн Сайдын 2022 оны А/68 тоот тушаалаар “Тариалангийн бүс нутагт үржүүлж буй малд, үзлэг, ангилалт, ээмэгжүүлэлт, зохиомол хээлтүүлэгийн ажлыг явуулах” ажлыг зохион байгуулж, малын үржүүлэг, технологийн 4 нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлснээр 38% буюу 58270 толгой малыг ээмэгжүүлэн бүртгэлжүүлж, 85% буюу 24888 толгой малыг үзлэг, ангилалтад хамруулсан. Мэдээллийн нэгдсэн системд нийт 40978 толгой малыг бүртгэж, баяжилт хийсэн. Аймгийн хэмжээнд малын үржлийн ажил, үйлчилгээ явуулах чиглэлээр Дархан суманд “Мандах он” ХХК, “Билгүүт шанд” ХХК, Хонгор суманд “Хонгор үржил” ХХК, Шарын гол суманд “Хадат бөөгийн толгой” ХХК-тус тус үйл ажиллагаа явуулж байна. Ажил үйлчилгээ явуулж буй малын үржүүлэг, технологийн нэгжүүдэд мэдээлэл өгөх, мал аж ахуйн тендер болон сонгон шалгаруулалтад оролцоход нь технологийн зөвлөмж, техникийн тодорхойлолт боловсруулахад чиглэл өгч дэмжин хамтран ажилласан. ХХААХҮЯ-аас зохион байгуулж буй биотехнологийн дэвшилтэт технологийг орон | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | нутагт нэвтрүүлэх, малын үүлдэр, угсааг сайжруулах, өндөр ашиг шимтэй мах, сүү, мах-сүүний үхэр, хонь үржүүлэх чиглэлээр зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалтад Шарын гол сумын махны үхрийн “Агро таана” ХХК-ийн мал зүйч хамрагдаж мэргэжил, арга зүйгээр хангагдлаа. 2022-2023 онд МУСҮТ, ХХААГ хамтран зохиомол хээлтүүлгийн ажлыг явуулахаар гэрээ байгуулан “Нутаг академи” ХХК-ийн үржлийн нэгжээр гүйцэтгүүлэн ажилласан.<br>2023 онд Хонгор, Орхон, Шарын гол сумдын 560 үнээг хээлтүүлэгт хамруулан улсын төсвөөс 42.0 сая төгрөг зарцуулсан. Мөн малчдын хүсэлтээр 101 өрхийн үхэр сүрэгт генекологын үзлэг хийж ашиг шим, үүлдэрлэг байдлын чиглэлээр зөвлөгөө өгч ажилласан.<br>Биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажлын хүрээнд малын чанарыг сайжруулахаар Хонгор сумын Талын толгойн суурьшлын бүсийн малчдад зохиомол хээлтүүлгийн ач холбогдолын талаар мэдээлэл танилцуулга хийж ажилласан. 2021-2023 онуудад 2144 үхэр, 300 хонь, 100 ямаанд зохиомол хээлтүүлэг хийсэн. 2024 онд малын үржүүлэг технологийн “Мандах он” ХХК-тай гэрээгээр улсын төсвийн хөрөнгөөр 4 сумын 230 үхэрт өндөр ашиг шимтэй малын үрээр зохиомол хээлтүүлэг хийхээр ажиллаж, үүнээс 240 үнээнд үзлэг явуулж, 197 үнээнд зохиомол хээлтүүлэг хийгээд байна.<br>**Үр дүн:** 2021-2024 онд нийт 2341 үхэр, 300 хонь, 100 ямаанд зохиомол хээлтүүлсэн байна. Үүнд 65 хувь буюу 1393 толгой тугал, 75 хувь буюу 225 толгой хурга, 85 хувь буюу 85 толгой ишиг бойжуулсан байна. | |
| 141 | 2.3.2.3. Махны экспорт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж ажиллана. | 2020-2024 | ХБТХОХ | 6.0 | СХЗХ-ээс 2576.9 т мах экспортод гаргахаар тохирлын үнэлгээнд | Экспортын махны хэмжээг 121.5 т буюу 5%-иар нэмэгдүүлнэ. | 1.5 | 0.0 | Мах, махан бүтээгдэхүүнийг нэг цонхны бодлогоор алын тболомжийг судалж, хэрэгжүүлэх үүрэг бүхий ХХААХҮЯ-ны холбогдох газрын дарга нар, МЭЕГ, ХААБ, МХГ, Гаалийн байгууллага, Монголын махны холбооны төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг 2022-2023 онд махан бүтээгдэхүүний экспортын зураглал гаргаж, цахим системд шилжүүлэх, ил тод болгох, нэг цонхны бодлогод шилжүүлэх талаар хэлэлцэж шийдвэрлэснээр 2022-2023 онд ХХААХҮЯ цахимд шилжиж, стратегийн хүнсийг | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдаж, сертификат олгосноос Дархан меат фүүдс ХХК нийт 2431.7 т буюу 94.3%-ийн мах экспортолсон. | | | | экспортлох, импортлох зөвшөөрөл олгох систем http://eximp.mofa.gov.mn/ ашиглалтанд орсон.<br>“Дархан Меат фүүдс” ХХК, Дархан Эрдэнэ мах комбинат ХХК хоёр мал төхөөрөх үйлдвэр HACCP, ISO9001, ISO22000 стандарт нэвтрүүлсэн. Мах экспортлохоор бэлтгэл хангаж, хүсэлт гаргаснаар 2021, 2022 онд ХХААХҮЯ, МХЕГ, МЭГ-аас томилогдсон ажлын хэсэг экспортын хянан магадлагаагаар мах, махан бүтээгдэхүүн экспортлоход Мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн шаардлагыг хангаж байгаа эсэх, үйлдвэрийн бодит байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх хяналтыг хийж, зөвлөгөө өгч ажилласнаар амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын хэрэгжилт 100 хувь хангагдаж, дулааны аргаар боловсруулсан мах экспортод гаргах боломж бүрдсэнээр мах экспортлох ажлыг хийж байна.<br>Стандарт хэмжилзүйн хэлтсээс хүсэлтийн дагуу экспортод гаргах тохирлын үнэлгээг хийж, Дархан меат фүүдс ХХК сертификат олгосноор Казакстан, Узбекистан улс руу 2022 онд 192 тонн мах экспортод гаргасан. Энэ нь Засгийн газар БНХАУ-тай экспортын гэрээ хэлцэл түр хойшлогдож, мөн Ковидтой холбоотой БНХАУ-ын хил хаалттай, ОХУ-ын хил тодорхой хугацаанд хаалттай байсан нь тоо хэмжээнд нөлөөлсөн. 2023 онд Дархан меат фүүдс ХХК Узбекистан, БНХАУ, Иран улс руу нийт 86300.3 тонн махыг экспортод гаргалаа. 2024 онд Дархан меат фүүдс ХХК 1142.3 тонн махыг БНХАУ, Узбекистан улс руу экспортолоод байна. Дархан эрдэнэ мах комбинат ХХК-ийн үйлдвэр малын мах экспортлох хүсэлт гаргаж, дэмжигдээд байна.<br>**Үр дүн:** 4 жилийн төлөвлөлтөөр өссөн дүнгээр 2022-2024 онд нийт 724.5 т мах экспортлохоор төлөвлөсөнөөс гүйцэтгэлээр 2022 онд 192 т, 2023 онд 86300.3.т, 2024 онд 1142.3 т, нийт 87634.3 тонныг Казакстан улс руу адууны шулсан мах, Узбекистан улс руу үхрийн мах гулуузаар, Узбекистан улс, БНИУ-руу ангилж, савласан хонины мах, БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан мах махан | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүтээгдэхүүнийг экспортолсон. Энэ нь суурь онтой харьцуулахад 85.2 мян.т-оор нэмэгдсэн. | |
| 142 | 2.3.2.4. Өрхийн аж ахуй эрхлэгч иргэдийг бодлогоор дэмжиж ажиллана. | 2020-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | 1200.0 | Туслах аж ахуйн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. | Гахайн-2, шувууны-2, зөгийн-4 загвар аж ахуйг төрөлжүүлэн байгуулна. | 300.0 | 0.0 | Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд туслах аж ахуйг түлхүү хөгжүүлэх гахай, тахиа, зөгийн өрхийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 2021-2023 онуудад аймгийн Засаг даргын захирамжаар хотын төвөөс мал гаргах, туслах аж ахуй гахай, шувуу, зөгийн аж ахуй эрхлэгчдэд суурьшлын бүс байгуулах фермер, малчдыг дэмжих ажлыг зохион байгуулж ажилласан. Орхон сумын Ноёнхонгорын 15 га газарт туслах аж ахуй гахай, шувуу, зөгийн аж ахуйг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс дэд бүтэц татахад 190.0 сая.төг, өрөмдмөл худаг гаргахад 26.0 сая.төг зарцуулсан бөгөөд нийт 46 өрхөд газар олгосон. Мөн гахайн байр барихад төмөр замын дэр модыг хямдралтай үнээр олгож дэмжлэг үзүүллээ. 2020-2023 онуудад туслах аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр тахиа, зөгийний аж ахуй чиглэлээр 13 хоршоо, 5 аж ахуй үйл ажиллагаа явуулж, тахианы аж ахуйдад хоногийн настай дэгдээхий авч сүрэг сэлбэсэн байна.<br>Тахианы "Хермони шүүдэр" ХХК-д ЗБДС-ийн 40.0 сая.төг-ийн зээлд 2021 онд хамрагдаж, хоногийн настай өсвөр шувуу худалдан авсан ба 2022 онд Зөгийн аж ахуй "Ачлалт алтан зөгий" ХХК-д 30 сая.төг, "Бат ихэр заяа" ХХК-д ХСХ-ийн 26.0 сая.төг-ийн зээлэнд хамрагдаж, үйл ажиллагаагаа тус тус өргөтгөсөн. Мал аж ахуйн салбараас ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлд сүүний загвар аж ахуй "Ангир сартуул" ХХК 65 сая.төг, Дархан бөднө хоршоо 70.0 сая.төг, тахианы "Газар агуу" ХХК 290.0 сая.төг, "Билгүүт шанд хайрхан" ХХК-ийн үржлийн нэгж 135.0 сая.төг, "Шимт агро"ХХК-ийн тэжээлийн үйлдвэрийн төсөл 290.0 сая.төг, нийт 850.0 сая.төг-ийн зээлд хамрагдлаа.<br>Аймгийн ХХААГ, ХХҮГ хамтран Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас "Малжуулах төсөл"-д 10 өрхийг хамруулан нийт 50 сая.төг-ийн, ажлын байр дэмжих төсөлд зөгийн 1 аж ахуйд 10 сая.төг, сүү, цагаан идээ боловсруулах 2 иргэнд 17 сая.төг-ийн дэмжлэг тус тус үзүүлсэн байна.<br>УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд Арилжааны банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх "Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | болон хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл”-д мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй 69 малчин, фермер, аж ахуйн нэгжийн хүсэлт, судалгааг нэгтгэн ХХААХҮЯ-д хүргүүлсэнээр сүүний үхрийн чиглэлээр 1 иргэн 70.0 сая.төг, махны үхрийн аж ахуй эрхлэх чиглэлээр 2 фермер 510.0 сая.төг, зөгийн аж ахуйн чиглэлээр 7 аж ахуйн нэгж, иргэн 320.0 сая, тахианы аж ахуйн чиглэлээр 2 аж ахуйн нэгж 1250.0 сая төгрөгийн дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөтгөж, өрхийн аж ахуйн үйлдвэрлэл нэмэгдэхэд дэмжлэг боллоо.<br>2024 онд Дархан сумын шувууны “Газар агуу” ХХК нь ХХААХҮЯ-аас авсан зээлийн санхүүжилтээр 20.0 мянган толгой хоногийн настай дэгдээхэй авч сүрэг сэлбэн үржүүлж, ажлын байр нэмэгдүүлэн шувууны 1 байр шинээр барьсан бөгөөд бүрэн автомат тоног төхөөрөмж суурьлуулаад байна.<br>Дархан сумын гахайн “Зоосон хоншоорт” ХХК нь гахайн мах үйлдвэрлэлээр 2023 онд 11.6 тн мах, 2024 оны хагас жилийн байдлаар 6.5 тн махыг төвлөрсөн хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлээд байна. ХХААХҮЯамны харьяа МУСҮТөвөөс Дархан сумын 1 зөгийчинд 5 жилийн хугацаатай 10 бүл зөгийн түрээсийн гэрээний үндсэн дээр олгож дэмжлэг үзүүллээ.<br>ХХААХҮЯ-ны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024.04.03-ны өдрийн 08-00-04-21 дугаартай удирдамжаар төлөвлөгөөт шалгалтад 6 иргэний зөгийн аж ахуйг хамруулж, үйл ажиллагааг 8.40 кодтой “Зөгийн бал үйлдвэрлэлийг шалгах” хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд 3 бага, 3 дунд эрсдэлтэй дүгнэгдсэн. Шалгалтаар үйл ажиллагаа явуулах ажлын байргүй, хүнсний бүтээгдэхүүний шошго стандартын шаардлага хангахгүй, дотоод хяналт хангалтгүй зэрэг нийт 72 зөрчил илрүүлж, шалгалтын явцад илэрсэн зөрчлийн 36 буюу 50%-ийг арилгуулж, 3 иргэнд нийт 39 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлэв. ХБАБХТ хуулийн хэрэгжилт дундажаар 48.3%, ТХШТ хуулийн хэрэгжилт дундажаар 47.2%, зөгийн стандартын хэрэгжилт 94.6%-тай байна.<br>**<u>Үр дүн:</u>**<br>2022 онд 3704 гахай, 11 аж ахуйн нэгж, 122 өрхөд 3179 бүл зөгий, 3 фермерт 32480 шувуу тоологдсон нь 2021 онтой харьцуулахад гахай | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 90%, шувуу 119%-аар өсч, зөгийн бүл 19 %-аар буурсан.<br>2023 онд 69 өрхөд 1892 гахай, 3 аж ахуйн нэгж, 128 өрхөд 35212 тахиа, 9 аж ахуйн нэгж, 142 өрхөд 3690 бүл зөгий тоологдож, суурь онтой харьцуулахад гахай 95 хувиар буурсан, 7,7 хувиар тахиа, 13,8 хувиар зөгийн тоо, толгой өссөн үзүүлэлттэй гарсан боловч зөгий эрхлэгчдийн тоо цөөрсөн байна. Өрхийн аж ахуй эрхлэгч загвар аж ахуй нэгжийн тоо тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. | |
| 143 | 2.3.2.5. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ.<br>(Мал, амьтны гоц халдварт болон зооноз өвчнөөс бусад) | 2021-2024 | ХБТХОХ, Мал эмнэлгийн газар | Улс, орон нутгийн төсөв | 2019 онд 3 нэрийн халдварт өвчнөөр 60 голомтод, 270 тохиолдол бүртгэгдсэн. | Мал, амьтны халдварт өвчний голомт, тохиолдлын тоо суурь оноос 0.5-аас доошгүй хувиар буурсан байна. | 102.5 сая.төг | 26.7 сая.төг | **2021 он:** Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахдаа халдварт өвчний тархварзүйн сүүлийн 25 жилийн судалгаанд үндэслэн зөвхөн эрсдэл бүхий бүс нутгийн мал сүрэгт дархлаажуулалт хийхэд анхаарч хүртээмжтэй, оновчтой, үр дүнтэй байхаар тооцож, 11 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 440.0 толгой мал, амьтан хамруулахаас 453.8 мян.толгой малыг хамруулж, 41.0 сая төгрөгийн 1.2 мянган литр шингэн, 1.3 мянган тун хуурай вакцин зарцуулжээ. Энэхүү арга хэмжээнд вакцин худалдан авахад 20,4 сая төгрөг, тарилгын үйлчилгээний хөлсөнд **58,8** сая.төгрөг, нийт 79.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн.<br>Тухайн жилийн төлөвлөгөөг 102.9 хувиар биелүүлсэн дүнтэй байна.<br>**Хэрэгжилт 100 хувь**<br><br>**2022 он:** Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан 11 нэр төрлийн сэргийлэх дархлаажуулалтад 404.8 мянган толгой мал хамруулахаас, 411.1 мянган толгой малыг хамруулж, 1.2 мянган л шингэн, 1.3 мянган тун хуурай вакцин буюу 70.8 сая төгрөгийн вакцин эм бэлдмэлийг зарцуулжээ. Энэхүү арга хэмжээнд орон нутгийн төсвөөс вакцин худалдан авахад 33.2 сая төгрөг, тарилгын үйлчилгээний хөлсөнд 77.4 сая.төгрөг, нийт 110.6 сая төгрөгийг зарцуулан, хугацаанд нь төлөвлөгөөт арга хэмжээг 101.5 хувиар биелүүлсэн.<br>**Хэрэгжилт 100 хувь**<br><br>**2023 он:** Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, мал амьтны гоц | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд 12 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 444.4 мян.толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөж, 11 дүгээр сарын байдлаар 420.0 мян.толгой мал амьтныг хамруулж, 62.1 сая төгрөгийн 1.1 мянган литр шингэн, 1.3 мянган тун хуурай вакцин зарцуулжээ. Энэхүү арга хэмжээнд вакцин худалдан авахад 42.2 сая төгрөг, тарилгын үйлчилгээний хөлсөнд 77.9 сая.төгрөг, нийт 120.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн.<br>2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар 94 хувь байна.<br>**Хэрэгжилт 100 хувь**<br><br>**2024 он:** Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд 2024 онд мал, амьтны халдварт өвчин /боом, цусан халдварт, дотрын халдварт хордлого, шөвөг яр, сахуу, гахайн мялзан, гахайн цусан халдварт, галзуу, дуут хавдар,бруцеллез/-өөс сэргийлэх дархлаажуулалтад 336.3 мян.толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөн 08 дугаар сарын байдлаар 286.2 мян.толгой мал амьтныг хамруулж, 96.2%-ийн гүйцэтгэлтэй.<br>**Хэрэгжилт 100 хувь**<br><br>**Үр дүн:** 2021-2024 онуудад 12 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад жил бүр дунджаар 431.6 мянган толгой мал хамруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухайн жилийн 3 дугаар сараас эхлэн технологит хугацаанд зохион байгуулж, тайлан дүн мэдээг холбогдох газруудад хүргүүлж хэвшсэн. Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд дархлаажуулалтын арга хэмжээнд хамрагдсан малын тоо, толгой, тарилгын нэр, төрөл, зарцуулсан эм биобэлдмэлийн хэмжээ, үйлчилгээ үзүүлсэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн мэдээллүүдийг оруулж, цахим санд тогтмол баяжуулалт хийсэн. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Мал сүргийн 10-иас доошгүй хувийг өвчний шинж тэмдэгт суурилсан идэвхгүй тандалт, эрт илрүүлгийн үзлэгт хамруулснаар мал амьтны гоц халдварт, халдварт өвчин гарах, тархах эрсдэлээс урьдчилан сэргийлж байна. Үзлэг, тандалтаар ямар нэгэн өвчний сэжигтэй тохиолдол илрээгүй.<br>Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг товлолын хугацаанд нь хэрэгжүүлсний үр дүнд мал амьтны гоц халдварт өвчин гараагүй, харин нь халдварт өвчний гаралт 2021, 2022 оноос 40 хувиар буурсан үзүүлэлттэй байна. | |
| 144 | 2.3.2.5. Жил бүр 10,0 мянган малыг зооноз өвчний тандалт шинжилгээнд хамруулж, малаас хүнд халдварлах өвчний эрсдэлийг бууруулна. | 2021-2024 | ХБТХОХ, Мал эмнэлгийн газар | Улсын төсөв 87.0 | 2460 Бруцеллёзын халдварлалт 0,3 хувь | Зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэрэгжүүлж бруцеллёзын халдварын түвшин 0.02%- иар буурсан байна. | 20.0 | | **2021 онд** саалийн үнээ, хээлтүүлэгч /адуунаас бусад/ малд бруцеллёз өвчний тархалтыг тогтоох, үхрийн сүрьеэ, лейкоз өвчнөөр эрүүлийг баталгаажуулах шинжилгээнд 7.1мян.толгой саалийн үнээ, 0.4 мян.толгой эм хонь, 1.8 мян.толгой богийн хээлтүүлэгч, нийт 9.3 мян.толгой мал шинжилгээнд хамруулсан. Өвчний халдварлалтыг тогтоох тандалт шинжилгээний зардалд улсын төсвөөс 8.9 сая төгрөгийг зарцуулсан.<br>Бруцеллёз өвчний шинжилгээнд хамрагдсан үнээний 0,47 хувь, хуцны 0,2 хувь нь эерэг урвалтай гарсан байгааг 2020 оны өвчлөлтэй харьцуулахад бруцеллёзын халдварлалтын түвшин 0.02%- иар буурсан.<br>**Хэрэгжилт-100 хувь**<br>**2022 онд** шүлхий, бог малын мялзан өвчин, үхрийн арьс товруутах өвчин, хонь, ямааны цэцэг, үхрийн сүрьеэ, лейкоз, бруцеллёз өвчний шинжилгээнд өссөн дүнгээр 8.2 мянган толгой мал хамруулсан.<br>Бруцеллёзын шинжилгээнд 1.5 мян.толгой хээлтүүлэгч, 0.3 мян.толгой үнээг хамруулахад халдварлалтын хувь 0,2%-тай байв. Бруцеллёзын халдварлалтын түвшин 0.2%- иар буурсан байна.<br>Үхрийн сүрьеэ, лейкоз өвчнүүдээр тайван бүс болох нь батлагдсан. Өвчний халдварлалтыг тогтоох тандалт шинжилгээний зардалд улсын төсвөөс 6.4 сая төгрөгийг зарцуулсан.<br>Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд халдваргүйтгэлийн тусгай зориулалтын автомашин /Фотон маркын 5 тн- | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ын багтаамжтай, туулах чадвар сайтай/-ыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар /85 сая төгрөг/ худалдан авч, халдваргүйтгэлийн арга хэмжээг хэрэгжүүлснээр өвчлөлийг бууруулахад эергээр нөлөөлсөн.<br>**Хэрэгжилт- 100 хувь**<br>**2023 он:** зооноз өвчний тандалт шинжилгээнд 6.7 мянган толгой мал хамруулахад , 0.1 хувь нь бруцеллёз өвчний эерэг урвалтай буюу өвчний халдварлалт өмнөх оноос 0.1%- иар буурсан байна.Өвчний халдварлалтыг тогтоох тандалт шинжилгээний зардалд улсын төсвөөс 7.3 сая төгрөгийг зарцуулсан.<br>Зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжийг давхардсан тоогоор 389 малчин, мал бүхий иргэд хүргэж, малаас хүнд халдварладаг өвчний хор уршгийг тайлбарлан таниулав.<br>**Хэрэгжилт-100 хувь**<br><br>**2024 он:** Үхрийн сүрьеэ, лейкоз өвчингүй, тайван бүсийг баталгаажуулах, малаас хүнд халдварлах бусад зооноз / бруцеллёз, лейкоз, сүрьеэ, адууны ям/ өвчний халдварлалтын түвшинг тогтоох зорилгоор аймгийн Засаг даргын захирамж дагуу тандалт шинжилгээг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 6 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тандалт шинжилгээнд 17500 толгой үхэр , 330 толгой адуу хамруулахаар төлөвлөснөөс 08 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар саалийн 8711 үнээ, 146 толгой адуунаас цусны дээж авч шинжилгээд хамруулаад байна.<br>Мөн зах зээлд борлуулагдаж буй сүү, сүүн бүтээгдэхүүнээс 115 дээж авч бруцеллёз өвчний шинжилгээ хийж гүйцэтгэв.<br>**Үр дүн:** Зооноз өвчин /бруцеллёз, үхрийн лейкоз, сүрьеэ/ -ний тандалт шинжилгээнд 2021 онд 9.3 мян.толгой мал, 2022 онд 8.2 мян.толгой мал, 2023 онд 6.7 мянган толгой мал хамруулан, тандалтын цахим системд шинжилгээний үр дүн, мэдээллийг байршуулж, цахим санд баяжилт хийсэн.<br>2021 онд бруцеллёз өвчний шинжилгээнд хамрагдсан үнээний 0,47 хувь, хээлтүүлэгч малын 0,2 хувь нь эерэг урвалтай гарсан бол 2022 онд бруцеллёзын шинжилгээнд хамрагдсан үнээний 0.2 хувь, 2023 онд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бруцеллёз өвчний шинжилгээнд хамрагдсан үнээний 0.1 хувь нь эерэг урвалтай, 2024 онд бруцеллёз өвчний шинжилгээнд хамрагдсан үнээний 96 цусны дээж эерэг урвал /өвчтэй/ үзүүлсэн бөгөөд эдгээр дээжүүдийг баталгаажуулах шинжилгээнд УМЭАЦТЛабораторит хүргүүллээ.<br>Дархан-Уул аймаг үхрийн сүрьеэ, лейкоз өвчингүй, тайван бүс болох нь батлагдсан. | |
| 145 | 2.3.2.5. Мал эмнэлгийн лабораторийн мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээ, баталгаажуулалт хийх чадавхыг нэмэгдүүлэн, итгэмжлэлийн хүрээг өргөтгөнө. | 2021-2024 | ХБТХОХ, Мал эмнэлгийн газар | Улсын төсөв 160.0 | Итгэмжлэлд хамрагдсан байна. 2 ажилтанг урт, дунд хугацааны сургалтад хамруулна. | Багаж төхөөрөмжийн шинэчлэл, урсгал засвар, 2 ажилтанг урт, дунд хугацааны сургалтад хамруулна. | 50.0 | | **2021 он:** Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл бүс орон нутгийн хэмжээнд нэмэгдэж байгаа тул бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, худалдааны чөлөөт байдлыг хангах, мал эмнэлгийн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үл тохирлыг арилгах, итгэмжлэлд хамрагдах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд нийт 24.0 сая төгрөгийг, үүнээс шинжлэгч 2 эмчийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад 0.2 сая төгрөг , оношлуур, эм урвалж, хэрэглэгдэхүүнээр хангахад 23.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан.<br>Үүний үр дүнд Сорил болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага стандартын дагуу ҮЛ ТОХИРОЛГҮЙ үнэлэгдэж, 2 жилийн хугацаатай итгэмжлэлийн эрх авч, экспортын бүтээгдэхүүнд шинжилгээ, баталгаажуулалт хийхээр итгэмжлэлийн хүрээг өргөтгөв.<br>**Хэрэгжилт-100 хувь**<br><br>**2022 он:** Аймгийн мал эмнэлгийн газрын лаборатори нь малын халдварт өвчнүүдийн оношилгоо, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн /мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур, өндөг/-ний 8.5 мянган дээжид магадлан шинжилгээг хийж, хүнсний болон боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн чанар аюулгүй байдлыг хангасан тухай дүнг гаргаж, 119 худалдаа эрхлэгч, 5 үйлдвэрийн газарт хариуг хүргүүллээ. Тухайн онд лабораторийн оношлуур, эм урвалж, хэрэглэгдэхүүн, багаж, тоног төхөөрөмжийг сайжруулахад 22.2 сая төгрөг зарцуулсан байна.<br>Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори, Мал эмнэлгийн хүрээлэн, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори зэрэг мэргэжлийн байгууллагуудаас 2022 онд зохион | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байгуулсан 2 удаагийн шинжилгээний ур чадварын хөтөлбөрт оролцож, **“Хангалттай сайн”** гэж үнэлэгдсэн. Мөн Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд “Мал эмнэлгийн лабораторийн хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, хэмжлийн эргэлзээг үнэлэх сургалт”-д лабораторийн эрхлэгч, ийлдэс судлалын шинжээч эмч нар оролцож, чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, ажлын байранд тавигдах чанар хангалтын шаардлагуудын талаар мэдлэг, ур чадваруудыг эзэмшлээ.<br>**Хэрэгжилт-100 хувь**<br><br>**2023 он:** Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээ баталгаажуулалт хийх чадавх, итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх хүрээнд оношлуур, эм урвалж, хэрэглэгдэхүүн, багаж, тоног төхөөрөмжийг сайжруулахад 26.3 сая төгрөг зарцуулсан байна. Үүний үр дүнд хүнсний нян судлалын шинжилгээнд ХРОМО агар, нян судлалын шинжилгээнд антибиотикийн мэдрэг үзэх, шимэгч судлалын шинжилгээнд гельминтийн өндгийг өсгөвөрлөн төрөл зүйлийн тодорхойлох зэрэг арга, аргачлалыг шинжилгээндээ нэвтрүүлэн итгэмжлэлийн хүрээг өргөтгөх бэлтгэл ажил хийгдэж, Үндэсний итгэмжлэлийн төвд лабораторийн итгэмжлэлийн эрхээ сунгуулах хүсэлтээ хүргүүлээд байна.<br>Лабораторийн шинжлэгч эмч нар цахим болон танхимын 12 удаагийн сургалтад хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн. Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори, Мал эмнэлгийн хүрээлэн, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори зэрэг мэргэжлийн байгууллагуудаас 2023 онд зохион байгуулсан 2 удаагийн шинжилгээний ур чадварын хөтөлбөр, шинжээч эмч нарын сургалт, итгэмжлэлийн бэлтгэл ажилд зэрэгт 1.0 сая төгрөг зарцуулаад байна.<br>**Хэрэгжилт-90 хувь**<br><br>**2024 он**: Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу итгэмжлэлийн тодорхойлсон хүрээг гоц халдварт өвчний молекул биологийн | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 6, зөгийн балны хүнсний нян судлалын 5 шинжилгээний аргаар тус тус өргөтгөсөн.<br>Лабораторийн шинжээч эмч нарын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Улсын Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораториос зохион байгуулсан 2 удаагийн цахим, 1 удаагийн танхимын сургалтад шинжээч эмч нарыг хамруулав.<br>**Үр дүн:** Бүс, аймаг, орон нутгийн хэмжээнд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, улмаар худалдааны чөлөөт байдлыг хангуулах зорилтын хүрээнд Мал эмнэлгийн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үл тохирлыг арилгах, итгэмжлэлд хамрагдах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.<br>Үүний үр дүнд MNS ISO/IES 17025 Сорил болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага стандартад заасны дагуу ҮЛ ТОХИРОЛГҮЙ үнэлгдэж, 2 жилийн хугацаатай итгэмжлэгдсэн.<br>Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори, Мал эмнэлгийн хүрээлэн, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори гэсэн газруудаас зохион байгуулсан шинжилгээний ур чадварын хөтөлбөрт оролцож **“Хангалттай сайн”** гэсэн үнэлгээг 2021, 2022, 2023 онд авсан.<br>Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандартын дагуу лабораторийн чанарын удирдлагын баримт бичиг, шинжилгээний арга аргачлалын нэр төрлийг нэмэгдүүлэн 4 дэх удаагаа итгэмжлэлд хамрагдаж, 4 жилийн хугацаатай буюу 2028 оны 03 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл итгэмжлэлийн тодорхойлсон хүрээнд сорилт гүйцэтгэх техникийн чадавхтай, лабораторийн чанарын менежментийн тогтолцоотой болохыг нотлох гэрчилгээгээ гардан авсан. | |
| 146 | 2.3.2.5. Сум бүрт малын гаралтай бүтээгдэхүүний чанарыг тодорхойлох, баталгаажуулах | 2022-2024 | ХБТХОХ, Мал эмнэлгийн газар | УТХО, төсөл, хувийн хөрөнгө оруулалт 55.0 | Сумдад малын гаралтай бүтээгдэхүүн ий | Хонгор суманд лаборатори байгуулна. | 15.0 | | **2021 он:** Аймгийн мал эмнэлгийн лабораторийг түшиглэн орон нутгийн нэгжүүдэд ажиллаж байгаа малын эмч нарыг мах, сүүнд ариун цэврийн шинжилгээ хийх, зарим төрлийн оношлох шинжилгээний арга зүйг эзэмшүүлэх /нян будаж харах, шимэгч хорхойн төрөл зүйл тодорхойлох, баасаас дээж авч өндөг | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | лаборатори байгуулна. | | | | чанарыг тодорхо йлох, баталгаа жуул ах лаборат ори | | | | илрүүлэх г,м/ сургалтуудыг жил бүр нэг удаа байгуулж, хүн амын хүнсэнд нийлүүлэгдэж буй мах сүүний чанар, аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүллээ.<br>Шарын гол, Хонгор сумдад анхан шатны мал эмнэлгийн лаборатори бэхжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмжийн судалгааг хийж, Цэцүүх, Монветмед, Синапс ХХК-наас нийлүүлэх 25 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслийн өртөг 80.0-100.0 сая.төгрөг байна.<br>**2022 он:** Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж "Мөнжөөлэй ХХК" нь 2022 оноос эхлэн эмчилгээ, оношилгоо, үйлчилгээнийхээ хүрээг тэлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн. Тус эмнэлгийн үйл ажиллагааг дэмжиж, оношилгоо, шинжилгээний хүрээг өргөтгөх, орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлж, Дархан сумын “Хоршоог хөгжүүлэх сан”-аас 50.0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлийг олгосон.<br>**2023 он:** Хонгор сумын ЗДТГазраас мал эмнэлгийн үйлчилгээний 4 нэгжийн оношилгоо, яаралтай тусламжийн багаж хэрэгслээр хангахад 19. 1 сая төгрөг зарцуулжээ.<br>Дархан сумын ЗДТГазраас мал эмнэлгийн 3 нэгжид 1.0 сая төгрөгийн, Орхон сумын ЗДТГазраас мал эмнэлгийн 2 нэгжид 0. 4 сая төгрөг, Шарын гол сумын ЗДТГазраас мал эмнэлгийн 1 нэгжид 1.0 сая төгрөгийг туслалцаа үзүүлсэн нь нэгжүүдийн ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг боллоо.<br>**2024 он:** Хүнсний аюулгүй байдлыг ханган, мал эмнэлгийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор мал эмнэлгийн ажил үйлчилгээний бүртгэл мэдээллийн сан болох Мал эмнэлгийн нэгдсэн системээр дамжуулан малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжээс бэлтгэн гарч буй мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн тодорхойлж, улсын байцаагчаар баталгаажуулан мал эмнэлгийн гэрчилгээг олгож ажиллаж байна.<br>2024 оны 08 дугаар сарын 22-ны байдлаар мал эмнэлгийн нэгдсэн системээр дамжуулан 2101 мал эмнэлгийн гэрчилгээ, 1566 магадлан шинжилгээний QR бүхий гэрчилгээ тус тус | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | олгогдсон.<br>Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хийх шинжилгээний орчин үеийн багаж тоног төхөөрөмжийн судалгаа, тооцооллыг хийж, лабораторийн оношлох чадавхыг дээшлүүлэх, мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээний арга аргачлалыг нэмэгдүүлэх, малын гаралтай бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангах үүднээс төсөл боловсруулан, “Шинэ хөдөө” төсөл болон холбогдох газруудад хүргүүлээд байна.<br>Mercy corps төслийн нэгжээс боловсруулсан “Сумын мал эмнэлгийн нэг цэгийн үйлчилгээний лабораторид тавигдах техникийн шаардлага, зардал, үр ашгийн тооцоо” судалгаанд үндэслэн нэгжүүдэд байгаа тоног төхөөрөмж, хөрөнгийн судалгааг гарган, үр дүнг үндэслэн 2022 онд Шарын гол сумын Мал эмнэлгийн нэгжид малын гаралтай бүтээгдэхүүний чанарыг тодорхойлох лаборатори байгуулах судалгааг хийсэн.<br>Мөн сумдын мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь малын гаралтай бүтээгдэхүүний чанарыг тодорхойлох лабораторитой болж үйл ажиллагаагаа өргөжүүлж байна.<br>Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/04 тоот тушаалын дагуу мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээний QR код бүхий цахим гэрчилгээ олгох үйл ажиллагаа 2021 оны 2-р сараас эхлүүлж, Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд мэдээллүүдийг оруулж малын шилжилт хөдөлгөөнийг хянах, малын хулгайтай тэмцэх, мал эмнэлгийн үйлчилгээ, тайлан, мэдээ гаргах үйл ажиллагааг цахимжуулж, Дархан сумын “Мөнжөөлэй” мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, “Тээвэр-Дархан” ХК–ийн мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори нь мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн өрөө тасалгааг стандарт зааврын дагуу тохижуулан, малын түүхий мах, сүүнд мал эмнэлэг, ариун цэвэр магадлан шинжилгээг хийж QR код бүхий цахим гэрчилгээ олгох ажлыг эхлүүлсэн. 2021 оны байдлаар цахим системээр 2249 ш QR код бүхий цахим гэрчилгээ олгогдсон байна. Энэхүү цахим гэрчилгээний QR кодыг хэрэглэгчид гар утасны апплейкшинээр уншуулж тухайн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүтээгдэхүүний гарал үүслийг мэдэх боломжтой юм. **Хүрсэн түвшин: Сумдын мал эмнэлгийн лабораторитой болсон** **Үр дүн:** Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн лаборатори байгуулахад сумдын ЗДТГ-аас дэмжлэг үзүүлснээр сумдын эмч нар малын гаралтай бүтээгдэхүүний чанарыг тодорхойлох чадавхтай болсон. Аймгийн хүн амд эрэлт хэрэгцээтэй, шаардлагатай байгаа “Төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээний мал эмнэлгийн нэгж” бий болсон нь ард, иргэдийн тэжээж буй үүлдрийн нохой, муур, төрөл бүрийн амьтан, шувуу, усны амьтан, загас гэх мэт амьтныг эмчлэх, оношлох, асаргаа сувилгаа хийх, өвчнөөс урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг эмчилгээ, үйлчилгээний шинэ төрлийг нэвтрүүлсэн. | |
| 147 | 2.3.2.6. Махны чиглэлийн үхэр, хонины аж ахуйд махны гарц нэмэгдүүлэх үржил, селекцийн ажлыг эрчимжүүлнэ. | 2020-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | 1,900.0 | Эрчимжсэн мал аж ахуйн /ЭМАА/ хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Бэлчээрийн огтонотой тэмцэх ажлыг 60.0 мян.га-д явуулсан. о/тэмцэх-6 сая.төг, ЭМАА-406.5 сая төг. 2021 онд 180 тн ногоон | Таримал тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэн эрчимжсэн мал аж ахуйд нийлүүлнэ. | 207.8 | 0.0 | Орон нутгийн малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх үхэр-хонины махны гарц нэмэгдүүлэх, үржил селекцийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор махны чиглэлийн бух худалдан авах тендер зарлаж “Билүүт шанд хайрхан” ХХК шалгаран Гереформ үүлдрийн 4 бух нийлүүлж үржилд сайжруулагчаар ашиглаж байна. Мөн сумдад малын тоо, толгойн албан татварын хуримтлагдсан хөрөнгөөр үржлийн хээлтүүлэгчийг худалдан авч үржилд ашиглаж байна. Хонгор сум Баяд, Керей үүлдрийн хуц, Баяндэлгэрийн улаан үүлдрийн ухна нийт 60 толгой хээлтүүлэгчийг худалдан авахад 25.0 сая.төг зарцуулсан бөгөөд хээлтүүлэгчийн суурь байгуулан ажиллаж байна. Ноёнхонгорт үйл ажиллагаа явуулж буй Түмэн Монгол Суффолк” ХХК нь УБ хотын “Тайшир өргөө” ХХК-аас мах-ноосны Бершон, Суффолк, Арманов, Меринос үүлдрийн нийт 348 эр, охин хонь авч сүрэг сэлбэн үржүүлсэн.. ХХААХҮЯ-ны харъяа МУСҮТ Монгол улсад нутагшуулсан гойд ашиг шимт малын дуудлага худалдаа зохион байгуулсан бөгөөд Лимүзин, Ангус үүлдрийн 5 бухыг гэрээний үндсэн дээр авч үржилд сайжруулагчаар ашиглаж байна. 2022-2021 онд Эрчимжсэн мал ахуй эрхлэгчдийг дэмжих зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн 57.8 сая төгрөгийн хөрөнгөөр 180 тонн буюу 9000 боодол ногоон тэжээлийг бэлтгэн 2022 оны мал төллөлтийн үеэр 148 | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэжээл бэлтгэсэн. | | | | эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон малчдад олгож дэмжлэг үзүүлсэн.<br>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2019-2023 онуудад Монгол улсад “Тэжээлийн тогтвортой менежмент” төсөл хэрэгжиж, 2023 онд төслийн хаалтын зөвлөгөөнд аймгаас төлөөлөл оролцсон. Мал аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах зорилгоор тэжээл үйлдвэрлэлийн салбарын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, цаашид тогтвортой хөгжүүлэх, төлөвлөх талаар чиглэгдсэн дүгнэлтүүдийг орон нутгийн төлөөлөлтэй хэлэлцүүлэн зөвлөмж өгсөн. ЖДҮ-ийг дэмжих сангийн зээлэнд “Шимт агро” ХХК тэжээлийн үйлдвэр байгуулах төсөлд 290.0 сая.төг-ийн дэмжлэг авсан байна.<br>УИХ-ын 36-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХХААХҮЯ-аас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр тэжээлийн үйлдвэрүүдэд дотоодоос түүхий эд худалдан авахад эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл олголтод 1 аж ахуйн нэгж хамрагдан 66.0 сая.төг-ийн дэмжлэг авсан. Аймгийн хэмжээнд 2021 онд 942.5 га, 2022 онд 970 га, 2023 онд 850 га талбайд таримал тэжээл тариалсан. Таримал тэжээлийн чиглэлээр 2 аж ахуйн нэгжид нийт 356 сая төгрөгийн дэмжлэг, тусламж үзүүлсэн.<br>2024 оны хагас жилийн байдлаар ХХААХҮЯ-аас хөнгөлөлттэй нөхцөлөөр олгогдох мах-сүүний үхрийн болон туслах аж ахуйн үндсэн хөрөнгийн зээлийн дэмжлэгт хамрагдах хүсэлт ирүүлсэн нийт 12 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг дэмжиж ХХААХҮЯ-д уламжилсан байна. Малын үржил, селекцийн ажлыг сайжруулах ажлын хүрээнд 36 үнээнд өндөр ашиг шимтэй малын үрээр зохиомол хээлтүүлэг хийлээ.<br>ХХААХҮ-ийн Сайдын 2024 оны А/137 тоот тушаалын дагуу бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх зорилгоор Монгол үүлдрийн 40 толгой өсвөр хуц, 40 толгой өсвөр ухныг ялган төвлөрүүлэх нийлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үржлийн малын стандартын шаардлага хангасан богийн хээлтүүлэгчийг сонгох ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.<br>**Үр дүн:** Аймгийн малын сүргийн тоо, толгой сүүлийн 3 жил тогтвортойгоор 11-16 хувиар | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | буурсан үзүүлэлттэй байна. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай мал аж ахуйг хөгжүүлэх, нэг малаас ашиг шимийг нэмэгдүүлэх, үүлдрийг эрчимжүүлэн сайжруулах, бэлчээрийн даацад тохируулан газрыг ашиглах, сайжруулах, хамгаалахад анхаарч байна.<br>Аймгийн хэмжээнд нийт цэвэр, эрлийз нутгийн шилдэг омгийн малын тоо нийт мал сүргийн 24.9 хувь буюу 54.1 мянган толгой мал байна. Нийт мал сүргийн 17,6 хувь буюу 46008 толгой үхэр тооллогдсон байна.<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн хур системийн хөгжүүлэлтийг хийгээд 2 жил болж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд баталгаажсан үүлдэр, омгийн 23.4 мянган толгой малыг ялган тэмдэглэн, ашиг шимийн үзүүлэлтийг тодорхойлон бүртгэсэн байна.<br>Үржил, селекцийн ажлыг эрчимжүүлснээр нэг малаас гарах махны гарц бух 350-450 кг, хуц 50-65 кг, ухна 45-60 кг, дунджаар шүдлэн насны үхэр 180-220 кг, хонь 30-35кг, ямаа 25-35 кг-ын гарцтай байна.<br>Үүнтэй холбогдуулан намрын технологийн ажлын хүрээнд аймгийн хэмжээний нийт 261.8 мянган толгой малыг малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлж, үнэлэх, баталгаажсан үүлдэр омгийн малд үзлэг, ангилалтын ажлууд үргэлжлэн хийгдэнэ. | |
| **2.3.3. Худалдаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, цахим үйлчилгээг нэвтрүүлнэ.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 148 | 2.3.3.1. Согтууруулах ундаа худалдан борлуулж түгээр үйлчилдэг ААН-үүдэд 2 жилд 1 удаа аттестатчилал явуулна. | 2021-2024 | ХБТХОХ | - | Аттестатчилалд нийт 380 худалдаа, үйлчилгээний газар буюу хүнсний дэлгүүр 287, баар, кафе, зоогийн газар 92-ыг хамруулж, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, цуцлах саналыг шийдвэрлүүлсэн. | Стандарт хэрэгжилтийн шалгалтын 2 удаа хийнэ. | - | - | Аймгийн Засаг даргын 2022 оны №01-А/06, 07, 43, 125 захирамжаар тусгай зөвшөөрлийг согтууруулах ундаа худалдаалах 314, түгээр үйлчлэх 98, нийт 412 аж ахуйн нэгжид олгож, 5 аж ахуйн нэгжийг цуцалсан. Дархан-Уул аймагт ХХААХҮЯ-ны сайдын “Норматив тогтоох тухай” 2020.08.19-ны өдрийн А/272 тоот тушаалаар согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, нийслэл, суманд 1000 хүн ам тутамд 4 хүртэл байхаар тогтоосон нормын мөрдөлт 2020 онд 8, 2021 онд 9-аар их, 2022 онд 7-оор бага, өмнөх онтой харьцуулбал 11-ээр буюу 2.6 %-аар бууруулсан байна.<br>Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих хууль шинээр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр олгож, бүрдүүлэх материалын жагсаалтад өөрчлөлт орсон.<br>ХХААХҮ-ийн сайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хавсралтын 23 дахь заалтад тусгагдсаны дагуу согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг сар бүрийн 5-ны дотор ХХААГ-аас ХХААХҮЯ-д албан хүргүүлсэн.<br>Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах 319, үйлчлэх 101 тусгай зөвшөөрөл эзэмшигч байна. Архи, спирт үйлдвэрлэх, шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй үйлдвэр байхгүй.<br>**Үр дүн:** ХХААХҮС-ын баталсан норматив хэмжээгээр Дархан-Уул аймгийн хүн амд 434 тусгай зөвшөөрөл олгох боломжтойгоос 420 согтууруулах ундаа худалдах, түгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Үүнд Дархан суманд 352 Орхон суманд 11, Хонгор суманд 20, Шарын гол суманд 37 тусгай зөвшөөрөл олгогдсон байна. | 100% |
| 149 | 2.3.3.1. Худалдаа, нийтийн хоолны салбарын ААН-үүдийг шаардлагатай стандартын сургалтыг явуулна. | 2021-2024 | ХБТХОХ, Стандарт, хэмжил зүйн хэлтэс | - | MNS 5021-1:2019”, MNS 4946:2019” стандартын сургалтыг 6 удаа зохион | Стандартын сургалт 2 удаа явуулж Стандартын дундаж үнэлгээг 87% хүргэнэ. | - | Тэмцээн, уралдааны зардал аж ахуйн нэгж, ажилтны хөрөнгө | **2021 онд** тохирлын гэрчилгээ авах хүсэлт ирүүлсэн хүнсний худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч 161 аж ахуйн нэгж, иргэний үйлчилгээнд тохирлын үнэлгээг хийж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, стандартын хэрэгжилтийг 86 ба түүнээс дээш хангуулж гэрчилгээг олгосон.<br>Шинээр болон шинэчлэн батлагдсан стандартыг мэдээлэх, сурталчлах зорилгоор аймгийн ХХААГ, "Хөгжлийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулж, 243 худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч нарыг хамруулсан. Стандарт хэрэгжилтийн дундаж түвшин 85% байна. | | | | шийдэл" олон улсын байгууллагын "BEST" хөтөлбөртэй хамтран 2 удаагийн цахим сургалт, чанарын менежмент тогтолцооны танхимын сургалт -1 удаа нийт 89 иргэн, аж ахуй нэгжийг хамруулан, салбарын хууль, дүрэм журам холбогдох стандартуудаар материалыг бэлтгэн танилцууллаа.<br>**2022 онд** шинээр болон шинэчлэн батлагдсан стандартыг мэдээлэх, сурталчлах зорилгоор 19 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, нийт 1050 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан, салбарын хууль, дүрэм журам, холбогдох 3 төрлийн стандартаар мэдээлэл бэлтгэн танилцууллаа. Мөн цахимаар MNS 5021-1:2019, MNS 4946:2019, MNS 5760:2020 стандартуудаар зөвлөмж бэлтгэн онлайнаар хэрэглэгчдэд түгээж, 150 гаруй иргэн, аж ахуй нэгжийн хандалт авлаа.<br>**2023 онд** тохирлын гэрчилгээ авах хүсэлт ирүүлсэн хүнсний худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч 204 аж ахуйн нэгж, иргэний үйлчилгээнд тохирлын үнэлгээг хийж, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан гэрчилгээг олголоо.<br>Орхон, Хонгор, Шарын гол сумын хүнсний худалдаа эрхлэгч нийт 31 иргэнд "Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 5021-1:2019 стандартаар сургалт, мэдээлэл хийлээ.<br>**2024** онд тохирлын гэрчилгээ авах хүсэлт ирүүлсэн хүнсний худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч 130 аж ахуйн нэгж, иргэний үйлчилгээнд тохирлын үнэлгээг хийж, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан гэрчилгээг олголоо.<br>Стандартын хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх жил, "Стандарттай Монгол" нөлөөллийн аяны хүрээнд Хонгор сумын төвд болон Салхит багт хүнсний худалдаа эрхлэгч 19 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлд 2024.04.04, 2024.04.08-ны өдрүүдэд Жижиглэн худалдааны газар, | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | түүний үйлчилгээ ерөнхий шаардлага MNS 5021-1:2023, Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошгололтод тавих шаардлага MNS 6648:2016 стандартуудаар, ШУТИС-ийн ДаТСургуультай хамтран сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 20 ажилтанд MNS 4946:2019 стандартуудаар нийт 4 удаа сургалт мэдээлэл хийлээ.<br>**Үр дүн: "Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Хэмжилзүйн тухай хууль, чанарын менежментийн тогтолцооны 9, MNS 5021-1:2019", MNS 4946:2019" стандартын 9 сургалтад нийт 1209 иргэнийг хамруулан зохион байгуулсны үр дүнд хүнсний худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгчдийн стандартын мэдлэг дээшилж, стандарт хэрэгжилтийн түвшин 89%-д хүрээд байна.** | |
| 150 | 2.3.3.1. Худалдаа үйлчилгээнд стандартчилал, тохирлын үнэлгээгээр дэмжлэг үзүүлэн баталгаажуулалт хийнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Стандарт, хэмжил зүйн хэлтэс | - | Засгийн Газрын 2018 оны 291-р тогтоолоор батлагдсан тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтад багтсан 15 нэр төрлийн 139 бүтээгдэхүүн, 9 нэр төрлийн | Тохирлын үнэлгээ хийх: Үйлчилгээ: 6 нэр 125 ААНБ<br>Бүтээгдэхүүн: 4 нэр төрөл 6 ААНБ<br>Экспорт: 2 нэр төрөл 2 ААНБ | - | - | **2021 онд** 17 ААН, иргэний 13 нэр төрлийн 82 бүтээгдэхүүн, 164 ААН, иргэний 7 нэр төрлийн 182 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг олгож, баталгаажуулалт хийлээ.<br>3 ААН, 1 иргэний 4 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортод гаргахаар хүсэлт гаргасны дагуу тухай бүр тохирлын үнэлгээг хийж 106ш сертификат олголоо. Үүнд:<br>- 41408 ш үхэр болон сарлагийн хөх шир<br>- 1945 т хагас боловсруулсан мах<br>- 20 т түүхий мах<br>- 23109 ш эсгий бүтээгдэхүүн<br>**2022 онд** 16 ААН, иргэний 11 нэр төрлийн 117 нэрийн бүтээгдэхүүн, 160 ААН, иргэний 9 нэр төрлийн 166 нэрийн үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг олгож, баталгаажуулалт хийлээ.<br>11 аж ахуйн нэгж, 1 иргэн 4 нэр төрлийн бүтээгдэхүүн экспортлохоор хүсэлт гаргасны дагуу тухай бүр үнэлгээг хийн БНХАУ, Итали, Турк Герман, Норвеги зэрэг 10 улс руу экспортын 67 ш гэрчилгээ олголоо. Үүнд:<br>-192 тонн мах | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 228 үйлчилгээний газрыг баталгаажуулж, гэрчилгээ олгосон | | | | -23967 ширхэг үхэр болон сарлагийн хөх шир<br>-103200 тонн төмрийн хүдэр<br>-56482 ширхэг эсгий бүтээгдэхүүн<br>**2023 онд** 20 ААН, иргэний 16 нэр төрлийн 147 бүтээгдэхүүн, 214 ААН, иргэний 9 нэр төрлийн 220 нэрийн үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг олгож баталгаажуулалт хийлээ.<br>8 аж ахуйн нэгж, 1 иргэний 5 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортод гаргахаар хүсэлт гаргасны дагуу тухай бүр тохирлын үнэлгээг хийж 518 ширхэг сертификат олголоо. Үүнд:<br>-Таймлесс ХХК 631 ширхэг эсгий бүтээгдэхүүнийг Норвеги улс руу,<br>-Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК 762607 т, Ган бөмбөлөг ундарга ХХК 34100 т, Феррум металл монголия ХХК 8400т, Хайрхантоб ХХК 6800т, Эйч Эс Эм Жи ХХК 13500т төмрийн баяжмалыг БНХАУ улс руу,<br>-Дархан меат фүүдс ХХК 86300,3т махыг Узбекистан, БНХАУ, Иран улс руу,<br>-Дархан минж ХХК 9105 ширхэг шириййг БНХАУ руу,<br>ХХЭ Н.Мөнгөнбаяр Монгол гэрийг тус тус экспортод гаргалаа.<br>**2024 онд** 19 ААН, иргэний 16 нэр төрлийн 142 бүтээгдэхүүн, 136 ААН, иргэний 7 нэр төрлийн 142 нэрийн үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг олгож баталгаажуулалт хийлээ.<br>16 аж ахуйн нэгжийн 5 нэр төрлийн бүтээгдэхүүнийг экспортод гаргахаар хүсэлт гаргасны дагуу тухай бүр тохирлын үнэлгээг хийж 407 ширхэг сертификат олголоо. Үүнд:<br>-Таймлесс ХХК 4970,2 кг эсгий бүтээгдэхүүнийг Норвеги, Солонгос улс руу, | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | -13 аж ахуйн нэгж 1123565 тонн төмрийн хүдэр болон төмрийн баяжмалыг БНХАУ рууБНХАУ улс руу,<br>-Дархан меат фүүдс ХХК 1342,3т махыг Узбекистан, Казакстан, БНХАУ улс руу,<br>-Дархан минж ХХК 19525 ширхэг ямааны арьсыг Итали улс руу,<br>-Алижан ХХК 14,5 тонн адууны гэдсийг Ккaзакстан улс руу тус тус экспортод гаргалаа.<br><br>**Үр дүн: давхардсан тоогоор 70 ААН-ийн 16 нэр төрлийн 479 бүтээгдэхүүний, 677 ААН, иргэний 9 нэр төрлийн 719 үйлчилгээний газарт баталгаажуулалт, 16 ААН, 1 иргэний 5 нэр төрлийн бүтээгдэхүүн экспортод гарахад 789 удаа тохирлын үнэлгээ хийж, баталгаажуулалтын зөвлөлийн хурлыг 42 удаа зохион байгуулж шийдвэрийн дагуу, нийт 1433 ш тохирлын гэрчилгээ олгосон байна.** | |
| 151 | 2.3.3.1. Худалдаа үйлчилгээнд дэмжлэг үзүүлэн хэмжил зүйн шалгалт тохируулга, баталгаажуулалт хийнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Стандарт, хэмжил зүйн хэлтэс | | Орчин цагийн үйлчилгээний шинэ төрөл болох захиалгат болон хүргэлтийн үйлчилгээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана. | Орчин цагийн үйлчилгээний шинэ төрөл, хэлбэрийг нэвтрүүлэхэд нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, судалгаа гаргана. | 5.0 | - | 2021 онд нийт 5079 ширхэг хэмжүүр, хэмжих хэрэгсэл баталгаажуулсан байна.<br>Үүнд:<br>Цахилгааны лаборатори: 2100 ш<br>Эзэлхүүн, хий шингэний лаборатори: 1556 ш<br>Механик, цулын лаборатори: 567 ш<br>Дулаан даралтын лаборатори: 856ш, нийт 5079 ширхэг хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийж, 18ш хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн байна.<br>2022 онд нийт 9164 ширхэг хэмжүүр, хэмжих хэрэгсэл баталгаажуулсан байна.<br>Үүнд:<br>- Цахилгааны лаборатори: 6107 ш<br>- Эзэлхүүн, хий шингэний лаборатори: 1332 ш<br>- Механик, цулын лаборатори: 813 ш<br>- Дулаан даралтын, эрүүл мэнд лаборатори: 912 ширхэг хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийсэн байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2023 онд нийт 10771 ширхэг хэмжүүр, хэмжих хэрэгсэл баталгаажуулсан байна. Үүнд:<br>- Цахилгааны лаборатори: 7397 ширхэг<br>- Эзлэхүүн, хий шингэний лаборатори: 1379 ширхэг<br>- Механик, цулын лаборатори: 839 ширхэг<br>- Дулаан даралт, эрүүл мэндийн лаборатори: 1042 ширхэг хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийж, 114 ширхэг хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн байна.<br>2024 онд нийт 15153 ширхэг хэмжүүр, хэмжих хэрэгсэл баталгаажуулсан байна. Үүнд:<br>- Цахилгааны лаборатори: 8537 ширхэг<br>- Эзлэхүүн, хий шингэний лаборатори: 5423 ширхэг<br>- Механик, цулын лаборатори: 632 ширхэг<br>- Дулаан даралт, эрүүл мэндийн лаборатори: 480 ширхэг хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийж, 81 ширхэг хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн байна.<br>**Үр дүн:** 2021-2024 оны хөтөлбөр хэрэгжих хугацаанд 41138 ширхэг хэмжүүр, хэмжих хэрэгсэл баталгаажуулсан байна. Үүнд:<br>Цахилгааны лаборатори: 24852 ш<br>Эзлэхүүн, хий шингэний лаборатори: 9783 ш<br>Механик, цулын лаборатори: 2835 ш<br>Дулаан даралт, эрүүл мэндийн лаборатори: 3311 ширхэг хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт, 359 хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийж, 148 хэмжих хэрэгсэлд хэмжих хэрэгслийг ашиглахыг хориглосон мэдэгдэл өгч, | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хэмжлийн нэгдмэл байдлыг хангуулан ажиллалаа. | |
| 152 | 2.3.3.1. Хэмжил зүйн лабораторийг анги нарийвчлал сайтай эталон хэмжих хэрэгслээр шинэчилнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Стандарт, хэмжил зүйн хэлтэс | 145,0 | - | Эталон 1 төрлөөр нэмэгдүүлнэ. | - | - | 2022 онд тус хэлтсийн хэмжилзүйн нэгдсэн лабораторид нэн шаардлагатай байгаа эталон төхөөрөмжийн судалгааг гаргаж байгууллагын 2022-2025 оны төсвийн төсөөлөлд тусгуулж, Стандарт хэмжилзүйн газар болон аймгийн ЗДТГ-т хүргүүлж ажилласны дүнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 30 сая төгрөгийн өртөг бүхий DC100, 500A, AC-500-1500A хэмжих хязгаартай амперклиш шалгах эталон төхөөрөмж, DC-0-1000V, AC-0-1000A, 0-10G, 0-10МОМ хэмжих хязгаартай мультметр шалгах эталон төхөөрөмж, 1G, 10G, 100G , 1T хэмжих хязгаартай HKW-03GB10 маягийн эсэргүүцлийн ороомгуудыг 2024 оны 1-р улиралд Стандарт хэмжилзүйн газраас шийдвэрлэж өглөө.<br>**2021-2024 оны Хөтөлбөр хэрэгжих хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар F2 ангийн багц туухай, 220г хэмжих хязгаартай жин, 20л багтаамжтай мерник, DC100, 500A, AC-500-1500A хэмжих хязгаартай амперклиш шалгах эталон төхөөрөмж, DC-0-1000V, AC-0-1000A, 0-10G, 0-10МОМ хэмжих хязгаартай мультметр шалгах эталон төхөөрөмж, 1G, 10G, 100G , 1T хэмжих хязгаартай HKW-03GB10 маягийн эсэргүүцлийн ороомгуудыг Стандарт хэмжилзүйн газраас шийдвэрлэж өгсөн.**<br>**Үр дүн: Эдгээр төхөөрөмжтэй болсноор өөрийн болон ойролцоох аймаг сумдын аж ахуйн нэгж байгууллагуудын цахилгааны нарийн хэмжүүрүүдийг шалгаж баталгаажуулж байна.** | 100% |
| 153 | 2.3.3.2. Худалдаа, үйлчилгээнд орчин цагийн үйлчилгээний | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж | 60.0 | Орчин цагийн үйлчилгээний шинэ | Орчин цагийн үйлчилгээний шинэ төрөл, хэлбэрийг нэвтрүүлэхэд нөлөөллийн арга | 5.0 | - | Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй 444 худалдаа, үйчилгээний байгууллага байна. Үүнээс хүнсний дэлгүүр 289, мухлаг 49, минимаркет 38, супермаркет 20, хайпермаркет 2, орчин цагийн ая тухтай дэлгүүр 9, агуулах | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэ төрөл, хэлбэрийг нэвтрүүлэн, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, цахим үйлчилгээг өргөжүүлнэ. | | ахуйн газар | | төрөл болох захиалгат болон хүргэлтийн үйлчилгээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана. | хэмжээ зохион байгуулж, судалгаа гаргана. | | | 17, зах 5, ШТС-ийн дэргэдэх дэлгүүр 2, махны төрөлжсөн дэлгүүр 13 байна. Сумдаар ангилбал Дархан сум 349, Шарын гол сум 53, Орхон сум 13, Хонгор сум 29 худалдаа, үйлчилгээний байгууллага байна. Үүнээс 1 супермаркет, 1 минимаркет хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлсэн байна. Орчин цагийн үйлчилгээний сүлжээ дэлгүүр болох CU, GS25, Ди-24, АМУ молл, зэрэг хэрэглэгчдэд үйлчилгээгээ ойртуулсан төрөлжсөн худалдаа, үйлчилгээний газар шинээр нэмэгдсэн.<br>Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудад хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлсэн 20 байгууллага байна. Орчин цагийн худалдааны стандартад нийцсэн 7 худалдаа, үйлчилгээний газар нэмэгдлээ. Үүнд: Хүнсний дэлгүүр 1, минимаркет 2, махны дэлгүүр 1, ая тухтай дэлгүүр 1, кофе шоп 1, түргэн хоол 1 /KFC/ нэмэгдсэн ба Хүслэн бөөний төв, Hi март дэлгүүр урсгал засвар хийж, үйлчилгээгээ сайжруулсан. Маргад бейкери шинээр үйлчилгээгээ эхлүүлж, Номин худалдааны төвийн шинэ салбарын барилга баригдсан.<br>Өрхийн үйлдвэрлэл, улирлын чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ, худалдаа эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор түрээсийн зардалгүй Худалдааны гудамжийг байгуулсан бөгөөд шаардлагатай асар майхны төсөв, нийлүүлэгчийн судалгаа зэргийг гарган Хас майхан ХХК-аас 83.0 сая төгрөгийн 24ш асар, Хаан гагнаас ХХК, Хатуу төмөр ХХК-аас 35.0 сая.төг-ийн ширээ нийлүүлэх гэрээг шууд худалдан авалтаар гүйцэтгэж, Найрамдал талбайд байршуулснаар 150 гаруй түр ажлын байрыг бий болгосон. Худалдааг хөдөлмөр халамж үйлчилгээний газар хариуцан ажиллуулж байна.<br>ХХААХҮЯ-аас төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийн шилдэг бүтээгдэхүүн, шинэ ургацын дээжийг нэг дороос, үйлдвэрийн үнээр хэрэглэгчдэд хүргэх зорилгоор “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл” нэгдсэн арга хэмжээ жил бүрийн 09 дүгээр сард Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагддаг арга хэмжээнд тус аймгаас 2021-2023 онд нийт давхардсан тоогоор 68 аж ахуй нэгж, иргэн оролцож, бүтээгдэхүүн үйлчилгээгээ | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | танилцуулсан.<br>Монгол улсад орчин цагийн худалдаа, нийтийн хоол, хоршооны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан салбарын яамны шагналаар нийтийн хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарт олон жил үр бүтээл, идэвх зүтгэлтэй, хөдөлмөрийн тогтвортой амжилт гарган ажилласан ажилтанд “Тэргүүний ажилтан” тэмдэг-55, “Жуух бичиг”-15, ХАҮТ, ХЭХХ-той хамтран худалдааны 100 жилийн ойн медалиар 800 хүнийг шагнаж урамшуулсан. Жижиглэн худалдаа, агуулахын худалдаа, ахуй үйлчилгээний салбар, хоршоодын дунд зохион байгуулсан спортын нөхөрсөг тэмцээнд 2022 онд нийт 8 багийн 56 хүн гар бөмбөг, 5 хүн ширээний теннисийн төрлөөр оролцсон. 2024 оны 3-р сард аймгийн ИТХ, ХХААГ, БТСГ хамтран Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт Эрсдэлгүй Дархан-IV аяны шилжин явах тугийг гардуулан өгч, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний нийт 30 гаруй багийн 300 гаруй тамирчид гар бөмбөг, шатар, ширээний теннисийн төрлөөр оролцож хамтын ажиллагаагаа өргөжүүллээ. 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр ЕБС, СӨБ-д хүнс нийлүүлдэг болон нийлүүлэх хүсэлтэй нийт 81 хүнсний чиглэлийн үйлдвэрлэл эрхлэгч болон сургууль, цэцэрлэгийн холбогдох ажилтнуудын хамруулан Ерөнхий гэрээ байгуулах замаар бүтээгдэхүүнийг цахим худалдаанд байршуулж, худалдан авах ажилллагааг зохион байгуулах талаар ойлголт олгосон.<br>**Үр дүн:** Хүнсний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 431 судалгааг шинэчилж гаргасан ба өмнөх онтой харьцуулахад худалдааны чиглэлийн үйлчилгээ 10,8%-иар өссөн байна. Худалдааны гудамд 24 ш асар түрээсийн зардалгүй Найрамдал талбайд байршуулснаар 150 гаруй иргэний түр ажлын байр бий болсон, орчин цагийн ая тухтай сүлжээ 9 дэлгүүр шинээр нэмэгдсэн. Хүргэлтийн үйлчилгээтэй 2 дэлгүүр, 20 хоол үйлдвэрлэлийн газар хүргэлтийн үйлчилгээ нэвтрүүлсэн байна. 2024 онд хүргэлтийн үйлчилгээ нэвтрүүлсэн 1 хоол үйлдвэрлэлийн газар, шинээр худалдаа үйлчилгээний 7 газар нэмэгдснээс орчин цагийн ая тухтай дэлгүүр 1 байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 154 | 2.3.3.3. Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг дэмжин хөгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Стандарт, хэмжил зүйн хэлтэс | 8.0 | “Төвийн бүсийн түншлэл -2021” үзэсгэлэн худалдааг амжилттай зохион байгуулсан. | Үзэсгэлэн худалдаа зохион байгуулж Брэнд-1 Шилдэг-2 бүтээгдэхүүн шалгаруулна. | 104.0 | 104.0 | 2008-2020 онд аймгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр шалгарсан аж ахуйн нэгж, бүтээгдэхүүний танилцуулга судалгааг сумаар гарган холбогдох газарт хүргүүлж, цахимд бүтээгдэхүүн үйлчилгээг байршуулан сурталчилж, аймгийн брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх “Нэг суурин–Нэг бахархал аян”-ыг зохион байгуулж, туршлага судлах аялал, “Дарханд үйлдвэрлэв” цахим ном, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх сургалт, шилдэг сав баглаа боодол бэлгийн багц шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж 2.0 сая төгрөг зарцууллаа.<br>“Эх орончи худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл-2021” цахим үзэсгэлэн, “Монгол-Японы-Эдийн Засгийн түншлэлийн үзэсгэлэн”, Улаанбаатар хотод “Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаа”-нуудад нийт 98 аж ахуй нэгж, иргэн оролцож, бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулж сурталчилж ажилласнаар 2021 онд “Шилдэг хоршоо”-оор Орхон сумын Орхон шимт ногоо хөрс хоршоо, 2022 онд Улсын тэргүүний шилдэг хоршоогоор "Баян зөгий” хоршоо, Орхон сум шилдэг сумаар, 2023 онд “Импортыг орлох шилдэг хүнс” номинацид Золбоо зөгийн бал тус тус шалгарч орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан ажилласан байна.<br>Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг ”Төвийн бүсийн түншлэл-Намрын ногоон өдрүүд”, “Хөдөлмөрийн яармаг”, “Цагаан сар” үзэсгэлэн худалдаануудад нийт давхардсан тоогоор 809 гаруй үйлдвэрлэгч хамрагдаж, 2.36 тэрбум гаруй төгрөгийн борлуулалт хийгдлээ.<br>2021 оны төвийн бүсийн шилдэг бүтээгдэхүүнээр Баян Балчир ХХК-ийн “Угааж ариутгасан өлгийн багц”, Мөнх Ундрам Хүнс ХХК-ийн “Sugar art бялуу”, аймгийн брэнд бүтээгдэхүүнээр Дархан цасхан сүү ХХК-ийн “Цасхан зайрмаг”, Төвийн бүсийн Түншлэл-2021 үзэсгэлэнгийн Гран при шагналаар Жүр Үр ХХК тус тус шалгарлаа.<br>2022 оны аймгийн брэнд бүтээгдэхүүнээр Улаанбаатар гурил ХХК-ийн Овъёостой гурил, шилдэг хүнсний бүтээгдэхүүнээр Дархан цасхан сүү ХХК-ийн Цөцгийтэй тараг, шилдэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүнээр “Хатан ивээл хайрхан” ХХК-ийн “Уулын гутал К-19” | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шалгарлаа.<br>2023 аймгийн брэнд бүтээгдэхүүнээр Хатан ивээл хайрхан ХХК Д-61 гутал, шилдэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүнээр Дархан ширэн урлал ХХК-ийн Ширэн бүс, шилдэг хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүнээр “Говь дүүрэн шим” ХХК-ийн “Гэр бүл талх” шалгарлаа.<br>Орон нутгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон худалдаа эрхлэгчдийг дэмжин Худалдааны гудамжийг Найрамдал талбайд гарган түрээсийн төлбөргүйгээр 150 гаруй хүний ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Хөгжлийн шийдэл ТББ-ын 5.9 сая төгрөгийн санхүүжилттэй цахим каталоги гаргаж, 4 салбарын 37 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг сурталчилж ажиллалаа.<br>**Үр дүн:** Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг үзэсгэлэн худалдаануудад 809 гаруй үйлдвэрлэгчид оролцож, 2.36 тэрбум гаруй төгрөгийн борлуулалт хийж, аймгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчилан, цахим каталоги гарган худалдаа, үйлчилгээг дэмжиж ажилласан. Аймгийн брэнд бүтээгдэхүүнээр Дархан цасхан сүү ХХК-ийн цасхан зайрмаг, Улаанбаатар гурил ХК-ийн овъёостой гурил, Хатан ивээл хайрхан ХХК-ийн D-61 загварын гутал шалгарч, 3 брэнд бүтээгдэхүүнээр нэмэгдлээ. | |
| 155 | 2.3.3.4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Орон нутгийн өмчийн газар | - | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр дотоодын үйлдвэрээс 80 төрийн байгууллага 2051.2сая төгрөгийн жагсаалтад байгаа | Хууль тогтоомжийг сурталчлах сургалт зохион байгуулах, мэдээ тайлан гаргана. | - | 2,303,1 сая төгрөг | Жижиг, дунд үйлдвэрийн газраас “Эх оронч худалдан авалт-Үндэсний үйлдвэрлэл-2021” цахим үзэсгэлэн худалдаагаар оюуны өмч, экспортын боломж, бараа бүтээгдэхүүний сурталчилгаа, сургалтын үйл ажиллагаануудыг цахимаар сурталчлан ажиллаж, орон нутгаас 8 аж ахуйн нэгжийг оролцууллаа. Хөгжлийн шийдэл ОУБ-тай хамтран төрийн худалдан авалт, “Хөдөлмөр эрхлэлт ба хамтын ажиллагаа бидний оролцоо” сэдэвт бизнес эрхлэгчдийн форум, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйл ажиллагаа явуулж байгаа төр, хувийн хэвшлийн байгууллагуудын “Боловсролын ажилтны зөвлөгөөн”-д “Худалдан авах ажиллагаанд жижиг, дунд үйлдвэрлэл хэрэглэгчдийг дэмжих бодлого, хэрэгжүүлэх арга аргачлал“, “Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, хууль эрх зүйн орчны шинэчлэл” зэрэг мэдээллийг аж ахуйн нэгжид хүргэж ажиллалаа.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан | | | | дотоодын үйлдвэрээс бараа бүтээгдэхүүн худалдан авалт 2020 онд 1.1 тэрбум төгрөг, 2021 онд 7.8 тэрбум төгрөг, 2022 онд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 152,893.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34, өвсний үндэс төслийн хүрээнд хэрэгжих 615.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 15,895.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 47, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1,802.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6, авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 2,062.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, БОХНСАХЗ-аар санхүүжигдэх 234.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, нийт 173,502.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс давхардсан тоогоор 206 удаагийн тендер сонгон шалгаруулалтыг 100 хувийн гүйцэтгэлтэй, 2,304.1 сая төгрөгийн хэмнэлт, үр ашигтай зохион байгуулан ажиллалаа. Гэрээ байгуулах эрх олгосон 90 төсөл, арга хэмжээний 33 төсөл, арга хэмжээ буюу 37 хувьд орон нутгийн компаниуд шалгарч, 35.7 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан байна.<br>2024 оны 2-р сард төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа - хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн нэтворкинг форумыг төр хувийн хэвшлийн 130 гаруй байгууллага оролцлоо. Форумын үеэр банк, аж ахуйн нэгж, орон нутагт хэрэгжиж буй ОУБ-ын төсөл хөтөлбөр, сургууль цэцэрлэг аж ахуйн нэгж зэргийн хамтын ажиллагааны гэрээнүүд үзэглэгдэж, зөгийн бал, өндөг, гурил, сүүн бүтээгдэхүүний 60.0 гаруй сая төгрөгийн худалдан авах гэрээ хийгдлээ. Боловсролын байгууллагын хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүнийг Ерөнхий гэрээ байгуулах аргаар нийлүүлэхээр ТХААГ, ХХААХҮЯ, Дархан-Уул аймаг хамтран хэрэгжүүлэхээр сургалтыг 70 боловсролын байгууллага болон хүнс үйлдвэрлэл эрхлэгч нарт сургалт хийж, мэдээллээр хангасан. 2024.08.16-ны дотор энэхүү тендер мах, сүү, төмс, хүнсний ногооны багцаар зарлагдаж, Дархан-Уул аймгаас Дархан эрдэнэ мах комбинат ХХК, Арцат алтайн уулс ХХК мах нийлүүлэхээр хүсэлт гаргасан.<br>ХХААХҮЯ-ны сайдын хөрөнгө оруулалтаар | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | батлагдсан “Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих тоног төхөөрөмж”, “Шинэ хөдөө төсөл”-ийн хүрээнд 221 иргэн, аж ахуйн нэгжийн 11.0 тэрбум төгрөгийн 460 ширхэг тоног төхөөрөмж авах хүсэлтийг хүлээн авч эрэмбэлэн аймгийн Засаг даргын 2024.04.05-ны өдрийн 01-А/150 дугаар захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу эрэмбэлэн ажлын хэсгийг 2 удаа хуралдуулж, хэлэлцүүлснээр нийт 159 төрлийн 472 ширхэг тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн тодорхойлолт, хурлын тэмдэглэлийг боловсруулан ХОХБТХ-т шилжүүллээ.<br>**Үр дүн:** 2020-2022 онд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр дотоодын үйлдвэрээс бараа бүтээгдэхүүн худалдан авалт нэмэгдэж, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 173,502.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөнөөс 100 хувийн гүйцэтгэлтэй, 2,303.0 сая төгрөгийн хэмнэлт, үр ашигтай зохион байгуулсан. Гэрээ байгуулах эрх олгосон 90 төсөл, арга хэмжээний 37 хувьд орон нутгийн компаниуд шалгарч, 35.7 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан байна. 2024 онд зөгийн бал, өндөг, гурил, сүүн бүтээгдэхүүний 60.0 гаруй сая төгрөгийн худалдан авах гэрээ хийгдсэн. | |
| **2.4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ** | | | | | | | | | | |
| **2.4.1. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлнэ.** | | | | | | | | | | |
| 156 | 2.4.1.1. “Аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө-2030” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | 2021-2024 | ХБТХОХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 10.0 | АйТиЭм-2021” Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 4 ААНБ амжилттай оролцсон. | Аялал жуулчлалын цогцолбор байгуулах төр, хувийн хэвшлийг дэмжин ажиллана. | - | - | 2021-2022 онд Олон улсын “Ай Ти Эм” аялал жуулчлалын үзэсгэлэн худалдаанд манай аймгийн Аялал жуулчлалын нэгдсэн холбоо, “Цайны их зам” ХХК-ууд 10 сая, “Ачлалт алтан зөгий” 2 сая, “Комфорт” зочид буудал 8 гэрээ, “Дарханы каллиграфи” 500 орчим, “Дарханд үйлдвэрлэв” 1 сая төгрөгийн борлуулт хийж амжилттай оролцсон.<br>2023 онд мөн Олон улсын “Ай Ти Эм” аялал жуулчлалын үзэсгэлэн худалдаанд аймгаа төлөөлөн “Цайны их зам” ХХК, “Ачлалт Алтан Зөгий” ХХК, “Дарханд Үйлдвэрлэв” жижиг дунд үйлдвэр эрхлэгчид улсын үзэсгэлэнд тус тус оролцож ирсэн.<br>2024 онд HoReCa Mongolia Conference “Жуулчдаа дайлах Монгол зоог” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан манай аймгийн Аялал жуулчлалын холбоо, Зочид буудлын холбоо, зочид буудлуудын төлөөллүүд оролцож “***Монгол зоогийн контент бүтээж*** | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | ***жуулчдад нөлөөлөх нь***" сэдвээр Арт гэр студийн тогооч илтгэл тавьсан.<br>"Улаанбаатар травел экспо-2024" үзэсгэлэнд "Цайны их зам" ХХК, "Ачлалт Алтан Зөгий" ХХК-иуд орон нутгаа сурталчлан оролцсон.<br><br>Үр дүн: Нийт 5 удаагийн олон улсын үзэсгэлэнгийн арга хэмжээнд 12 аж ахуйн нэгж байгууллага оролцож, 150 гаруй сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулалт хийж, хамтран ажиллах бизнесийн гэрээнүүдийг байгуулсан байна.. | |
| 157 | 2.4.1.2. Аялал жуулчлалын үйлчилгээний чиглэлээр сургалт зохион байгуулж, хүний нөөцийг чадавхжуулна. | 2021-2024 | ХБТХОХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 5.9 | Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Зочин угтагч бэлтгэх 100 хувийн тэтгэлэгтэй ажлын байртай мэрэгшүүлэх" сургалтад"Компорт цогцолбор" ХХК хамрагдсан | 2 удаа сургалт зохион байгуулна. | 1.5 | 0.0 | 2021 онд Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Зочин угтагч бэлтгэх 100 хувийн тэтгэлэгтэй ажлын байртай мэргэшүүлэх" сургалтад "Компорт цогцолбор" ХХК-ийн 2 ажилтан хамрагдсан.<br>2022 онд Дархан хоттой танилцах "Сити тур" аяллыг зохион байгуулж, Дархан хотын их дээд сургуулиудад шинээр элсэн нийт 90 гаруй оюутан сурагчид болон шилжин ирсэн иргэдийг хамруулан Дархан хотын музей, түүхэн дурсгалт газруудаар аялуулсан.<br>2023 онд Европын Холбооны санхүүжилттэй НАЙРАМДАЛ төслийн хүрээнд НАЙРАМДАЛ төсөл, аймгийн ЗДТГ, Байгаль орчин аялал жуулчлалын газар хамтран "Тогтвортой аялал жуулчлал" чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, төрийн байгууллага, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын холбоо, Зочид буудал, зоогийн газар, жуулчны бааз, амралт сувилал, бусад холбоодын төлөөлөл, тур оператор, шинээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэд нийт 70 ААНБ, иргэд хамрагдуулсан.<br>"Тогтвортой аялал жуулчлал" хөгжүүлэхэд гарц шийдэл эрэлхийлэх сургалт, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах өдөрлөгийг "ДАРХАН 50" цогцолборт зохион байгуулж, Дугуйн холбоо, Мастер тогоочдын холбоо, Дархан Загасчлалын холбоо, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Жижиг дунд бизнесийг дэмжих төв, Дархан Аялал жуулчлалын холбоод, Данс дүүрэн ХХК,Sky зочид буудал, Цайны их зам ХХК өөрсдийн бүтээгдэхүүн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үйлчилгээг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулан оролцлоо.<br>2024 онд аймгийн хэмжээнд нийт 39 зочид буудал, дэн буудал 648 өрөөтэй, 1050 ор хоногийн хүчил чадалтай, амралт сувиллын чиглэлээр 2, амралтын газар 18, хүүхдийн зуслан 1 нийт 1650 хүн хүлээж авах хүчин чадалтайгаар тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, амралтын газруудын удирдлага, менежерүүдийг сургалтад хамруулахаар БОАЖЯам, Монголын зочид буудлуудын холбоо, мөн орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан байна.<br><br>**Үр дүн:** Сургалтыг 6 удаа зохион байгуулж, аялал жуулчлалын салбарт ажилладаг 270 хүнийг бартер, зөөгч, бармен, угтагч, зэрэг мэргэшлийн ур чадвар эзэмшүүлсэн. | |
| 158 | 2.4.1.3. Дархан -Уул аймгийн шинэлэг, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ. | 2022-2023 | ХБТХОХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 6.0 | - | Дархан -Уул аймгийн шинэлэг, брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ. | 3.0 | 0.0 | 2021 онд Дархан-Уул аймгийн “Цайны их зам” ХХК нь Монгол морины нуруунд тааруулан урласан байгальд ээлтэй мод огтлохгүй карбон материалаар яс модыг хийсэн бат бөх хөнгөн эмээлүүдийг өнгө загварын өргөн сонголттойгоор үйлдвэрлэж худалдаанд гаргасан.<br>2022 онд Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй “Цайны их зам” ХХК, Аялал жуулчлалын нэгдсэн холбоо НҮТББ хамтран Америк Европ, Англи Ковбой Австрали стандартын болон өдөр тутмын хүүхдийн эмээл, уралдаанч хүүхдийн эмээлүүдийг үйлдвэрлэн урлаж брэнд бүтээгдэхүүнээ болгосон.<br>Нүүдэлчин соёлын наадамд соёлын биет бус өв тээгчдэд наадамд орох зардалд 15,0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн хөгжүүлэх сангаас дэмжсэн.<br>2023 онд Морьт харвааны төвийг байгуулж 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>2024 онд “Бурхантын өвлийн наадам-2024” арга хэмжээнд “Сатурн экстрем Монголиа”-ийн Агаарын бөмбөлөг, “Тайж хасар банхар” НҮТББ-ын Монгол банхар чарга болон хоол үйлчилгээний газруудыг дэмжин оролцуулж хамтран ажилласан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | **Үр дүн:** Эмээл, морьт харвааны төв 4 брэнд бүтээгдэхүүн үйлчилгээтэй болсон. | |
| 159 | 2.4.1.4. Байгалийн үзэсгэлэнт газар, ан амьтан, нүүдлийн соёл иргэншил, уламжлал мал аж ахуй, амьдралын хэв маягт түшиглэсэн аялал, жуулчлалыг хөгжүүлнэ. | 2021-2022 | ХБТХОХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 19.0 | - | АЖ -ын хөгжүүлэх малчдын нөхөрлөлтэй болсон байна. | - | - | 2021 онд Улсын хэмжээнд 21 аймаг, Улаанбаатар нийслэл хотын үзэсгэлэнт байгаль, түүх соёлын үнэт бахархал болсон 198 дурсгалт газрыг агуулсан “Дэлхийн бахархал Монголд” номын нээлт болов. Уг ном нь Уйгаржин Монгол бичиг, Англи хэл, Крилл монгол хэл дээр хийгдсэн бөгөөд 21 аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтарч бүтээсэн юм. Тус номонд Дархан-Уул аймгийн 9 бахархал орсон юм.<br>2022 онд Байгалийн үзэсгэлэнт газар ан амьтан, нүүдлийн соёл иргэншил, уламжлалт мал аж ахуй, амьдралын хэв маягт түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд малчдын нөхөрлөлийг татан оролцуулах зорилгоор Дархан Загвар гоёл жил бүрийн хавар, намрын улиралд морин аялал зохион байгуулсан.<br>2023 онд Байгалийн үзэсгэлэнт газар ан амьтан, нүүдлийн соёл иргэншил, уламжлалт мал аж ахуй, амьдралын хэв маягт түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор байгалийн баялаг түшиглэн амьдардаг малчдын нөхөрлөл, хоршоо 11, ойн нөхөрлөл 71, уламжлалт мал аж ахуй эрхэлж жуулчдад тогтмол үйлчилгээ үзүүлдэг 2 иргэнийг судалгааг гаргаж баталгаажуулав.<br>2024 онд НИТАЖ-ыг хөгжүүлэхээр сумдын малчин айл өрх, нөхөрлөлийг аялал жуулчлалд татан оролцуулж нүүдэлчин ахуй, соёл, уламжлалт мал аж ахуй, амьдралын хэв маяг, байгалийн үзэсгэлэнт газруудтай танилцуулах морин аяллын хөтөлбөр боловсруулж аялагчдаа хүлээн авах бэлтгэл ажлыг хангаад байна.<br>Хонгор сумын 2 дугаар багийн Зочин толгой чиглэлд 2, Могойн гол-1, Хар бэлчирт 2 малчин айл, нөхөрлөл амрагчдаа авахад бэлэн болсон бөгөөд БНСУ-аас амрагч төлөөлөгч ирэхээр захилга өгөөд байна.<br>**Үр дүн:** Аймгийн хэмжээнд 71 нөхөрлөл, 11 хоршоо, иргэдийн 100 гаруй бүлэг байгалийн үзэсгэлэнт газар, уламжлалт мал аж ахуйг түшиглэн аялал жуулчлалын салбарт бүтээгдэхүүн борлуулж байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 160 | 2.4.1.5. Нисэх онгоцны буудал барьж ашиглалтад оруулна. | 2022-2024 | ХБТХОХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | ОНТХО179.5 | Нисэх онгоцны буудал байхгүй | Нисэх буудлын зурвасыг хашаажуулна. | 179.5 | 0.0 | Дархан сумын Малчин багт нисэх буудал, агаарын хөлөг хөөрч буух зурвас байгуулахаар төлөвлөж, орон нутгийн төсвөөс 179.5 сая төгрөг батлагдаж, зураг, төсөв боловсруулах ажил хийгдэж байна.<br><br>**Үр дүн**: Нисэх буудлын зурвасыг шинээр байгуулах ажлын судалгааны ажил хийгдсэн. Хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн | 70% |
| **2.4.2. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ**. | | | | | | | | | | |
| 161 | 2.4.2.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ. | 2022-2024 | ХБТХОХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 5.0 | - | Сургалтын төвүүдтэй хамтран ажиллаж салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ. | 5.0 | 0.0 | 2021 онд БОАЖЯ-аас Зочлох үйлчилгээний сургалт, жуулчны бааз, амралт сувиллын газарт зориулсан сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Нийт 90 гаруй оролцогч хамрагдсан.<br>2022 онд МОАЖХ-оос тур операторуудын сургалт, Аялал жуулчлалын үндэсний төвөөс чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 60 хүн хамрагдсан.<br>2023 онд Европын Холбооны санхүүжилттэй НАЙРАМДАЛ төслийн хүрээнд НАЙРАМДАЛ төсөл, аймгийн ЗДТГ, Байгаль орчин аялал жуулчлалын газар хамтран “Тогтвортой аялал жуулчлал” чадавхжуулах сургалтыг 2 зохион байгуулж, төрийн байгууллага, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Зочид буудал, зоогийн газар, жуулчны бааз, амралт сувилал, бусад холбоодын төлөөлөл, тур оператор, шинээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэд нийт 70 ААНБ, иргэд хамрагдсан.<br>2024 онд аймгийн хэмжээнд нийт 39 зочид буудал, дэн буудал 648 өрөөтэй, 1050 ор хоногийн хүчил чадалтай, амралт сувиллын чиглэлээр 2, амралтын газар 18, хүүхдийн зуслан 1 нийт 1650 хүн хүлээж авах хүчин чадалтайгаар тус тус үйл ажиллагаа явуулж байна.<br>Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, амралтын газруудын удирдлага, менежерүүдийн сургалтад хамруулахаар БОАЖЯам, Монголын зочид буудлуудын холбоо, мөн орон нутгийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | **Үр дүн:** Сургалтыг 6 удаа зохион байгуулж, аялал жуулчлалын салбарт ажилладаг 270 хүнийг бартер, зөөгч, бармен, угтагч, зэрэг мэргэшлийн ур чадвар эзэмшүүлсэн. | |
| 162 | 2.4.2.2. Тусгай сонирхолын аялал жуулчлалын төрлүүдийг хөгжүүлнэ. | | ХБТХОХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 5.0 | - | Хараа голын мөсний баяр зохион байгуулна. | 5.0 | 5.0 | 2021 онд Ахмадуудын спортын III их наадмыг спортын 3 төрөл Софт волейбол, дартс, Граунд голь 3 төрлөөр зохион байгуулж, 150 ахмад настан хамруулж нийт 900,0 мянган төгрөгийг зарцуулсан.<br>2022 онд “Байгаль дэлхийгээ хайрлаж, хог хаягдалгүй аялцгаая” уриатайгаар иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, чөлөөт цагаараа спорт аяллын төрлөөр хичээллэх, хог хаягдлыг багасгаж, ангилахыг дадал болгох, байгальд ээлтэй арга замаар аялах зорилготойгоор “Билүүтийн толгойн” чиглэлд явган аяллын арга хэмжээ зохион байгуулж, нийт 80 гаруй иргэд болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, клубын гишүүд оролцлоо.<br>2023 онд Автомашины бартаат замын уралдаан “Чингис мастер кросс-2023” уралдааныг аймгийн ЗДТГ, Монголын автомастеруудын холбоо, хамтран зохион байгуулж, тэмцээнд нийт 63 тамирчин оролцож 7 гараанаас хэсгийн 4, хагас шигшээ 2, финалын нэг гараанаас шилдгүүд тодорсон. “Чингис мастер кросс-2023” уралдааны шагналын сан 20 сая төгрөг зарцуулсан.<br>Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутагт ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Тусгай сонирхлын спорт, аялал жуулчлал тэмцээнийг “Дарханы Загасчлалын Холбоо” ТББ-тай хамтран “Дархан цом-2023” мөсний спортын загасчлалын дадлага, сургалтыг “Түшиг Уул” ХХК-ийн хиймэл нуурт зохион байгуулсан. Тус арга хэмжээнд дотоодын 24 багийн 72 тамирчин оролцсон.<br>2024 онд “Бурхантын өвлийн наадам-2024” арга хэмжээ, Чингис мастер кросс арга хэмжээ, Дархан тайж хасарын нэрэмжид тэмцээнийг тус тус төрийн байгууллагууд болон мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж нийт 12 аймгийн 1500 гаруй төлөөллийг хамрагдсан.<br>**Үр дүн:** Тусгай сонирхлын 7 арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 163 | 2.4.2.3. Спорт, аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | 2021-2023 | ХБТХОХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 5.0 | - | "Дархан-90" уулын замын унадаг дугуйн наадмыг зохион байгуулна. | 10.0 | - | 2022 онд Дархан хотын брэнд наадам болгох зорилгоор Төвийн бүсийн 2-р аялал болох "Дархан-88" уулын дугуйн II наадмыг "Залуучууд театраас Мангирт, Чоно харайхын даваа, Аргалын гарам нийт 90 км маршрут замыг туулж уралдсан. Тус наадамд нийслэл Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, ОХУ-ын Буриад улсын баг тамирчид, Баянхонгор, Дорноговь, Дундговь, Эрдэнэт, Өмнөговь аймгуудын нийт 24 багийн 186 гаруй тамирчид оролцлоо.<br>2023 онд Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх орон нутагт ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Тусгай сонирхлын спорт, аялал жуулчлал тэмцээнийг "Дарханы Загасчлалын Холбоо" ТББ-тай хамтран "Дархан цом-2023" мөсний спортын загасчлалын дадлага, сургалтыг зохион байгуулж, нийт 24 багийн 72 тамирчин оролцсон.<br>"Дрон шоу", "Дрифт шоу" зэрэг орон нутгийн чанартай спортын төрлүүдээр эвент арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг болсон.<br>2024 онд Мөсний загасчлалын олон улсын аварга шалгаруулах, Хойд бүсийн Мөсөн сурын чуулга харваа, Дархан айс дрифт уралдаан, Чингис мастер кросс, Дархан тайж хасарын төвийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 12 аймгаас нийт 1500 гаруй хүн оролцсон байна.<br>"Darkhan walking festival-50" уртын алхалтын арга хэмжээг зохион байгуулж олон улсын тэмдэг тэмдэглэгээг маршрутын дагуу байрлууллаа. Морь уналга, нохой чарга, агаарын бөмбөлөг, хүүхдийн галт тэрэг, хоол үйлчилгээ зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан ажиллаа.<br>**Үр дүн:** Спорт аялал жуулчлалын төрлийн 6 арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. | 100% |
| 164 | 2.4.2.4. Орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан жуулчдын тоог нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Байгаль орчин, аялал жуулчл | - | - | Тур оператор компаниудтай хамтран ажиллана. | - | - | 2021, 2022 онд Олон улсын "Ай Ти Эм-2021" аялал жуулчлалын үзэсгэлэнд "Аялал жуулчлалын нэгдсэн холбоо", "Дархан загвар гоёл" ХХК-ууд өөрсдийн онцлох "Монгол урлал брэнд"-ийн бүтээгдэхүүнийг танилцуулан, шинэлэг, брэнд бүтээгдэхүүнийг сурталчлан оролцлоо. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | алын газар | | | | | | Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын нэгдсэн холбоо НҮТББ нь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд нэгдсэн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, холбоо, клубуудын хамтын ажиллагааг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа явуулах чиглэлээр хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулан орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор хамтран ажиллаж байна.<br>2023 онд "Тогтвортой аялал жуулчлал" хөгжүүлэхэд аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах өдөрлөгийг "ДАРХАН 50" цогцолборт зохион байгуулж, Дугуйн холбоо, Мастер тогоочдын холбоо, Дархан Загасчлалын холбоо, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Жижиг дунд бизнесийг дэмжих төв, Дархан Аялал жуулчлалын холбоод, Данс дүүрэн ХХК,Sky зочид буудал, Цайны их зам ХХК өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулсан.<br>2024 онд Мөсний загасчлалын олон улсын аварга шалгаруулах, Хойд бүсийн Мөсөн сурын чуулга харваа, Дархан айс дрифт уралдаан, Чингис мастер кросс, Дархан тайж хасарын төвийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 12 аймгаас 1500 гаруй хүн оролцсон.<br>"Darkhan walking festival-50" уртын алхалтын арга хэмжээг зохион байгуулж олон улсын тэмдэг тэмдэглэгээг маршрутын дагуу байрлууллаа. Морь уналга, нохой чарга, агаарын бөмбөлөг, хүүхдийн галт тэрэг, хоол үйлчилгээ зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан ажиллаа<br>**Үр дүн:** Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг 5 удаа сурталчилсан. | |
| **2.5. ЭРЧИМ ХҮЧ** | | | | | | | | | | |
| **2.5.1. Төвлөрсөн дулаан хангамжийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж, айл өрхийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна.** | | | | | | | | | | |
| 165 | 2.5.1.1. Гэр хорооллын айл | 2021-2024 | ХБТХОХ, | 4,870.8 | | Дархан сумын 5, 6, 7, 8 дугаар багийн | - | - | Дархан сумын 7, 8-р баг Манхантолгойн Нарантолгойн айл өрхийг инженерийн шугам | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | өрхүүдийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлнэ. | | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | | | гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд 30 айлыг холбоно. | | | сүлжээнд холбох ажлыг Цагаан зуун ХХК гүйцэтгэж 2020 онд ашиглалтад оуулсан. 2022 оны жилийн эцсээр 28 айл төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. 2023 онд 8 айл шинээр төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсоноор нийт 36 айл холбогдоод байна. Дархан сумын 5-р багийн гэр хороололд 2019-2021 оны хооронд Бурхан хясаат ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан ч ашиглалтын зардал өндөр гарч байгаагаас шалтгаалан айл өрхүүд шугам сүлжээнд холбогдоогүй байна. Дархан сум 5-р баг, Дулааны төв шугам К27-К35 худгийн Ф377*9мм голчтой 1222хос метр шугамыг Ф530*10мм шугамаар, К35-К39 худгийн Ф325*9мм голчтой 375хос метр шугамыг Ф480*10мм шугамаар, 13ш дулааны төв худаг өргөтгөх ажлыг “Одкон холдинг” ХХК, 2023 оны 04 сарын 19-ний өдрөөс ажил эхлээд, зураг, төсвийн дагуу шугам хоолойг угсрах ажил хийгдэж байна. ТК29 дүгээр худгаас газар шорооны ажил эхэлсэн.<br>2024 оны 04 сарын 19-ний өдрөөс эхлэн 2023 оны ажлыг үргэжлүүлэн гүйцэтгэж шугам хоолой угсрах ажил хийгдэж дууссан. Нөхөн сэргээлтийн ажил үргэжилж байна. Ажлын явц-90%<br>**Үр дүн:** Дархан сумын 5, 7, 8-р багийн нутаг дэвсгэрт нийт 760 айл инженерийн дэд бүтэцтэй амины орон сууцны хороолол болох боломж бүрдсэн. 6, 7-р баг 930 гаруй айл өрхийг дахин төлөвлөлтөд хамруулж 2750 айлын нийтийн орон сууцны хороолол барих боломж бүрдэнэ. | |
| 166 | 2.5.1.2. Тосгон чиглэлийн гадна дулааны шугам шинээр татаж, төвлөрсөн шугаманд холбоно. | 2021-2023 | ХБТХОХ | 1,100.0 | Дархан сумын 1,2,3 дугаар багт байрлах Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, багийн төвийн байрууд төвлөрсөн дэд | Өрхийн эмнэлэг, Багийн төвийг төвийн дулааны шугамд холбоно. | 60 | | 1. 2022 онд Тосгон чиглэлийн гадна дулааны инженерийн шугам сүлжээний ажлыг /Дулааны шугам ф100мм-ф150мм-ийн хоорондын 1350м урттай шугам/ “Өгөөмөр баян булаг” ХХК улсын төсвийн 0,935 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>2. Дархан сумын 1,2,3 дугаар багт байрлах Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, багийн төвийн байруудыг холбохоор ажлын зураг, төсөв боловсруулагдсан. Шугам угсралтын ажлын зураг төсөв магадлалын албаар 1.134 сая төгрөгөөр баталгаажиж өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд дулаан, хэрэгцээний халуун ус, хүйтэн усны шугамын угсралтыг Дарханы дулааны сүлжээ ТӨХК, бохир усны шугамын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүтцэд холбогдо огүй | | | | Дархан ус суваг ХК гүйцэтгэж төрийн өмчийн сургууль цэцэрлэг, багийн төв, өрхийн эмнэлэгүүд төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон.<br>**Үр дүн:** Төвийн дулаан хангамж, цэвэр бохир усны шугам, Ус дулаан дамжуулах төв баригдсан. Төрийн байгууллага, аж ахуй нэгж байгууллагууд төвлөрсөн дэд бүтцийн шугамд холбогдох боломж бүрдсэн. | |
| 167 | 2.5.1.3. Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумын гэр болон орон сууцны хорооллын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ. | 2021-2022 | ХБТХОХ | Австри улсын 1.0 сая еврогийн хөрөнгө оруулалта Ар | Дархан сумын гэр хорооллын 18%, Хонгор, Орхон, Шарын гол сумын гэр хорооллын 30% гэрэлтүүлэгтэй | Дархан, Хонгор, Орхон, Шарын гол суманд 1417ш гэрэлтүүлэг шинээр суурилуулна | 1.0 сая евро | 1.0 сая евро | Австри улсын 1 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө оруулалтаар Дархан суманд 941 ш, Орхон суманд 90 ш, Шарын гол суманд 220 ш, Хонгор суманд 166 ш, нийт 1417 ширхэг гэрэлтүүлгийг шинээр суурилуулсан.<br>**Үр дүн:** Дархан сум, Хонгор, Орхон, Шарын гол суманд нийт 1417 ш гэрэлтүүлэг шинээр суурилууллаа. | 100% |
| 168 | 2.5.1.3. Гэр хорооллын гудамж, зам талбайд гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, | УТХО 12,000.0 | Дархан сумын гэр хорооллын 20% гэрэлтүүлэг-тэй | Орон сууцны хороолол доторх гэрэлтүүлэг | 1,800.0 | 0.0 | 2021 онд Дархан сумын 14-р баг Байгаль орчны уулзвараас Монгол банкны уулзвар хүртэлх 0.760 км зам дагуу 50 ш гэрэлтүүлэг, Дархан сумын 9, 10, 11, 12-р баг Хээтэй хорооллын арын 2.3 км авто зам дагуу 150 ш гэрэлтүүлэг, Шинэ Хуучин Дарханыг холбосон 3 дахь төв магистрал зам дагуу 40 ш гэрэлтүүлэг, Шинэ Хуучин Дарханыг холбосон 2 дахь төв магистрал зам дагуу 80 ш гэрэлтүүлэг шинээр суурилуулсан.<br>Нийтийн орон сууцны засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын 8-14 дүгээр багуудын 28 байрны фасад засварын ажил бүрэн хийгдлээ.<br>Хотын гэрэлтүүлэг төслийн хүрээнд Дархан сумын гэр хорооллын багуудад нийт 5460 ш гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлыг 2022-2023 онд хийж гүйцэтгэж байна.<br>Дархан сумын 6, 7-р багт 900 ш гэрэлтүүлэг, Дархан сумын 13-р багт 34 ш, Дархан сумын 1-р багт 18 ш, Дархан сум 25-р хороололд 35 ш, Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд 290 ш, Дархан сумын 1, 2, 8-р багийн | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | авто зам дугуй 69 ш гэрэлтүүлэг суурилуулах ажил хийгдсэн.<br><br>**Үр дүн:** Гэр хорооллын 6806ш гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажилд 15.4 тэрбум төгрөг, төв авто зам дагуу 850ш гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажилд 3.5 тэрбум төгрөг, нийтийн орон сууцны фасадны 28711у/м гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажилд 1.5 тэрбум төгрөг зарцуулж байна. Ингэснээр аймгийн төвийн гэр хороолол 100%, НОС-ны фасад 100% гэрэлтүүлэгтэй болно. | |
| 169 | 2.5.1.4. "Эрчим хүч хэмнэх" дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулна. | 2021-2023 | ХБТХО Х, ЗАА | УТХО 3,300.0 | 2021 онд 10-н байр буюу 54 блок байрны гадна дулаалга өнгө будгийн ажлыг хийж гүйцэтгэсэн. | Барилгын дулаан алдалт буурсан байна. | 316.2 | 0.0 | Дархан сумын 10-р баг 6-р байр, 11-р баг 10, 12-р байрууд, 13-р баг 13, 24-р байрны дулаалга, гадна фасад засварын ажлыг УТХО-213,6 сая.төг-өөр "Цахир түмэн Алтай" ХХК гүйцэтгэж байна. /5 байр/<br>Дархан сумын Нийтийн зориулалттай орон сууцны 170 байрны цоколд хаалт хийх ажлыг 204.0 сая.төг-өөр гүйцэтгэсэн.<br>2021-2022 онд 19 байр 100%<br>2023 онд 5 байр 90%<br>**Үр дүн:** Нийт 24 орон сууцны өнгө будаг, угсармал орон сууцны гадна дулаалга өнгө будгийн ажлыг бүрэн дуусгасан. | 100% |
| 170 | 2.5.1.5. Цахилгаан, дулааны эрчим хүчний эх үүсвэрийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2021-2023 | ХБТХО Х, ЗАА | 57,800.0 | Тосгон чиглэлийн дулаан хангамжийн ажил 65% гүйцэтгэлтэй байна. | Дулааны ф200м, ф150мм дулааны шугам хоолой 1.2 км хийгдсэн байна. | 11,690.0 | 0.0 | 2021 онд Дархан сумын 1-р баг, тосгон чиглэлийн шугамын шинэчлэлийн ажлыг:<br>Цэвэр усны шугам угсралт-1,350км,<br>Бохир усны шугам угсралт-1,900,<br>Өргөлтийн насосын станц барилга -1ш,<br>Бохир усны насосын станц барилга тоноглол-1ш, УДДТ-ын барилга дулаан механикийн тоноглол -1ш гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>2022 онд Дархан сумын 1-р баг, Тосгон чиглэлийн гадна дулааны инженерийн шугам сүлжээний ажлыг /дулааны шугам ф100мм-ф150мм-ийн хоорондын 1350м урттай шугам/ улсын төсвийн 930.0 сая.төг-өөр гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>- 2023 онд Орон нутгийн төсвийн 670.0 сая.төг-ийн хөрөнгө оруулалтаар төвийн дулаан, цэвэр бохир усанд холбох ажлыг "ДДС" ТӨХК, "Дархан-Ус суваг" ХК гүйцэтгэсэн.<br>**Үр дүн:** Төвийн дулаан хангамж, цэвэр бохир усны шугам, ус дулаан дамжуулах төв баригдсан. 4-р сургууль, 13-р цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төв, 1,2,3-р багийн төвийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байрууд төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. | |
| 171 | 2.5.1.5<br><br>. Цахилгаан, дулааны эрчим хүчний эх үүсвэрийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ЗАА | 1,050.0 | - | Усны болон дулааны ашиглалтын ухаалаг хэрэглээтэй болсон байна. | - | - | Монгол улс болон Австри улсын засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх ухаалаг тоолуур суурилуулах" хөнгөлөлттэй зээлийн төсөл хэрэгжихээр үндсэн гүйцэтгэгч шалгаран зургийн ажил эхэлсэн. Уг төслийн хүрээнд 15.000 ш LXSG-K LXSG-R загварын ухаалаг тоолуурыг суурилуулахаар төлөвлөгдөж байна. Төслийн гүйцэтгэгчээр Автсри улсын "Ти Ар Эм" компани шалгарсан.<br>2021 онд 15-р баг, Мангирт хэсгийн 286 хэрэглэгчдэд хүйтэн усны хэрэглээнд ухаалаг тоолуур суурилуулсан.<br>2022 онд 15-р баг, Мангирт хэсгийн 19 хэрэглэгчдэд хүйтэн усны хэрэглээнд ухаалаг тоолуур суурилуулсан.<br>2023 онд Австри улсын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Дархан суманд 15000ш ухаалаг усны тоолуур суурилуулах бэлтгэл ажлыг хангасан.<br>2024 онд Дархан Ус суваг ХК 4000 ухаалаг тоолуур суурилуулсан. /15000-ыг суурилуулна./<br>**Үр дүн:** Дархан сумын 15-р баг, Мангирт хэсгийн 305 хэрэглэгч ухаалаг тоолууртай болсон. Уг ажил бүрэн дууссанаар 15000 хэрэглэгч ухаалаг тоолууртай болж, 14 км шугам хоолой шинэчлэгдсэн. | 100% |
| **2.6. ЗАМ, ТЭЭВЭР, ЛОЖИСТИК** | | | | | | | | | | |
| **2.6.1. Орон нутгийн чанартай авто замын засвар, шинэчлэлтийн ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | |
| 172 | 2.6.1.1. Дархан-Шарын гол чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгоно. | 2021-2023 | ХБТХО Х, | УТХО 40,176.5 | 17км авто зам хатуу хучилттай болсон. | 48.8 км авто замыг хатуу хучилттай болгож 24у/м, төмөр бетон гүүрийг ашиглалтад оруулна. | 17,58 7.1 | 12,521.0 | Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай 17 км авто замын ажлыг 2020 онд “Төгс зам” ХХК гүйцэтгэж ашиглалтад оруулсан.<br>Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай 22,3 км авто замын ажлыг 2023 онд Анандын зам ХХК гүйцэтгэж ашиглалтад орсон.<br>Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай 8,7 км авто зам /Дархан-Уул, Шарын гол сум/ ажлыг ЗЗБ ХХК гүйцэтгэж байнгын ашиглалтад оруулсан.<br>Төсөвт өртөг- 7,378,991,275₮<br>**Үр дүн:** Дархан-Шарын гол чиглэлийн 48.8 км авто зам болон 24у/м төмөр бетон гүүрийг 2023 онд бүрэн ашиглалтад орсон. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 173 | 2.6.1.2. Хонгор сумаас Салхит баг хүртэлх 13.1 км авто замын хатуу хучилттай болгоно. | 2020-2024 | ХБТХОХ | УТХО 7,809.9 | 13.1км авто замын далангийн суурийн ажил бүрэн хийгдсэн. | 13.1км авто замыг хатуу хучилттай болгоно. | 6,222.8 | 6,222.8 | Хонгор сумаас Салхит баг хүртэлх 13,1 км хатуу хучилттай авто замын ажлын эхний үе шатны 12 ш дугуй хоолой, 2 ш дөрвөлжин хоолой, 13,1 км авто замын далангийн ажил хийгдсэн. 2 дахь үе шатны ажил 13.1 км авто замын суурь хийх, авто замыг хатуу хучилттай болгох ажил 100 хувь дуусаж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>**Үр дүн:** Хонгор сумаас Салхит баг хүртэлх 13,1 км авто замыг хатуу хучилттай болгох ажил бүрэн дууссан. | 100% |
| 174 | 2.6.1.3. Аргалын гармаас “Зулзагын гол” хүүхдийн зуслан хүртэл 10 км замыг хатуу хучилттай болгоно. | 2022-2023 | ХБТХОХ, | УТХО 7,720.2 | Хатуу хучилттай авто зам 0.0км | 13,9 км авто замыг хатуу хучилттай болгоно. | 8,544.3 | 4,443.0 | Аргалын гармаас Зулзага чиглэлийн 10.3 км авто замын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй, Зулзагын гүүрнээс Овоо хүртэлх 3.6 км авто замын ажил 40% гүйцэтгэлтэй байна.<br>Зулзагын гол дээрх 18у/м төмөр бетон гүүрний ажил 70 хувийн гүйцэтгэлтэй 2023 онд төсөв нэмэгдүүлэхтэй холбоотой ажил түр зогссон. 2024 онд бүрэн ашигалалт оруулах төлөвлөгөөтэй байна.<br><br>**Үр дүн:** Аргалын гармаас Зулзага хүртэлх 13.9 км авто зам, 18 у/м төмөр бетон гүүрний ажил 70 хувийн биелэлтэй байна. | 70% |
| 175 | 2.6.1.4. Алслагдсан баг, суурин газруудыг авто замын сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ | 712.0 | Гэр хорооллын доторх 1.7 км авто замын суурийн ажил хийгдсэн | Гэр хорооллын дотор 1.3 км сайжруулсан шороон замын ажил хийнэ. | 15,300.0 | 150.0 | 1.Тэди төвийн уулзвараас хуучин нисэх онгоцны буудал хүртэлх 2.8 км авто зам, явган зам, дугуйн зам, гэрэлтүүлэг, уулзварын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг 7,4 тэрбум төгрөгөөр Түвшин гэгээ ХХК гүйцэтгэж байна. Ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна. 2023 онд бүрэн хэрэгжүүлж дуусна.<br>2. Дархан сум 5-р баг Дархан сумын ЗДТГ-МСҮТ-Олон улсын авто зам хүртэлх 1.063 км хатуу хучилттай авто зам, явган зам, дугуйн зам, уулзварын өргөтгөл шинэтгэлийн ажлыг 1,9 тэрбум төгрөгөөр “Түвшин гэгээ” ХХК гүйцэтгэж байна. 2023 оны бүрэн хэрэгжүүлж дуусна.<br>Ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>3.Төв авто зам-Төмөр замын гарам хүртэлх авто зам, явган замын засвар шинэчлэлтийн ажлыг 2,5 тэрбум төгрөгөөр<br>Ажил 0 хувийн гүйцэтгэлтэй байна. Цахимбар инженеринг ХХК гэрээ байгуулсан.<br>4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хатуу хучилттай 0,26 км авто зам ажил/ Малчин баг, Хөтөл хороолол/1,3 тэрбум /<br>Ажил 40 хувийн гүйцэтгэлтэй байна. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 5. Дархан сум, 6, 7-р багт 1.827 км хатуу хатуу хучилттай авто зам хучилттай авто зам, явган замын ажлыг Дархан АЗЗА ТӨХК 2,1 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байна. Ажил 90 хувийн гүйцэтгэлтэй. 2023 оны 11-р сард бүрэн хэрэгжүүлж дуусна.<br>2024 онд 1.Тэди төвийн уулзвараас хуучин нисэх онгоцны буудал хүртэлх 2.8 км авто зам, явган зам, дугуйн зам, гэрэлтүүлэг, уулзварын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг 7,4 тэрбум төгрөгөөр Түвшин гэгээ ХХК гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>2. Дархан сум 5-р баг Дархан сумын ЗДТГ-МСҮТ-Олон улсын авто зам хүртэлх 1.063 км хатуу хучилттай авто зам, явган зам, дугуйн зам, уулзварын өргөтгөл шинэтгэлийн ажлыг 1,9 тэрбум төгрөгөөр "Түвшин гэгээ" ХХК гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>3.Төв авто зам-Төмөр замын гарам хүртэлх авто зам, явган замын засвар шинэчлэлтийн ажлыг 2,5 тэрбум төгрөгөөр Биг рентал ХХК гүйцэтгэж 70 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хатуу хучилттай 0,26 км авто зам ажил/ Малчин баг, Хөтөл хороолол/1,3 тэрбум /<br>Ажил 40 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>5. Дархан сум, 6, 7-р багт 1.827 км хатуу хатуу хучилттай авто зам хучилттай авто зам, явган замын ажлыг Дархан АЗЗА ТӨХК 2,1 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байна. Ажил 90 хувийн гүйцэтгэлтэй.<br>**Үр дүн:** Алслагдан багуудын 4 байршилд авто замын засвар шинэчлэлт, шинээр авто зам тавьснаар замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдаж, иргэд стандарт шаардлага хангасан хатуу хучилттай авто замаар зорчино. | |
| 176 | 2.6.1.5. Дархан сумын 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбосон авто замын гүүрэн гарцын шинээр байгуулна. | 2018-2023 | ХБТХОХ | УТХО 7,400.0 | Гүүрийн 3-н багана хийгдсэн. | Сумын төвийн 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбох авто замын гүүрэн гарц хийнэ. | 6,142.4 | 1,542.0 | Дархан сумын 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбох төмөр зам дээгүүрх авто замын 56.2 у/м, 12.6 м өргөнтэй гүүрний тулц хана хийх ажлыг 2022 онд хийж гүйцэтгэсэн.<br>2023 онд төмөр зам дээгүүрх гүүрэн гарц болон гүүрний 2 талын авто зам, явган зам, гэрэлтүүлэг шинээр хийх ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Гүүрний металл хийцийн угсралт хийгдэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 90% 2023 онд хэрэгжүүлж дуусна.<br>2024 онд Дархан сумын 1, 8 дугаар багийг холбосон гүүрийн ажил бүрэн дуусч 2024 оны | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 05 дугаар сарын 27-ны өдөр замын хөдөлгөөнийг нээсэн.<br>**Үр дүн:** Дархан сумын 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбосон авто замын гүүрэн гарцын шинээр байгууллаа. | |
| 177 | 2.6.1.5. Шарын гол сумын төвийн доторх авто замыг үе шаттайгаар засварлана. | 2021-2024 | ХБТХОХ | УТХО, ОНТХО, ОНХСан 1,906.5 | 1.141км авто замыг бүрэн шинэчилсэн | Сумын төвийн доторх 1.4 км авто замын засвар шинэчлэлт хийнэ. | 1,300.0 | 1,040.0 | 2022 онд Сумын төвийн доторх 1.4 км авто зам, явган замын засвар шинэчлэлтийн ажлыг “Өсөх урам” ХХК гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br><br>**Үр дүн:** Сумын төвийн доторх 2.5 км авто замыг бүрэн шинэчлэгдсэн. | 100% |
| 178 | 2.6.1.5. Энхтал багийг аймгийн төвтэй холбох 13.4км сайжруулсан шороон зам шинээр барина. | 2021-2024 | ХБТХОХ | 600.0 | Зам байхгүй | Энхтал багийг аймгийн төвтэй холбох сайжруулсан шороон зам 6.7 км | 300.0 | | Энхтал багийг аймгийн төвтэй холбох 13.4 км сайжруулсан шороон зам шинээр барих ажлын зураг, төсөв боловсруулсан. 2025 онд УТХО-ийн төсвийн төсөлд саналыг хүргүүлсэн.<br>Үр дүн: 13.4 км сайжруулсан шороон замын зураг төсөв боловсруулсан. | 30% |
| 179 | 2.6.1.6. Авто замын хөдөлгөөний эрчмийн судалгаанд үндэслэн 3 уулзварыг гэрлэн дохиотой болгоно. | 2022-2024 | ХБТХОХ, | ОНТХО 245.0 | Дархан сумын хэмжээнд нийт 10 уулзвар гэрлэн дохиотой | Шинэ зам, Хүслийн хотхоны дэргэдэх 4 -н замын уулзварын гэрлэн дохиог хийнэ. | 125.0 | 0.0 | Консулын уулзварын дэргэдэх 4-н замын уулзварыг өргөтгөн, гэрлэн дохиог шинэчлэх, Мобикомын дэргэдэх 4-н замын уулзварыг өргөтгөн тойрог уулзвар болгох, Дархан сум 27-р байрны дэргэдэх 4-н замын уулзварыг өргөтгөх, DBS-ын дэргэдэх 4-н замын уулзварыг өргөтгөх, гэрлэн дохиог шинэчлэх, Хүнсний үйлдвэрээс Өргөө баг руу чиглэсэн авто замыг өргөтгөж, уулзварыг өргөтгөн шинэчлэх, ажлуудыг хийлээ.<br>**Үр дүн:** 2023 онд нийт 5 уулзварын өргөтгөл хийгдэж гэрлэн дохио хийгдсэн. | 100% |
| 180 | 2.6.1.7. Орон сууцны хорооллуудын доторх авто замын сүлжээг өргөтгөх, шинэчлэх, засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, | УТХО, ОНТХО 12,135.0 | 106.33 км авто замын 20 хувь нь шинэчлэгдсэн | Хотын доторх төв авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлын эхний үе шатны ажлыг 3-н байршилд эхлүүлнэ. | 3,295.0 | 2,545.1 | 1. Консулын уулзвараас- DBS-ын уулзвар хүртэлх 0,479 км хатуу хучилттай авто замын засвар шинэчлэлт, явган зам, гэрэлтүүлэг, шугамын хүчитгэл, гэрлэн дохионы ажлыг 1,9 тэрбум төгрөгөөр Өнөр зам ХХК Их хотын гарц ХХК гүйцэтгэж хэрэгжилт 100%.<br>2. Хүнсний үйлдвэрийн урд талын хоёр урсгалтай хатуу хучилттай авто зам, явган зам уулзварын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг 2.5 тэрбум төгрөгөөр Шилдэг зам ХХК гүйцэтгэж 100 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>3. DBS-ын уулзвараас-Аюулгүйн тойрог хүртэлх 1,33 км хатуу хучилттай авто зам, явган замын ажлыг 2,2 тэрбум төгрөгөөр Цахимбар инженеринг ХХК гүйцэтгэлээ. Ажил 100 хувийн гүйцэтгэлтэй байна. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 4.Хүнсний захын уулзвараас хүнсний хойд уулзвар хүртэлх авто зам шинэчлэлт, явган зам, дугуйн замын ажлыг 2,0 тэрбум төгрөгөөр Бурхант эко асфальт" ХХК гүйцэтгэж хэрэгжилт 100%. **Үр дүн:** Хотын доторх эрчим ихтэй 4 хэсэгт авто замын засвар шинэчлэлтийн ажил хийгдсэнээр замын хөдөлгөөний нэвтрэх чадвар нэмэгдэж, хөдөлгөөний эрчим буурч стандартад нийцсэн авто зам, уулзварууд ашиглалтад орно. | |
| 181 | 2.6.1.7. Гэр хорооллуудын доторх авто замын сүлжээг өргөтгөх, шинэчлэх, засварлах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХО Х, | 2,300.0 | 3.2км авто замын буталсан чулуун суурь хийгдсэн. | Дархан сум, 1, 2, 8 дугаар багт хатуу хучилттай авто замын ажлыг дуусгана. | 2,135. 1 | 2,135.1 | Дархан сумын 1, 2, 8 дугаар багийн аймгийн төвийн хатуу хучилттай 3.2 км авто зам, явган зам, гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэж 2022 онд бүрэн ашиглалтад оруулсан. **Үр дүн:** Дархан сум, 1, 2, 8 дугаар багт хатуу хучилттай авто замын ажил бүрэн дууссан. | 100% |
| **2.6.2. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ.** | | | | | | | | | | |
| 182 | 2.6.2.2. Нийтийн тээврийн хэрэгслийн 15 зогсоолын тохижилтыг хийнэ. | 2022-2024 | ХБТХ ОХ, | УТХО, ОНТХО2 25.0 | | Нийтийн тээврийн 5 зогсоолыг стандартад нийцүүлэн тохижуулна. | 225. 0 | 225.0 | 1.Тэди төвийн уулзвараас хуучин нисэх онгоцны буудал хүртэлх 2.8 км хатуу хучилттай авто замд 5 байршилд нийтийн тээврийн хэрэгслийн 5 зогсоол, 2.Консулын уулзвараас- DBS-ын уулзвар хүртлэх 0,479 км хатуу хучилттай авто замын засвар шинэчлэлт, явган зам, гэрэлтүүлэг, шугамын хүчитгэл, гэрлэн дохионы ажилд 1 байршилд 1 нийтийн тээврийн зогсоолыг, 3.DBS-ын уулзвараас-Аюулгүйн тойрог хүртэлх 1,33 км хатуу хучилттай авто зам, явган замын ажилд 3 барйшилд 3 нийтийн тээврийн зогсоолыг гаргах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. **Үр дүн:** Хотын доторх автозамын шинэчлэлтийн ажилтай холбогдуулан нийтийн тээврийн 6 зогсоолыг стандартад нийцүүлэн тохижуулж, шинээр 3 зогсоол хийсэн. | 100% |
| **2.7. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ** | | | | | | | | | | |
| **2.7.1. Газрын харилцааны төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 183 | 2.7.1.1. Аймгийн газар зохион байгуулалтын | 2022 | ГХБХБ Г | 35.0 | -. | Аймгийн газар зохион байгуула лтын | - | - | Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох ажлыг Газар дэлхий ХХК нь | 50% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ерөнхий төлөвлөгөөг тодотгож, хэрэгжилтийг хангуулна. | | | | | ерөнхий төлөвлөг өөтэй болсон байна | | | тендерт шалгаран 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдөр К1015166 тоот гэрээ байгуулан ажиллаж байна. Уг ажлыг 420,000,000.0 /Дөрвөн зуун хорин сая/- төгрөгөөр хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсэн./орон нутгийн төсөв, Хонгор сумын ОНХС/.<br><br>Газар дэлхий ХХК нь бэлтгэл үе шат болон хээрийн судалгааны 1 дүгээр үе шатны ажлуудаа гүйцэтгэн гэрээний дагуу явцын 1, 2 дугаар тайлангаа аймгийн Засаг даргын 2024-08-30 өдрийн 01-А/368 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт 2024-09-09 өдөр танилцуулсан. | |
| 184 | 2.7.1.2. Орхон, Хонгор сумдын төвийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангуулах. | 2021-2024 | ХБТХОХ | 130.0 | Сумдын ерөнхий төлөвлө-гөөний хэрэгжих хугацаа дууссан | Хонгор сумын ерөнхий төлөвлөгөө шинэчлэгдсэн байна. | 65.0 | | Орхон, Хонгор сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврын төслийг боловсруулсан. Хонгор сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 450.0 сая төгрөгөөр хийгдэхээр батлагдсан.<br>**Үр дүн:** Орхон, Хонгор сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврын боловсруулсан. Хонгор сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 450.0 сая төгрөг шийдвэрлэгдсэн. | 70% |
| 185 | 2.7.1.3. Дархан сумын 7, 14, 29, 30 дугаар хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна. | 2021-2024 | ХБТХОХ | ОНТХО230.0 | | 7 дугаар хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй болсон байна. | 230.0 | 0.0 | Дархан сумын 12 дугаар баг, 7, 14 дүгээр хороолол, 15 дугаар багт байрлах 29, 30 дугаар хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан.<br>Дархан сумын 13-р багт Залуус-1 хороолол 102га талбайд, 15-р багт Залуус-2 хороололд 23га талбайд хорооллуудыг төлөвлөн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Инженер геодези ХХК гүйцэтгэж, аймгийн ИТХ-ын 2023.02.10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Дархан сумын 12 баг, 14-р хорооллын газар эзэмшигч нарыг зохион байгуулалтад оруулж 110 айлыг “Идиал групп” ХХК-тай гэрээ байгуулан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажлыг 2021 онд эхлүүлсэн. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байна. | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад 2023 онд тусгагдсан 750 сая төгрөгийн санхүүжилттэй Дархан сумын 1, 3, 5, 6, 7, 8, 9, 14, 15 дугаар багийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг хийх тендер Төрийн худалдан авах ажиллагааны газраар зарлагдан одоогоор гүйцэтгэгч тодроогүй байна. Энэхүү ажил хийгдсэнээр Дархан сумын нутаг дэвсгэрт дахин төлөвлөлтийн 9-н байршилд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө бүрэн хийгдэж дуусах болно.<br>2024 онд Дархан сумын 14 дүгээр хорооллын амины орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 32 дугаар тогтоолоор батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>**Үр дүн:** Залуус 1,2 төслийн хүрээнд 127 га талбайд, Дархан сумын 14 дүгээр хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнүүд боловсруулагдсан. Дэд бүтэц татах эхнийүе шатны ажлыг 47.0 тэрбум төгрөг, 2 үе шатны ажлыг 2024-2025 онд 30.0 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлнэ. | |
| 186 | 2.7.1.4. Дархан сумын 4, 5, 6, 7, 8 дугаар багийн гэр хорооллыг дахин төлөвлөлтийн хүрээнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, ГХБХБГ, Аймгийн Ерөнхий архитектор | ОНТХО80.0 | Архитектор төлөвлөлтийн даалагавар боловсруулж батлуулсан | 6 дугаар багийн 19 дүгээр хороолол тээвэрчид, Ханжаргалант Б аян-давааны гудамжуудад ХЕТ боловсруулна. | 75.0 | 35.0 | 2021-2023 онд Дархан сумын 4, 5, 6, 7, 8 дугаар багийн нутагт 5 байршилд нийт 136 га талбайд дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр ажлын даалгавар боловсруулж батлуулсан.<br>2023 онд Дархан сумын 13-р багт Залуус-1 хороолол 102 га талбайд, 15-р багт Залуус-2 хороололд 23 га талбайд хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг "Инженер геодези" ХХК нь гүйцэтгэж аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад 2023 онд тусгагдсан 721 сая төгрөгийн санхүүжилттэй Дархан сумын 1, 3, 5, 6, 7, 8, 9, 14, 15 дугаар багийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг хийх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Циркул проект” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж судалгааны ажлаа эхлүүлээд байна.<br>**Үр дүн:** Дархан сумын нутаг дэвсгэрт дахин төлөвлөлтийн 8 байршил 283,3 га газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдэнэ. | 70% |
| 187 | 2.7.1.5. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд | 2021-2024 | ХБТХОХ, | | | Орхон сумын гудамж, зам, талбай, үл | 0.0 | 0.0 | 2021-2023 онд Хаягийн мэдээллийн системд Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын нийт 13270 нэгж талбар, 1044 байшин, | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөрөнгийг хаягжуулж, мэдээллийг нэгдсэн системд байршуулна. | | ГХБХБГ | 135.0 | | хөдлөх эд хөрөнгийг хаягжуул-на. | | | 880 гудамж, нэгж талбар болон барилгын 12823 орц гарцын мэдээллийг байршуулсан байдаг. Үүнээс Орхон сумын 79 гудамж, 1351 хашаа, 138 өвөлжөө хаваржаа, 159 барилга хаягийн мэдээллийн системд орсон.<br>Үл хөдлөх хөрөнгө, зам талбай гудамжны хаягийн тэмдгийг үйлдвэрлэх, газар дээр нь байршуулах ажил хийгдээгүй байна.<br>2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 2/1655 дугаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу аймгийн хэмжээнд шинээр болон түр хаяг олгох, бүртгэх, орон нутгийн төсвийн хөрөнгөөр тэмдэгжүүлэх арга хэмжээг системийн шинэчилсэн хувилбар хэрэглээнд бүрэн нэвтрэх хүртэл түр хугацаанд зохион байгуулаагүй.<br>**Үр дүн:** Аймгийн хэмжээнд нэгдсэн хаягжуулалтын мэдээллийн сантай болсон байна. Орхон сумын гудамж, зам, талбай, хашаа, үл хөдлөх хөрөнгөнд 1727 хаягжуулалтыг хийсэн байна. | |
| 188 | 2.7.1.6. Аймгийн хэмжээнд байгаа Газар зүйн нэрийн тодруулга хийж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэж оруулна. | 2021-2024 | ХБТХОХ, ГХБХБГ, Газар зүйн нэрийн салбар зөвлөл | 25.0 | Нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийг геопортал программтай болсон. | Хонгор сумын Газар зүйн нэрийн тодруулга хийж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ. | 1.0 | 0.0 | 2021-2023 онд Дархан-Уул аймгийн 4 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 3.3 мянган км.кв талбайд нийт 1841 газар зүйн нэрийг тодруулах ажил хийгдэх шаардлагатай байгаа учраас БХБ сайдын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 123-р тушаалаар батлагдсан “Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ БД81-103-21”-ийг баримтлан Хонгор сум 82,3 сая төгрөгийн газар зүйн нэрийн тодруулалтын ажлын төсвийг гарган холбогдох газруудад хүргүүлсэн.<br>Хонгор сумын нутаг дэвсгэрт байрлах 300 өвөлжөө, хаваржааны хаяг дугаарыг газар зүйн нэртэй уялдуулан хаяг дугаар олгож газар зүйн мэдээллийн санд оруулан 2023 оны 05 сарын 15-нд Хонгор сумын засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсэн ба улмаар багийн ИНХ-ийн саналыг тусган, Хонгор сумын ИТХ-ын 2023.09.11-ны өдрийн 30 дугаар тогтоолоор хаягийн тогтоолыг батлуулсан. Аймгийн хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалтын ажилд 82 сая төгрөг шаардлагатай бөгөөд төсөв хөрөнгийн асуудал шийдэгдээгүй тул газар зүйн нэрийн тодруулалтын ажил хийгдээгүй.<br>2024 онд Газар зүйн нэрийн зургийн тодруулалт хийж мэдээллийн санд бүртгэх ажлыг | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гүйцэтгэхээр "Геомэп" ХХК шалгарч хээрийн судалгааны ажил хийгдэж байна.<br><br>**Үр дүн: Үр дүн:** УИХ-ын 43 дугаар тогтоолоор батлагдсан Дархан-Уул аймгийн 660 газар зүйн нэрийг тулгаж хянасан байна. Мөн Хонгор сумын газар зүйн нэрийн тодруулалт хийгдэж мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн байна. | |
| 189 | 2.7.1.7. Газрын ашиглалт, хяналтыг сайжруулж, мониторингийн системийг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, ГХБХБГ | - | Газар эзэмших, ашиглах эрхийн гэрээ дүгнэх журам батлагдсан. | (тайлан, дүгнэлт) | 0.0 | 0.0 | 2021-2023 онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар Газар эзэмших, ашиглах эрхийн гэрээ дүгнэх журмын 14-р зүйл гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх тухай заалт болон тус журмын гуравдугаар хавсралтын дагуу egazar цахим системийн дагуу нийт 65 газар эзэмшигчийн гэрээ дүгнэсэн байна.<br>2023-2024 онд газар дээрээ барилга, байшин бариагүй үйлдвэрлэлийн зориулалттай 46 нэгж талбар, худалдаа үйлчилгээний зориулалттай 112 нэгж талбар, нийтийн орон сууцны зориулалттай 91 нэгж талбар буюу нийт 249 нэгж талбарын газар ашиглалтанд хяналт хийж аймгийн Засаг даргад танилцуулж гэрээг дүгнэсэн байна.<br>**Үр дүн**: Газраа зориулалтын дагуу ашиглаагүй иргэн хуулийн этгээдийн газрыг хуулийн дагуу хяналтад авч газар эзэмших эрхийг хүчингүй болгох эсвэл газар ашиглалт сайжирч хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгажуулах ажил хийгдсэн байна. | 100% |
| **Дэд бүтэц** | | | | | | | | | |
| **2.7.2. Хот төлөвлөлтийн хүрээнд шинэ суурьшлын бүсийг байгуулж, хот, суурины дэд бүтцийг шинэчлэн сайжруулна.** | | | | | | | | | |
| 190 | 2.7.2.1. Шинэ суурьшлын бүсийн айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангана. | 2021-2024 | ХБТХОХ | 700.0 | "ДСЦТС" ХК-д зураг, төсөв хийж өгөх тухай хүсэлт гаргасан, зураг төсвийн зардалыг тооцоололыг гаргасан. | Орхон сумын 2 дугаар баг Энхтал, Ноёнхонгорын 900 гаруй айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангагдана. | - | - | ДСЦТС" ХК нь Дархан сумын Малчин баг болон Орхон сумын Энхтал баг, Ноёнхонгорын Шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн ажлаар 0,4 кВ-ын 2км агаарын шугам шинээр барьж 40 айл өрхийг цахилгаан эрчим хүчээр холбосон.<br>2024 онд Дархан сумын Малчин баг болон Орхон сумын Энхтал баг, Ноёнхонгорын Шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн ажлаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө 24.5 сая.төг-өөр 0,4 кВ-ын агаарын шугам шинээр барьж 16 айл өрхийг цахилгаан эрчим хүчээр холбосон.<br>**Үр дүн**: 2021-2023 онд Малчин, Энхтал, Ноёнхонгор шинэ суурьшлын бүсэд 2 км | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | агаарын шугам шинээр барьж 56 айл өрхийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангасан. | |
| 191 | 2.7.2.1. 35/6кВ-ын Хонгор дэд станцын иж бүрэн шинэчлэл хийнэ. | 2021 | ХБТХОХ | 592.0 | 35/6кВ-ын Хонгор дэд станцын тоноглол хуучирсан | 35/6кВ-ын Хонгор дэд станцын иж бүрэн шинэчлэл хийснээр чанар хүртээмж сайжирна. | 592.0 | - | Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК нь 700 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан дулааны цахилгаан станц ТӨХК-ны цахилгааны гаргалгаагаас Хонгор сумын төв хүртэлх 18 км газарт 35/6кВ-ын агаарын шугам шинээр татах ажлыг хийж гүйцэтгэлээ | 100% |
| 192 | 2.7.2.1. Туслах тосгоны түгээх сүлжээний К35.11.3- К35.11.6 худаг хүртэл Ф50-70 мм голчтой 120 хос метр шугамыг Ф89 болгон өргөтгөнө. | 2021 | ХБТХОХ | ДДС ТӨХК 29.4 | Ф50-70мм голчтой, 120 хос метр шугамыг Ф89 болгон өргөтгөнө. | - | -- | | Туслах тосгоны түгээх сүлжээний К35.11.3-К35.11.6 худаг хүртэлх Ф50-70 мм голчтой 120 хос метр шугамыг Ф89 мм шугамаар өргөтгөх ажлыг 29.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “ДДС” ТӨХК хийж гүйцэтгэлээ. | 100% |
| 193 | 2.7.2.1. Түгээх сүлжээний К18.10-К18.16 –ийн хооронд Ф89-Ф100 мм шугамыг өргөтгөж шинэчлэн солино. | 2021 | ХБТХОХ | ДДС ТӨХК 57.2 | К18.10-К18.16 -ийн хооронд шугам өргөтгөнө. | - | -- | - | Түгээх сүлжээний К18.10-К18.16–ийн хооронд Ф89-Ф100 мм шугамыг өргөтгөж шинэчлэх ажлыг 57.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “ДДС” ТӨХК хийж гүйцэтгэлээ. | 100% |
| 194 | 2.7.2.1. 2 дугаар хорооллын ДХ4-ДХ3 хүртэл Ф89 мм 66 хос метр халаалтын шугамыг Ф133 мм шугамаар өргөтгөх, ДХ3-Дх38 худаг хүртэл Ф89 мм-ийн 53 хос метр шугамыг Ф108 мм шугамаар өргөтгөнө. | 2021-2024 | ЗАА | ДДС ТӨХК 47.7 | ДХ4-ДХ3 хүртэл Ф89мм 66 хос метр,ДХ3-Дх38 худаг хүртэл Ф89мм-ийн 53 хос метр шугамтай | ДХ4-ДХ3 хүртэл Ф133мм 66 хос метр, ДХ3-Дх38 худаг хүртэл Ф108мм-ийн 53 хос метр шугам өргөтгөнө. | | | . Дархан сумын 2 дугаар хорооллын ДХ4-ДХ3 хүртэлх Ф89 мм 66 хос метр халаалтын шугамыг Ф133 мм шугамаар өргөтгөх ажлыг 47.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “ДДС” ТӨХК хийж гүйцэтгэлээ. | 100% |
| 195 | 2.7.2.1. Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулна. | 2021-2024 | ЗАА | 350.0 | 2021 онд аваар осол гараагүй, өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэл 96% | Сургууль, цэцэрлэг, НЗОС-ны инженерийн шугам сүлжээний шугам хоолойг шинэчлэн сольж сайжруулна. | 100.0 | - | 2023-2024 оны өвлийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хооронд “ДДЦС” ТӨХК-ийн ээлжит бүрэн зогсолтыг хийж засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>2024-2025 оны Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд Эрчим хүчний салбарын ерөнхий инженерүүдийн 2024.05.15-ны өдрийн хурлаар “Төвийн бусийн нэгдсэн сүлжээний | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 2024 оны зуны бага ачааллын горим ажиллагаа”-г баталсан графикын дагуу 2024.06.10-2024.06.13-ны өдрийн хооронд “ДДЦС” ТӨХК-ийн ээлжит бүрэн зогсолтыг хийж засварын ажлыг гүйцэтгэж байна.<br>Эрчим хүч, инженерийн шугам сүлжээний байгууллагууд болох “ДДС” ТӨХК, “ЦДҮС” ТӨХК-ийн ТБС, “Дархан-Ус суваг” ХК, “ДСЦТС” ХК нь их болон урсгал засварын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байна.<br>**Үр дүн:** Дархан-Уул аймгийн хот суурин газар, дэд бүтэц, түлш, эрчим хүчний байгууллагуудын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөв байдал 100% хэрэгжилттэй, аваар осол гараагүй, айл өрх, албан байгууллагын халаалтыг графикт хугацаанд залгасан. | |
| 196 | 2.7.2.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, | 3,100.0 | 31 хорооллын цахилгаан, цэвэр бохир усны төв шугам татагдсан. | - | 9,230.0 | 0.0 | Дархан сумын 9,10,12,15-р багийн нутаг дэвсгэрт байрлах 31-р хорооллын цэвэр, бохир усны шугам хоолой, цахилгаан хангамж угсрах ажил бүрэн дууссан. Улсын комисс ажиллаж хүлээлгэн өгсөн.<br>**Үр дүн:** Залуус хороолол-1,2 төслийн хүрээнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, төвлөрсөн цахилгаан хангамж, цэвэр, бохир усны шугам татах ажил хийгдсэн. 2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд төвлөрсөн дулаан хангамж татах 11.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлэхээр саналыг хүргүүлээд байна. | 100% |
| 197 | 2.7.2.3. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн үйлдвэрлэлийн бүсийн инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын | 27,313.0 | ТК-80 дулааны худгаас ТК-94 дулаан худаг хүртлэх шугам хоолойн насжилт дууссан. | - | 2,483.0 | 0.0 | Дархан сумын 13-р баг үйлдвэрийн бүсэд ТК-80 дулааны худгаас ТК-94 дулааны худгийн хооронд улсын төсвийн 2,483 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар дулааны төв Ф200 Ф250 мм шугам шинэчлэлтийн ажилд тендер зарлан Цагаан зуун ХХК шалгарч барилга угсралтын ажил бүрэн дуусаж 2022.09.30-ны өдөр улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан.<br><br>**Үр дүн**: Төрийн болон Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Арьс шир боловсруулах үйлдвэрийн дулаан хангамжийн эх үүсвэр бүрэн шийдвэрлэгдэнэ. | 100% |
| 198 | 2.7.2.4. Үндсэн тосгон туслах тосгоны бохир усны шугамын өргөтгөлийн ажлыг хийнэ. | 2022-2022 | Аймгийн ЗДТГ, Газрын харилцаа, | Улсын төсөв | | | | | Улсын төсвийн 8.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын 6, 7 дугаар багийн нутаг дэвсгэрт гэр хорооллыг дахин төлөвлөж, инженерийн шугам сүлжээнд холбох ажлын гүйцэтгэгчээр “Эс энд Эй трэйд” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Нийт дулааны 4298 м хос | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | барилга, хот байгуулалтын газар | | | | | | шугамын угсралтын ажил бүрэн дууссан. Бохир усны шугам 3880 м газарт хийгдэхээс 3820 м газарт бохир усны шугамын ажил хийгдсэн байна. 11 ус дулаан дамжуулах төвийн барилга, 1 насос станцын төвийн барилга угсралтын ажил хийгдсэн. УДДТөв болон насос станцын дулаан механикийн тоног төхөөрөмж суулгах гагнуурын ажил угсралтын ажил дууссан. | 100% |
| 199 | 2.7.2.4. Усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ. | 2022 | ХБТХОХ | 185.0 | Давснаас хлор гаргах төхөөрөмж байхгүй. | Давснаас хлор гаргах төхөөрөмжтэй болсон байна. | 185.0 | - | Дархан хотын хэрэглэгчдийг стандартанд нийцсэн ундны усаар хангах зориулалттай халдваргүйжүүлэх төхөөрөмжийн ашиглагдаж буй шингэн хлорын технологийг хоолны давснаас хлор гарган авах зарчимаар ажилладаг технологи нэвтрүүлэхээр компанийн инженер, техникийн ажилчдаас бүрдсэн баг судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэн 2024 оны 03 дугаар сард төсөл боловсруулж дууссан. Тус төслийн хүрээнд хоолны давснаас хлор гарган авах технологи нэвтрүүлэн ундны усыг халдваргүйжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр болох 300,000,000 төгрөгийг төсвийг Дархан-Уул аймгийн 2024 оны төсвийн тодотголд тусгаж өгч дэмжлэг үзүүлэхийг хүссэн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Аймгийн Засаг даргад 01/167, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад 01/166 дугаар албан тоот бичгээр тус тус хавсралт /39 хуудас төслийн материал, 3 хуудас техникийн тодорхойлолт, Монгол улсад худалдан борлуулах эрхтэй албан ёсны байгууллагын танилцуулга материал 24 хуудас/-ын хамт хүргүүлж ажилласан болно**.** | 100% |
| 200 | 2.7.2.5. Шарын гол, Хонгор сумдын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, засварын ажлыг эхлүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, | УТХО 445.2 | Хонгор сумын цэвэрлэх байгууламж 150м3/хоногт суурилагдсан хүчин чадалтай | 200м3/хоногт | 1,288,8 | 445,2 | Хонгор сумын Цэвэрлэх байгууламжийн барилгын их засварын ажлын зураг төсөв боловсруулах ажил хийгдсэн. Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд 445.2 сая төгрөг батлагдсан. Гүйцэтгэгчээр “Чанарын түншлэл” ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 100% хэрэгжиж байнгын ашиглалтад хүлээн авсан. | 70% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Шарын гол сумын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажлын зураг, төсөв боловсруулагдсан. 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд 843,6 сая төгрөгийн тусгасан.<br>**Үр дүн:** Хонгор сумын цэвэрлэх байгууламж шинэчлэлтийн ажил хийгдсэнээр 150м3/хоногт хүчин чадлыг 200м3/хоног болгон өргөтгөсөн.. Шинэчлэлтийн ажил 100 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 201 | 2.7.2.6. Шарын гол суманд “Шинэ орчин” хувийн орон сууцны хорооллын дэд бүтцийг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | 2021-2024 | ХБТХО Х, | УТХО 941.4 | Ф159, Ф219, Ф273мм 1458у/м ган яндан шинэчлэх | Шинэ орчин” хувийн орон сууцны хорооллын дэд бүтцэт татах 2 үе шатны ажлыг хэрэгжүүлнэ. | 188.3 | 188.3 | Шинэ орчин 74 айлын амины орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний ажил 2020 онд орон нутгийн төсвийн 278.0 сая төгрөгийн санхүүжилтээр, 2021 онд орон нутгийн төсвийн 168.0 сая төгрөгийн санхүүжилтээр, Шарын гол ХК 140.0 сая төгрөг, Бар трейд ХХК 104.5 сая төгрөгийн санхүүжилтээр нийгмийн хариуцлагын хүрээнд төвлөрсөн дулаан, цэвэр ус, бохир усны шугам шинээр татах ажил хийгдсэн. Энэхүү ажил хийгдсэнээр эхний 22 айлыг инженерийн шугам сүлжээнд холбогдох боломж бүрдсэн.<br>Шарын гол сумын Дархан баг “Шинэ орчин” хувийн орон сууц руу дулааны төв магистрал шугам татах, өргөтгөх ажилд 941.4 сая төгрөг батлагдсан бөгөөд 2023 онд 752.7 сая төгрөгөөр санхүүжүүлж, тус ажлын гүйцэтгэгчээр “Цахир түмэн алтай” ХХК шалгарч гэрээ байгуулсан. 2023 онд бүрэн ашиглалтад оруулсан.<br>**Үр дүн:** Тус төсөл хэрэгжсэнээр Шинэ орчин” хувийн орон сууцны хорооллын дулааны эх үүсвэр бүрэн шийдвэрлэгдлээ. | 100% |
| 202 | 2.7.2.7. Орхон сумын цэвэрлэх байгууламжийг шинээр барина. | 2021-2024 | ХБТХО Х | УТХО 1,540.0 | Цэвэрлэх байгууламж байхгүй | Цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн эхний үе шатны ажил хийгдэнэ. | 40.0 | 40.0 | 2021-2022 онд аймгийн орон нутгийн төсвийн 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Их мянган инженерчлэл” ХХК нь Орхон сумын цэвэрлэх байгууламжийн зураг, төсөв боловсруулж, Барилга хөгжлийн төвд Магадлал хийлгэж 2022. 06.03-ны өдөр захиалагчид хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн 2024 оны төсвийн төсөлд тусгуулахаар саналыг БХБЯ болон Сангийн яамны цахим мэдээллийн сан болох PIMIS –д байршуулла.<br>2024 онд Орхон сумын цэвэрлэх байгууламжийн ажлыг “Ноён өндөр констракшин” ХХК гүйцэтгэж Бүрэн ашиглалтад орлоо. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | **Үр дүн:** Барилгын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй. | |
| 203 | 2.7.2.8. Дархан хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажлыг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулна. | 2016-2022 | | Азийн хөгжлийн банк | | Хоногт 24000м3 бохир усыг хүлээн авах хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон байна. | | | Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244/3245 төсөл нь үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.<br>1.А1 багцын гүйцэтгэл 78%-тэй,<br>2. А2 багцын гүйцэтгэл 93%-тай,<br>3. А3 багцын гүйцэтгэл 89%-ийн гүйцэтгэлтэй.<br>Төслийн хэмжээнд нийт гүйцэтгэл 86.6%-тай байна. Пфайфер Эмит түншлэлтэй 2022 оны 06 сард гэрээ цуцалж 2022 оны 10 сарын 26 өдөр Байгууламж ХХК-тай төслийн үлдэгдэл ажлыг хийж дуусгах шинэчилсэн гэрээг 12,926,000,246 төгрөгний үнийн дүнтэйгээр гэрээ байгуулсан.<br>**Үр дүн**: Нийт бетон цутгалтын **98%** хийгдсэн. Хийц бүтээц арматурчлалын **95%** угсрагдсан. Тоног төхөөрөмж угсралтын **28%** хийгдсэн. Технологийн шугам хоолой угсралтын **50%** хийгдсэн. Буцаан булалт дүүргэлтийн ажил 45%-ийн гүйцэтгэлтэй. Цахилгаан, механик тоног төхөөрөмж худалдан авалтын **82%** төслийн талбайд нийлүүлэгдсэн. | 100% |
| 204 | 2.7.2.9. Хотын цэвэр усны төв шугамын засвар шинэчлэлтийн ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ. | 2022-2024 | ХБТХОХ, ГХБХБГ | 5,600.0 | 15 цэгт цэвэр усны шугам хоолойн гэмтэл байнга гардаг | Цэвэр усны байнга гэмтэл гардаг 5 цэгт засвар шинэчлэлт хийгдэнэ. | 300.0 | 300.0 | 2021-2023 онд Дархан сум, Цэвэр усны шугамын шинэчлэлийн ажлын 5.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 15-н байршилд /Дархан сумын 3, 8, 9, 10, 11, 13, 15-р багт хийхээр төлөвлөж, нийт ф80мм-ф630мм 10.6км шугам хоолойг шинэчлэх ажлыг 90% гүйцэтгэлтэй хийгээд байна.<br><br>**Үр дүн:** Гэмтэл гардаг аваарын байдалтай байгаа 15 цэгт цэвэр усны шугамын шинэчлэлт хийгдэнэ. | 90% |
| 205 | 2.7.2.11. Зөөврийн усан санг төвлөрсөн шугамд холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2022-2024 | ЗАА | 150.0 | Гэр хорооллын ус түгээх цэгүүдийг төвлөрсөн системд холбоно. | Зөөврийн усан 1 санг төвийн цэвэр усны шугамд холбоно. | 24.8 | 0.0 | 2022 онд Дархан-Ус суваг" ХК нь Дархан сумын 1-р багийн ус түгээх 2-р худгийг төвлөрсөн цэвэр усны шугам хоолойд холбох ажил хийгдсэн.<br>2023 онд Дархан сумын 5-р багийн нутаг дэвсгэрт байрлах №5 худгийг төвлөрсөн системд холбох ажлыг 24.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн.<br><br>**Үр дүн:** Найдвартай төвлөрсөн шугам хоолойн 1 шугамаар ундны ус хэрэглэнэ. 24 цагийн найдвартай ундны усаар хангах боломж бүрдүүлсэн. Ус түгээлтийн зардал буурсан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 206 | 2.7.2.12. Төв суурин газрын үерийн ус зайлуулах далан сувгийг засварлах ажлыг үе шаттай гүйцэтгэнэ. | 2022-2024 | ХБТХООХ, ЗАА | 4,270.9 | Дархан сумын 15-р багт 1.2км урт ус зайлуулах сувагтай. | Дархан сумын 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 15, 16 дугаар багийн үерийн бетон доторлогоотой далан, байгууламжийн ажил хийгдсэн байна. | 3,800.0 | 706.7 | Улсын төсвийн 4.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3.0 км урт үерийн ус зайлуулах сувгийг Дархан сумын 15-р багт нийт 4-н байршил, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 31-р хороололд үерийн ус зайлуулах далангийн шинэчлэлтийн ажлыг хийхээр төлөвлөсөн. Дээрх төсөл арга хэмжээнүүдийг 2023 оны 10 сард бүрэн дуусаж байнгын ашиглалтад хүлээн авсан. Ажлын гүйцэтгэл 100% биелэлтэй байна.<br><br>**Үр дүн:** Дархан сумын 15-р багт 2022 онд 0.851км урт үерийн ус зайлуулах хоолойг хийж, ажлын гүйцэтгэлд 400.0 сая төгрөг зарцуулсан бол 2023 оны 10-р сард тус төсөл 100% хэрэгжиж дууссан. | 100% |
| 207 | 2.7.2.13. Хотын ногоон байгууламжийг жил бүр нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХБТХООХ, ЗАА | 400.0 | Аймгийн ИТХ-ын 2021.10.17-ны 07-р тогтоолоор "Ногоон Дархан 2032" хөтөлбөрийг батлуулж, 11 жилийн хугацаанд 20.0 сая мод тарих аяныг эхлүүлсэн. | Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. | 100.0 | - | 2021 он<br>Нийтийн эзэмшлийн зам талбайн 22 байршлийн 122 га-д мод бут зүлэг тарьж, 300000 нэг наст мандлын цэцгийг гаргасан.<br>2022 он<br>Нийтийн эзэмшлийн 17756 м2 газрыг зүлэгжүүлж, 2128 м2 талбайд цэцгийн мандал байгуулан, 26748 мод, бут тарих ажилд 6.2 мянган иргэн, 203 аж ахуйн нэгж байгууллага хамрагдаж 254,0 сая.төг-ийг зарцуулсан.<br>2023 он<br>“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-аас хаврын тарилтаар нийтийн эзэмшлийн зам талбайд 420 мод, үржүүлгээр 40000, нэг наст мандлын цэцэг 300000, харандаан суулгац 20000 ширхгийг тус тус суулгаж, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажиллласан.<br>**Үр дүн:** Нийтийн эзэмшлийн зам талбайн 122 га-д ногоон байгууламжийн шинэ болон нөхөн тарилтууд хийгдсэн. | 100% |
| 208 | 2.7.2.14. Хүний эрүүл мэнд, амьдрах орчинд учруулж буй ургамал, амьтны сөрөг нөлөөллийг бууруулна. | 2021-2024 | ХБТХООХ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 56.0 | Шарилж устгах ажлыг 200га-д, Хориотой ургамалын устгал хийх ажлыг 385гад хийсэн. | Хавар, намар 5-10 удаа урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, зөөж тээвэрлэх хориотой ургамлын устгал хийнэ. | 40.0 | 40.0 | 2021 онд Хээрийн зэрлэг амьтан суурьшлын бүсэд орж ирсэн тохиолдолд барьж авч, зөөн тээвэрлэх, нутаг шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хонгор сумын 2-р багийн нутаг Мухарын голд зусаж буй малчдын хот руу болон бэлчээрт мал руу хүрэн баавгай дайрсан тохиолдлууд гарсан. Иргэдийн өгсөн мэдээллийн дагуу “Зэрлэг амьтан | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хамгаалах нийгэмлэг” ТББ, Амьтан асралт ХХК-ийн хамтран Хустайн даваа, Могойн голоор зусаж буй нийт 300 гаруй малчдад зөвлөмж, сэрэмжлүүлгийг өгч ажилласан.<br>Шарилжгүй Дархан” дэд хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 23 дугаар тогтоолоор батлуулсан.<br>**2021 онд:** 1-р үе шат: Дархан –Уул аймгийн Дархан сумын хэмжээнд ургаж байгаа хог ургамлын 75%-нь шарилж луулийн төрлийн ургамалууд байгаа ба эдгээр ургамалуудыг устгахад дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Хог ургамлын грибцид Зингер хорыг эзэнгүй 86 га талбайд УГТХ-ийн хор цацдаг трактороор цацаж.<br>6-р сарын 18-наас 28 хүртэл 10 хоног 10 хүн автомакстай ажиллаж шарилж устгал хийсэн. Үүнд ДХТҮГ-ын хариуцдаг талбайн 29 га, Сөхүүдийн нутаг дэвсгэр ургадаг хог ургамалтай талбай 16 га, Эзэнгүй гэх тодотголтой 127га, гэр хороолол сөхгүй багуудын нутаг дэвсгэр дахь хог ургамалтай талбай-48га нэг бүрчлэн хэмжиж 3н үе шаттай 100 га шарилж усгтал хийсэн<br>2-р үе шат: 7-р сарын 10наас 17 ны хооронд 7 хоног 10 хүн хадуууртай хадаж 8 автомакстай хүнээр хорыг 100га талбайд цацаж хосолмол аргыг хэрэглэж ажилласан.<br>3-р үе шат: 8-р сарын 10-16 хүртэл 6 хоног 10 хүн хадуууртай ажиллаж сөх багуудтай хамтран хадуур хор гербицид өгч хамтран 100 га талбайн шарилж устгал хийсэн. Нийт 300 га талбайн шарилжийн 26 хоногт 30 ажилтан ажиллаж 9,9 сая төгрөгийг зарцуулсан.<br>**2022 онд:**<br>1-р үе шат: 6-р сарын 16 наас 27 ны хооронд 10 хоног 5 тн усны машин пад трактор 6 автомакс 10 хүний бүрэлдэхүүнтэй 220 га талбайн шарилж устгаж ажилласан<br>2-р үе шат: бороо их орсонтой холбоотой 7-р сарын 23наас 30 ны хооронд 8 хоног 10 хүн хадуууртай хадаж 5 автомакстай хүнээр хорыг 220 га талбайд цацаж хосолмол аргыг хэрэглэж ажилласан.<br>3-р үе шат: 8-р сарын 25-наас<br>9-р сарын 3 хүртэл 9 хоног 12 хүн хадуууртай ажиллаж 200 га талбайн шарилж устгал хийсэн. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Нийт 640га-д 27 хоногт 32 ажилтан ажиллаж 19,9 сая төгрөгийг зарцуулсан.<br>**2023 онд:** 1-р үе шат: 6-р сарын 30 наас наас 7-р сарын 3 ны хооронд 3 хоног 5 тн усны машин пад трактор 10 автомакс 10 хүний бүрэлдэхүүнтэй 200 га талбайн шарилж устгаж ажилласан.<br>2-р үе шат: бороо их орсонтой холбоотой 7-р сарын 20ноос 30 ны хооронд 10 хоног 10 хүн хадуууртай хадаж 5 автомакстай хүнээр хорыг 180 га талбайд цацаж хосолмол аргыг хэрэглэж ажилласан.<br>3-р үе шат: 8-р сарын 1 нээс үргэлжлэн шалилж хадах ажил 12 хүн 25 хүртэл хадах арга хэмжээг авч ажиллаж 180 га талбайн шарилж устгал хийсэн.<br>Нийт 560 га-д 38 хоногт 32 ажилтан ажиллаж 18,1 сая төгрөгийг зарцуулсан.<br>**2024 онд:** 19,9 сая төгрөгийг зарцуулсан. Шарилжгүй дарханы дэд хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 7-р сарын 3,4,5 ны өдрүүдэд нийт 200 га талбайд 120 литр раундап:<br>8 кг алмазис, хор цацаж 1-р шатны шарилж устгалын ажил хийж гүйцэтгэсэн.<br>2-дугаар үе шатыг 7-р сарын 25-наас 31-ны хооронд хор болон цахилгаан хадуур гэсэн хосолмол 2 аргаар дээрхи 200 га талбайд устгалыг ахин хийсэн.<br>3-р шатны ажлыг 8-р сарын 10 наас 30 хүртэл нийтийн эзэмшлийн 29 га талбайн шарилжыг 4удаа хадаж устгаж, 84 га талбайн эзэнгүй талбай д үлдсэн шарилжыг цахилгаан хадуууraap хадаж устгалыг бүрэн хийж гүйцэтгэлээ. Шарилж их ургасан албан газрын судалгааг гаргаж албан бичиг явуулж, Нийт 2баг, 44 сөхүүдэд 3,5 кг алмазис<br>**Үр дүн:** Шарилж устгалын ажлыг 640 га талбайд, Хориотой ургамлын устгалыг 385 га талбайд хийж гүйцэтгэсэн. | |
| 209 | 2.7.2.15. “Эко жорлон” төслийг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. | 2021-2024 | ХБТХО Х, Захира гчийн ажлын алба, Байгал ь орчин, | 270.0 | 20 өрх эко нойлтой болсон. | “Эко жорлон” төслийн эхний үе шатны ажлыг хэрэгжүүлнэ. | 80.0 | - | Аймгийн Засаг даргын 2021 оны 01/А 223 захирамжаар “ЭКО ЖОРЛОН” төсөл батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Дархан дахин төлөвлөлт” ААТҮГазар “Дэлхийн зан ОУБ”-тай хамтран уг байгууллагын санхүүжилтээр Дархан сумын 15 дугаар багт 20 өрхөд “Эко жорлон” төслийг хэрэгжүүлэн сертификат, батламж олгож, 35 өрх хувийн зардлаар “Дэлхийн Зөн” ОУБ, “ЧББА”, ”Экололс” | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аялал жуулчлалын газар | | | | | | ХХК-иар сайжруулсан ариун цэврийн байгууламжийг 70,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.<br>2022 онд Орон нутагт нүхэн жорлонг хоргүйжүүлэх ажлын хүрээнд “Био технологийн инкубатор” ХХК 80,5 сая төгрөгийн санхүүжилтээр 22,9 тн биобэлдмэлийг 2 удаагийн давтамжтайгаар Дархан сумын 1, 2, 3 дугаар багийн 2290 өрхийн нүхэн жорлонг ариутгах ажлыг 100 хувь гүйцэтгэлээ.<br>2023 онд БОАЖЯ-ны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 01/06 дугаартай удирдамжийн дагуу Аялал жуулчлалын бааз, амралтын 17 газраас 13 газар нь стандартын шаардлага хангасан эко болон био жорлонтой болгож 4 газар нь стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлон байна. Нийт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 2 тэрбум орчим төгрөгийн зардал гарсан байна. Нүхэн жорлонгоо сайжруулж байгальд ээлтэй ариун цэврийн байгууламж байгуулсан 230 айл өрхийн бохирыг төрөөс зардлыг нь хариуцаж 11,500,000 сая төгрөгийн зардлаар соруулах ажил хийж байна.<br>2024 онд “Эколос” ХХК иргэдтэй гэрээ хийж 50 сайжруулсан ариун цэврийн байгууламж, “Их хаан бугуйвч” ХХК 50 шинээр суурилуулсан байна.<br><br>**Үр дүн**: Шинээр сайжруулсан ариун цэврийн байгууламжийг 336 иргэн, аж ахуйн нэгж 3,5 тэрбум төгрөгөөр бий болгож, Дархан сумын 1,2,3 дугаар багийн **2290** айл өрхийн нүхэн жорлонг 100,0 сая төгрөгөөр ариутгах, хоргүйжүүлж, 230 өрхийн бохирыг 11,5 сая төгрөгөөр соруулсан | 100% |
| **2.7.3. Айл өрхийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | |
| 210 | 2.7.3.1. “Орон сууц” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | - | Орон сууц дэд хөтөлбөр 2012-2020 хугацаа дууссан | 400 айл | 34,600.0 | 0.0 | “Орон сууц” дэд хөтөлбөрийн хүрээнд тус аймгийн хэмжээнд 2021 онд 318 айлын орон сууц баригдаж 318 айл өрх, 2022 онд 584 айлын орон сууц баригдаж 536 айл өрх, 2023 онд 17 байршилд 1793 айлын нийтийн орон сууц баригдаж байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>2024 онд 25 байршилд 1905 айлын орон сууц баригдаж байна. 4 байршилд 299 айлын орон сууцны барилга ашиглалтад орсон байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | **Үр дүн:** 2021-2024 онд нийт 2946 айлын орон сууц ашиглатад орсон. | |
| 211 | 2.7.3.2. “Тохилог орчин-Эко хороолол” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХ ОХ | 35,500.0 | 2022 онд Хөтөлбөрийн 2 дугаар үе шатанд 5 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг 95%-тай хэрэгжүүлсэн. | “Тохилог орчин-Эко хороол л” дэд хөтөлбөрийн гуравдахь үе шатны ажил хийгдэнэ. | 28,510.0 | 0.0 | - Дархан сумын 15-р багт "Гэр хорооллын доторх хатуу хучилттай авто замын ажил нь ИШС хүчитгэлийн ажил, цахилгааны шугамын шилжүүлэх, хүчитгэх ажил, цэвэр усны хүчитгэл болон шинэчлэх ажил, тохиромжгүй материал ухаж ачих ажлууд бүгд 100 хувь, далангийн ажил 60%, суурийн доод үеийн ажил 100% хэрэгжиж байна.<br>- Дархан сумын 5-р баг 0,6 км авто замын ажлыг УТХО-2 663,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 90%<br>- Дархан сумын 9, 10-р баг, Аймгийн төвийн доторх авто замын шинэчлэлт, засварын ажил /БАГЦ 3 DBS-Аюулгүйн тойрог 1.33 км хатуу хучилттай авто замын их засвар шинэчлэлт, Буталсан чулуун суурь 310 м3, суурийн доод үе 464 м3, суурь АБ хучилт 1237.6 м3, өнгө АБ хучилт 1190 м3, АБ нөхөөс 32 м3, АБ гагнаас 5830 у/м, ногоон байгууламж 12560м2, мод тарих 70ш ажлыг УТХО-2 203,1 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 90%.<br>- Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын ажлыг /Дархан сумын 6-7-р баг нийт 1,827 км авто зам тохиромжгүй материал ухаж ачих 25300,2 м2, зөөврийн далан байгуулах 47597,42 м3, ул хөрс нягтаршуулах 27103,9 м2, буталсан чулуун суурь/ “Дархан АЗЗА” ТӨХК улсын төсвийн 2,14 тэрбум.төгрөгөөр гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 90%<br>- Аймгийн төв доторх авто замын шинэчлэлт засварын ажил /багц 2/ 5-р баг Хүнсний үйлдвэрийн урдах авто замын засварыг ажлын Улсын төсвийн 2,6 тэрбум төгрөг. Гүйцэтгэл 90%<br>-2024-2025 онд Хорооллын доторх авто зам /Дархан сум 15-р баг/ 650.0 сая төгрөг | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | -2024-2026 онд Олон улсын Төмөр замын гармаас-Хара голын төмөр бетон гүүр хүртэлх авто зам /Дархан сум 1,2,3-р баг/ 6.4 тэрбум төгрөг, Гэр хорооллын доторх авто зам /Дархан сум 8-р баг/ 620.0 сая, Гэр хорооллын доторх авто зам /Дархан сум 15-р баг/ 820 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт хийгдэж байна.<br><br>**Үр дүн:** 21.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8.2 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулж, нийт гүйцэтгэл 90%-тай байна. | |
| 212 | 2.7.3.3. Дархан сумын 4, 5, 6, 7, 8 дугаар багийн гэр хорооллыг дахин төлөвлөлтийн хүрээнд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, “Дархан Дахин төлөвлөлт” ОНӨААТҮГ | 3,100.0 | | Хувийн хэвшлийн оролцоотой 60 айлын орон сууцыг ашиглал-тад оруулна. | - | - | Дархан сумын 4, 5, 6, 7, 8 дугаар багийн нутагт 5 байршилд нийт 136 га талбайд дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр ажлын даалгавар боловсруулж батлуулсан. Ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчээр "Инженер геодези" ХХК шалгарч гэрээ байгуулсан.<br>Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил 2021 онд эхэлсэн бөгөөд 2022 оны 10-р сард захиалагч байгууллагад хүлээлгэн өгөх гэрээ байгуулагдсан. Одоо гүйцэтгэлийн ажил 60% тай явж байна.<br>Инженер геодези ХХК-ны гүйцэтгэж байгаа ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил үргэлжилж байна. Тухайн баг бүрийн иргэдтэй уулзуулж, иргэдийн саналыг төлөвлөгөөнд тусгаж, компанийн удирдлага, инженерүүдтэй удаа дараа уулзалтуудыг хийж, саналаа өгсөн.<br>Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад 2023 онд тусгагдсан 750 сая төгрөгийн санхүүжилттэй Дархан сумын 1, 3, 5, 6, 7, 8, 9, 14, 15 дугаар багийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг хийх тендер Төрийн худалдан авах ажиллагааны газраар зарлагдан гүйцэтгэгчээр Циркул проект ХХК шалгарсан байна. Одоогоор хуваарийн дагуу баг бүрийн иргэдтэй уулзалт хийж, санал авах ажил явагдаж байна. Энэхүү ажил хийгдсэнээр Дархан сумын нутаг дэвсгэрт дахин төлөвлөлтийн 9-н байршилд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө бүрэн хийгдэж дуусах болно. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Мөн Дархан сумын 4, 5 дугаар багийн нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөл сонгон шалгаруулах тендерийг 2024.05.22, 2024.07.26, 2024.08.29 нд тус тус зарлаад байна.<br>**Үр дүн:** Тендер сонгон шалгаруулалт зарлагдан, ажил хийгдэж байна. | |
| **2.7.4. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | | |
| 213 | 2.7.4.1. Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дахин төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлж, орон сууцжуулна. | 2021-2024 | ХБТХОХ, “Дархан Дахин төлөвлөлт” ОНӨА АТҮГ | - | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын ажлын даалгаврыг боловсруул-сан. | Зураг төслийг хийлгэнэ. | 75.0 | 35.0 | 2021-2023 онд Дархан сумын 4, 5, 6, 7, 8 дугаар багийн нутагт 5 байршилд нийт 136 га талбайд дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр ажлын даалгавар боловсруулж батлуулсан. Ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчээр "Инженер геодези" ХХК шалгарч гэрээ байгуулсан.<br>Дархан сумын хэмжээнд нийт 9-н байршилд дахин төлөвлөлтийн хүрээнд Орон сууцжуулах ажлыг Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.<br>2024 онд Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын 420,0 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар Газар дэлхий ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажлаа гүйцэтгээд байна. Аймгийн ГЗБ ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа сум нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг уялдуулан хийж гүйцэтгэнэ.<br>**Үр дүн:** Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон сууцжуулах бэлтгэл ажлыг хангаж байна. | 100% |
| 214 | 2.7.4.2. Хувийн орон сууцыг төвлөрсөн, инженерийн дэд бүтцэд үе шаттайгаар холбоно. | 2021-2024 | ХБТХОХ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | - | 23,25 дугаар хороололд 80 гаруй айл өрх холбогдсон. | 23, 25 дугаар хороололд 25 айл, 5, 7, 8 дугаар багийн гэр хороололд 40 айл холбогдоно. | 0.0 | 0.0 | Дархан сумын 9,10 дугаар багт байрлах 23, 25 дугаар хорооллуудад 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 166 айл өрх инженерийн шугам сүлжээнд холбогдоод байна.<br>Дархан сум 8-р баг, Нарантолгой хэсэгт 36 айл инженерийн шугам сүлжээнд холбогдсон.<br>2024 онд Найрамдал төслийн хүрээнд Дархан сумын 5 дугаар багийн Залуучууд, Цагаан нуур, Хүнсчид, Үйлдвэр, 8 дугаар багийн Нарантолгойн, Манхантолгой хэсгийн нийт 591 айлын инженерийн шугам сүлжээнд холбох зураг төсөв хийгдсэнээс 179 айл хүсэлтээ гаргаж гэрээгээ байгуулсан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Манхантолгойн хэсэгт 35 айлын техникийн нөхцөл гарсан.<br>Нарантолгой хэсэгт 45 айл инженерийн шугам сүлжээнд холбогдсон.<br><br>**Үр дүн:** Нийт 202 өрх инженерийн шугам сүлжээнд холбогдсон. | |
| 215 | 2.7.4.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бага өртөгтэй орон сууцаар иргэдээ хангах ажлыг бодлогоор дэмжинэ. | 2021-2024 | ХБТХОХ, ГХБХБГ, Захирагчийн ажлын алба | 200.0 | | 2 үйлдвэрлэгчийг дэмжиж ажиллана. | 520.4 | 462.9 | 2023 онд Төрийн болон хувийн хэвшлийн ажилтан албан хаагчдыг хямд өртөгтэй орон сууцаар хангах ажлын хүрээнд Дархан сумын 6-р багт Дарханы Дулааны сүлжээ ТӨХК 800 мкв, Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар 800мкв, Дархан-Уул аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоо ТББ, Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК -ны ажилчдын орон сууц барих газар олголтыг хийсэн.<br>2024 онд тухайн 4 байршилд нийт 454 айлын орон сууцны барилга төлөвлөж ажлын зураг төсөл баталгаажуулж 3 байршилд барилга угсралтын ажил эхлээд байна. Мөн Дархан сум 11-р баг, 13-р хороололд Дархан сумын ЗДТГ ажилчдын 54 айлын орон сууцны барилгын ажил 45%-тай явагдаж байна.<br><br>Залуус хороолол: 10.0 мянган айл өрх буюу 36.0 мянга гаруй хүн ам суурьших хотхоны инженерийн дэд бүтэц татах ажилд 2022-2026 онд 86.5 тэрбум төгрөг зарцуулж байна. Эхний үе шатны ажил 56.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажил болох төвлөрсөн дулаан хангамж, Цэвэр бохир ус, цахилгаан хангамж татах 9-н багц ажлын гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан. Ажлын гүйцэтгэл 25% биелэлтэй. Хоёрдахь үе шатны ажил болох 30.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 6-н багц ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.<br><br>Дахин төлөвлөлт: 2024 онд УТХ 725 сая хөрөнгө оруулалтаар Дархан сумын 1, 3, 5, 6, 7, 8, 9, 15 дугаар багийн нийт 9 | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байршилд Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр Эдийн Засгийн Хөгжлийн Яамнаас зарласан тендерт Улаанбаатар хотын “Церкуль Проект” ХХК шалгарч, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Дархан сумын 5-р баг, Хүнсний ар, 8-р багийн Наран толгой, Манхан толгой айл өрхүүдийн амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэхээр дулааны шугамд холбох ажлыг “Дархан Дахин Төлөвлөлт” ААТҮГ, “Дархан Дулааны Сүлжээ” ТӨК-ууд гүйцэтгэж байна.<br>Дархан сумын 5-р баг Орос клуб орчмын 8.3 га газарт ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган дахин төлөвлөн, барилгажуулах, орон сууцжуулах ажлын хэсгийн аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан сонгон шалгаруулалтыг барилгын компаниудын дунд зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байна.<br><br>**Үр дүн:** Төрийн болон хувийн хэвшлийн ажилтан албан хаагчдыг хямд өртөгтэй орон сууцаар хангах ажлын хүрээнд:<br>-Дарханы Дулааны сүлжээ ТӨХК, Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар, Дархан-Уул аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоо ТББ, Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК болон Дархан сумын ЗДТГ-ын ажилчдын орон сууц барих газар олголтыг хийсэн.<br>-Залуус хорооллын төсөл,<br>-Дахин төлөвлөлтийн ажлууд шат дараатай хийгдэж байна. | |
| **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | | |
| **3.1. ТӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО** | | | | | | | | | | |
| **3.1.1. Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, *“Түгжрэлгүй төрийн үйлчилгээ”*-г нэвтрүүлнэ.** | | | | | | | | | | |
| 216 | 3.1.1.1. Үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ТЗУХ, МТА | 2.5 | И-Монголиа системийн 2 шатлалт 89 үйлчилгээ | Үйлчилгээний төрлийг 5 хүртэл нэмэгдүүлнэ. | - | - | Дархан-Уул аймагт төрийн үйлчилгээний “Хурдан” төв 2023 оны 4 дүгээр сарын 7 ны өдөр байгууллагдсан | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2024 онд 55 байгууллагын 1001 үйлчилгээг цахимаар үзүүлж байна. Дархан сумд 2 киоск, Хонгор, Орхон, Шарын гол сумдуудад тус тус 1 киоск машинаар иргэдэд үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Тус киоск нь төрийн болон хувийн хэвшлийн 600 гаруй үйлчилгээг нэг дороос иргэдэд үйлчилгээ үзүүлэх боломжтой.<br>**Цахим Хөгжил, Инноваци, Харилцаа Холбооны яамнаас хэрэгжүүлж буй Жишиг Цахим аймаг төслийн хүрээнд “Дижитал Дархан” Иргэдэд зориулсан портал аппликейшн** хийгдэж байна. Энэ нь иргэд нэг аппликейшнээс бүх төрлийн төрийн үйлчилгээ, төрийн байгууллагуудад өргөдөл, гомдол санал хүсэлтээ гаргах мөн хэрэглээний төлбөрөө төлдөг болох юм. | |
| 217 | 3.1.1.2. “E-Mongolia”-г орон нутагт нэвтрүүлэх, иргэдийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | МТА | ОНТ 2.0 | Лавлагааны тоо: 488 | “E-Mongolia” хэрэглээг нэмэгдүүлж, иргэд олон нийтэд сурталчилна. | - | | 2021 онд И-Монголиа системээр иргэдэд Дархан-Уул аймгийн ЗДТГ, БОАЖГ, ЦГ, ОБГ, ДОНЗТ, ЭМГ, ХХААГ, Дархан сум, АТҮТ, “Дархан-Ус суваг” ХК, “Дархан дулааны сүлжээ” ТӨХК зэрэг 11 байгууллагын 89 төрлийн 210 лавлагааг гаргасан байна.<br>2022 онд СХЗХ Тохирлын үнэлгээ хийлгэх /Иргэн, ААНБ/, ОБГ-Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтын хүсэлт /ААНБ/ 2 байгууллагын 3 үйлчилгээг шинээр нэвтрүүллээ. Мөн НҮНТөв болон Орхон, Хонгор, Шарын гол сумдуудад тус бүр угтах үйлчилгээний ажилтан ажиллаж байгаагаас гадна 38 төрлийн 2038 лавлагаа г гаргасан байна.<br>2023 онд 64 төрлийн 8205 лавлагааг и-монголиа системээр гаргасан байна.<br>2023 онд тус аймагт ТЦҮХ байгуулагдаж үйл ажиллагааны хүрээнд ХУРДАН төвийг байгуулан иргэд олон нийтэд төрийн цахим үйлчилгээг сурталчилан таниулж 39 байгууллагын 440 цахим үйлчилгээ үзүүлсэн.<br>2024 оны байдлаар “ХУРДАН” цэг нь 11252 үйлчилгээ үзүүлэн ажилласан байна. Үүнд:<br>Лавлагаа-9900<br>1 шатлалт үйлчилгээ-152<br>Зөвлөгөө мэдээллийн тоо-523<br>Олон шатлалт үйлчилгээ-1173 үйлчилгээнүүдийг үзүүлэн ажилласан байна.<br>**Үр дүн:** 2024 оны байдлаар “ХУРДАН” цэг нь 11252 үйлчилгээ үзүүлэн ажилласан байна. Үүнд: | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Лавлагаа-9900<br>1 шатлалт үйлчилгээ-152<br>Зөвлөгөө мэдээллийн тоо-523<br>Олон шатлалт үйлчилгээ-1173 үйлчилгээнүүдийг үзүүлэн ажилласан байна.<br>E Mongolia цахим системээр согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл сунгах, шинээр авах хүсэлтийн тохиргоог хийлгэж хүсэлтийг цахмаар хүлээн авч ажиллаж байна. | |
| 218 | 3.1.1.3. Үйлчилгээний стандартыг баталж мөрдүүлнэ. | 2021-2024 | ТЗУХ, МТА | 2.0 | Стандарт байхгүй | Стандар-тыг мөрдүүлнэ | - | - | 2021 онд MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо стандартыг УБТЗ-ын Дархан татах хэсэг, Улаанбаатар гурил ХХК, Хонгор сумын ЗДТГ үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн.<br>2022 онд MNS ISO 22000:2019 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо стандартыг Дархан эрдэнэ мах комбинат ХХК, MNS ISO/IEC 27001:2021 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо стандартыг Нийгмийн даатгалын хэлтэс, MNS ISO 21001 : 2021 Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо стандартыг ШУТИС-Дархан технологийн сургууль тус тус үйл ажиллагаандаа хэрэгжүүллээ.<br>**Үр дүн:** 2021-2024 онд менежментийн тогтолцооны 4 стандартыг 6 байгууллага үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна | 100% |
| 219 | 3.1.1.3. 70371212 нээлттэй утсыг тогтмол ажиллуулах, оператортой болгож байнгын ажлын байрыг бий болгоно. | 2021-2024 | ТЗУХ, МТА | 2.0 | 7037-1212 дугаарт ирсэн нийт дуудлагын тоо 578 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн цаг хугацаа, чанарыг | - | - | Нийт 8 төрийн байгууллага, 4 дэд бүтцийн байгууллага болон Аймгийн ЗДТГ өдөр тутмын санал гомдолд дуудлага хүлээн авахаас гадна “Иргэдийн индэр” нээлттэй хэлэлцүүлэгт шууд дуудлагын утсыг ажиллуулж нийт 2809 иргэний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.<br>“Иргэдийн индэр” нээлттэй хэлэлцүүлгийг 2022 онд 6 удаа зохион байгуулж 1393 иргэн биечлэн оролцож, санал асуулт ирүүлснийг тухай бүрт нь шийдвэрлэсэн бол<br>2023 онд нийт 5 удаа зохион байгуулж 2743 иргэн биечлэн оролцож, санал асуулт ирүүлснийг тухай бүрт нь шийдвэрлэсэн.<br>2024 онд “ИРГЭДИЙН ИНДЭР” нээлттэй уулзалтыг зохион байгуулж нийт 300 гаруй иргэн уулзалтад оролцож, 47 иргэн тулгамдаж буй санал, хүсэлт ирүүлснийг тухай бүрт нь шийдвэрлэсэн.<br>Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн 7037-1212 утсыг тогтмол ажиллуулан, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлтэд хяналт танвин ажиллаж байна.<br>**Үр дүн:** 70371212 утсанд нийт дуудлагын тоо 2809, Иргэдийн индэр нээлттэй хэлэлцүүлгийг нийт 11 удаа зохион байгуулж 4136 иргэн оролцож санал, асуулт ирүүлснийг шийдвэрлэсэн байна. | |
| 220 | 3.1.1.4. Төрийн байгууллагуудын able програмын ашиглалтыг сайжруулж, өргөдөл, гомдлыг цахимд бүртгэлжүүлэн шийдвэрлэнэ. | 2021-2024 | МТА | - | Авлэ програмд 26 агентлаг, 4 сумын ЗДТГ, 26 баг, цэцэрлэгийг 100 хувь хамруулсан | 10 байгууллагын програмын ашиглалтыг сайжруулна. | - | - | 2021 онд Дархан-Уул аймгийн 4 сумын ЗДТГ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлаг able програмын ашиглалтыг хангаж, өргөдөл гомдлыг хяналтад авч, шийдвэрлэж хэвшсэн<br>2022 онд 124 байгууллагын нийт 3433 хэрэглэгч бүртгэлтэй байна. Able програмын ашиглалтыг хангаж, 371 өргөдөл, гомдлыг хяналтад авч, шийдвэрлэсэн.<br>2023 онд Эйбл систем нь 124 байгууллагын нийт 3591 хэрэглэгч бүртгэгдсэн ба able програмын ашиглалтыг хангаж, 341 өргөдөл гомдлыг хяналтад авч, шийдвэрлэсэн.<br>“И-ДАРХАН цахим платформ”-ын вэб сайт болон гар утасны аппликейшныг хэрэглээнд нэвтүүлсэн.<br>Ашиглаж буй хэрэглэгчийн тоо 503, төрийн болон ОНӨГ зэрэг 46 байгууллагыг системд бүртгэж админ нарт практик сургалт орсон.<br>И-Дархан аппликэйшн, Төрийн байгууллагуудын үйлчилгээнд иргэд санал гомдол явуулдаг систем хэрэгжиж эхэлснээр нийт 99 санал гомдол хүлээн авч шийдсэн.<br>2024 онд И-Дархан санал асуулга, өргөдөл гомдлын нэгдсэн аппликэйшн болон вэб сайтыг нэвтрүүлсэн.<br>И-Дархан системд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол тухайн байгууллагад шууд илгээгдэнэ. Эрсдэлийг мэдээлэх систем болох “Эрсдэл Дархан” систем ашиглалтад орж иргэдээс ирсэн эрсдэлийн мэдээллийг админаас дэд бүтцийн байгууллагуудад руу шилжүүлэх зэрэг цахим ашиглалтыг сайжруулах сургалт болон иргэдэд сурталчилгаа мэдээллийг тогтмол түгээн ажиллаж байна. Систем ашиглалтын зөвлөгөө зааврыг утсаар болон цахимаар өгч ажиллаж байна.<br>Байгууллагуудад шинээр ажилд орж байгаа болон тухайн байгууллагынхаа удирдагчийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | эрх солигдож буй байгууллагуудад систем ашиглалт, тохиргооны талаар сургалт хийсэн.<br>**Үр дүн**: Эйбл систем нь 124 байгууллагын нийт 3591 хэрэглэгч бүртгэлтэй байна. Able програмын ашиглалтыг хангаж, нийт 712 өргөдөл гомдлыг хяналтад авч, шийдвэрлэснээс гадна Өргөдөл, гомдлыг И-Дархан, Эрсдэл аппликэйшнаар бүртгэлжүүлж, цахимаар хүлээн авч нийт 471 санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэж ажилласан. | |
| 221 | 3.1.1.5. Багийн хөгжлийн төвүүдийг үе шаттайгаар компьютерээр хангаж, үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | 2020-2024 | ТЗУХ, МТА | - | 26 баг | Багийн төв дээрээс төрийн үйлчилгээний цахим систем Е.Монголиа үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ. | - | - | "Цахим Дархан" төслийн хүрээнд Дархан сумын нийт 7 багийн төвд, Шарын гол, Орхон, Хонгор сумдын төвийн багуудад тус бүр байгуулан нийт 11 цэгт төрийн үйлчилгээ үзүүлж байна.<br>**Үр дүн:** Багийн хөгжлийн төвүүдийг үе шаттайгаар компьютерээр хангах ажил **100 хувь хийгдсэн** | 100% |
| 222 | 3.1.1.6. Цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын тоог нэмэгдүүлнэ. | 2020-2024 | ТЗУХ, МТА | - | Давхардсан тоогоор 285 байгууллага 150 төрлийн төрийн үйлчилгээ | Иргэдийн сэтгэл ханамж 5%-иар дээшилнэ. | - | - | Төрийн цахим үйлчилгээний төв И-Монголиа төвөөс нийт 61 байгууллагын 923 төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Үүнд олон шатлалт үйлчилгээ-801, лавлагаа- 121<br>Шинээр Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт, Эрүүл мэндийн байгууллагаас цаг авах, эмнэлгийн магадлагаа, Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, шинжилгээний хариу, ХХҮГ-аас хүүхэд асарсны тэтгэмж, авах хүсэлт, мөнгөн тэтгэмжийн үйлчилгээ, НД- аас ажилгүйдэлийн, жирэмсний болон амаржсны тэтгэмж авах хүсэлт, сайн дураар даатгуулах хүсэлт зэрэг үйлчилгээг үзүүлж байгаа бол Дархан-Уул аймгаас Стандарт хэмжил зүйн төв, Ус суваг, ЭМГ, Авто тээврийн төв, УБГ, БОАЖГ зэрэг байгууллагууд зарим үйлчилгээний тусгай зөвшөөрлийг цаг алдалгүй авах болсон. Тухайлбал Дархан ус суваг ХК техникийн нөхцөл олгох хүсэлт, Стандарт хэмжил зүйн газар тохиролын үнэлгээ хийх хүсэлт зэрэг үйлчилгээг үзүүлдэг болсон.<br>Дархан-Уул аймгийн 273 иргэнээс E-Mongolia системийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч ажилласан бөгөөд иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ **80** хүртэл хувиар нэмэгдсэн байна.Мөн Дархан-Уул аймгийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран ХУРДАН төвийн оператор ажилтнуудад цахим сургалтыг явуулсан Мэдээллийн технологийн чиглэлээр 12 удаагийн цахим, танхимийн сургалтад хамрагдаж, танхим болон цахимаар 4 удаагийн сургалтыг зохион байгууллаа<br>**Үр дүн:** Нийт 61 байгууллагын 923 төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Иргэдийн сэтгэл ханамж 80%-иар нэмэгдсэн. | |
| 223 | 3.1.1.7. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд чанарын менежентийн тогтолцооны стандартын хэрэгжилтийг байнга сайжруулна. | Жил бүр | ХШҮХ | 18.0 | - | 66.65% | - | - | Аймгийн хэмжээнд ISO 9001 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн байгууллага-23, HACCP тогтолцоог нэвтрүүлсэн байгууллага-1, "Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо. Шаардлага" MNS ISO 45001 стандартыг нэвтрүүлсэн байгууллага-4, Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001 стандартыг нэвтрүүлсэн байгууллага-2, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000 стандартыг нэвтрүүлсэн байгууллага-2, Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO/ IEC 27001 стандартыг нэвтрүүлсэн байгууллага-1, Боловсролын байгууллагын чанарын менежментийн тогтолцоо ISO 21001 стандартыг нэвтрүүлсэн байгууллага-1 үйл ажиллагаа явуулж байна.<br>**Үр дүн:** 35 аж ахуйн нэгж байгууллагын 100 гаруй чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн, удирдах ажилтнуудыг хамруулан 5 удаагийн сургалтыг зохион байгуулж ажилласны үр дүнд Улаанбаатар гурил ХХК ISO 9001 чанарын менежментийн тогтолцоо, Дархан мах эрдэнэ комбинат ХХК Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн гэрчилгээгээ гардан авлаа. | 100% |
| **3.1.2. Шийдвэр гаргахад иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 224 | 3.1.2.1. Бодлогын баримт бичиг, дүрэм журмын төсөлд иргэдээс цахим орчинд санал авах үйл | 2021-2024 | ТЗУХ, МТА | - | Цахимаар авсан санал асуулгын тоо: 11 | Цахимаар иргэдээс санал авах орчныг бүрдүүлнэ. | - | - | www.smartdarkhan.com, google form, Иргэдээс санал авах Иргэдийн индэр нээлттэй хэлэлцүүлэг, санал гомдлын шууд дуудлагын утсаар болон тухай бүрд нь нээлттэй санал асуулга цахимд байршуулан ажилласан. | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг идэвхжүүлнэ. | | | | | | | | Мөн Дархан-Уул аймгийн албан ёсны цахим хуудас http://darkhan.gov.mn/, google form, “Дархан-Уул аймаг” цахим хуудас, “Дархан хот” пэйж хуудсаар Иргэдээс санал авах Иргэдийн индэр нээлттэй хэлэлцүүлэг, санал гомдлын шууд дуудлагын утсаар болон тухай бүрд нь нээлттэй санал асуулга цахимд байршуулан ажиллаж байна.<br>Аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний Танхим, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар хамтран “Архидан согтуурахтай тэмцэх хөтөлбөр”-ийн төсөлд<br>Газрын багц хуулийн төсөлд<br>Газрын ерөнхий хуулийн төсөл:<br>Геодези, зураг зүйн тухай /шинэчилсэн найруулга/:<br>Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл:<br>Дархан-Уул аймгийн 2022 оны “Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө<br>Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл<br>Үндсэн хуулийн өөрчлөлтийн төсөл<br>Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд боловсролын багц хуулийн төсөлд<br>Дархан-Уул аймгийн хэмжээнд “Бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого олж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг тогтоох” тогтоолын төсөлд санал авч ажиллалаа<br>**Үр дүн:** Нийт 2021-2024 онд 18 санал асуулга авсан. | |
| 225 | 3.1.2.2. Иргэний танхимын хэлэлц үүлгийг цахимаар зохион байгуулж хэвшүүлнэ. | 2021-2024 | ТЗУХ, МТА | - | Цахимаар авсан санал асуулгын тоо: 11 | 3-аас доошгүй | - | - | 2021 онд Иргэний танхимын хэлэлцүүлгийг 10 удаа цахимаар зохион байгуулсан.<br>2022 онд Иргэний танхимын хэлэлцүүлгийг 17 удаа танхим болон цахимаар зохион байгуулсан ба “Иргэдийн индэр” нээлттэй хэлэлцүүлгийг 6 удаа зохион байгуулж 1393 иргэн биечлэн оролцож, санал асуулт ирүүлснийг тухай бүрт нь шийдвэрлэсэн бол | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2023 онд 5 удаа зохион байгуулж 2743 иргэн биечлэн оролцож, санал асуулт ирүүлснийг тухай бүрт нь шийдвэрлэсэн.<br>2024 онд 1 удаа зохион байгуулж 300 гаруй иргэн биечлэн оролцож, 47 иргэн санал асуулт ирүүлснийг тухай бүрт нь шийдвэрлэсэн.<br><br>**Үр дүн**: Иргэний танхимыг нийт 27 удаа, Иргэдийн индэр нээлттэй хэлэлцүүлгийг нийт 12 удаа зохион байгуулж 4436 иргэн оролцож санал, асуулт ирүүлснийг шийдвэрлэсэн байна. | |
| 226 | 3.1.2.3. Төрийн зарим чиг үүрэг /хөндлөнгийн хяналт тавих, төсөл хэрэгжүүлэх, сургалт явуулах, санал асуулга явуулах гэх мэт/-ийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, иргэн, ТББ-ын оролцоог нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХБТХ ОХ, НБХ | 400 сая хүртэл | 6 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн | Төр, ТББ-ын хамтын ажиллагаа сайжирсан байна. | 520.4 | 462.9 | 2021 онд Иргэдийн оролцоотой төсөл хөтөлбөрт 13 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж 73.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон бол, 2022 онд 31 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 520.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон бол 2023 онд 88 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг санхүүжилт олгосон байна.<br>2024 онд Иргэдийн оролцоотой төсөл хөтөлбөрт 18 төсөл, арга хэмжээг 261 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн.<br>**Үр дүн:** Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 150 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 2.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн. | 100% |
| **3.1.3. Төрийн албан хаагчдыг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран сурч хөгжих орчныг бүрдүүлж, мэдлэг, чадварыг дээшлүүлэн, тогтвор суурьшилтай ажиллуулна.** | | | | | | | | | | |
| 227 | 3.1.3.1. Төрийн албан хаагчийн сургалтын бодлогын төлөвлөгөө гаргаж, төрийн албан хаагч 1 бүрээр сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулна. | 2021-2024 | ТЗУХ | 20.0 | 98 төрийн байгууллага | Сургалтын хөтөлбөрийг боловс-руулж, мөрдөнө. | - | - | 2021 онд 98 төрийн байгууллага сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэн ажилласан,<br>2022 онд 72 төрийн байгууллага сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэн ажилласан,<br>2023 онд мөн 72 төрийн байгууллага сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэн ажилласан,<br>2024 онд мөн 72 төрийн байгууллага сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэн ажилласан,<br>**Үр дүн:** Нийт давхцсан тоогоор 314 төрийн байгууллага сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэн ажилласан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 228 | 3.1.3.2. Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн эрхэлсэн, ахлах, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны багц сургалт, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх болон мэргэшүүлэх, мэргэшил дээшлүүлэх институтийн богино хугацааны сургалтад ирүүлсэн квотын дагуу үе шаттай хамруулна. | 2021-2024 | ТЗУХ | - | 14 албан хаагч | 80 хүртэл төрийн албан хаагч | - | - | 2021 онд Төрийн албаны сургуулиас зохион байгуулдаг эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2,ахлах түшмэлийн багц сургалтад 6, төрийн албанд шинээр томилогдсон албанхаагчдын мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 13, төрийн албанд шинээртомилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 14, Мэргэшил дээшлүүлэхинститутийн богино хугацааны сургалтад 40 албан хаагч тус тус суралцаж, нийт 75 албан хаагч цахим хэлбэрээр сургалтад хамрагдаж төгссөн.<br><br>2022 онд Төрийн албаны сургуулиас зохион байгуулдаг төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 13, шинээр томилогдсон албан хаагчдын мэргэшүүлэх багц сургалтад 6, албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт 11, ахлах түшмэлийн багц сургалтад 7, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 1 нийт 38 албан хаагч хамрагдсан.<br><br>2023 онд Төрийн албаны сургуулиас зохион байгуулдаг төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 13, шинээр томилогдсон албан хаагчдын мэргэшүүлэх багц сургалтад 6, албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт 11, ахлах түшмэлийн багц сургалтад 7, нийт 37 албан хаагч хамрагдсан.<br><br>2024 оны эхний хагас жилд Төрийн албаны сургуулиас зохион байгуулдаг төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад 5, шинээр томилогдсон албан хаагчдын мэргэшүүлэх багц сургалтад 7, албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт 8, ахлах түшмэлийн багц сургалтад 5, нийт 25 албан хаагч хамрагдсан.<br><br>**Үр дүн:** Нийт 175 албан хаагч Төрийн албаны сургуулийн эрхэлсэн, ахлах, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны багц сургалт, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх болон мэргэшүүлэх, мэргэшил дээшлүүлэх институтийн богино хугацааны сургалтад хамрагдсан байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 229 | 3.1.3.3. Төрийн албан хаагчдыг олон улсын онлайн болон гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлнэ. | 2021-2024 | ТЗУХ | - | 1 албан хаагч | 10 хүртэл төрийн албан хаагч | - | Бусад улсын тэтгэлэгт хөтөл-бөрөөр | 2021 онд Удирдлагын академи болон Сингапурын Үндэсний их сургуулиас хамтран зохион байгуулсан "Data innovation lab virtual capacity building program" сургалтад аймгийн ЗДТГ-ын 5 албан хаагч суралцаж гэрчилгээ авсан.<br>2022 онд Английн Лондон хотод төвтэй Хүний нөөцийн институт (CIPD)-ийн сургалтад 1 албан хаагч онлайнаар 6 сарын хугацаатай, Энэтхэг улсад Жижиг бизнес эрхлэгч, сургагч багш нарыг бэлтгэх дунд хугацааны /2022.09.12/ сургалтад тус улсын Гадаад харилцааны яамны тэтгэлгээр 2 албан хаагч суралцсан.<br>2023 онд албан хаагч мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаагүй.<br>2024 онд Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ-ын дарга Д.Элдэвсайхан нь 2024.03.09-17-ны өдрүүдэд Словени улсын Айдовшина хотод зохион байгуулагдсан солилцооны хөтөлбөр, Орхон сумын Засаг дарга Б.Түмэнцогт, Дархан сумын ЗДТГ-ын дарга Б.Батзул нар БНСУ-д зохион байгуулагдсан NEAR олон улсын туршлага судлах форум, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Мөнхсүрэн БНСУ-ын Нутгийн удирдлагын институт (LOGODI)-ийн төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрийн богино хугацааны сургалтад тус тус хамрагдсан.<br>**Үр дүн:** Нийт 11 албан хаагч гадаад улсад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна. | 100% |
| 230 | 3.1.3.4. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн байгууллага бүр “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ТЗУХ | - | 98 байгууллага | 3 агентлаг, 5 цэцэрлэг, 5 сургууль | - | - | 2021 онд 98 төрийн байгууллага урт, богино, дунд хугацаагаар баталж хэрэгжүүлэн ажилласан,<br>2022 онд 72 төрийн байгууллага урт, богино, дунд хугацаагаар баталж хэрэгжүүлэн ажилласан,<br>2023 онд 72 төрийн байгууллага урт, богино, дунд хугацаагаар баталж хэрэгжүүлэн ажилласан,<br>2024 онд 72 төрийн байгууллага урт, богино, дунд хугацаагаар баталж хэрэгжүүлэн ажилласан,<br>**Үр дүн:** Нийт 314 төрийн байгууллага урт, богино, дунд хугацаагаар баталж хэрэгжүүлэн ажилласан | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 231 | 3.1.3.5. Төрийн албаны тухай хуульд заасан чадахуйн зарчимд үндэслэн төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах, томилох, албан тушаал дэвшүүлэх зарчмыг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ТЗУХ | - | 41 сул орон тоо нөхөгдсөн | Төрийн албаны тусгай шалгалтын дүн | - | - | 2023 он: Төрийн албаны зөвлөлийн Дархан Уул аймаг дахь Салбар зөвлөлөөс 2023 оны 3 дугаар улирлын байдлаар төрийн албаны тусгай шалгалтыг 10 удаа зохион байгуулж 96 сул орон тоог нээлттэй зарлаж Төрийн албаны тухай хуульд заасан чадахуйн зарчимд үндэслэн төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагч болон төрийн албаны нөөцөд байгаа 292 иргэнээс албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагын дагуу сонгон шалгаруулж 134 иргэнийг нэр дэвшүүлж, 127 сул орон тоо нөхсөн байна. Төрийн жинхэнэ албанд орох хүсэлтэй иргэнийг сонгон шалгаруулж, төрийн албан хаагчийн нөөц бүрдүүлэх зорилгоор төрийн албаны ерөнхий шалгалтыг улирал тутам зохион байгуулж 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 388 иргэд шалгалт өгөхөөр бүртгүүлж үүнээс 253 иргэн шалгалт өгч 110 иргэн шалгалтад тэнцэж төрийн албан хаагч нөөцөд бүртгүүлсэн байна.<br>**Үр дүн:** Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн дагуу чадахуйн зарчимд үндэслэн 127 сул орон тоог нөхсөн байна. | 100% |
| 232 | 3.1.3.6. Салбар зөвлөлийн харьяа 23 Ёс зүйн зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангах, Ёс зүйн зөвлөлийн дүрэм боловсруулж, мөрдүүлнэ. | 2021-2024 | ТЗУХ, ТАЗСЗ | - | 8 албан хаагч оролцсон | 23 ёс зүйн зөвлөл | - | - | 2023 он: Улсын Их Хурлын сахилга хариуцлагын байнгын хороо, Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл хамтран Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төслийг хэлэлцүүлэн, “Төрийн албаны шинэтгэл, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим систем, танилцуулга сургалт, төрийн байгууллагын Ёс зүйн хорооны 100 гишүүнийг чадавхжуулах сургалтыг 2023 онд зохион байгуулж, төрийн байгууллагын 400 гаруй албан хаагчдыг оролцуулан сургалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Салбар зөвлөлөөс шинээр батлагдсан хууль тогтоомжийг төрийн албан хаагчдад сурталчлах, сургалт зохион байгуулах чиг үүргийн хүрээнд 2023 оны 10 дугаар сард “Төрийн албан хаагчийн ёс зүй, гүйцэтгэлийн удирдлага” сэдэвт сургалтыг 26 төрийн байгууллагын 878 төрийн албан хаагчийг хамруулан сургалт зохион байгууллаа.<br>**Үр дүн**: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан төрийн байгууллагын ёс зүйн хорооны ажиллах дүрэм, журам батлагдаж, хуулийг хэрэгжүүлэх | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | чиглэлээр сургалт зохион байгуулж 1200 гаруй төрийн албан хаагчийн хамруулла. | |
| **3.1.4 Гадаад улс орнуудын муж, хотуудтай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.** | | | | | | | | | | |
| 233 | 3.1.4.1. Шууд болон ах дүү хотуудын уламжлалт найрсаг харилцааг өргөжүүлнэ. | 2021-2024 | ТЗУХ | - | Ах дүүгийн 6 хот | 1-2 гадаадын шинэ муж, хот | - | - | 2021 онд Япон, Азийн хөгжлийн банк, Австри, НҮБ, АНУ, Европын холбоо зэрэг 6 улстай уламжлалт найрсаг харилцааг өргөжүүлсэн.<br>2022 онд Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард улс, АНУ-ын ЭСЯам, БНХАУ-ын У Хай, ОХУ-ын Братск хот, Испанийн хаант улсын Астариус муж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, БНСУ-ын Чёнвон хотууд,<br>Япон Улс, БНСУ-ын Кёнги аймаг, Канад улсын Рижайна муж , Монтенегро улсын Бар хот, Бүгд найрамдах Солонгос улсын Тэжонь хот, Бүгд Найрамдах Энэтхэг улс, Бүгд Найрамдах Буриад улс, Бүгд Найрамдах Турк улсын Зейтинбурну, Гөнэн хот, Канад улс зэрэг 11 улс, 5 хот, 1 аймаг, 1 мужтай уламжлалт найрсаг харилцааг өргөжүүлсэн.<br>2023 онд 5 элчин сайд, 9 олон улсын байгууллагыг хүлээн авч, 4 санамж бичиг байгуулсан.<br>2024 онд Канад, Япон, Эстони, БНПУ-ын Элчин сайдууд болон АНУ-ын ЭСЯ-ны дэд Консул нарыг хүлээн авч уулзсан. Энх тайвны корпус, Жайка, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Азийн хөгжлийн банк, Найрамдал төслийн санхүүжүүлэгч ЕХ-ны суурин төлөөлөгч, Тайван дах Европын холбооны суурин төлөөлөгчийн газрын дарга, НҮБ-ийн хүүхдийн сан, БНСУ-ын Аялал жуулчлалын төрийн өмчит Корпорац КТО, БНСУ-ын Би Флатийн Сервис зэрэг 9 олон улсын байгууллагтай хамтын ажиллагаа өрнүүлсэн.<br>**Үр дүн**: Давхцсан тоогоор нийт 31 улстай уламжлалт найрсаг харилцааг өргөжүүлж, 9 олон улсын байгууллагтай хамтын ажиллагаа өрнүүлсэн. | 100% |
| 234 | 3.1.4.2. Орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг гадаадын төсөл хөтөлбөрт хамруулах, байгууллагуудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ. | 2021-2024 | ТЗУХ | - | - | 10 хүртэл орон нутгийн ААНБ | - | - | 2021 онд Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, дэд бүтэц, хөдөө аж ахуйн салбаруудад орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж гадаадын төсөл хөтөлбөрт хамруулж 8 улстай хамтран ажилласан.<br>2022 онд ЕВРОП-ДАРХАНЫ ИННОВАЦ ЭНТРЕПРЕНЕРШИП ТӨВ-д бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж "Гарааны бизнесийг чадавхжуулах модуль-1, 2" сургалтад харилцан туршлага судлах зорилгоор 10 гаруй бизнес | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | эрхлэгчид, 8 аж ахуйн нэгж байгууллага хамрагдсан.<br>2023 онд Найрамдал төслийн хүрээнд Австри улсын “ЮНИ КРЕДИТ” банкны санхүүжилтээр эргэн төлөх нөхцөлгүйгээр 7,5 сая еврогийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн.<br>2024 онд -НҮБ-ийн хүүхдийн сангаас Нэгдсэн эмнэлэгт 94000 ам долларын үнэ бүхий Эмнэлэгийн хог хаягдлыг боловсруулах байгууламжийг нийлүүлсэн.<br>-АХБ-ны 10.6 тэрбум санхүүжилтээр 960 хүүхдийн сургууль ашиглалтад орсон.<br>-Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр нийт 35.730 мкв талбайтай, 250 ортой, өдөрт 800 хүнд амбулатори болон эмчилгээ үзүүлэх, тусгай тоноглол бүхий 6 мэс заслын өрөөтэй, сард 5000 хүнд оношилгоо хийх 20,000 лабораторийн шинжилгээ хийх хүчин чадал бүхий эмнэлэг байхаар төлөвлөжээ.<br>**Үр дүн**: Найрамдал төслийн хүрээнд 8 улстай хамтран ажиллаж, 7.5 сая еврогийн хөрөнгө оруулалтаар Аймгийн хэмжээнд нийт 14 км цэвэр усны шугам, 15 мянган ширхэг ухаалаг тоолуурыг шинэчилсэн. | |
| **3.3. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО** | | | | | | | | | | |
| **3.3.1 Аймгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 235 | 3.3.1.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн гишүүдийг шинэчлэн байгуулж, жил бүр төлөвлөгөө батлуулна. | 2021-2024 | ТЗУХ, ОБГ | ҮА зардал | Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг шинэчлэн байгуулсан. | Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн гишүүдийг шинэчлэн байгуулж, төлөвлөгөөг дүгнэж, зөвлөлийн хуралдааныг 1-ээс доошгүй удаа хийнэ. | 100,0 | 100,0 | 2021 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн гишүүдийг шинэчлэн байгуулж, төлөвлөгөөг дүгнэж, зөвлөлийн хуралдааныг 2 удаа:<br>2022 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн гишүүдийг шинэчлэн байгуулж, төлөвлөгөөг дүгнэж, зөвлөлийн хуралдааныг 2 удаа:<br>2023 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн гишүүдийг шинэчлэн байгуулж, төлөвлөгөөг дүгнэж, зөвлөлийн хуралдааныг 2 удаа тус тус хуралдаж Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыг баталгаажуулж мөрдөн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2024 онд Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хანган ажиллаж байна.<br>**Үр дүн:** 6 удаагийн хурлаар нийт 2021-2024 онд хийж гүйцэтгэх төлөвлөгөөг хэлэлцүүлэн, жилийн эцэст гүйцэтгэлийг гарган ажилласан. | |
| 236 | 3.3.1.2. Ах дүүгийн харилцаа Оросын холбооны улс, Солонгос улсын ижил төрлийн үйл ажиллагаатай байгууллагатай танилцах, сургалтад хамрагдана. | 2021-2024 | ТЗУХ, ОБГ | 87.5 | | БНСУ-ын олон улсын галын академид 15 алба хаагчийг хамруулна. | - | - | Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газраас 2021 онд ОХУ-ын Иргэний хамгаалалтын албаны академид 1 алба хаагч<br>2022 онд ОХУ-ын Гал эсэргүүцэх албаны академид 1 алба хаагч, Дотоод хэргийн их сургуульд 6 алба хаагч тус тус суралцсан.<br>2023 оны 10-р сарын 02-нд Турк улсад зохион байгуулагдсан найрамдал төслийн хүрээнд европын орнуудтай хийх уулзалтад Дархан-Уул аймгийн Гамшгийн нөхцөл байдал хариу арга хэмжээ, удирдлага зохион байгуулалт сэдвээр илтгэлд 1 алба хаагч тус тус оролцсон.<br>2024 онд ОХУ-ын Гал эсэргүүцэх албаны академид 4 алба хаагч шалгаруултанд хамрагдаж суралцахаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.<br>**Үр дүн:** 2021-2024 онд Онцгой байдлын газраас нийт 13 алба хаагчдыг өөрийгөө хөгжүүлэх, сурч боловсроход дэмжин ажилласан байна. | 100% |
| 237 | 3.3.1.3. Зарлан мэдээлэх дуут дохионы тоог нэмэгдүүлж, нэгдсэн удирдлагад оруулна. Хөрөнгө оруулалтын зардлыг батлуулна. | 2021-2022 | ОБГ | ОНТ | Нийт 10 ширхэг дуут дохио ашиглагдаж байна.<br>Дуут дохио тус бүрт алба хаагч очиж ажиллуулдаг | Үйл ажиллагаанд бүрэн оруулах, бэлэн байдлыг хангана. | | | Дархан-Уул аймгийн хэмжээнд “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дуут дохиог нэгдсэн удирдлагад оруулах, өргөжүүлэх төсөл”-ийг боловсруулан.<br>Дархан сумын 2021 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дуут дохиог нэгдсэн удирдлагад оруулах, өргөжүүлэх төсөл”-ийн ажлын хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 01-ний байдлаар нийт 10 байршилд Радио болон GSM дохио хүлээн авах хосолсон нэгдсэн удирдлагын системийн угсралт, суурилуулалт хийж гүйцэтгэн, хэвийн ажиллагааг шалгаж баталгаажуулсан.<br>Радио холбооны удирдлагын холболтыг хийх ажлын хүрээнд “Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХХК-аас радио релейний 306-р станцад нийгмийн хариуцлагын хүрээнд үнэ төлбөргүй суурилуулах зөвшөөрөл олгосны дагуу 1 ширхэг дахин дамжуулах станц, антен-фидерийн байгууламж суурилуулж тохиргоо хийлээ. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 238 | 3.3.1.4. Дархан сумын эргэн тойронд аянга зайлуулах хамгаалалтын системийн тоог жилд нэгээр нэмж байгуулна. | 2021-2024 | ТЗУХ, ОБГ | 60.0 | 2021 онд 1 ширхэг аянга зайлуулагч хийгдэх ажил явагдсан. | 1 ширхэг аянга зайлуулагч хийнэ. | - | - | Дархан сумын эргэн тойронд аянга зайлуулах хамгаалалтын систем нь 2019 онд Дархан сумын 9, 15-р багт хийгдсэн байна. 2021-2023 онд дахин аянга зайлуулах хамгаалалтын систем хийх төсвийг шийдвэрлэх боломжгүй байсан.<br>2024 онд аянга зайлуулагч, хамгаалалтын системийг хийж гүйцэтгүүлэн ажиллахыг Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдын Засаг дарга нарт албан бичиг хүргүүлэн 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр биелэлтийг авахаар ажиллаж байна.<br>**Үр дүн:** 2024 онд аянга зайлуулагч хийж гүйцэтгэх ажлыг Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдууд зохион байгуулан биелэлтийг хангуулна. Төсвийн тодотголд 20 сая төгрөг санал оруулсан. | 50% |
| **3.3.2. Дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг дээшлүүлнэ.** | | | | | | | | | |
| 239 | 3.3.2.1. Төлөвлөгөөний дагуу сум багуудын Засаг дарга нарт орон нутгийн хамгаалалтын талаар сургалт зохион байгуулж, сумангуудыг тодотгож, үүрэг гүйцэтгэх сургалт дадлага тодотголыг жил бүр хийсэн байна. | 2021-2024 | ЦШ | 10.0 | | Томилгоот байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанууд томилгоожиж, үүрэг гүйцэтгэх боломж хангагдана. | - | - | 2021-2024 онд Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөнд тусгагдсан 10 сумангын томилгоот бүрэлдэхүүний тодотголыг тухайн жил бүр хуваарийн дагуу 2 удаа сум тус бүр дээр тодотгож ажилласан. 2021-2024 онд Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас дэвшүүлсэн “Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх замаар эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог идэвхжүүлж, төр захиргааны байгууллага, нийт иргэдийн оролцоонд тулгуурласан Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх” сургалтыг 2021-2024 онд давхардсан тоогоор 465 иргэнд 9 удаа зохион байгуулсан.<br>**Үр дүн:** 2021-2024 онд давхардсан тоогоор 465 иргэнд 9 удаагын сургалт зохион байгуулж ажиллалаа. | 100% |
| 240 | 3.3.2.2. Аймгийн дайчилгаа удирдах бүлэгт томилгооны | 2021-2024 | ЦШ | | | Томилгоот байгууллага, аж ахуйн | - | - | 2021-2024 онд Аймгийн дайчилгаа удирдах бүлгийн цугларах, шилжүүлэх байрын бүрэлдэхүүний тодотголыг хагас болон бүтэн жилээр хийж томилгоот | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дагуу үүрэг гүйцэтгэх үндсэн үүргийн талаар сургалт дадлага зохион байгуулж, шаардлагатай материал, хувцас хэрэглэлээр хангана. | | | 10.0 | | нэгж, албан тушаалтануу д томилгоожи ж, үүрэг гүйцэтгэх боломж хангагдана. | | | бүрэлдэхүүнд тэдгээрийн гүйцэтгэх үүргийн талаар 8 удаагийн сургалт зохион байгуулж 218 хүнээр нууцын баталгаа гаргуулан утсан холбоог тодотгож ажилласан. Дархан-Уул аймгийн "Зэвсэгт хүчний анги, салбарыг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө", "Орон нутгийн цэргийн отряд, суманг байгуулах, бэлтгэлийг хангах төлөвлөгөө"-ний дагуу бие бүрэлдэхүүн, техникийг тогтоосон хугацаанд татан нийлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах, холбоо, зарлан мэдээллийн сувгийн бэлэн байдал найдвартай ажиллагааг хангах, тогтмолжуулах, зарлан мэдээлэл хүргэх бүдүүвчийн дагуу цахилгаан холбоо, төрийн холбоо, үүрэн холбоо биет холбоочин зэргийг тодотгон ажилласан.<br>Үр дүн: Аймгийн дайчилгаа удирдах бүлгийн цугларах, шилжүүлэх байрын бүрэлдэхүүний бэлэн байдал үүрэг гүйцэтгэх боломж хангагдсан. | 100% |
| 241 | 3.3.2.3. Хээрийн сургалтын төвд хичээлийн байр, ерөнхий цэргийн саад, буудлагын талбайг тохижуулж, төхөөрөмжилнө | 2021-2024 | ЦШ | 50.0 | | Сургалтын материаллаг бааз бэхжинэ. | - | - | 2021-2024 онд Дархан-Уул аймгийн Цэргийн штабын хээрийн сургалтын төвд 20 сая төгрөгийн цэргийн байр хоёрыг шинээр барьсан, 4,7 сая төгрөгийн дээвэр, камер, сэргээн сайжруулах урсгал засварыг хийж тохижилтын болон материаллаг баазыг дэмжиж ажиллалаа. ЗДТГ-ын Цэргийн штабын үйл ажиллагааны бэлэн байдал, цэргийн бүртгэл, нууц хадгалалт хамгаалалтыг хангахад шаардлагатай техних хэрэгслийг 18 сая төгрөгөөр авч албанд ашиглаж байна.<br>**Үр дүн:** 2021 онд 50 иргэн, 2022 онд 70 иргэн, 2023 онд 120 иргэн, 2024 онд 147 иргэн 2021-2024 онуудад нийт 347 иргэн сургалтад хамрагдсан. | 100% |
| **3.4. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГО** | | | | | | | | | | |
| **3.4.1. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.** | | | | | | | | | | |
| 242 | 3.4.1.1. Эрх зүйн хөтөчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, давтан сургана. | 2021-2024 | ХЭЗХ | ОНТ 5.0 | 50 Эрх зүйн хөтөч бэлтгэсэн | Нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулж , гэрээг дүгнэнэ. | ОНТ 5.0 сая төгрөг | - | **2021 онд** Хууль зүйн туслалцааны төвийн байранд эрх зүйн хөтөчийн буланг 5 сая төгрөгөөр тохижуулсан. 38 эрх зүйн хөтөчтэй хамтран ажиллах гэрээ байгуулж "Дархан-Уул аймгийн Эрх зүйн хөтөч" нэртэй цахим хуудас үүсгэн Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | явуулж буй сургалт, мэдээ мэдээллийг хүргэж ажилласан.<br>**2022**.12.30-ны өдөр Байгаль орчны хууль, эрх зүйн чиглэлээр 18 байгууллагын 53 эрх зүйн хөтчийг чадавхжуулах давтан сургалтыг зохион байгуулсан.<br>**2023 онд** Эрх зүйн хөтчийн нэгдсэн зөвлөгөөнийг 4 дүгээр улиралд зохион байгуулсан.<br>**2024 онд** "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх" Үндэсний хөтөлбөр хэрэгжиж дууссан, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлын хүрээнд "Дэмжлэг хүсэх тухай" ХЗДХСайдын дугаар албан бичгийн дагуу сумдын ЗДТГ-ын дарга, Насан туршийн боловсролын төвийн захирал нарт асуулга судалгаанд эрх зүйн хөтөч болон иргэдийг хамруулж дүнг ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлж, судалгаанд иргэдийг хамрагдахыг уриалсан зар, линк болон QR кодыг Дархан-Уул аймаг FB, цахим хуудаст байршуулсаны үр дүнд 106 иргэн, 20 эрх зүйн хөтчийг асуулга судалгаанд хамруулсан.<br>**Үр дүн:** 18 байгууллагын 53 эрх зүйн хөтчийг чадавхжуулах давтан сургалтад хамруулсан. Эрх зүйн хөтчийн үйл ажиллагаа тогтмолжсон байна. | |
| 243 | 3.4.1.2. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран эрх зүйн сургалт, сурталчилгаа явуулна. | 2021-2024 | ХЭЗХ | Орон нутгийн төсөв, ТХ 4.0 | "Хуулийн цаг нэвтрүүлэг"-ийг 2 удаа зохион байгуулж, 5800 иргэн мэдээлэл авсан. | Аймгийн МТА-тай хамтран Хуулийн цаг нэвтрүүлгийг улирал бүр зохион байгуулж, ТББ-ыг оролцоог нэмэгдүүлнэ. | ОНТ 1.0 сая төгрөг | - | **2021 онд** "Хуулийн цаг", "Тодруулга ярилцлага" нэвтрүүлэг, "DBS" телевизэд нийт 4 удаа 5 хуулиар,<br>**2022 онд** "Хуулийн цаг" нэвтрүүлгээр шинээр батлагдсан 7 хуулиар мэдээлэл бэлтгэн нийтийн сүлжээгээр түгээж иргэд 11305 удаа үзэж сонирхсон,<br>**2023 онд** 7 хуулиар мэдээлэл бэлтгэн олон нийтийн сүлжээгээр түгээж нийт 8558 удаа үзэж сонирхсон. Улиралд 1-2 хуулиар мэдээлэл бэлтгэж хэвшсэн.<br>**2024 онд** "Хуулийн цаг" нэвтрүүлгийг Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн талаар иргэдээс авсан асуултуудад хариулт өгөх байдлаар бэлтгэн Дархан-Уул аймаг facebook хуудсаар түгээж 1000 иргэн үзэх сонирхлоо.<br>Хууль, тогтоомжоор хийсэн сургалт:<br>Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль, тогтоомжоор:<br>2021 онд 7 хуулиар 980 албан хаагчид,<br>2022 онд 9 хуулиар 2413 албан хаагч, иргэдэд, | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2023 онд 11 хуулиар 1613 албан хаагч, иргэдэд сургалт зохион байгуулсан.<br>2024 онд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль зэрэг 10 сэдвээр 6 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 65 аж ахуйн нэгж, байгууллагын 2653 ажилтан албан хаагч хамрагдлаа.<br>**Үр дүн:** Хуулийн цаг нэвтрүүлгийг улирал 1-2 хийж хэвшсэн бөгөөд 2021-2024 онд нийт 37 хууль, тогтоомжоор 7659 албан хаагч, иргэдэд сургалт хийсэн. | |
| 244 | 3.4.1.3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХЭЗХ | ОНТ, ТХ 3.0 сая төгрөг | 2018-2020 оны дундаж- 91.4% | 93.4 хувьд хүргэнэ. | 1.0 сая төгрөг | ОНТ 1.5 сая төгрөг | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ:<br>2021 онд 98.42%-иар,<br>2022 онд 93.5%-иар тус тус үнэлэгдсэн.<br>2023 оныг Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлж буй "Авлигатай тэмцэх таван Ш ажиллагаа"-ны нэг арга хэмжээ болох "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд "НЭГДЬЕ" аяныг Дархан-Уул аймагт зохион байгуулсан бөгөөд цахим сүлжээнд постер, шторк, нийтлэлүүдийг 64300 орчим иргэнд хүргэсэн ба хэрэгжилт 100%-ийн үнэлгээтэй байна.<br>"Шүүр ажиллагаа"-ны хүрээнд ЗГХЭГ-ын 2023 оны ХЭГ/595 тоот албан бичгээр ирүүлсэн 11 чиглэлээр хяналт, шалгалт хийж нийт 52 зөрчил илэрсэн. Үүнээс хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулаагүй томилогдсон, хөрөнгө орлогоо мэдүүлэх үүргээ биелүүлээгүй 8 зөрчил илэрснээс 6 зөрчлийг арилгаж 2 зөрчлийг арилгах боломжгүй байна.<br>2024 оны байдлаар Дархан-Уул аймгийн 2024 оны "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгаж аймгийн онцгой комисс, БШУГ, СУГ-уудад хүргүүлж бусад төрийн байгууллагуудад able прогроммаар дамжуулан байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх чиглэлийг өгсөн. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцэст тайлагнана.<br>**Үр дүн:** Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн сүүлийн 3 жилийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 97.3%-н үнэлгээтэй байна. | 100% |
| 245 | 3.4.1.3. Соён гэгээрүүлж, | 2021-2024 | ХЭЗХ | ОНТ, ТХ 1.2 сая төгрөг | 2020 онд 338 хүнд сургалт хийж, радио | Соён гэгээрүүлэх, урьдчилан | 200.0 мянга | - | Сургалт:<br>Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлнэ. | | | | телевиз, лед дэлгэцээр 48 төрлийн шторк, подкастыг 2880 удаа, цахим хуудсуудаар 20154 хүнд хүргэсэн. | сэргийлэх ажлын хүртээмж нэмэгдсэн байна. | | | 2021 онд 4 удаагийн сургалтаар 290 албан хаагчид,<br>2022 онд 10 удаагийн сургалтаар 1035 албан хаагч, иргэдэд,<br>2023 онд 11 удаагийн сургалтаар 548 албан хаагч, иргэнийг тус тус сургалтад хамруулсан.<br>2024 онд 54 удаагийн сургалтаар нийт 3910 албан хаагч, оюутан, сурагч, иргэдийг сургалтад хамруулсан.<br>Сурталчилгаа:<br>2021 онд орон нутгийн 9 хэвлэл мэдээллийн хэрэгслээр тв шторк, инфографик, нийтлэл, теле зохиомж, зурагт хуудас, цахим ном зэргийг нийт 9877 удаагийн давтамжтай цацаж давхардсан тоогоор 960.177 хүнд мэдээлэл өгсөн.<br>2022 онд 2208 албан хаагч, иргэдийг сургалтад хамруулж, 22 шторкийн орон нутгийн телевизээр 110400 давтамжтайгаар, 45 мэдээ, шторкийг 18232 иргэнд түгээсэн.<br>2023 онд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан аян, арга хэмжээний хүрээнд шинээр бэлтгэсэн шторкыг орон нутгийн телевизээр 3400 удаагийн давтамжтайгаар цацаж, цахим сүлжээнд постер, шторк, нийтлэлүүд 64300 орчим иргэнд хүрсэн байна.<br>2024 онд 1 подкаст нэвтрүүлэг бүтээж 10 удаагийн сурталчилгааны постыг олон нийтийн сүлжээнд байршуулсан.<br>Бусад:<br>Дархан-Уул аймгийн ЗДТГ болон Хонгор сумын ЗДТГ-аас санаачлан “Дэвжээ” тэмцээнийг 2022 онд 7 байгууллага, 2023 онд 8 байгууллагын дунд зохион байгуулсан.<br>Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Нэгдсэн Үндэсний байгууллагаас гаргасан “Таны эрх, таны оролцоо-Авлигад үгүй гэж хэлье” уриан дор соён гэгээрүүлэх өдөрлөг зохион байгуулж ЕБС-ийн ахлах ангийн 300 сурагчид, 40 иргэн хамрагдлаа.<br>**Үр дүн:** 2021-2024 онд 79 удаагийн сургалтаар 5783 албан хаагчид сургалт зохион байгуулж, урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, шторкыг орон нутгийн телевиз, цахим сүлжээнд 123,677 удаагийн давтамжтайгаар, цахим сүжээнд байршуулсан постер, мэдээллийг давхардсан тоогоор 1,042,709 хүн үзсэн | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хандалттай байна. 1 өдөрлөг, 2 тэмцээн, 4 контент хийж бүтээсэн. | |
| **3.4.2 Гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангуулна.** | | | | | | | | | | |
| 246 | 3.4.2.1. Хууль зүйн туслалцааны төвийг ажиллах нөхцөлөөр хангана. | 2021-2024 | ХЭЗХ | ОНТ, ТХ 4.0 сая төгрөг | Хууль зүйн туслалцааны төвийг Нийтийн үйлчилгээний нэгдсэн төвийн байранд шилжүүлэн байрлуулсан. | Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлсэн байна | - | - | **2021 онд** Дархан-Уул аймаг дахь Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран “Хууль зүйн туслалцаа авах эрх-2021” өдөрлөгийг зохион байгуулж 36 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч тухайн жилд нийт 144 иргэд туслалцаа үзүүлсэн.<br>**2022 онд** 372 иргэнд хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн. Нийт хүлээн авсан хэрэг-62. Үүнээс:<br>- Шүүхээр шийдвэрлүүлсэн хэрэг-41,<br>- Хэрэг хянан шийдвэрлэх шатанд байгаа-21.<br>**2023 онд** 464 хүнд туслалцаа үзүүлсэн. Үүнд: иргэний 3 хэргийг хүлээн авч, 120 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 89 холбогдогч, 2 хохирогчтой 73 эрүүгийн хэргийг хүлээн авч, 54 холбогдогч, 1 хохирогчтой 49 хэргийг шүүхээр, 10 холбогдогчтой 7 хэргийг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлж, 21 холбогдогч, 1 хохирогчтой 14 хэргийн үлдэгдэлтэй, 344 иргэнд эрүүгийн хууль болон эрүүгийн чиглэлээр зөвлөгөөг өгсөн.<br>**2024 онд** 316 иргэнд хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн. Үүнд: иргэний 1 хэргийг хүлээн авч, 82 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 72 холбогдогч, 1 хохирогчтой 65 эрүүгийн хэргийг хүлээн авч, 34 холбогдогч, 1 хохирогчтой 31 хэргийг шүүхээр, 11 холбогдогчтой 7 хэргийг шүүхийн өмнөх шатанд шийдвэрлүүлж, 24 холбогдогчтой 24 хэргийн үлдэгдэлтэй, 225 иргэнд эрүүгийн хууль болон эрүүгийн чиглэлээр зөвлөгөөг өгсөн.<br>Хууль зүйн туслалцааны төвийг Дархан сумын ЗДТГ-ын байранд 12 мкв өрөөнд байрлуулж үйлчлүүлэгчтэй уулзах боломжоор бүрэн хангаж, ажлын байр, интернетийн зардлыг бүрэн хариуцаж байна.<br>Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 2-А/92 дугаар тушаалаар тус төвийн улсын өмгөөлөгчдийн 2024 оны бичиг хэргийн зардалд 203.000 төгрөг гаргаж санхүүжүүллээ.<br>**Үр дүн**: 2021-2024 онд төлбөрийн чадваргүй 1304 иргэнд туслалцаа үзүүлсэн. | 100% |
| **3.4.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлж, иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.** | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 247 | 3.4.3.1. Камерын тоог нэмэгдүүлж, урсгал засвар үйлчилгээг хийж, шаардлагад нийцүүлнэ. | 2021-2024 | ХЭЗХ | Улсын болон орон нутгийн төсөв 100.0 сая төгрөг | Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт 2020 оны 11 дүгээр сарын байдлаар 54.0%-тай байна. | Дархан сумын 1,2 дугаар багийн нийтийн эзэмшлийн гудамж талбайг камержуулна. | 40.0 сая төгрөг | 66.0 сая төгрөг | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн амгалан тайван ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Дархан суманд 246, Хонгор суманд 46, Шарын гол суманд 35, Орхон суманд 5 нийт 332 хяналтын камер ажиллаж байна.<br>2021 онд Хонгор сумын салхит багт 11 цэгт 21 камер 40 сая төгрөгөөр,<br>2022 онд Шарын гол сумын нутаг дэвсгэрийн 8 цэгт 11 камерыг 53 сая төгрөгөөр, Дархан сумын 4, 7 дугаар багт байрлах нүхэн гарцуудад 4 цэгт 8 ширхэг камерыг 13 сая төгрөгөөр, хогийн цэгүүдэд 31 камерыг 57,448,000 төгрөгөөр суурилуулсан.<br>2023 онд “Ногоон бүс” төслийн хүрээнд гэмт хэрэг зөрчил ихээр гардаг Дархан сумын 4, 5, Өргөө багийн нутаг дэвсгэрийг сонгон авч 80 цэгт 125 хяналтын камер суурилуулсан.<br>“Ногоон бүс” төслийн хүрээнд 2023-2024 онд Дархан сумын 7 багийн нутаг дэвсгэрт 170 байршилд 292 хяналтын камерыг суурилуулж 24 цагийн хяналттай болгосон. Ингэснээр гэмт хэргийн илрүүлэлт 74.7 хувьтай өссөн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс буюу 2023 оны 8 дугаар сараас 2024 оны 8 дугаар сар хүртэл 16.6 хувьтай өссөн үзүүлэлт юм. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийг шуурхай илрүүлэх зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага, иргэн, ААНБ, сууц өмчлөгчдийн холбоодыг үйл ажиллагаа явуулж буй газрынхаа гадна болон дотор орчинд “Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага” MNS 64235:2019 стандартыг хангасан, орчноо бүрэн хянах боломжтой камер суурилуулах, стандартад нийцсэн камерыг холбогдох хуулийн дагуу Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд үнэ төлбөргүй холбох тухай аймгийн Засаг даргын захирамж гарсан.<br>2024 онд мөн тус төслийн хүрээнд Дархан сумын 13, 14, 16 дугаар багуудын нутаг дэвсгэрт 60 цэгт 110 хяналтын камерыг шинээр суурьлуулах ажил тендерийн шатандаа үргэлжилж байна.<br>**Үр дүн:** 2021-2024 оны хооронд 196 хяналтын камерыг 543,448.000 төгрөгөөр суурилуулсан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2024 онд шинээр 110 хяналтыг камерыг суурилуулахаар ажиллаж байна. | |
| 248 | 3.4.3.2. Устгал арга хэмжээ, сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна. | 2021-2024 | ХЭЗХ | Орон нутгийн төсөв 4.0 сая төгрөг | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэсэн гэмт хэрэг 9 бүртгэгдэж нийт 23 хүн холбогдон шалг агдсан, 10 хүнд холбогдох 4 хэрэг, үйлдлийг илрүүлсэн. | Өсвөр насны болон оюутан сурагчид сургуулийн орчинд хар тамхи мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр устгалын ажлыг зохион байгуулна. | 10 сая төгрөг | Орон нутгийн төсөв 20 сая төгрөг | Устгал:<br>**2021 онд** 385 га талбайд 2 үе шаттайгаар зохион байгуулж 10 сая төгрөг,<br>**2022 онд** 305 га талбайд 2 үе шаттайгаар устгал хийж аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 20 сая төгрөг,<br>**2023 онд** 11 цэгт 450 га газарт гар аргаар болон техникээр устгалын ажлыг хийж гүйцэтгэн Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 29,930,000 төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.<br>**2024 онд** аймгийн ГХУСАЗСЗ-өөс 29,930,000 төгрөгийн төсөв батлуулан устгалыг 2 үе шаттайгаар 420 га газарт гар аргаар болон техник хэрэгслээр хийж гүйцэтгэсэн.<br>Сургалт:<br>2021 онд 6 удаагийн сургалтаар 325 хүнд, 2022 онд 7 удаагийн сургалтаар 477 хүнд, 2023 онд 4 удаагийн сургалтаар 2145 хүнд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.<br>2024 онд Цагдаагийн Ерөнхий газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Боловсролын ерөнхий газартай хамтран Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөтэй бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд өсвөр насны хүүхэд, залуучуудыг холбогдохоос урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн мэдлэг, ойлголт, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр “Анзаар” аяныг аймгийн хэмжээнд 9 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>**Үр дүн**: 2021-2024 онд 1560 га талбайд устгал хийж 89,860,000 төгрөг зарцуулсан. 2021-2024 онд нийт 17 удаагийн сургалтаар 2947 хүнд сургалт нөлөөллийн ажил зохион байгуулсан. | 100% |
| 249 | 3.4.3.3. Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | 2021-2024 | ХЭЗХ | 10.0 | Урьдчилан сэргийлэх чиглэлээр 18 арга хэмжээ, хэлэлцүүлэг, зөвлөгөөн, 75 удаагийн сургалт явуулж, 3500 гарын авлага, | Урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулна. (хэсэгчилсэн, тусгай арга хэмжээ, зөвөлгөөн) | | | Хэсэгчилсэн арга хэмжээ:<br>2022 онд One night” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж биеэ үнэлэлт зохион байгуулсан 1 гэмт хэргийг,<br>2023 онд “Буудал” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, биеэ үнэлэлт зохион байгуулсан 1 гэмт хэргийг шүүхээр шийдвэрлүүлсэн. 2023 онд ЦЕГ-аас зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зөвлөмж тараасан. | | | | хэмжээний хүрээнд 5 удаа хяналт шалгалтыг байгуулсан.<br>2024 онд 9 хэсэгчилсэн арга хэмжээ, 42 удаагийн сургалт, төрийн байгууллага давхардсан тоогоор 13, ТББ 11, ААН 29, нийт 53 байгууллагын 1650 орчим иргэн, оюутан, сурагчид хамрагдсан.<br>Сурталчилгаа:<br>2021 онд мэдээлэл, сурталчилгааг 11 удаа, 5 удаагийн сургалтад 55 охид, эмэгтэйчүүд хамрагдсан. Багийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтад 20 ажилтан хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдсэн.<br>2022 онд “Мөрөөдлийн шүхэр” аян, “Хяналт” нэгдсэн арга хэмжээ, “Нуугдмал” нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд 461 хүнд сургалт, мэдээлэл хийж нөлөөллийн ажил зохион байгуулсан.<br>2023 онд “Нууцалъя” аяны хүрээнд 1 сургалт, бусад арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан 2 сургалт нийт 3 сургалтаар 310 хүнд мэдээлэл өгч, нөлөөллийн ажил зохион байгуулсан.<br>2024 онд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор сургалт, сурталчилгаа 36, уулзалт хэлэлцүүлэг 4, өдөрлөг, зөвлөгөөн 2, нийт 42 удаагийн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг удирдамж төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.<br>**Үр дүн:** 2021-2024 онд 11 хэсэгчилсэн арга хэмжээ, 4 аян, 51 сургалт зохион байгуулж 2496 хүнд мэдээлэл өгч, нөлөөллийн ажлил зохион байгуулсан. | |
| 250 | 3.4.3.4. Архинд донтох эмгэгтэй иргэдийг албадан болон сайн дурын эмчилгээнд хамруулах, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, согтууруулах | 2021-2024 | ХЭЗХ | Орон нутгийн төсөв, */Албадан эмчилгээний зардал/* 4.3 сая төгрөг | Архинд донтох эмгэгтэй 135 иргэнийг бүртгэлд судалгаанд хамруулсан. | Архинд донтох эмгэгтэй 21 иргэнийг албадан эмчилгээнд хамруулна. | ОНТ 1.1 сая төгрөг | ОНТ 2,0 төгрөг | **Сайн дурын болон албадан эмчилгээ:**<br>**2021 онд** Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасагтай хамтран 285 иргэнийг сайн дурын эмчилгээнд хамруулж 17 хүн архинаас татгалзсан.<br>**2022 онд** 25 иргэн албадан эмчилгээнд хамрагдсан бол 2.6 сая төгрөгөөр Аймгийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасагт 6 ортой нэг өрөөг засаж тохижуулан 2022 оноос үйл ажиллагаагаа эхлүүлж 174 иргэнийг сайн дурын эмчилгээнд хамруулж 21 хүн архинаас татгалзсан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 278 | 5.1.2.1. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хувийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 1,025.0 | Архитектор төлөвлөлтийн даалгавар боловсруулж батлуулсан | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах /Дархан сумын 5 дугаар баг/ | | | Дархан сумын 5-р багийн нутаг дэвсгэрт байрлах гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн дулаан, цэвэр ус хангамж, бохир усны шугам угсралтын ажил 2019-2021 онуудад хэрэгжиж улсын комисс ажиллаж ашиглалтад оруулсан.<br><br>2024 онд УТХ 725 сая хөрөнгө оруулалтаар Дархан сумын 1, 3, 5, 6, 7, 8, 9, 15 дугаар багийн нийт 9 байршилд Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр Эдийн Засгийн Хөгжлийн Яамнаас зарласан тендерт Улаанбаатар хотын “Церкуль Проект” ХХК шалгарч, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Дархан сумын 5-р баг, Хүнсний ар, 8-р багийн Наран толгой, Манхан толгой айл өрхүүдийн амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэхээр дулааны шугамд холбох ажлыг “Дархан Дахин Төлөвлөлт” ААТҮГ, “Дархан Дулааны Сүлжээ” ТӨК-ууд гүйцэтгэж байна.<br>Дархан сумын 5-р баг Орос клуб орчмын 8.3 га газарт ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган дахин төлөвлөн, барилгажуулах, орон сууцжуулах ажлын хэсгийн аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан сонгон шалгаруулалтыг барилгын компаниудын дунд | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байна.<br><br>**Үр дүн:** Тендер сонгон шалгаруулалт зарлагдан, ажил хийгдэж байна. | |
| 279 | 5.1.2.2. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ,, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 3,238.2 | Архитектор төлөвлөлтийн даалгавар боловсруулж батлуулсан. | Хэсэгчил-сэн ерөнхий төлөвлөгөө боловсруу-лах /Дархан сумын 6,7 дугаар баг/ | - | - | 2021 онуудад дулаан хангамжийн шугам сүлжээ, ус дулаан дамжуулах төвийн барилга, дулаан механикийн угсралтын ажил хийгдэж ашиглалтад оруулсан. 2022 оноос эхлэн Дархан сумын 6, 7 дугаар багуудын гэр хорооллын байршилд дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр тендер зарлаж гүйцэтгэгчээр “Инженер геодези” ХХК шалгарч ажлыг гүйцэтгэж байна.<br><br>2024 онд УТХ 725 сая хөрөнгө оруулалтаар Дархан сумын 1, 3, 5, 6, 7, 8, 9, 15 дугаар багийн нийт 9 байршилд Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр Эдийн Засгийн Хөгжлийн Яамнаас зарласан тендерт Улаанбаатар хотын “Церкуль Проект” ХХК шалгарч, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байна.<br><br>**Үр дүн:** Тендер сонгон шалгаруулалт зарлагдан, ажил хийгдэж байна. | 90% |
| 280 | 5.1.2.3. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хувийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 682.6 | Архитектор төлөвлөлтийн даалгавар боловсруулж батлуулсан. | Хэсэгчил-сэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах /Дархан сумын 7, 8 дугаар баг/ | - | - | Нутаг дэвсгэрт 2018-2020 онуудад гэр хорооллын хэсэгт төвлөрсөн инженерийн шугам сүлжээний ажил хийгдэж ашиглалтад оруулсан. Тухайн хэсгүүдэд ерөнхий төлөвлөгөө хийлгэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэгчээр "Инженер геодези" ХХК шалгарч ажлыг гүйцэтгэж байна.<br><br>2024 онд УТХ 725 сая хөрөнгө оруулалтаар Дархан сумын 1, 3, 5, 6, 7, 8, 9, 15 дугаар багийн нийт 9 байршилд Хот суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр Эдийн Засгийн Хөгжлийн Яамнаас зарласан тендерт Улаанбаатар хотын “Церкуль Проект” ХХК шалгарч, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Хүнсний ар, 8-р багийн Наран толгой, Манхан толгой айл өрхүүдийн амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэхээр дулааны шугамд холбох ажлыг “Дархан Дахин | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Төлөвлөлт" ААТҮГ, "Дархан Дулааны Сүлжээ" ТӨК-ууд гүйцэтгэж байна.<br><br>**Үр дүн:** Тендер сонгон шалгаруулалт зарлагдан, ажил хийгдэж байна. | |
| 281 | 5.1.2.4. Хотын төвийн мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлж шинэ суурьшлын бүс байгуулна. | 2021-2024 | Дархан сумын ЗДТГ | 555.0 | 190.0 | Гахайн-2, шувууны 1 загвар аж ахуйг байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | 31.4 | 0.0 | Нийт 13 байгууллагын 70 гаруй албан хаагч ажиллаж малтай өрх 90,1 хувь, Гахайтай өрхийн 60 хувийг гаргаж дунджаар 64,7 хувийг тус тус гаргасан байна.<br>Хотын төвөөс малаа гаргаагүй өрхийг "Эрчимжсэн мал аж ахуй", "Туслах аж ахуй"-н суурьшлын бүсэд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж, Төвийн гэр хорооллын 5, 6, 7, 8, 15 дугаар багийн нутаг дэвсгэрт мал, туслах аж ахуй (гахай) нэвтрүүлэхгүй байхыг 5, 6, 7, 8, 15 дугаар багийн Засаг дарга нарт үүрэг болгон ажиллаж байна.<br>Туслах аж ахуйн суурьшлын бүсийн худгийг ажилд оруулах ажлыг Орхон сумын ЗДТГ-тай хамтран хэрэгжүүлж тус бүсэд гахайгаа гаргасан 7 өрхөөс хэрэгжилт хангасан 5 иргэний газрын гэрчилгээг гаргууллаа.<br>**Үр дүн**: Мал аж ахуйн суурьшлын бүсэд нийт 31 өрх шилжин суурьшиж ус цахилгаанаар бүрэн хангагдсан. ХХҮГ-тай хамтран хотын төвөөс малаа гаргаагүй өрх малаа зарах хүсэлт ирүүлсэн бөгөөд 1 иргэний малыг малжуулах төсөлд худалдан борлуулах ажлыг гүйцэтгэж 1 өрхийг малгүй болгоод байна.<br>Гэр хорооллын бүсэд байнгын хяналт хийж байна. 2023 оны 10 дугаар сарын байдлаар малтай өрх 90,1 хувь (5.6.7.8.15-р баг), Гахайтай өрхийн 60% хувийг тус тус гаргаад байна. | 100% |
| **5.1.3.Түүхий эдийн нөөцөд тулгуурлан, орон нутгийн онцлогт тохирсон эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 282 | 5.1.3.1. Дархан үйлдвэр технологийн парк"-ийн ТЭЗҮ боловсру улж, ҮТП-ын 1, 2 дугаар бүсэд | 2021-2022 | ХБТХОХ | ОНТ, 209.0 | ТЭЗҮ-ийг боловсруулж, аймгийн ИТХ-ийн хуралдаанаар батлуулна | Паркийн гишүүн аж ахуйн нэгжийг хөнгөлөлттэй зээлийн | - | - | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 2/02 дугаарт тогтоолоор "Дархан үйлдвэр технологийн парк" ОНӨААТҮГ-ын ТЭЗҮ боловсруулах ажилд 50.0 сая | 0% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрлэлийг кластер хэлбэрээр хөгжүүлнэ. | | | | | бодлогоор дэмжинэ. | | | төгрөгийг батлан шийдвэрлэж өгсөн боловч уг газар нь нэгдүгээрт тухайн ажлыг хугацаанд нь хийгээгүй, хоёрдугаарт ТЭЗҮ боловсруулах ажлыг зах зээлийн ханш нь 250 сая төгрөгөөр хийхээр санал ирсэн зэрэг шалтгааныг үндэслэн байнгын хороо нь төсвийн тодотгол хийх замаар аймгийн ИТХ-ын 2021 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 01 дугаарт тогтоолоор хөрөнгийн эх үүсвэрийг өөр зүйлд зарцуулахаар шийдвэрлэсэн байна. | |
| 283 | 5.1.3.3. Эрчимжсэн мал аж ахуйг мах, сүүний чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | 2,400.0 | Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр батлуулан хэрэгжүүлж байна. ЭМАА-н суурьшлын бүс, махны чиглэлийн 100 үхрийн цогцолбор аж ахуй байгуулсан, мах-сүүний 285 үхэрт зохиомол хээлтүүлэг хийсэн. Нийт 406,5 сая төг зарцуулсан | Мах-сүүний чиглэлийн үхрийн загвар аж ахуйн тоог нэмэгдүүлэх дэмжлэг үзүүлнэ. | 800.0 | 130.0 | МУЗГ-ын 2022 оны МУЗГ-ын 92 тоот тогтоолоор батлагдсан журмын дагуу Дархан-Уул аймагт үржүүлж болох баталсан үүлдэр, омгийн малыг аймагтаа үржүүлэх, төвлөрсөн хүн амын мах, хүнсний хангамжийг орон нутгаас хангах чиглэлээр орон нутгийн хөгжлийн сангийн 150.0 сая.төг-ийн санхүүжилтээр Сэлэнгэ үүлдрийн 100 хээлтэгч худалдан авч, цөм сүргийн аж ахуйг байгуулж нутагшуулан үржүүлж байна. Хонгор сумын Хар бэлчирт үржүүлж буй махны чиглэлийн үхрийн аж ахуйн байдалтай аймгийн ажлын хэсэг танилцаж, Сэлэнгэ үхрийг цаашид үржүүлэх үржлийн болон маллагаа, тэжээллэгийн талаар чиглэл өгч ажилласан. Аймгийн эрчимжсэн аж ахуй эрхэлж буй иргэд, фермерүүдэд төл бойжилтийн үеэр 180.0 тн буюу 9000 боодол ногоон тэжээл, 9.0 тн хужир олгож дэмжлэг үзүүлсэн.<br>Аймгийн ХХААГ, ГХБХБГ-тай хамтран Хонгор сумын Хар бэлчирт 20 га газрыг мах-сүүний хосолмол болон махны чиглэлийн үхэр үржүүлэх чиглэлээр 5 иргэн, аж ахуйн нэгжид газар олгох ажлыг зохион байгууллаа.<br>ЭМАА-н бүс нутаг байгуулах мал бүхий иргэдийн суурьшлын бүсийг Хонгор сумын Талын толгойд байгуулан аймгийн ОНХС-ийн 213,9 сая төгрөгийн өртгөөр суурьшлын бүсийн цахилгааны ажлыг, 52,8 сая төгрөгөөр 2 худгийн ажлыг, Дархан сумын ОНХС-ийн 8,2 сая төгрөгөөр ус хадгалах сав нийт 274,9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан.<br>Махны чиглэлийн загвар аж ахуй байгуулах орон нутгийн төсвөөс 130.0 сая.төг-өөр махны үхэр худалдан авах тендерийг зарласан. Энэхүү Сэлэнгэ үүлдрийн махны тугалтай үнээ худалдан авах тендэрт “Чоно анд хамтдаа” ХХК шалгарч гэрээ байгуулсан | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | болович тодорхой шалтгаанаар үхэр нийлүүлэх ажил хойшлогдсон.<br>Мах-сүүний чиглэлийн үхрийн загвар аж ахуйн тоог нэмэгдүүлэх дэмжлэг үзүүлэх чиглэлээр ХХААХҮЯ, ХХААГ, аймаг, сумдын ЗДТГ-ууд хамтран ажиллаж байна. Дархан сумын 1-р багийн сүүний үхрийн загвар “Ангир сартуул” фермер нь хар тарлан үхрийн аж ахуйтай бөгөөд хөдөлмөр хөнгөвчилөх сүүний саалтуур нэвтрүүлж, эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллаж байна. Уг сүүний аж ахуй нь 2023 онд ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдаж, 65.0 сая төгрөгийн дэмжлэг авсан.<br>“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажлын тайланг бэлтгэж, Аймгийн Засаг даргын зөвлөл болон ИТХТ-ийн хуралд танилцуулсан.<br>Аймгийн ХХААГ, ХХҮГ-тай хамтран хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас “Малжуулах төсөл”-д 10 өрхийг хамруулан нийт 50 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна. Ажлын байр дэмжих төсөлд сүү, цагаан идээ боловсруулах 2 иргэнд 17 сая.төг-ийн дэмжлэг үзүүлсэн. Мал аж ахуйн салбарын чиглэлээр сумдын ХХС-ийн зээлэнд Шарын гол сум 30 сая.төг, Хонгор сум 2 иргэнд 50 сая.төг олгож үйл ажиллагааг нь дэмжээд байна.<br>УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд Арилжааны банкны эх үүсвэрээр санхүүжүүлэх “Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээл”-д мал аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй 69-н малчин, фермер, аж ахуйн нэгжийн хүсэлт, судалгааг нэгтгэн ХХААХҮЯ-д хүргүүлснээр сүүний үхрийн чиглэлээр 1 иргэн 70.0 сая, махны үхрийн аж ахуй эрхлэх чиглэлээр 2 фермер 510.0 сая.төг-ийн, дэмжлэг аваад байна. 2023 онд эрчимжсэн аж ахуй эрхэлж буй иргэд, фермерүүд нийт 580.0 сая, төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсанаар загвар аж ахуйн тоо нэмэгдэх боломж бүрдсэн.<br>2024 онд Улсын төсвийн хөрөнгөөр 4 сумын 230 үнээнд өндөр ашиг шимтэй малын үрээр зохиомол хээлтүүлэг хийхээр малын үржүүлэг технологийн “Мандах он” ХХКомпанитай гэрээний үндсэн дээр ажиллаж хагас жилийн | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байдлаар 163 үнээд үзлэг явуулж 36 үнээнд зохиомол хээлтүүлэг хийгээд байна. Махны үхрийн үүлдэр угсааг сайжруулах, сүрэг сэлбэх чиглэлээр Казакын цагаан толгойт, Герефорд, Сэлэнгэ үүлдрийн үхэр үржүүлэх фермер, малчдын сонирхол нэмэгдсэн байна.<br>**Үр дүн:**<br>Аймгийн хэмжээний нийт мал сүргийн 17,6 хувь буюу 46008 толгой үхэр тооллогдсон байна.<br>Цаашид манай аймаг нь Төвийн бүсийн эрчимжсэн хөдөө аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахад ХХААХҮЯ-тай хамтран эрчимжсэн мал аж ахуй газар тариалангийн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхээр холбогдох суурь судалгааг гаргаж эхэлсэн байна.<br>Аймгийн хэмжээнд үржүүлж байгаа 2100 малчин мал бүхий өрх, аж ахуйн нэгжид нийт 46,008 толгой үхэр сүрэг, үүнээс 360 малчин өрхөд цэвэр, эрлийз малын тоо 8571 толгой малын дэлгэрэнгүй тоон судалгааг гаргасан байна. Үүнээс: Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр 52 иргэн, аж ахуйн нэгж, 39 хоршоо нийт 3331 толгой мах, мах сүүний үхрийг үржүүлж байна. | |
| 284 | 5.1.3.4. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж ажиллана. | 2021-2024 | ХБТХОХ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | 100.0 | | 1 Үйлдвэрлэгчийг дэмжиж ажиллана. | - | - | 2023 онд Дархан сумын 13-р баг Үйлдвэрчний 2-р гудамж 203 тоот 1 нэгж талбар 8 га газрыг үйлдвэрлэлийн чиглэлээр газар олгосон.<br>2024 онд Дархан сум, 3-р багт байршилтай Очир ган бетон ХХК 120м3, Дархан сум, малчин багт байрлалтай чулуун карьер ХХК 120м3 хүчин чадалтай бетон зуурмагны үйлдвэрүүд ашишлалтад орсон<br>**Үр дүн:** Аймгийн хэмжээнд барилгын материал үйлдвэрлэлийн ААНБ-уудын 2024 онд тусгай зөвшөөрлийн сунгалт болон шинээр авсан бүртгэлийг шинэчлэн гаргалаа. Аймагт тусгай зөвшөөрөлтэй 24 ААНБ, 33 тохирлын гэрчилгээтэй 30 ААНБ барилгын материал үйлдвэрлэл эрхэлж байна Зарим ААНБ хэд хэдэн нэр төрлөөр бүтээгдэхүүн үйлдвэрлэж тухайн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ авч үйлдвэрлэл эрхэлнэ. Өнгөрсөн оноос 7 ААНБ тохирлын гэрчилгээ авч нэмэгдсэн байна. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 285 | 5.1.3.5. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг дахин боловсруулах үйлдвэрлэлийг кластер хэлбэрээр хөгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | 500.0 | Төмс, хүнсний, жимс жимсгэнэ дахин боловсруулах үйлдвэр байхгүй. | Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг дахин боловсруулах үйлдвэрлэлийг байгуулна. | 200.0 | 0.0 | Салбарын суурь судалгаагаар төмс, хүнсний ногооны тариалан эрхэлдэг 32 аж ахуйн нэгж, 1687 иргэн байна. Аймгийн хэмжээнд 12.5 мян.т багтаамжтай 9.0 мян.ш зоорь ашиглагдаж байна. 2021 онд төмс 7850.5 тн, хүнсний ногоо 17974.7 тн ургац, 2022 онд төмс 553.6га-аас 7476.16тн буюу га-аас 135цн, хүнсний ногоо 1438.6га-аас 20119.31тн буюу 139.9цн, 2023 онд төмс, хүнсний ногоо 7476.2тн, хүнсний ногоо 20005 тн ургац хураан авсан. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүнсний ногооны үйлдвэрлэлээр өрхийн орлогыг нэмэгдүүлэх, баталгаатай үрээр хангах зорилгоор 2022 онд 2.5 сая.төг-ийн 2.0тн төмсний элит үр, 55.2 сая.төг-ийн 12 нэр төрлийн хүнсний ногооны үрийг 80%-ийн хөнгөлөлттэй үнээр тариалан эрхлэгчдэд, ХААДС-аас 4.6 сая.төг-ийн үнэ бүхий 10 нэр төрлийн Солонгос үрийг 80%-ийн хувийн хөнгөлөлттэй үнээр өрхийн тариалан эрхлэгч 200 иргэнд тус тус олгож, нэр төрлийг нэмэгдүүлсэн. 2023 онд ХХААХҮЯ-аас 126.2 сая.төг-ийн 11 нэр төрлийн хүнсний ногооны үрийг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр үр үржүүлэгч болон тариалан эрхлэгчдэд сумын ХАА-н тасгаар дамжуулан олгосон байна. Хүнсний хувьсгал хөдөлгөөний хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Арилжааны банкаар дамжуулан 5 жилийн хугацаатай 5 ба 6 хувийн хүүтэй хөрөнгө оруулалтын зээл, 2 жилийн хугацаатай 6 хувийн хүүтэй эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтийг ХХААХҮЯ-д уламжилсан.Үүнээс хүнсний ногооны тариалан эрхлэгч 76 иргэн, 6 аж ахуйн нэгжид 4336.25 сая.төг-ийн зээл авсан байна.<br>Аймгийн хэмжээнд Хүнсний ногоо боловсруулах, нөөшлөх, савлах, хатаах чиглэлээр Мөнхөт үржих зөгий ХХК, Цогт Ану ХХК-ийн Мандуул цех, Амгалан монгол ногоо ХХК, Батбүрэн толгой ХХК, Бидний дархан цех, Бошигтын хүү ХХК, Мэргэн зоос ХХК, Оргил нүдэн ХХК- 8 аж ахуйн нэгж, Наараа цех- 1 иргэн, нийт 29 ажилтантай, жимс жимсгэнэ боловсруулах 1 аж ахуйн нэгж, 2 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.<br>Төмс, хүнсний ногоо ангилан савлах Амгалан монгол ногоо ХХК, луувангийн шүүс | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | үйлдвэрлэх Оргил нүдэн ХХК-ийг НҮБ-ийн Secim төслөөс дэмжиж ажилласан. Хүнсний ногоо дахин боловсруулах Батбүрэн толгой ХХК-ийг репо санхүүжилттэй зээлээс 65.5 сая.төг, төмс, хүнсний ногоо тариалагч Чандмань ундрах хоршоо 28.0 сая төг-ийн зээл олгосон. 2024 онд ЖДҮХС-аас Амгаланзаяа ХХК-д жимс, жимсгэнэ тариалаж, жимстэй цай үйлдвэрлэхэд 300 сая төг, үхрийн нүд жимс тариалж, чанамал үйлдвэрлэхэд 200 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл олгож,, дэмжлэг үзүүлсэн. Улаанбаатар хотын Вагро, Газар шим, Дөрвөн өлзий зэрэг хүнсний ногоо боловсруулах томоохон үйлдвэрүүд 2000 тонн багтаамжтай түхий эдийн агуулах, цэгийг байршуулж, өргөст хэмх, сонгино, лууван, хүрэн манжин зэрэг бүтээгдэхүүнийг Орхон сумын хүнсний ногооны тариалан эрхлэгчидтэй гэрээлэн түүхий эдийг кластер хэлбэрээр татан төвлөрүүлж байна. ХХААГ, "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран зохион байгуулсан "Хүлэмжийн зохистой дадал" сургалтанд 2023 онд 30, 2024 онд Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран 15 хүлэмжийн аж ахуйн эрхлэгчдэд хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүллээ. Бүтээгдэхүүн үйлчилгээг нийтэд таниулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Хөгжлийн шийдэл ТББ ын санхүүжилтээр Цахим каталогит Батбүрэн толгой, Найрамдал мөөг, аймгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Цэц.мн сайтаар Батбүрэн толгой Наараа кимчи цехийн үйл ажиллагааг сурталчилсан.<br>Жимс, жимсгэнийн тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 5 аж ахуйн нэгж 2020-2023 онд жилд дунджаар 6.9 га талбайд жимс жимсгэнэ тариалж, 21.3тн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлсэн. Чацаргана жимс тариалалтаар Барчиншангай нөхөрлөл ЗБН-ийг 2020 онд 20.0 сая.төг, Мод бут жимс, жимсгэнэ тариалагч Өгөөж ирээдүй ХХК-д 2022 онд 40.0 сая.төг-ийг тус тус ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлээс санхүүжилт олгосон.<br>**Үр дүн:** Хүнсний ногоо боловсруулах, нөөшлөх, савлах, хатаах чиглэлээр 3 аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээлэнд хамрагдаж үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, нийт 8 аж ахуйн нэгж, 1 цех, нийт 29 ажилтантай, жимс | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | жимсгэнэ боловсруулах 1 аж ахуйн нэгж, 2 ажилтантайгаар тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотын 3 үйлдвэрт кластер хэлбэрээр түүхий эд бэлтгэн нийлүүлж байна. | |
| 286 | 5.1.3.6. Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | - | Махан бүтээгдэхүүн 109 тонн, сүүн бүтээгдэхүүн 190 мян.л, гурил 22244 тонн, талх 420 тонн, нарийн боов 572 тонн үйлдвэрлэсэн байна. | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг 1.5-2.0%-иар нэмэгдүүлнэ. | - | - | Орон нутгийн хүнсний боловсруулах үйлдвэрийн 2023 оны гүйцэтгэлээр махан бүтээгдэхүүн 186.2тонн, сүүн бүтээгдэхүүн 116.1 мян.л, гурил 32282.41тонн, талх, гурилан бүтээгдэхүүн 1411.48тонн үйлдвэрлэсэн нь суурь түвшинтэй харьцуулахад гурил 45.1%, талх, нарийн боов 42.2%, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 70.8%-аар өссөн байна.<br>Өвлийн улирлын сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхээр 2022-2023 онд 2 үйлдвэр, 2023-2024 онд 1 үйлдвэр сонгон шалгаруулалтад хамрагдаж, 26 малчинтай гэрээ байгуулан үйлдвэрлэлийг тасралтгүй явуулж байна. Хаврын улирлын цаг агаарын нөхцөл байдал, малын тарга тэвээрэгтэй холбоотойгоор малчдаас сүүний нийлүүлэлт 2023 онд 5-р сарын 20-оос, 2024 онд 5-р сарын 10-аас нэмэгдсэн. Тус аймагт 1 үйлдвэрт технологийн шинэчлэл хийж, 3.0 мян.ш/цаг зайрмаг үйлдвэрлэх хүчин чадалтай урсгал шугамыг 2021 онд бүрэн угсарч ашиглалтад оруулснаар хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, 7 нэр төрлийн зайрмаг үйлдвэрлэдэг байсан бол 13 нэр төрөл болгон нэмэгдүүлж, “Цасхан зайрмаг” “Брэнд, шилдэг бүтээгдэхүүн”-ээр шалгарлаа. Мөн 3 үйлдвэр цөцгийтэй тараг /0.9 гр чихэртэй, чихэргүй/ үйлдвэрлэж, ЕБС-ийн хүүхдэд сард 2-3 удаа нийлүүлэлт хийлээ. Аарцан бүтээгдэхүүн “Сырок” нэрийн бүтээгдэхүүний шинэ технологийг 2020 онд туршиж, 2021 онд үйлдвэрлэлд нэвтрүүлж, 40.0 мян.ш-ийг үйлдвэрлэж, өмнөх оноос 50 хувиар нэмэгдүүлж, 2023 онд “Импортыг орлох шилдэг бүтээгдэхүүн”-ээр шалгарсан.<br>Гурилын 3 үйлдвэр бүрэн автомат тоног төхөөрөмжтэй, гурилаар бүрэн хангаж, улсын хэмжээний хэрэгцээт гурилын 40-50 хувийг хангах хэмжээний үйлдвэрлэл явуулдаг Гурилын үйлдвэрүүд зээлийн хүүгийн хөнгөлөлтөд хамрагдаж, намрын ургац хураалтаас үр тарианы чанараас хамааран жилд 40-90 мян.т улаанбуудай татан авч байна. Гурилын 2 үйлдвэр чанарын | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | менежментийн стандарт нэвтрүүлж, БНХАУ-руу экспортлох хянан магадлагаанд тэнцсэн ба 2023 онд 1 үйлдвэр 20.0 т гурил экспортолсон. Мөн овъёостой гурил аймгийн “Брэнд бүтээгдэхүүн”-ээр шалгарсан. 2024 онд гурилын агуулах дүүрч, 1-1.5 сар хугацаанд сул зогсолт хийж, үйлдвэрийн технологийн засвар үйлчилгээг хийлээ.<br>Талх, нарийн боовны 17 аж ахуйн нэгж, 14 иргэн, хэрчсэн гурилын 4 аж ахуйн нэгж, 8 иргэн үйлдвэрлэл явуулж байна. Үүнээс 2021-2023 онд 4 аж ахуйн нэгж, 5 цех шинээр нэмэгдэж, 2024 онд 2 цех иргэнээс аж ахуйн нэгж рүү шилжсэн. Хөрөнгийн аргаар үйлдвэрлэх талхны технологи 2 цехээр нэмэгдэж, 4 боллоо. Хүнсний хувьсгалын хүрээнд хөнгөлөлттэй зээлд 7 аж ахуйн нэгжид үзүүлснээр 3 нь ажлын байрыг стандартад нийцүүлж, 4 нь технологийн шинэчлэл хийж, хүчин чадлыг 2 хувиар нэмэгдүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжрууллаа.<br>Хаврын улиралд 100-200 тонн махны нөөц бүрдүүлэн, нийлүүлж махны хангамжийг нэмэгдүүлж ажилласан. Мах боловсруулах 3 үйлдвэр, ангилан савлах болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний 1, мал төхөөрөх 2 үйлдвэр болон сумдын Засаг дарга нарт мал, махны үнэ хямд үед махны нөөц бүрдүүлэх талаар чиглэл хүргүүлж ажилласан. Мөн махны салбарын малчин, мал мах бэлтгэгч, мал төхөөрөх үйлдвэр, мах боловсруулах үйлдвэр, махны төрөлжсөн дэлгүүр, хүнсний дэлгүүрийн төлөөлөл, зах худалдааны төв, 2023 онд нийт 21, 2024 онд 47 үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгч нартай "Мал, махны бэлтгэл, махны нөөц бүрдүүлэх", борлуулах талаар уулзалт хийлээ. Уг уулзалтад 2023.01.01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн **Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт** /ЗГ-ын тогтоол 2022 оны №224/,2023.09 сард батлагдсан **Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам** /ЗГ-ын тогтоол 2023 оны №344/-ыг танилцуулав.<br>Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, хүнсний боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч нартай ХХААГ-ын дарга үйлдвэрлэлийг | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | нэмэгдүүлэх чиглэлээр уулзалт хийж, санал хүсэлтийг сонсож, гарсан саналыг холбогдох байгууллага/ХХААХҮЯ, ЗДТГ/-д уламжилсан. Хүсэлтийн дагуу 2024 оны 5-р сард ХХААХҮЯ, БШУГ, ТХААГ Дархан-Уул аймагт Ерөнхий гэрээгээр борлуулалтыг нэмэгдүүлэх ажлыг эхлүүллээ.<br>Хүнсний хувьсгал хөдөлгөөний хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Арилжааны банкаар дамжуулан 5 жилийн хугацаатай 5 ба 6 хувийн хүүтэй хөрөнгө оруулалтын зээл, 2 жилийн хугацаатай 6 хувийн хүүтэй эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтийг ХХААХҮЯ-д уламжилсан. Үүнээс 2023-2024 онд сүү боловсруулах 1 үйлдвэр 80.0 сая.төг, гурилын 2 үйлдвэр 43.0 тэрбум төг, гурилан бүтээгдэхүүний 5 үйлдвэр 850 сая.төг, махан бүтээгдэхүүний 4 үйлдвэр 3544.0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлэнд хамрагдаж үйл ажиллагаag өргөжүүлэхэд дэмжлэг боллоо. Үүнээс 2024 онд хүнсний боловсруулах 12 үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зарцуулалтад хяналт тавьж ажилласан.<br>**Үр дүн:** Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 2020 онтой харьцуулбал гурил 45.1%, талх, нарийн боов 42.2%, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 70.8%-аар өссөн байна. 2023-2024 онд 12 үйлдвэрт 47.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн ба 2024 онд үр дүнд хяналт тавьж ажилласан. | |
| **ЗУРГАА. ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | | | | | | | | | | |
| **6.1 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | | | | | |
| **6.1.1 Халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | | |
| 287 | 6.1.1.1. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийг төсөвт тусгана. | 2021-2024 | СТСХ | - | | 150 | - | - | Аймгийн хэмжээнд 2021 оны Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг авахтай холбогдуулан хөрөнгө гаргах асуудлын 599.2 сая төгрөг,<br>2022 онд 127.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж нийт 726,2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжилт хийсэн.<br>2023 онд Засаг даргын нөөц санд төлөвлөгдсөн 1 тэрбум 246.4 сая төгрөг | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2024 онд Засаг даргын нөөц санд төлөвлөгдсөн 627.4 сая төгрөгийн төсөвт тусган болзошгүй гамшиг, халдварт өвчин, ковид цар тахлаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна.<br>**Үр дүн**: 2021 онд 599.2 сая төгрөг, 2022 онд 127.0 сая төгрөг. Нийт 726.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжилт хийсэн. | |
| 288 | 6.1.1.2. Эмч мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах дадлага болон онолын сургалтыг тасралтгүй зохион байгуулна. | 2021-2024 | НБХ | 12.0 | | 500 | | | **2021** онд ДЭМБ, ЭМЯ-ны төслөөр “Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын эсрэг Дархан-Уул аймгийн хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх” ажлын хүрээнд нийт 4 удаагийн сургалтад 550 хамрагдсан.<br>**2022** онд Аймгийн томуугийн тоо баримт дээр тулгуурлан судалгаа хийж, PISA үнэлгээний босго үзүүлэлттэй болсон. Шинэ Коронавирусийн халдварын оношилгоо, эмчилгээний түр заавар болон Халдварт өвчний талаар чадавхжуулах сургалтад 404 эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд хамрагдсан.<br>**2023** он Халдварт өвчнөөс сэргийлэх, Улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалт, Халдварын сэргийлэлт хяналт, Тууралтат халдварын тохиолдол, сэргийлэх арга хэмжээ” “Короновируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдал” зэрэг 14 удаагийн сургалтад 384 эмнэлгийн ажилтан, мэдээлэл сурталчилгаанд 4353 хүнд, ТВ-ийн мэдээлэл 6 удаа, цахим мэдээлэл 8 төрлөөр хийсэн байна.<br>**2024** онд Монголын тархвар, халдвар судлаач эмч нарын нийгэмлэг (МТХСЭНН)-ээс Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын хүсэлтийн дагуу Дархан-Уул аймгийн ЭМГ, НЭ, ӨЭМТ, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 50 эмч мэргэжилтнүүдэд “Халдвар хяналтын ажилтан, түүний гүйцэтгэх үүрэг” сэдвээр сургалт боллоо. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | - Дархлаажуулалтын үндэсний товлолыг Монгол Улсын Засгийн газрын 2023.12.27-ны өдрийн 472-р тогтоол шинэчлэгдэн батлагдсан тул харьяа эрүүл мэндийн байгууллагын 150 эмч, мэргэжилнүүдэд чадавхжуулах сургалт зохион байгуулсан.<br>Эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах дотоодын сургалт тасралтгүй явагдаж байгаа бөгөөд давхардсан тоогоор 348 ажилтан хамрагдсан байна<br>**Үр дүн:** 2021 онд 550, 2022 онд 404, 2023 онд 384, 2024 онд 548 эмч, мэргэжилтнүүдийн чадавхыг сайжруулах дадлага болон онолын сургалтыг зохион байгуулсан. | |
| **6.1.2 Халдварт цар тахлын голомт, бусад тусламж үйлчилгээнд ажиллах эмч, эмнэлгийн ажилтан, тоног төхөөрөмжийн нөөцийн бэлэн байдлыг хангана.** | | | | | | | | | | |
| 289 | 6.1.2.1. 3 болон 4 дүгээр улиралд томуугийн вакцин хийх ажлыг эрчимжүүлнэ. | 2021-2024 | НБХ | 36.0 | | 90%-аас доошгүй | 9.0 | - | **2021** онд Томуугийн 11170 хүн тун вакцинд зорилтот бүлэг буюу 2-11 насны хүүхэд болон, жирэмсэн эмэгтэйчүүдийг 100% хамруулсан.<br>**2022** онд Томуугийн дархлаажуулалтанд нийт 8625 иргэд хамрагдаж 63% байна.<br>**2023** онд Томуугаас сэргийлэх дархлаажуулалтыг 2023.10.20-ноос эхлэн 0-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, Эрүүл мэндийн ажилтанууд, 65-с дээш насны ахмадууд, архаг хууч өвчтэй иргэд гэсэн зорилтот бүлгүүдэд хийсэн ба хамрагдалт 94% байна.<br>**2024** он Томуугийн улирлын вакцинд 6-15 насны хүүхдүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, архаг хууч өвчтэй 6300 хүнд хийгдэхээр вакцины татан авалт хийгдэж байна. 9 сардаа багтааж бүрэн хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна.<br>Улаанбурхан, улаанууд өвчний сэргийлэх нэмэлт вакцинд зорилтот бүлгийн 3011 иргэнийг хамруулсан. Үүнд:<br>зорилтот бүлгийн хүүхэд 10671 /75%/<br>ЭМА 575 /80,0%/<br>СӨББ, ЕБС, амрамж, түр хамргаалах байрны багш ажилчид 1611 /72.5%/<br>Эрсдэлт бүлгийн 42 иргэн хамрагдсан байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | УГУ нөхөн дархлаажуулалтын 1-р тунд 577, 2-р тунд 1071 буюу нийт 1648 зорилтот бүлгийн хүүхдийг 90% хамруулсан.<br>**Үр дүн:** 2021 онд 100%, 2022 онд дархлаажуулалт 63%, 2023 онд 94%, 2024 онд 90%-тай байна. | |
| 290 | 6.1.2.2. Тархвар Судлалын Заалтаар сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг дархлаажуулалтад хамруулна. | 2021-2024 | НБХ | - | | 90.3% | | | **2021 он:** Улирлын томуугийн вакцинд 2-11 насны нийт 11170 хүүхэд хамруулахаас 11082 хүүхэд 88 жирэмсэн эхийг дархлаажуулсан байна. Хамрагдалт 90%<br><br>**2022** онд Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтад 171081 хүн хамрагдсанаас 5-11 насны хүүхэд 1-р тун 301, 2-р тун 234, нийт 535 хүүхэд, 12-17 насны хүүхдэд 1-р тун 9065, 2-р тунд 7866 хүн хамрагдсан бол 2023 онд Короновируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтад 5-11 нас 565, 12-17 нас 16891, 18-аас дээш 153915 буюу нийт 171371 хүүхэд 1-4-р тун хийлгэсэн.<br>**2023** оны 05 сараас эхлэн Улаанбурхан, улаануудын нэмэлт дархлаажуулалтын товлолт вакцин 1-р тунд 1763 хүүхэд хамрагдахаас 1763 хамрагдаж хэрэгжилт 100%, 2-р тунд 1543 хүүхэд хамрагдахаас 1543 хамрагдаж хэрэгжилт 100%-тай байна. Нэмэлт дархлаажуулалтад 17500 вакцин ирсэнээс 10022 хүүхэд сайн дурын үндсэн дээр хамрагдсан нь хамрагдалт 57,3%-тай байна. Нийт хэрэгжилт 85.8%-тай байна.<br>**2024** онд Тархвар судлалын заалтаар: Галзуугийн эсрэг дархлаажуулалтад 81 хүн, хачигт энцефалитын эсрэг дархлаажуулалтад 200 хүн хамрагдсан. Улаанбурхан, гахайн хавдар, улаанууд өвчний эсрэг товлолын дархлаажуулалтын 1-р тунд 856, 2-р тунд 691 хүүхэд хамрагдсан.<br>Улаанбурхан өвчний дэгдэлт гарсан тул нэмэлт болон нөхөн дархлаажуулалтад 3106 зорилтот бүлгийн иргэнийг хамруулсан байна. Дархлаажуулалтын | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | дараах урвал хүндрэл илрээгүй. Хамрагдалт 91% байна.<br>**Үр дүн:** 2021-2024 онд Тархвар судлалын заалтаар дархлаажуулалтад 90-91% хамрагдсан байна. | |
| 291 | 6.1.2.3. Халдварт өвчнөөс сэргийлэх хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг хангана | 2021-2024 | ЭМГ, НБХ | Улсын төсөв | | Тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ | | | Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр Улсын төсвийн 850 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулсан.<br>Халдвартын тасгийн бэлэн байдал 400 сая төгрөгөөр тоног төхөөрөмжөөр хангасан.<br>Дезкамер бүрэн суурилуулж ашиглалтад оруулсан.<br>1-р давлагаанд: Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн А/11 тоот тушаалаар Эрүүл мэндийн газрын Тохиолдлын удирдлагын тогтолцооны бие бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. ЭМГ-ын ТУТ Даваа-Баасан гаригуудад шуурхай штабын хурлыг зохион байгуулан, шийдвэрлэвэл зохих асуудлуудыг тухай бүр шийдвэрлэн, зохион байгуулалтын арга хэмжээ авч байна. ЭМА-ны ТУТ баг хуралдаж, ЭМГ-ын дарга 345 үүрэг даалгавар өгч ажилласан бөгөөд хэрэгжилт 96%-тай байна.<br>Эрүүл мэндийн албаны шуурхай штабын хариуцлагатай жижүүрүүдийг 24 цагаар ажиллуулж эхэлсэн.<br>Эмчлэн тусгаарлах, тусгаарлан ажиглах байранд эмч, сувилагч, үйлчлэгч хуваарийн дагуу халдварын голомтод орж ажиллаж байна. Дуудагдан ажиллах эмч, мэргэжилтнүүдийн хуваарь, ажиглан тусгаарлах байр, эмчлэн тусгаарлах байранд ажиллах эмч ажилчдын хуваарийг гарган, үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж байна.<br>Батлагдсан тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой эмнэлэг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах зорилгоор хувийн хэвшлийн ор бүхий эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нартай уулзалт 5 удаа хийж эмнэлэг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг танилцуулан бэлэн байдлыг хангуулсан.<br>Шарын гол суманд тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой тус сумын Тулга сувилалд ажиглан тусгаарлах байраар бэлтгэн иргэдийг тусгаарласан. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Нэгдсэн эмнэлгийг Шинэ короновируст халдвар /Covid-19/-ын сэжигтэй болон батлагдсан тохиолуудыг тусгаарлан эмчлэх зорилгоор халдвартын тасгийг бүрэн суллаж, хүүхдийн тасгийг хувийн хэвшлийн Цээнэ эмнэлэгт, дотор, мэдрэлийн тасгийг АШУҮИС-ийн харьяа Дархан салбар сургуулийн Сайхан сэтгэл эмнэлэгт, Мэс засал, гэмтэл, мэдээгүйжүүлгийн тасгийг Саран-Элит эмнэлэгт нүүлгэн шилжүүлж 301 ор бүхий эмнэлгийн бэлэн байдлыг хангуулан эмчлэн тусгаарлах байранд өвчтөн эмчлэгдэн гарсан байна.<br>2-р давлагаа: 6 сарын эхээр халдварын тархалт дахин нэмэгдсэнтэй холбоотой Коронавируст /Ковид-19/ халдварын үеийн эмнэлэг дэлгэх эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний дагуу орны бэлэн байдлыг ханган 301 орыг дэлгэн ажилласан.<br>Тохиолдлын удирдлагын тогтолцооны багийн штабын 7037-4157, 7037-1000 суурин утсыг 24 цагаар ажиллуулж, мэдээлэл солилцож байна. Утсаар өдөрт дунджаар 150-200, ачаалал ихтэй үед 300-350 дуудлага авч иргэнд мэдээлэл хүргэж ажилласан байна.<br>Өдөр бүр ЭМЯ, ЗӨСҮТ, ХӨСҮТ, аймгийн ЗДТГ, ОБГ, МХГ, ТГ, ЦГ зэрэг байгууллагуудад мэдээ, мэдээллийг 2 цаг тутам шуурхай хүргэн ажиллаж байна.<br>ЭМГ-ын ар гэрийн судалгааг шинэчлэн гаргасан.<br>Эрүүл мэндийн байгууллагууд короновирусын халдвартай тэмцэх, сэргийлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж амьсгалын замын өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэх замын зураглал гарган, тусламж үйлчилгээг зохион байгуулан ажиллаж байна.<br>Халдвар хамгийн ихээр голомтлон гарч байгаа багуудын хүн амын дунд өргөжүүлсэн тандалт хийсэн.<br>Шуурхай арга хэмжээний баг эмчлэн тусгаарлах, тусгаарлан эмчлэх болон гэрийн эмчилгээнд эмчлэгдэж байгаа иргэдийн эмчилгээ үйлчилгээ, тээвэрлэлт,ӨЭМТөвийн гэрийн эмчилгээнээс эмнэлэгт шилжих иргэдийг шилжүүлэн ажиллаж байна.<br>3-р давлагаа:<br>Аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн 850 ор үүнээс 10 эрчимт эмчилгээний | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | орны бэлэн байдлыг ханган Коронавирусийн халдварын батлагдсан тохиолдлыг авч хэвтүүлэн эмчилж, тусламж үйлчилгээг шуурхай хүргэн ажиллаж байна.<br>Сайн дурын шинжилгээ өгөх 2 цэгт түргэвчилсэн болон ПГУ шинжилгээ авч, өрхийн эмч нар эрэмбэлэн ангилалт хийж, хэвтэх иргэдийн нэрсийг Шуурхай арга хэмжээний багт хүргүүлж, гэрээр эмчлэгдэх хөнгөн өвчтөнд гэрийн багцын эмчилгээг шуурхай өгч ажиллаж байна. | |
| 292 | 6.1.2.4. Халдварт өвчнөөс сэргийлэх мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгаа зохион байгуулна. | 2020-2024 | НБХ | 8.0 | | 20000 иргэн | 2.0 | - | **2021** он Коронавируст халдвар (COVID-19) 21 төрлийн шторк сэрэмжлүүлгийг өдөр бүр 17 сувгаар 24-36 удаагийн давтамжтай явуулж байна. Орон нутгийн телевизийн цаг үеийн мэдээ мэдээлэл 82 удаа, тодруулга ярилцлага 21 удаа, зочны ярилцлага-7 удаа, оролцсон байна. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлье сэдвээр 74 удаагийн эрүүл мэндийн цахим LIVE нэвтрүүлэг бэлтгэн, хандсан хүний тоо 57326 байна. Ковид 19 эсрэг дархлаажуулалтын үеийн мэдээлэл сурталчилгаанд 104218 хүн хамрагдсан байна.<br>**2022** он Халдварт өвчнөөс сэргийлэх мэдээ мэдээлэл, сургалтад 164, Мэдээлэл, сурталчилгаанд 18007 хүн, RGB, DBS телевизүүдээр зөвлөмжийг 6-8 удаагийн давтамжтайгаар хүргэсэн байна. Орон нутгийн ТВ-ээр мэдээлэл 2 удаа, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 36 видео зөвлөмж, постер 56, эмчийн цахим зөвөлгөө 20. Хандалтын тоо-12251<br>**2023** он Амьсгалын замын халдвар, ТТӨ-өөс сэргийлэх, Дархлаажуулалт гэж юу вэ? Сургалт, мэдээллийг 4353 хүнд, ТВ-ийн мэдээлэл 6 удаа, цахим мэдээлэл 8 төрлөөр хийсэн байна.<br>**2024** он: Халдварт өвчнөөс сэргийлэх, тэдгээрийг бууруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх тандалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, цаашид авах | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | арга хэмжээг тодорхойлох зорилгоор зөвөлгөөнийг зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтэн 36 хүн оролцсон ба мэдээлэл,зөвөлөгөө, сэрэмжлүүлгийг цахимаар 14522 хүнд хүргэсэн: Эрсдэл бүлэгт чиглэсэн БЗДХ,ХДХВ,ДОХ-оос сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулж 1122 иргэд хамрагдсан. Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрөөр Эрүүл мэндийн байгууллагууд, Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг хамтран нус цэрээ ил задгай хаяхгүй байх, зөв ханиаж найтаах Дархан зах, Их дэлгүүр, Олон улсын худалдааны төв, Номин худалдааны төв, Үйлчилгээний төв зэрэг томоохон худалдааны газруудын түрээслэгч нар, үйлчлүүлэгч нарт чиглэсэн Эрүүл мэндийн байгууллагууд хуваарилагдсан газарт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, 2800 гаруй иргэдэд мэдээлэл өгч, зөвлөмж тарааж ажилласан.<br><br>Үр дүн: 2021 онд мэдээлэл сурталчилгаанд 104218 хүн, 2022 онд 12251, 2023 онд 4353 хүн, 2024 онд 22833 хүнд мэдэээлэл хүргэж ажилласан байна. | |
| 293 | 6.1.2.5. Цар тахлын үед ажиллах хүний нөөц болон эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангана. | 2021-2024 | НБХ | 200.0 | | Тоног төхөөрөмжийг сайжруулна. | 50.0 | | **2021** онд Burtgel.mohs.mn орлого, зарлага, нөөцийн мэдээллээ оруулан УОК-т 7 хоног бүрийн лхагва гаригт хүргүүлэн ажилласан.<br>**2022** онд эм, эмнэлгийн хэрэгсэл 30-90 хоногийн нөөцтэй,<br>**2023** онд Цар тахлын үед ажиллах хүний нөөц батлагдсан орон тоогоор ажиллаж байна.<br>Цар тахал, томуугийн дэгдэлт үүссэн үед нэмэлтээр ажилуулах хүний нөөцийн төлөвлөлт хийсэн, эм тарианы 2 сарын нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.<br>**2024** онд Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангаж эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийн 2 сарын нөөцийг бүх шатлалын эрүүл мэндийн байгууллага бүрдүүлсэн. Хонгор сумын ОНХС-с 19.5 сая төгрөгийн | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлсэн.<br>Шарын гол сумын ОНХС-аас 150.0 сая төгрөгөөр Рентген аппарат дагалдах хэрэгслээр хангасан.<br>**Үр дүн:** 2021-2024 онд ажиллах хүний нөөц болон эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг ханган 1-2 сарын нөөцийг бүрдүүлэн ажилласан. | |
| **6.1.3. Аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо эмчилгээний төвийг РТ-ПСР төхөөрөмжөөр хангана.** | | | | | | | | | | |
| 294 | 6.1.3.1. Оношлогоонд шаардлагатай оношлуурын бэлэн байдал, нөөцийг хангана. | 2020-2024 | НБХ | 140.0 | | PCR 1 | | Улсын төсөв 23.300.000 | 2021 онд Түргэвчилсэн шинжилгээ 93038 хийснээс эерэг 19143 гарсан. Эерэг илрэлтийн хувь 20.6%<br>PCR шинжилгээ 52577 хийж эерэг 12410 тохиолдол батлагдаж эмчилгээнд орсон байна. Эерэг илрэлтийн хувь 23.6%. Оношлуурын 3 сарын нөөцтэй бэлэн байдлыг ханган ажилласан<br>2022 онд ПГУ 5706, түргэвчилсэн 4494 хүнд шинжилгээ хийж ажилласан. Ковидын түргэвчилсэн оношлуур 1400 ширхэг, ПГУ ялгах 5706, тодорхойлох 4494 ширхэг нөөцтэй байна.<br>2023 онд PCR оношилгоонд 2771 оношлуур хангагдсанаас 1043 ш зарцуулж, нөөцөд 1728ш үлдэгдэлтэй байна.<br>2024 онд Коронавируст халдвар /Ковид-19/ыг илрүүлэх 135 шинжилгээ хийгдсэнээс 15 тохиолдол батлагдсан байна.<br>ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид 54 сорьц илгээсэн ба бүх сорьц баталгаажсан байна. Улаанбурхан өвчний оношилгоонд ашиглах вирус тээвэрлэх орчин 250 ширхэг ХӨСҮТ-с тээвэрлэн ирж сорьц тээвэрлэх бэлэн байдлыг хангасан.<br>**Үр дүн:** оношлуурыг 1 сарын нөөцтэй бэлэн байдлыг ханган ажилласан. | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 295 | 6.1.3.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ. | 2021-2022 | НБХ, ЭМГ | Улсын төсөв ОУБ санжүүжилт | - | 1 машин | - | - | ДЭМБ-ын санхүүжилтээр ЭМЯ, ЗТЯ хамтарсан тушаалын дагуу 2022 оны 05 дугаар сарын 16- ны өдрөөс “Монгол шуудан” ХХК-аар ковид болон томуугийн эерэг сорьцыг ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторит түргэн шуурхай тээвэрлэж байна. Олон улсын буцалтгүй тусламжаар Нэгдсэн эмнэлэгт 3 түргэн тусламжийн машин, Гэрэлтэй ӨЭМТ-д орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1 автомашиныг нийлүүлж нийт 4 автомашинаар парк шинэчлэл хийсэн.<br>**Үр дүн:** 4 машинаар парк шинэчлэл хийсэн | 100% |
| 296 | 6.1.3.3. Зориулалтын сорьц авах цэгийн кабинтай болно. | 2021-2022 | ЭМГ, НБХ | Улсын төсөв ОУБ санжүүжилт | - | 1 кабин | - | - | Сүрьеэгийн лаборатори байсан хэсгийг засварлаж Ковид-19 /PCR/ шинжилгээ авах цэгтэй болсон. Тус цэгээр 5706 хүнээс PCR шинжилгээ авсан байна.<br>**Үр дүн:** Зориулалтын сорьц, шинжилгээ авах 1 цэгтэй болсон. | 100% |
| **ДОЛОО. ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | |
| **7.1. Нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх багтаамж ихтэй нийтийн тээврийн шинэ технологи нэвтрүүлэх** | | | | | | | | | | |
| 297 | 7.1.1. Гэр хороололруу нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, | 5,600.0 | 10 автобусаар 4-н чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлж байна. | Ширээ нуруу, Мангирт, Толгойт чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ | 1,389.3 | 1,000.9 | 2022 онд 810 сая төгрөгөөр 4 шинэ сурагчдын автобус, 2024 онд 900 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 шинэ хүүхдийн автобус хүлээн авч нийт 8 хүүхдийн автобус 8 чиглэлд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: Мангирт-31-р сургууль чиглэл, Сондор-31-р сургууль чиглэл, Хабитад-ОИЦ сургууль чиглэл, Мангирт-ОИЦ чиглэл, Хөтөл-16-р сургууль чиглэл, Толгойт-1-р сургууль чиглэл, Ширээ нуруу-16-р сургууль чиглэл, Тосгон-4-р сургууль чиглэл<br>2024 онд парк шинэчлэлтийг 12.8 тэрбум төгрөгөөр бүрэн цахилгаан 20 автобусаар | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | нэмэгдүүлэн нийт 5 чиглэлд үйлчилгээ үзүүлж байна. Үүнд: Үйлчилгээний төв-Дархан сумын ЗДТГ чиглэл, Ширээ нуруу-Тосгон-Дархан зах чиглэл, Толгойт-Хөтөл хороолол чиглэл, Хабитат-Мангирт чиглэл, Автовокзал-Төмөр замын вокзал чиглэл<br><br>Үр дүн: 2022-2024 онд парк шинэчлэл хийгдэж бүрэн цахилгаан 20 автобус, хүүхдийн 8 автобусаар нэмэгдүүлэн, алслагдсан баг хорооллын иргэд болон хүүхдүүдэд үйлчилж байна. | |
| **7.2. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг дагалдах үйлдвэрүүдийн хамт хөгжүүлж ган бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангах** | | | | | | | | | | |
| 298 | 7.2.1. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ | - | Дархан Төмөрлөгийн үйлдвэр нь “Монгол Ган цогцолбор I” төслийн ТЭЗҮ-г боловсруулж дууссан. | Үндсэн суурь судалгаа хийгдэнэ. | - | - | “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь “Дархан” ҮТП-ийн хүрээнд “Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр”-ийн төсөл, Төмөртэйн уурхайн “Нойтон баяжуулах, хорголжийн үйлдвэр”-ийн төсөл болон “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.<br>“Эрдэнэс Монгол” ХХК-иас 6 үйлдвэрлэл технологийн парк байгуулахаар 2024-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөндөө тусгаж “Монгол ган цогцолбор I” төслийн нэр, хүчин чадлыг өсгөж “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төсөл болгон хэрэгжүүлэхээр болсон.<br>“Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр”-ийн төслийн ТЭЗҮ-г боловсруулж ЭБМЗ-өөр 2024 оны 06 сарын 24 өдөр хэлэлцүүлж хүлээн авах шийдвэр гарсан. Төслийн дараагийн шатны ажлуудыг эхлүүлэхээр ажиллаж байна.<br>“Нойтон баяжуулах, хорголжийн үйлдвэр”-ийн төсөл болон “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” төслийн ТЭЗҮ боловсруулах ажлыг “Эрдэнэс ҮТП” ХХК-иар хийлгэхээр ажлын даалгаврыг боловсруулж байна.<br>**Үр дүн:** Эдгээр 3 төслийг хэрэгжүүлснээр Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн хүчин чадал ашиглалтыг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн, импортыг орлох эцсийн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орон нутагт | 50% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 2000 шууд ажлын байр шинээр бий болно. Бусад төрлийн үйлдвэрлэл кластер хэлбэрээр хөгжих нөхцөл бүрдэнэ. Барилгын өртөг зардал, барилгын материалын үнэ тогтворжуулахад хувь нэмрийг оруулна. | |
| **7.3. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх** | | | | | | | | | | |
| 299 | 7.3.1. “Дархан арьс ширний цогцолбор” шинээр барьж ашиглалтад оруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | 450,000.0 | Арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт 20% | Арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт 60% | 150,000.0 | 0.0 | Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018.08.17-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор “Дархан арьс ширний цогцолбор” байгуулах шийдвэр гарч 180 га газрыг олгосон. “Дархан арьс ширний цогцолбор” үйлдвэрийг байгуулснаар 7500 орчим байнгын ажлын байр, жилдээ 10 сая.ш арьс шир боловсруулах 13 үйлдвэр, 10 мян.т ноос боловсруулах ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, түүний цэвэрлэх байгууламж, инженерийн дэд бүтцийн барилга байгууламж бий болох бөгөөд эрчим хүч, усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, дулаан хангамж, уурын зуух зэргийг барьж байгуулахад 15.4 сая ам долларын хөрөнгө оруулалтыг хийж, эрчим хүч 95%, дэд станц ажил гүйцэтгэл 90%, ус, дулаан хангамж 70%, бохир ус цэвэрлэх байгууламжийн аэро-танк зэрэг ажлууд өмнөх онд хийгдсэн.<br>Дархан арьс ширний цогцолбор ТӨХК-д аймгаас 25 га талбай газрыг олгож, бүтээн байгуулалтыг дэмжиж ажиллаж байна.<br>Үндэсний аудитын газрын дүгнэлтээр Дархан арьс ширний цоцгцолборын төслийн нийт төсөвт өртөг нь 86.2 тэрбум төгрөг үүнээс 40,8 тэрбум төгрөгийн ажил хийгдэж 47,4 хувийн гүйцэтгэлтэй байна<br>**Үр дүн:** “Дархан арьс ширний цогцолбор” байгуулах төслийн хүрээнд мастер төлөвлөгөө, ТЭЗҮ, төслийн ерөнхий төлөвлөгөө, техник технологийн процессын зургууд, Инженер хайгуулын судалгаа, арьс ширний үйлдвэрийн ажлын зургууд, Инженерийн шугам сүлжээний байгууламжийн ажлын зургууд, Испани Медиа Пост компанитай 600000 ш арьс шир нийлүүлэх туршилтын гэрээ, бохир ус цэвэрлэх байгууламжийн аэро-танк тус тус хийгдсэн. | 50% |
| **7.4. Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотууд болон орон нутагт хотхон байгуулан шилжүүлэх замаар хотын төвлөрлийг сааруулах** | | | | | | | | | | |
| 300 | 7.4.1. Эрдэмтдийн зөвлөлийн | 2021-2022 | НБХ | 12.0 | Аймгийн Засаг даргын 2018 | Хотын соёл, экологи, хөгжилд нэн | - | | 2021 онд "СУДЛААЧ 2021" эрдэм шинжилгээний онол практикийн XXII бага | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааг дэмжинэ. | | | | оны 01-А/355 захирамж | шаардлагатай, инноваци /Шинэчлэл, сайжруулалт/-ийн бүтээлийг шалгаруулна | | ОНТ 5.0 | хурлыг 2 удаа зохион байгуулсан. Хуралд 9 их дээд сургууль, коллежийн 370 эрдэмтэн багш, 6000 орчим оюутан залуучуудын төлөөлөл оролцсон. Шилдэг илтгэлүүдийг “Дээд боловсрол-Эрин үе” сэтгүүлд хэвлэн олны хүртээл болгосон. ОНТ-өөс 1,1 сая төгрөгийг зарцуулсан.<br>2022 онд Эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг 3 удаа зохион байгуулж 180 эрдэмтэн судлаач багш, оюутнууд оролцсон. ОНТ-өөс 9,278,300 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>2023 онд Их дээм мэргэжлийин сургуулиудын консорциумтай хамтран орон нутагт тулгамдсан асудалд шийдэл хайэ хамтран шийдвэрлэх арга замыг илэрхийлэх зорилгоор “Эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал-2023”-ыг эрдэмтэн багш, судлаачдын дунд зохион байгуулж, ОНТ-ийн 2.460.000 төгрөгийг дэмжлэг үзүүлсэн.<br>2024 онд “Эрдэм шинжилгээ-онол практикийн бага хурал-2024”-ийг багш, оюутнуудын дунд зохион байгуулахад 2.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>**Үр дүн:** Орон нутагт тулгамдсан асуудалд шийдэл арга зам тодорхойлох зорилгоор. 5 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээнд шаардлагатай зардалд ОНТ-ийн 12.878.300 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Шилдэг илтгэлүүдийг “Дээд боловсрол-Эрин үе” сэтгүүлд 2 удаа хэвлэн олны хүртээл болгосон. | |
| 301 | 7.4.2. Шинэ технологи нэвтрүүлсэн, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн иргэн, аж ахуй нэгжийг урамшуулна. | 2022-2023 | НБХ | 8.0 | - | Шинэ технологи, шинэ бүтээгдэх-үүн үйлдвэр-лэсэн иргэн 1, аж ахуйн нэгж 1- ийг урамшуулна. | | - | 2022 онд Эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачид, Их дээд мэргэжлийн сургуулийн консорциумтай хамтран “Дархан Инноваци-2022” арга хэмжээг зохион байгуулж, 1 бүтээлийг шалгаруулсан. ОНТ-ийн 4,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>2023 онд Дархан-Уул аймгийн Эрдэмтдийн зөвлөл, Шинжлэх ухаан, технологийн зөвлөл, Их дээд мэргэжлийн сургуулийн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | консорциум, Худалдаа ажүйлдвэрийн танхимтай хамтран Хотын соёл, экологи, хөгжилд нэн шаардлагатай, инноваци /Шинэчлэл, сайжруулалт/-ийн бүтээлийг шалгаруулах уралдааныг зарласан. тус арга хэмжээнд 10 бүтээл ирснээс 5 бүтээл инновацийг шалгаруулсан.<br>Тус арга хэмжээнд ОНТ-ийн 10,0 сая төгрөгийг дэмжлэг үзүүлсэн.<br>**Үр дүн:** Хотын соёл, экологи, хөгжилд нэн шаардлагатай, иновацийг шалгаруулсан. ОНТ 14,2 сая | |
| 302 | 7.4.3. Дархан-Өргөө политехник сургуульд Төвийн бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах авто зам, барилгын магадлан итгэмжлэгдсэн лаборатори, дадлага сургалтын полигон байгуулна. | 2021-2024 | НБХ | - | Дархан-Өргөө политехник сургуульд төвийн бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах лаборатори баригдсан. | Магадлан итгэмжлэгдсэн лаборатори нээсэн байна. | | - | Азийн хөгжлийн банкны "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх" төслийн хөрөнгө оруулалтаар 3,624014273 төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий Авто зам, барилгын материалын лаборатори, зам барилгын машин механизмын засварын газар, тоног төхөөрөмж машин механизмуудыг хүлээн авч 2023 оноос сургалтын үйл ажиллагааг эхлүүлэн үргэлжлүүлэн явагдаж байна.<br>**Үр дүн:** Барилга авто замын лаборатори анги нээгдэн, зам барилгын 3 анги хичээллэж байна. | 100% |
| 303 | 7.4.4. Дархан - Уул аймагт эрэлттэй ажилтан бэлтгэх төсөл хэрэгжүүлнэ. | 2022-2024 | НБХ | 8.0 | Шинээр авто зам гүүр барилгын ангид 68 хүүхэд сурч, 88% нь ажлын байртай болсон. | Судалгаанд түшиглэн эрэлттэй мэргэжилтэн бэлтгэх хүний нөөц, материаллаг баазыг бүрдүүлсэн байна. | | - | Дархан-Уул аймаг дахь Политехник коллеж Хөгжлийн төлөөх төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Холбооны Эдийн Засаг, Хөгжлийн Яам (BMZ) болон WILO групптэй хамтран санхүүжүүлсэн “Мэргэжилтнийг чадавхжуулснаар дулаан хангамжийн үр ашиг дээшилж, хэмнэлтийг бий болгох нь” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд дулааны эх үүсвэр дээр эрчим хүчний өндөр үр ашигтай ухаалаг насос, суурилуулан ажиллуулж холбогдох мэргэжлийн багш оюутнуудыг бэлтгэж байна.<br>Зах зээлийн эрэлтийн судалгаанд судалгаанд тулгуурлан УУЭХПТК дараах мэргэжлийн ангийг 2022 онд байгуулан мэргэжилтэн бэлтгэж байна. | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Метал боловсруулах суурь машины оператор 2.5 жил,<br>Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засварчин 2.5 жил,<br>Өрмийн машины оператор, Төмөрлөгийн үйлдвэрийн цехийн операторчин 1 жил<br>Дархан Өргөө ПТК Барилга авто замын Лабораторийг ашиглалтад оруулсантай холбогдуулан Зам Барилгын Лаборант Мэргэжлийн ангийг нээж мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн.<br>**Үр дүн:** Зах зээлийн эрэлтийн судалгаанд судалгаанд тулгуурлан УУЭХПТК 3, Дархан Өргөө ПТК 1 ангийг нээж мэргэжилтэн бэлтгэж байна. | |
| 304 | 7.4.5. Хөдөө аж ахуйн салбарын их, дээд сургуулиудыг өргөжүүлэхийг бодлогоор дэмжинэ. | 2021-2024 | НБХ | - | БШУЯ, холбогдох байгууллагуудад танилцуулсан | - | | - | ХААИС-ийн хичээлийн байрны засвар 2,8 тэрбум төгрөгийн төсөв өртөгтэй, гүйцэтгэл 81%, ШУТИС-ийн дотуур байрны засвар 300 сая төгрөгийн төсөв өртөгтэй, гүйцэтгэл 100%, АШУИС-ийн спорт заал 1,2 тэрбум төгрөгийн өртөгтэй баригдаж байгаа бөгөөд барилгын явц 45%, тус сургуулийн хичээлийн байрны засвар 700 сая төгрөгийн өртөгтэй засварлаж, гүйцэтгэл 99%-тай байна.<br>**Үр дүн:** 3 сургуулийн засварын ажил 5,0 тэрбум төгрөгийн төсөв өртөгтэй, гүйцэтгэл 81,2%-тай байна. | 100% |
| **7.5. Тэжээлийн ургамал, эмийн ургамал тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, загас үржүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдийг бодлогоор дэмжих** | | | | | | | | | | |
| 305 | 7.5.1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Хүнс, хөдөө аж ахуйн газар | 400.0 | Арьс шир ноосон бүтээгдэхүүн 22, гурил, гурилан бүтээгдэхүүн 52, мах, махан бүтээгдэхүүн 25, сүү, сүүн бүтээгдэхүүн 12, хүнсний ногоо боловсруулах 8 үйлдвэр цех үйл ажиллагаа явуулж, махан бүтээгдэхүүн | Боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана. | 100.0 | 16.2<br>145.9 | “**Уулзалт, сургалт:** ЖДҮГ, ХХААГ, Хөгжлийн шийдэл ТББ-ын Бест хөтөлбөртэй “Төрийн худалдан авалтын сургалт, хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл”, "Зээлжих боломжийг нэмэгдүүлэх нь", “Ажлын байрыг дэмжих зээл”, “Зээлийн батлан даалтад аж ахуй нэгжийг хамруулах нь”, “Хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт хууль тогтоомж, хөнгөлөлттэй зээлийн танилцуулга”, “Малчдын хоршоо - Үндэсний үйлдвэрт түүхий бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт”, “Хөдөө аж ахуй болон хүнсний салбарын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах сургалт”, “Хөнгөлөлттэй зээлийн мэдээлэл, төсөл хөтөлбөрийн танилцуулга”, “Жижиг, дунд бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх нь” таним, цахим 6 | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1.9%, сүүн бүтээгдэхүүний 1.9%, гурил 3.2дахин их, , гурилан бүтээгдэхүүн 18.3%, хүнсний ногоо хангаж байна. | | | | сургалт, “Хөдөө аж ахуйн салбарын санхүүгийн шинэ гарц, шийдэл” зөвлөгөөн, Бодлогын шийдэл ТББ-тай “Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах сургалт”, Японы Ядуурлыг бууруулах сангийн хөрөнгөөр Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл” /МОН 91:92/-ийн хүрээнд төсөлд хамрагдсан 70 өрх болон Газар шим өгөөж хоршоо, Орхон хөрс хоршооны гишүүдэд “Хүлэмжний хүнсний ногоо ургуулах технологи сургалт”, “Хоршооны ахисан шатны сургалт”, “Компос бордооны хэрэглээ үйлдвэрлэл”, “Ургамал хамгааллын сургалт”, “Усалгаатай тариалан”, “Хүнсний ногоо хадгалалт”, “Амьдрах ухаан”, “Хамгаалагдсан хөрсний аж ахуй” зэрэг цахим, танхим, талбайн хосолсон сургалт, Найрамдал төсөлтэй “Уур амьсгалын нөхцөлд тохирсон ухаалаг газар тариалан ба агропренершип чадавхижуулах” онол туршлага хосолсон сургалт, Монгол ногоо төсөлтэй “Төмс, хүнсний ногооны боловсруулалт, хэрэглээг нэмэгдүүлэх” зэрэг танхимын 34 сургалт, “Оёдлын салбарын 20000 кластр зөвлөгөөн”, Дэлхийн зөн ОУБ-тай “Хөдөлмөр эрхлэлт хамтын ажиллагаа зөвлөгөөн”, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг орон нутагт хэрэгжих төслийн уулзалт болон салбарын уулзалт, нийт 2400 хүнд, 2024 онд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий арга хэмжээнд нийт 800 гаруй иргэн, аж ахуйн нэгж, “Үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлэх” сэдэвт сургалтад нийт 58 сүү бэлтгэн нийлүүлэгч, сүү боловсруулах болон талх, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрийн ажилтнуудад зохион байгуулсан. Мөн Сүүний урамшуулалд малчдыг хамруулах зорилгоор сүү боловсруулах 2022-2023 онд 2 үйлдвэр 58 малчин, 2023-2024 онд 1 үйлдвэр 27 малчинд сургалтаар зөвлөгөө өгч ажиллав.<br>**Дэмжлэг:** “Ажлын байр дэмжих хөнгөлөлттэй зээл”-д 566 иргэн, 132 аж ахуйн нэгж 41.16 тэрбум төгрөг, Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хүрээнд 188 иргэн, аж ахуйн нэгжид 66.8 тэрбум төгрөгийн 5-6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкаар дамжуулан олголоо.<br>Зээлийн батлан даалтын сангийн хөнгөлөлттэй зээлд 13 аж ахуйн нэгж 2345.7 сая төгрөгийн | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | батлан даалт, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд 34 аж ахуйн нэгж 5.2 тэрбум төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд 117 иргэн, аж ахуйн нэгжид 937.4 сая төгрөгөөр тус тус хамрагдлаа. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 5 хоршооны 12 малчин өрх 390.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж, шинээр 45 мал аж ахуйн хоршоо байгуулагдлаа.<br>Хөгжлийн шийдэл ТББ-ын гарааны бизнесийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрт шинэ санаачилга, инноваци бүхий 9 аж ахуйн нэгжид 90.0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг олгосон. Европын холбооны 3.0 сая еврогийн буцалтгүй санхүүжилтээр аймгийн инновац, ногоон хөгжил, энтрепренершип, гарааны бизнесийг дэмжих тусгай хөтөлбөрүүдтэй “Найрамдал төсөл”-ийн гарааны бизнесийг дэмжих төсөлд 10 аж ахуйн нэгж тус бүр 70.0 сая төгрөгийн сургалт, тоног төхөөрөмжийн буцалтгүй тусламж авлаа. ЕХ-ны 12 төлөөлөгч нарт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах 28 аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилснаар 4 аж ахуйн нэгж Турк улсад туршлага судаллаа.<br>“Адра” ОУБ Сэлэнгэ, Дарханы гол бүсэд орон нутгийн органик хамтын баталгаажуулалтын байгууллага байгуулах замаар органик хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гаргах төсөл хэрэгжүүлэх судалгааны ажилд хөдөө аж ахуйн салбарын 30 хоршооны мэдээллийг гарган хүргүүлснээр 10 хоршоо уг төсөлд хамрагдаж, хамтын баталгаажуулалтын байгууллага байгуулах эхлэл тавигдлаа.<br>2024 онд арьс шир боловсруулах Дархан минж ХХК, бялуун бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Жүр үр ХХК-ийг “Хүнсний хувьсгал”-ын цахимаар сурталчилж, ургамлын гаралтай хүнс үйлдвэрлэгч 13 аж ахуйн нэгжийн 2023 онд авсан эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн үр дүнд хяналт хийж ажиллалаа.<br>**Үр дүн:** 2021-2024 онд нийт 13 ТББ-тай 73 удаагийн сургалт, уулзалт, зөвлөгөөн, форум, аяллыг зохион байгуулж, 3260 гаруй иргэнийг хамруулж, 164 иргэн аж ахуйн нэгж 7.6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг ЗБДС, ХХС, ЖДҮХС-аас, 19 аж ахуйн нэгж ОУБ-ын 790.0 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэгт хамрагдсан. 2023 онд 886 иргэн аж ахуйн нэгжид банкаар | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | дамжуулан 88.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон ба 2023-2024 онд хүнсний үйлдвэрийн 13 ААН-ийг дэмжиж, 44.52 тэрбум төгрөгийн зээлийн үр дүнд хяналт тавин ажилласан. Суурь онтой харьцуулахад: Арьс шир, ноосон бүтээгдэхүүний үйлдвэр 9-өөр нэмэгдэж 31, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр 6-аар нэмэгдэж 32 хүнсний ногоо боловсруулах үйлдвэр, цех 1-ээр нэмэгдэж 9 болсон. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулалтаар гурил 7530 тн-оор, талх, гурилан бүтээгдэхүүн 186 тн-оор, хиам 74 тн-оор, нэхий дээл 7343 ш-ээр,савхин дээл 856 ш-ээр тус тус өссөн., Бүтээгдэхүүний үйлдвэрлэл: арьс, шир боловсруулах, ширэн эдлэл 509.0 сая.төг-өөр, хүнс, нудаа 42812 сая.төг-өөр өссөн ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалт 41265 сая.төг-өөр тус тус өссөн. Тус салбарт хөнгөний 31, хүнсний боловсруулах 64 аж ахуйн нэгж ээлж байна. | |
| **7.6. Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах бодлого хэрэгжүүлж, хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангаж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулж, нөөцийн хуримтлал бий болгох** | | | | | | | | | | |
| 306 | 7.6.1. Усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, ЗАА | | Давснаас хлор гаргах төхөөрөмж байхгүй. | Давснаас хлор гаргах төхөөрөмжтэй болсон байна. | - | - | Дархан хотын хэрэглэгчдийг стандартанд нийцсэн ундны усаар хангах зориулалттай халдваргүйжүүлэх төхөөрөмжийн ашиглагдаж буй шингэн хлорын технологийг хоолны давснаас хлор гарган авах зарчимаар ажилладаг технологи нэвтрүүлэхээр компанийн инженер, техникийн ажилчдаас бүрдсэн баг судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэн 2024 оны 03 дугаар сард төсөл боловсруулж дууссан. Тус төслийн хүрээнд хоолны давснаас хлор гарган авах технологи нэвтрүүлэн ундны усыг халдваргүйжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр болох 300,000,000 төгрөгийг төсвийг Дархан-Уул аймгийн 2024 оны төсвийн тодотголд тусгаж өгч дэмжлэг үзүүлэхийг хүссэн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Аймгийн Засаг даргад 01/167, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад 01/166 дугаар албан тоот бичгээр тус тус хавсралт /39 хуудас төслийн материал, 3 хуудас | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | техникийн тодорхойлолт, Монгол улсад худалдан борлуулах эрхтэй албан ёсны байгууллагын танилцуулга материал 24 хуудас/-ын хамт хүргүүлж ажилласан болно. | |
| **7.7. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, цөлжилт, газрын доройтлыг бууруулах үндэсний зорилтыг хэрэгжүүлэх** | | | | | | | | | | |
| 307 | 7.7.1. Үржил шимтэй газрыг хамгаалж ойжуулалтын ажлыг 132 га талбайд хийнэ. | 2021-2024 | ХБТХООХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын ойн анги | 386.0 | Навчит модны ойжуулалт Хонгор сумын Жимс тохой гэх газар 10 га, Дархан сумын 5-р багт 2 га, Орхон сумын Хар эрэг гэх газар 10 га нийт 22 га талбайд ойжуулалт хийсэн. | Навчит шилмүүст модыг 20 га талбайд хийнэ. | 45.7 | 45.7 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал, сум хөгжүүлэх сангаас шилмүүст болон навчит модны тарьц, суулгацаар ойжуулалтын ажил гүйцэтгэсэн. Үүнд:<br>2021 онд 32 га талбайд навчит, шилмүүст модны тарьц, суулгацаар ойжуулалт, нөхөн сэргээлт ажил гүйцэтгэж, 26,5 сая.төгрөг зарцуулж, 29130 ширхэг мод тарьсан.<br>2022 онд 10 га талбайд шилмүүст модны тарьцаар ойжуулалт, нөхөн сэргээлт ажил гүйцэтгэж, 12,0 сая.төгрөг зарцуулж, 17000 ширхэг мод тарьсан.<br>2023 онд 42 га шилмүүст модны тарьцаар хийсэн ойжуулалтын ажилд 52,0 сая.төгрөгийн зарцуулж, 86,0 мян.ширхэг мод, бут тарьж, ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн.<br>2024 онд "Ногоон Дархан-2032" хөтөлбөрийн 5.2.3 дахь заалт "Шинээр үйлдвэрлэл үйлчилгээ, нийтийн орон сууц барих зориулалтаар газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ авсан, эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан, эрхийн гэрчилгээгээ сунгуулсан иргэн, аж ахуй нэгж, байгууллагууд газрынхаа 10 хувьтай тэнцэх талбайд тусгайлан заасан байршилд ногоон байгууламж, ойн зурвас байгуулах, эсхүл ногоон байгууламж, ойн зурвас бий болгоход зориулж талбайн хэмжээгээр 1 метр квадрат талбайг 1000 төгрөгөөр тооцож төлбөр төлнө"-ыг гэж заасны дагуу Зулзагын голын нарсан ойг тэлэх ойжуулалтын ажилд аж ахуйн нэгж, байгууллага иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас уул уурхайн олборлох үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | нэгж, байгууллагуудаас нийгмийн хариуцлагын хүрээнд 2024 оны 05-р сарын байдлаар 144,8 сая.төгрөг төвлөрүүлж, ойн мэргэжлийн байгууллагаар ойжуулалтын ажлыг гүйцэтгүүлж байна. Зулзагын голын нарсан ойг тэлэх ойжуулалтын ажил гүйцэтгэх гэрээний дагуу “Домогт Шарын гол” ХХК-нь 4,8 га талбайд, “Батбадрах дэлгэр” ХХК нь 22,5 га талбайд нарс болон навчит модыг тарьж, арчилгаа, усалгааг гүйцэтгэж байна.<br>Улсын төсвийн хөрөнгөөр байгалийн сэргэн ургалтад дэмжих ажлыг 50 га талбайд ойн мэргэжлийн байгууллагууд шан татаж зурвас гаргах, хөрсний өнгөн хэсгийг хуулж талбар гаргах, хөрсийг сийрүүлэх, уг талбарт нарс, хусны үр суулгаж хөнгөн хөрсөөр хучих аргаар гүйцэтгэж байна.<br>**Үр дүн**: Нийт 184 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн. | |
| **7.8. Аймгийн төвд хог хаягдлыг ангилан ялгах, эх үүсвэр дээр нь бууруулах, дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг дэмжиж, хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах** | | | | | | | | | | |
| 308 | 7.8.1. Хог дахин боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулж, хувийн хэвшлийн оролцоотой хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж ашиглалтад оруулна. | 2021-2022 | ХБТХОХ, Захирагчийн ажлын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 2,988.0 | Хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөө боловсруулах эрдэмтдийн баг байгуулагдаж хог хаягдлын суурь судалгааны ажлыг хийж, хог хаягдлын нөөцөд суурилсан органик хог хаягдал, пластик, барилгын хог хаягдлыг боловсруулах тус тус үйлдвэрүүдийн ТЭЗҮ-г | Хог дахин хүлээн авах зөөврийн 5 ширхэг чингэлгийг шинээр ашиглалтад оруулна. | 2,988.0 | 3,288.0 | 2021 он Аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/67 тоот захирамжаар “Дархан сумын хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах судалгааны ажлыг хийлгэх, үйлдвэр байгуулах” төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж шаардлагатай мэдээлэл, судалгаа, шинжилгээний ажлыг хийсэн. 2022 он Хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөө боловсруулах эрдэмтдийн баг байгуулагдаж суурь судалгааны ажлуудыг хийж, менежментийн төлөвлөгөөний хүрээнд хог хаягдлын нөөцөд суурилсан органик хог хаягдал, пластик, барилгын хог хаягдлыг боловсруулах үйлдвэрүүдийн ТЭЗҮ-г дуусгасан. - Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр МОН9206 ядуурлыг бууруулах төслийн хүрээнд 158.0 сая.төг-ийн санхүүжилтээр Дархан сумын 3, 5, 6, 12, 16-р багуудын нутаг дэвсгэрт хог хаягдал хүлээн авах 5 чингэлгийг | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хийж дуусгасан . | | | | байрлуулахаар “Гурван бүрэн” ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. 2023 он Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.Үүнд: - ОНТХ 0.5 тэрбум.төг-ийн хөрөнгө оруулалтаар хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэл /”Сан оргиу” ХХК/ 95 хувь, 0.3 тэрбум.төг-ийн хөрөнгө оруулалтаар аюултай хог хаягдлыг шатаах зуух барилгын ажлын гүйцэтгэл /”Технологи бридж” ХХК/ 95 хувийн гүйцэтгэлтэй байна. -УТХО 2.0 тэрбум.төг-өөр хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн ажлын сонгон шалгаруулалтад “Монголиан интернэшнл куалифайд инженеринг” ХХК шалгаран ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. -Европын Холбооны санхүүжилттэй “НАЙРАМДАЛ” төслийн II зорилт буюу Иргэдийн оролцоот засаглалыг дэмжих ажлын төлөвлөгөөний дагуу “Хоггүй Дарханыг хамтдаа бүтээе” сэдвээр “Дархан форум” хэлэлцүүлгийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт эрдэмтэн судлаачид, төрийн болон ТББ-ууд, иргэдийн төлөөлөл, орон нутгийн удирдлагууд оролцож “Зөвлөмж” гаргасан. -МХХДБҮХ-ны Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлөөс "Хогоо ангилья-Хогоо багасгая" уриан дор ангилсан дахивар хүлээн авах өдөрлөгийг хамтран зохион байгуулж, хамгийн их дахивар цуглуулсан иргэн аж ахуйн нэгжийг урамшуулан, хог хаягдлаар хийсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг дэлгэсэн. 2024 он Орон нутгийн төсвийн 0.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэл /”Сан оргиу” ХХК/ 100 хувь, 0.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар аюултай хог хаягдлыг шатаах зуух | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | барилгын ажлын гүйцэтгэл /”Технологи бридж” ХХК/ 100 хувь. -“Бараат” төвлөрсөн хогийн цэгийн ТЭЗҮ-г Найрамдал төслийн хүрээнд Турк улсын эрдэмтэн судлаачид боловсруулж байна. Үр дүн: Иргэд хог хаягдлаа ангилан ялгах дадалд хэвшин, хог хаягдлын талаарх салбар дундын хамтын ажиллагаа сайжирсан | |
| 309 | 7.8.2. Хог тээврийн тусгай зориулалтын автомашины парк шинэчлэлтийг ажлыг үе шаттай хийнэ. | 2021-2024 | ХБТХОХ | 1,902.0 | Хог тээврийн тусгай зориулалтын 3-н авто машин нийлүүлэгдсэн. | Хог тээврийн тусгай зориулалтын 3-н авто машин нийлүүлнэ. | 1,927.0 | 0.0 | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ”-т Хог тээврийн 8м3 багтаамжтай тусгай зориулалтын 4 авто машин, хово автомашин 1ш, тусгай зориулалтын ковш 1ш, хог цэвэрлэгээний тусгай зориулалтын 3ш техник нийлүүлэх ажилд 500.0 сая төгрөг, ухах, ачиж буулгах зориулалттай гинжит экскаваторыг 825 сая, Хятад улсад үйлдвэрлэсэн SHEHWA брэндийн TYS 165-3 HW маркийн түрэх зориулалттай бульдозерыг 388 сая төгрөгөөр тус тус нийлүүлсэн.<br>2022 онд Хог тээврийн тусгай зориулалтын шахдаг авто машин /Дархан сум, НААҮГ/, 207.7 сая төгрөг, 2023 онд Хог тээврийн авто машин /Дархан сум 7-р баг/ 104.0 сая төгрөг, 2024 онд Хог тээврийн авто машин /ДХТҮГ/ 84 сая төгрөгөөр санхүүжүүлэн парк шинэчлэлтийг үе шаттай хэрэгжүүлсэн.<br><br>**Үр дүн:** Хог тээврийн тусгай зориулалтын автомашины парк шинэчлэлтийн ажилд 12 техник нийлүүлэх ажилд 2.1 тэрбум төгрөг зарцуулсан. | 100% |
| 310 | 7.8.3. “Цэвэр хот” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ХБТХОХ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 7.0 | Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2021 оны 51 дүгээр тогтоолоор “Цэвэр хот” дэд хөтөлбөрийг батлуулсан. | Орчны бохирдлыг бууруулах аймгийн зөвлөлийг байгуулсан байна. | - | - | 2021 онд улсын төсвийн 343,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3190 айл өрхүүдэд цахилгаан халаагуураар нийлүүлсэн.<br>2022 онд Улсын төсвийн 2,0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 8 утаа шүүгчийг “Гал унтраах 54-р анги”, “8-р цэцэрлэг”-ийн нам даралтын зууханд суурилуулсан.<br>2023 онд “Дархан Геомаш” ХХК, “Идэр Хайрхан” ХХК нэр бүхий 7 аж ахуйн нэгж | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | байгууллага өөрийн хөрөнгөөр утаа шүүгч тавьж, 1 аж ахуйн нэгж төвлөрсөн халаалтын системд өөрийн зардлаар холбогдсон.<br>БОАЖЯ, ОББҮХ-ООС Угаарын хийн мэдрэгчийг зорилтот 1100 өрхөд олгохоор 346,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.<br>2024 онд “Утаагүй Дархан” дэд хөтөлбөрийг 96 хувийн хэрэгжилттэй хангуулж Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулсан. Хурлын хуралдаанаас тус хөтөлбөрийг үргэжлүүлэн 2024-2028 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх зорилгоор “Агаарын бохирдлыг бууруулах “ дэд хөтөлбөр болгон шинэчлэн боловсруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар тогтоолоор 6 зорилт, 27 арга хэмжээг батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>Мөн аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох төлөвлөгөө боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулахаар ажиллаж байна.<br>**Үр дүн:** 3190 өрх нүүрсний хэрэглээнээс татгалзаж цахилгаан халаагуур хэрэглэж, угаарын хийн мэдрэгчийг зорилтот 1100 өрхөд, 11 аж ахуйн нэгж уутат фильт тавьж агаар бохирдуулах эрсдэл буурсан. | |
| 311 | 7.8.4. “Шарилжгүй Дархан” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн жил болгон 150 га-аас багагүй талбайд шарилж устгалыг хийнэ. | 2021-2024 | ХБТХОХ, | 40.0 | Дархан сумын хэмжээнд нийт 240га талбайд шарилж устгалыг хийнэ | Дархан сумын хэмжээнд нийт 200га талбайд шарилж устгалыг хийнэ. | 20.0 | 0.0 | Шарилжгүй Дархан” дэд хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 23 дугаар тогтоолоор батлуулсан.<br>**2021 онд:** 1-р үе шат: Дархан –Уул аймгийн Дархан сумын хэмжээнд ургаж байгаа хог ургамлын 75%-нь шарилж луулийн төрлийн ургамалууд байгаа ба эдгээр ургамалуудыг устгахад дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: Хог ургамлын грибцид Зингер хорыг эзэнгүй 86 га талбайд УГТХ-ийн хор цацдаг трактороор цацаж.<br>6-р сарын 18-наас 28 хүртэл 10 хоног 10 хүн автомакстай ажиллаж шарилж устгал хийсэн. Үүнд ДХТҮГ-ын хариуцдаг талбайн 29 га, Сөхүүдийн нутаг дэвсгэр ургадаг хог ургамалтай талбай 16 га, Эзэнгүй гэх тодотголтой 127га, гэр хороолол сөхгүй багуудын нутаг дэвсгэр дахь хог ургамалтай талбай-48га нэг бүрчлэн хэмжиж 3н үе шаттай 100 га шарилж усгтал хийсэн<br>2-р үе шат: 7-р сарын 10наас 17 ны хооронд 7 хоног 10 хүн хадуууртай хадаж 8 автомакстай | 100% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хүнээр хорыг 100га талбайд цацаж хосолмол аргыг хэрэглэж ажилласан.<br>3-р үе шат: 8-р сарын 10-16 хүртэл 6 хоног 10 хүн хадууртай ажиллаж сөх багуудтай хамтран хадуур хор гербицид өгч хамтран 100 га талбайн шарилж устгал хийсэн. Нийт 300 га талбайн шарилжийн 26 хоногт 30 ажилтан ажиллаж 9,9 сая төгрөгийг зарцуулсан.<br>**2022 онд:**<br>1-р үе шат: 6-р сарын 16 наас 27 ны хооронд 10 хоног 5 тн усны машин пад трактор 6 автомакс 10 хүний бүрэлдэхүүнтэй 220 га талбайн шарилж устгаж ажилласан<br>2-р үе шат: бороо их орсонтой холбоотой 7-р сарын 23наас 30 ны хооронд 8 хоног 10 хүн хадуууртай хадаж 5 автомакстай хүнээр хорыг 220 га талбайд цацаж хосолмол аргыг хэрэглэж ажилласан.<br>3-р үе шат: 8-р сарын 25-наас<br>9-р сарын 3 хүртэл 9 хоног 12 хүн хадуууртай ажиллаж 200 га талбайн шарилж устгал хийсэн. Нийт 640га-д 27 хоногт 32 ажилтан ажиллаж 19,9 сая төгрөгийг зарцуулсан.<br>**2023 онд:** 1-р үе шат: 6-р сарын 30 наас наас 7-р сарын 3 ны хооронд 3 хоног 5 тн усны машин пад трактор 10 автомакс 10 хүний бүрэлдэхүүнтэй 200 га талбайн шарилж устгаж ажилласан.<br>2-р үе шат: бороо их орсонтой холбоотой 7-р сарын 20ноос 30 ны хооронд 10 хоног 10 хүн хадуууртай хадаж 5 автомакстай хүнээр хорыг 180 га талбайд цацаж хосолмол аргыг хэрэглэж ажилласан.<br>3-р үе шат: 8-р сарын 1 нээс үргэлжлэн шалилж хадах ажил 12 хүн 25 хүртэл хадах арга хэмжээг авч ажиллаж 180 га талбайн шарилж устгал хийсэн.<br>Нийт 560 га-д 38 хоногт 32 ажилтан ажиллаж 18,1 сая төгрөгийг зарцуулсан.<br>**2024 онд:** 19,9 сая төгрөгийг зарцуулсан. Шарилжгүй дарханы дэд хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 7-р сарын 3,4,5 ны өдрүүдэд нийт 200 га талбайд 120 литр раундап:<br>8 кг алмазис, хор цацаж 1-р шатны шарилж устгалын ажил хийж гүйцэтгэсэн.<br>2-дугаар үе шатыг 7-р сарын 25-наас 31-ны хооронд хор болон цахилгаан хадуур гэсэн хосолмол 2 аргаар дээрхи 200 га талбайд устгалыг ахин хийсэн. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 3-р шатны ажлыг 8-р сарын 10 наас 30 хүртэл нийтийн эзэмшлийн 29 га талбайн шарилжыг 4удаа хадаж устгаж, 84 га талбайн эзэнгүй талбай д үлдсэн шарилжыг цахилгаан хадууураар хадаж устгалыг бүрэн хийж гүйцэтгэлээ. Шарилж их ургасан албан газрын судалгааг гаргаж албан бичиг явуулж, Нийт 2баг, 44 сөхүүдэд 3,5 кг алмазис , раундап 30 литр хорыг өгч хамтран ажиллалаа<br>**Үр дүн**: Дархан сумын хэмжээнд нийт 2100 га талбайд 126 ажилтан, баг, СӨХ-тэй хамтран ажиллаж, ургамал хамгаалах бодис Алмазис гербецид-58,5 кг, PAUNDAP гербецид 492л зарцуулж, шарилж устгалын ажилд нийт 67,8 сая төгрөг зарцуулсанаар нийт талбайн 15-20% хиаг зүлэг ургаж байна. | |
| 312 | 7.8.5. Гэр хорооллын айл өрхийн хог татан авах, үнс хадгалах зориулалтын 2000 савыг гэр хорооллын айл өрхүүдэд үе шаттайгаар нийлүүлнэ. | 2021-2024 | Дархан сум здтг, ЗАА, Нийтийн аж ахуй үйлчилгээ-ний газар | | - | Үнсний савыг гэр хорооллын 400 айлд нийлүүлнэ. | 394.0 | 394.0 | 2021 онд гэр хорооллын айл өрхийн хогийг татан авах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 130.0 сая.төг-ийн хөрөнгө оруулалтаар 18м3 багтаамжтай Хово маркын авто машин, 2022 онд 8ш техникээр парк шинэчлэлтийг нэмэгдүүлэх ажилд 1927.0 сая.төг, 2023 онд иргэдийн хог хаягдлын боловсролыг дээшлүүлж, хотын өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар /19.6 сая.төг/ 95ш хуванцар хийх савыг бэлэн болгож, нийтийн эзэмшлийн зам талбайд байршуулсан.<br>2024 онд Дархан сум 7-р багт өөрөө татан авах механик бүхий 5 контейнер авч байрлуулсан.<br>**Үр дүн:** Гэр хорооллын айл өрхийн хог хаягдлын татан авалт сайжирсан. | 100% |
| **7.9. "Цахим үндэстэн" болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх** | | | | | | | | | | |
| 313 | 7.9.1. “Цахим Дархан” төсөл хэрэгжүүлнэ. | 2021-2024 | ТЗУХ, МТА | 267.0 | Аюулыг мэдээлэх аппликэйшнийг хийж гүйцэтгэх байгууллагууда ас үнийн санал авсан. | “Цахим сэрэмжлүүлэг Дархан” апплкейшнийг нэвтрүүлнэ. | 19,5 | - | Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, мэдээ, мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэж, төрийн ой санамжийг төгөлдөржүүлэх, түүнд суурилсан цахим үйлчилгээг хөгжүүлэхэд төслийн зорилгоор **4** зорилт, 7 үйл ажиллагаа, 31 арга хэмжээ бүхий “Цахим Дархан” төслийг батлуулж хэрэгжүүлэн ажиллалаа. Монгол улсын Засгийн газраас дэмжсэн “Цахим аймаг” бодлогын баримт бичгийн хүрээнд ЦХХХЯ орон нутгийн цахим шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор үндэсний хэмжээнд нэгдсэн бодлого | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | арга зүйгээр хангах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.<br>Дархан-Уул аймагт зохиогдож буй “Маргаашийн хот” уриатай “Ухаалаг хот” арга хэмжээний 2 дахь өдөр 21 аймгийн төвийн сумдуудын удирдлагууд, Дархан-Уул аймгийн төрийн албан хаагчид, ОУ-ын зочид төлөөлөгчдийг хамруулсан “Цахим аймаг” хэлэлцүүлэг, форумыг ЦХХХЯ, Дархан сумын ЗДТГ, Найрамдал төсөл хамтран зохион байгууллаа.<br>“Цахим Дархан” төсөл нь 2 үе шаттай явагдах бөгөөд 2018 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 15.3 км шилэн кабелийг Дархан сумын 10-16 дугаар багт тавьж айл өрхүүд болон ААНБ-уудыг холбосон байхаар төлөвлөн ажиллаж байна. Төслийн ажлыг гүйцэтгэгч байгууллага болох “Монголын Цахилгаан Холбоо” ХК-иас хэрэгжүүлээд байгаа.<br><br>“Цахим Дархан” төслийг 2021-2024 онуудад амжилттай хэрэгжүүлж, 2023 оны жилийн эцсийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээгээр 87.14%, 2024 онд уг төслийн хүрээнд “Ай Си Ти” ХХК-тай хамтран ажиллаж Дархан-Уул аймгийн албан ёсны цахим хуудас http://darkhan.gov.mn/ “Гэрээт ажилтний систем”, “Удирдлагын нэгдсэн дашбоард” системүүдийг шинээр хийж хөгжүүлэн Аймгийн “Мэдээлэл технологийн алба”, “Дархан сумын ЗДТГ” хүлээн авч хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна.<br><br>МУЗГ-аас Дархан-Уул аймгийг “Жишиг Цахим” аймаг болгох төсөл амжилттай хэрэгжиж байна. Энэ ажлын хүрээнд ЦХИХХЯ- наас манай аймагт шинээр нэвтрүүлж буй 10- н төрлийн / Инженерингийн, Шуурхай удирдлагын, Орон зайн, Хогны машины, Тээврийн хэрэгслэлийн, Байгууллагын удирдлагын, Аж ахуйн нэгжийн, Төлбөр тооцооны / цахим системийг хэрэглэгч байгууллага, иргэдэд танилцуулах,сургах “Дижитал Дархан” нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт Төрийн болон хувийн хэвшлийн 30 гаруй байгууллагын 400 гаруй албан хаагч, иргэд оролцсон. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Цахим шилжилтийн хүрээнд Дархан-Уул аймагт “Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Дарханы айл өрхүүд болон ААНБ-дад LXSG загварын алсын зайн удирдлагатай хүйтэн усны ухаалаг тоолуурыг суурилуулж эхэлсэн. Ингэснээр хэрэглэгч усны хэрэглээгээ бүрэн хянах, үр ашиггүй усны зарцуулалтыг багасгах зэрэг олон давуу тал бий болж байгаа юм.<br><br>“Дижитал Дархан”өдөрлөгийн хүрээнд өнөөдөр /2024.09.10/ Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү болон албаны бусад хүмүүс Дархан Ус суваг ХК-ийн удирдлагуудтай уулзан ухаалаг тоолуурын системтэй танилцаж шаардлагатай мэдээллийг авсан юм.<br><br>“Цахим Дархан” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн дижитал шилжилтийг эрчимжүүлэхээр өнгөрсөн 4 жилийн хугацаанд Дархан-Уул аймагт олон ажил, арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлсэн. Тухайлбал Смарт Дархан, Дижитал Дархан, Цахим аймаг хөтөлбөрийн хүрээнд:<br><br>- Төрийн байгууллагын дотоод удирдлагын систем<br>- -Эрсдэл аппликэйшн<br>- - Иргэдийн индэр аппликэйшн<br>- И-Дархан цахим хуудас<br>- Үнэлгээний хороо унагаах системийг тус тус нэвтрүүлэн ажиллаж байна.<br><br>Нэвтрүүлсэн системүүдийг салбарын сайд сайшаагаад цаашид цахим шилжилтийг эрчимжүүлж, төрийн болон бусад үйлчилгээг иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хурдан шуурхай, чирэгдэлгүй авах боломж нөхцөлийг бүрдүүлэх, орон нутагт дутмаг байгаа цахим технологийн салбарын мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх зэрэг тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхэд төр засгаас бодлогоор дэмжин анхааран ажиллахыг салбарын сайд онцоллоо. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 314 | 7.9.2. Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцооны системийн ашиглалтын чанарыг сайжруулна. | 2021-2024 | МТА | 28.0 | Төрийн дотоод удирдлагын мэдээлэл солилцооны системийн **хэрэглэгч байгууллагын тоо: 106 хэрэглэгчийн тоо: 725** | Хэрэглээг идэвхжүүлэх сургалт модулуудыг авч үндсэн хэрэглэгчийн тоог нэмэгдүүлнэ. | 7.0 | - | ABLE системд нийт **124** байгууллагын **3433** албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж, албан бичгийг бичиг хэргийн ажилтан нар хариуцан ажиллаж байна.<br>Ажилтан албан хаагчдад албан ёсны програм хангамжийн байгууллагаас хоёр удаагийн сургалт зохион байгуулсан Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцооны систем ашиглалтын хүрээнд хэрэглээж идэвхижүүлэх админ ашиглалтын 1 удаагийн модуль сургалтад ахлах ажилтан хамрагдан 24 удаагийн зөвлөн тулах үйлчилгээг албан хаагч мэргэжилтнүүдэд өгч, хэрэглэгчийн тоог 156 гаар нэмсэн.<br><br>**Үр дүн:** ABLE системд нийт 124 байгууллагын 3591 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж, албан бичгийг бичиг хэргийн ажилтан нар хариуцан ажиллаж байна.<br>Ажилтан албан хаагчдад албан ёсны програм хангамжийн байгууллагаас хоёр удаагийн сургалт зохион байгуулсан | 100% |
| **7.10. Төрөөс ноос ноолуур, арьс шир, мах болон экспортын ач холбогдол бүхий бусад түүхий эдийн нэгдсэн агуулах болон тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх** | | | | | | | | | | |
| 315 | 7.10.1. Бүс орон нутгийн тээвэр, ложистикийн төв шинээр барих ажлыг эхлүүлнэ. | 2022-2024 | ХБТХОХ, | 520.0 | ТЭЗҮ боловсруулагдаагүй | Зураг, төсөв, боловсруулна | - | - | Бүс орон нутгийн тээвэр, ложистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулсан.<br>Орон нутгийн тээвэр ложистикийн төвийг Хонгор сумын нутагт барьж байгуулахаар төлөвлөж, орон нутгийн төсвийн 399,2 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар 200 авто машины зогсоол барьж байгуулсан байгуулсан. Дархан-Сэлэнгийн шалган бүртгэх товчооны дэргэд авто тээврийн ложистикийн төв байгуулахаар төлөвлөсөн.<br>**Үр дүн:** Орон нутгийн тээвэр ложистикийн төвийг байгуулах эхний үе шатны ажлыг эхлүүлж авто зогсоолыг барьж байгуулсан. Дархан-Сэлэнгийн шалган бүртгэх товчооны дэргэд авто тээврийн ложистикийн төв байгуулахаар төлөвлөсөн. | 90% |
| **7.11. Дархан-Уул аймагт төрөл бүрийн шахмал хавтан, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх** | | | | | | | | | | |
| 316 | 7.11.1. Дотоодын үйлдвэрийн | 2022-2024 | ХБТХОХ | | Орон нутгийн төсвийн | 2-оос доошгүй | 300.0 | - | 2021-2024 оны байдлаар өрхийн бизнесийг дэмжих хүрээнд 1 аж ахуй нэгжид мод, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулах үйл | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | чанар стандартын шаардлага хангасан мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөнгөлөлттэй зээлээр дэмжиж ажиллана. | | Сумдын ЗДТГ | 500.0 | хөрөнгөөр 400 хос сурагчийн ширээ, сандал авсан. | ААНБ дэмжинэ | | | ажиллагааг дэмжиж ЗДТГ-ын бүртгэлтэй байрыг түрээслүүлж байна. Мөн сургуулийн орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд сумын орон нутгийн хөгжлийн сангийн 40,3 сая төгрөгийн хөрөнгөөр 2 сургуульд мод, модон бүтээгдэхүүнээр 25ш ширээ, 50ш сандал, 45ш хувцасны шүүгээ болон дотуур байрны тохижилт, 16 дугаар цэцэрлэгт 26ш хүүхдийн ор худалдан авч сурагчдын ая тухтай орчныг бүрдүүллээ. | |
| **7.12. Орон нутагт шилжин ирсэн иргэдийг ажилд авсан жижиг, дунд үйлдвэрлэлд хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагааг зохион байгуулах** | | | | | | | | | | |
| 317 | 7.12.1. Шилжин ирсэн иргэдийг ажлын байраар хангаж буй аж ахуйн нэгжүүдийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих | 2022-2024 | ХХААГ, Сумдын ЗДТГ | 500.0 | | | | | 2021-2024 оны байдлаар Хоршоог хөгжүүлэх сангаар сумын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж, иргэдэд 6 удаагийн зээлийн төсөл сонгон шалгаруулах товыг зарлаж, бөднө шувууны үржүүлэг, гэр гуанз, цагаан идээ, хүнсний дэлгүүр, блок зэрэг 13 аж, ахуй нэгж, иргэдэд 268,6 сая төгрөгийн зээлийг олгож, шинээр 23 ажлын байрыг нэмэгдүүлж ажиллалаа. | 100% |
| **7.13. Сумдын инженерийн дэд бүтцийн хангамжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж, хэрэглэгчдэд иж бүрэн, чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх, инженерийн шугам сүлжээний найдвартай, хэвийн ажиллагааг хангах** | | | | | | | | | | |
| 318 | 7.13.1. Орхон сумын төвийн “Цэвэрлэх байгууламжийн ажлыг Улсын төсвийн 2024 оны төвсийн төсөлд тусгуулахаар саналыг хүргүүлж ажлыг эхлүүлнэ | 2022-2024 | ХБТХОХ | 3,000,0 | ТЭЗҮ боловсруулагдсан | Зураг, төсөв, боловсруулсан байна | - | - | Улсын төсвийн 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын тендер зарлагдаж “Ноён өндөр констракшн” ХХК шалгарч, сумын төвийн цэвэрлэх станцын лабораторын барилга бүрэн дуусаж дотоод засвар үйлчилгээний ажил хийгдэж байна. Мөн цэвэрлэх станцын газар доорх байгууламтын ажил бүрэн хийгдэж тоног төхөөрөмж суурилалт, дээд сэндвичийн угсралтын ажил хийгдсэн. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 319 | 7.13.2. Шарын гол сумын төвийн “Цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг Улсын төсвийн 2024 оны төвсийн төсөлд тусгуулахаар саналыг хүргүүлж ажлыг эхлүүлнэ | 2022-2024 | ХБТХОХ | 2,904,0 | ТЭЗҮ боловсруулагдсан | Зураг, төсөв, боловсруулсан байна | - | - | Шарын гол сумын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажлын зураг, төсөв боловсруулагдсан. 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд 843,6 сая төгрөгийн тусгасан. | 100% |
| **7.14. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж, арчилж ургуулах ажлыг нарийвчилсан стратеги, төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх** | | | | | | | | | | |
| 320 | 7.14.1. “Ногоон Дархан-2032” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг хангуулах. | 2022-2024 | АЗДТГ, Сумдын ЗДТГ, БОАЖГ холбогдох бүх агентлагууд Иргэн, ААН | 2132556.0 сая.төг | 224672 ширхэг мод бут сөөг тарьж ургуулан, 35379 м2 талбайг зүлэгжүүлж, 12634 м2 талбайд цэцгийн мандал байгуулсан. | 197944 ширхэг мод бут тарьсан. | | | Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 онд 3 багийн нийт 305 өрх, төр, төсвийн 7 байгууллагын 580 албан хаагч, 10 аж ахуй нэгжийн оролцоотойгоор ойн сан, Хараа гол, Зулзага гол, ойн зурвас, төв суурин газруудад тус тус нийт 100,6 га талбайд 172,207 ширхэг мод тарьсан байна. Мөн цэцэрлэгт хүрээлэн ногоон байгууламж байгуулахаар 153,1 сая төгрөгийн хөрөнгөөр 12 га талбайг хашаажуулж төрийн албан хаагчийн төгөл болох 0,8 га талбайд 8523 ширхэг 10 нэр төрлийн мод, 2 га талбайд Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн албан хаагчид 2520 ширхэг 2 нэр төрлийн модыг тус тус тарилаа. | 100% |
| **7.15. Мэргэжлийн холбоонд эрхээ шилжүүлэн хийлгэх боломжтой төрийн чиг үүргийн талаарх судалгаа салбар бүрээр гаргаж, шилжүүлэх ажлыг үе шаттайгаар эхлүүлэх** | | | | | | | | | | |
| 321 | 7.15.1. Төрийн чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх ажлын судалгааг гаргана. | - | Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ | 100.0 | 2022 онд ЗГХЭГ-т саналаа хүргүүлсэн. | 2-оос доошгүй үйл ажиллагааг төрийн бус байгууллагад шилжүүлэх ажлыг эхлүүлнэ | 20.0 | - | Хонгор сумын нийтлэг үйлчилгээ болох нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, хог ачилт, сумын гэрэлтүүлэг, спорт заалны үйл ажиллагаа, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг түрээслэх, ногоон байгууламжийн хашаажуулалт, сурагчдын автобусны үйл ажиллагааг хариуцах чиглэлээр Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 10 дугаар тогтоолоор тохижилт үйлчилгээний орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагааг явуулж байна. Сумын 2024 оны хог хаягдлын хураамж 13,0 сая төгрөгийн төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 2024 оны 07 | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | дугаар сарын байдлаар 12,318,000 төгрөгийг төвлөрүүлэн, гүйцэтгэл 94,0 хувийн биелэлттэй байна. | |
| **7.16. Төрийн үйл ажиллагааг ил тод, шуурхай болгох, төрийн хүнд суртлыг арилгах, бизнес эрхлэгчдийг дэмжих тусгай зөвшөөрлийг цахимаар олгох, сунгах боломжийг бүрдүүлэх, тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн санг иргэдэд нээлттэй болгох** | | | | | | | | | | |
| 322 | 7.16.1. Энгийн болон тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг E Mongolia цахим системээр авч, цахим нэгдсэн санд байршуулна. | - | Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ, ЭМГ | 20.0 | E Mongolia цахим системд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг шилжүүлсэн | Нэгдсэн санг бий болгоно. | - | - | 2021-2024 оны байдлаар төрийн үйлчилгээг цахим системд шилжүүлэх хүрээнд 6 албан хаагчийн 5 удаагийн сургалтад хамруулж, ЗДТГ-ын 3,6 сая төгрөгийн хөрөнгөөр нэг цонхны үйлчилгээнд “Хурдан цэг”-ийг байгуулж, тохижилтын ажлыг гүйцэтгэн киоск машинаар иргэдэд нэг дороос төрийн бүх төрлийн үйлчилгээг авах нөхцөл боломжоор хангаж ажиллалаа. | 100% |
| **7.17. Улаанбаатар хотоос Дархан-Уул аймагт шилжин суурьших иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг нэгдсэн бодлого шийдвэр, төлөвлөгөөний дагуу хүлээж авах үйл ажиллагааг зохион байгуулах** | | | | | | | | | | |
| 323 | 7.17.1 Нээлтэй аймаг хөтөлбөр батлуулж хэрэгжүүлэх | 2023-2024 | АЗДТГ | 200.0 | Сүүлийн 3-н жилд 1159 иргэн шилжиж ирсэн | 200 сая | - | - | Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих цогц арга хэмжээний санал боловсруулах дэд ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Дугаар 01-А/298 захирамжаар 21 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих арга хэмжээний санал авах хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд ИТХ-ын дарга 1, ИТХ-ын төлөөлөгч 5, Хэлтэс агентлагийн дарга 15, Дэд ажлын хэсгийн гишүүд 17, ХАҮТ 1, Иргэдийн төлөөлөл 3 нийт 42 хүн оролцсон. “Нээлттэй Дархан” хөтөлбөрийн төслийг боловсруулж Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн хурал, аймгийн ИТХ-ийн Зөвлөлөөр хэлэлцүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 26-нд хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан бол аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 09 дугаарт тогтоолоор “Нээлттэй Дархан” | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | хөтөлбөрийг тодотгон баталсан. НҮБ-г Шилжилт хөдөлгөөний байгууллагаас сургалт зохион байгуулан цаашид аймгийн түвшинд хариуцан сургалт хийх асуудлыг хариуцан ажиллах 2 албан тушаалтан сургалтад оролцсон. Улаанбаатар хотод 2023 оны 03 дугаар сарын 10-н өдөр зохион байгуулсан Хот хөдөөгийн сэргэлт формд Дархан-Уул аймаг оролцож Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Архангай, Төв аймгуудыг төлөөлж илтгэл танилцуулга хийсэн. Нээлттэй аймаг форумыг 2023 оны 07 дугаар сард 3 өдөр турш зохион байгуулж давхардсан тоогоор 1017 иргэд оролцсон.<br>Шилжилт хөдөлгөөнтэй холбогдуулан нийгмийн дэд бүтцийг шийдвэрлэх ажлын хүрээнд Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Төрийн албан хаагчийн орон сууц, Төрийн өмчит байгууллагуудыг орон сууцыг нийт 4-н байршилд барих ажил хийгдэж байна. 2024 оны байдлаар НОС-ны барилга 22 байршилд 1860 айлын сууц баригдаж байна. Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021-2023 ЕБС 3-н байршилд 1760 суудалтай сургууль ашиглалтад оруулсан бол 2024-2025 онд 3-н байршилд 2940 суудалтай сургуулийн барилгыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 4-н байршилд Өрхийн эмнэлгийн барилга, 250 ортой төвийн бүсийн эмчилгээ оношилгооны төв барихаар төлөвлөсөн. 2023 оны жилийн эцсийн байдлаар 861 байнгын ажлын байрыг бий болгосон. Төрийн үйлчилгээг шилжин ирж байгаа иргэн аж ахуй, нэгж байгууллагад түргэн шуурхай үйлчлэх Улсын бүртгэлийн хэлтэс болон нэг цэгийн үйлчилгээ, Багийн төвүүдэд Хурдан систем төвийг байгуулан ажиллаж байна. | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Нээлттэй Дархан хөтөлбөр батлагдсан. 2024 онд Дархан-Уул аймагт 3548 иргэн, 15 аж ахуйн нэгж шилжин ирсэн. Ипотекийн зээл авсан 319 иргэн байна.<br>**Үр дүн**: Дархан-Уул аймагт 2021-2024 онд нийт 8199 иргэн, 15 ААН шилжин ирсэн байна. | |

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д. ЧАГНААДОРЖ

НЭГТГЭЛ БОЛОВСРУУЛСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХЗУЛ